



**ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН**

**ХОТЫН ХӨГЖЛИЙН ИНДЕКСИЙН СУДАЛГАА
/5 индекс үзүүлэлтийн хүрээнд/**

2023

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

11 сар

Улаанбаатар хот



Судалгааг удирдсан:

Х.Эрдэм-Ундрах

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал,
Хууль зүйн ухааны доктор (Dr.jur)

Зөвлөх:

А.Алтанзул

Хууль зүйн ухааны доктор, дэд профессор

Судалгааны багийн гишүүд:

М.Түвшинжаргал

Эрдэмтэн нарийн бичгийн дарга, Хууль
зүйн ухааны доктор (Ph.D)

Р.Хатансайхан

Эрдэм шинжилгээний ахлах ажилтан (LL.M)

О.Энххүслэн

Эрдэм шинжилгээний ахлах ажилтан (LL.M)

М.Ганди

Эрдэм шинжилгээний ажилтан

С.Нарантунгалаг

Эрдэм шинжилгээний ажилтан

Э.Сэлэнгэ

Эрдэм шинжилгээний ажилтан



ГАРЧИГ

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ	1
ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ	1
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	4
НЭГ. ТАЙЛАНГИЙН ТАНИЛЦУУЛГА.....	6
1.1. Төвч танилцуулга	6
1.2. Зорилго	6
1.3. Хэрэгжүүлэгч тал	6
1.4. Оролцогч талууд	7
1.5. Үр дүн.....	7
ХОЁР. “НИЙСЛЭЛИЙН БОДЛОГО БОЛОВСРУУЛАХ ЭРХ ЗҮЙН ОРЧИН” ИНДЕКС ҮЗҮҮЛЭЛТ	8
2.1. Зорилго	8
2.2. Арга зүй, тооцоолол	8
2.3. Судалгааны дата/ӨГӨГДӨЛ цуглуулах.....	22
2.4. Судалгааны ӨГӨГДӨЛ боловсруулалт, индексжүүлэх.....	22
2.5. Үр дүнгийн үзүүлэлт	35
2.6. Бүлгийн дүгнэлт	36
ГУРАВ. “НИЙСЛЭЛИЙН БОДЛОГО, БОЛОВСРУУЛАЛТ, ТӨЛӨВЛӨЛТ, ХЭРЭГЖИЛТ” /ОНОВЧТОЙ, ҮР ДҮН, НӨЛӨӨТЭЙ, ИЛ ТОД/ ИНДЕКС ҮЗҮҮЛЭЛТ	39
3.1. Зорилго	39
3.2. Арга зүй, тооцоолол	39
3.3. Судалгааны дата цуглуулах.....	41
3.4. Судалгааны дата боловсруулалт, индексжүүлэх	50
3.5. Үр дүнгийн үзүүлэлт	99
3.6. Бүлгийн дүгнэлт	100
ДӨРӨВ. “ШУДАРГА БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ” ИНДЕКС ҮЗҮҮЛЭЛТ	102
4.1. Зорилго	102
4.2. Арга зүй, тооцоолол	102
4.3. Судалгааны дата цуглуулах.....	127
4.4. Судалгааны дата боловсруулалт, индексжүүлэх	146
4.5. Үр дүнгийн үзүүлэлт	156
4.6. Бүлгийн дүгнэлт	193
ТАВ. “ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЗҮЙН ОРЧИН” ИНДЕКС ҮЗҮҮЛЭЛТ	194
5.1. Зорилго	194
5.2. Арга зүй, тооцоолол	194
5.3. Судалгааны дата боловсруулалт, индексжүүлэх	212
5.4. Судалгааны дата цуглуулах.....	215
5.5. Үр дүнгийн үзүүлэлт	219
5.6. Бүлгийн дүгнэлт	223
ЗУРГАА. “ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЭРХ ЧӨЛӨӨ” ИНДЕКС ҮЗҮҮЛЭЛТ	225
6.1. Зорилго	225
6.2. Арга зүй, тооцоолол	225
6.3. Судалгааны дата цуглуулах.....	226
6.4. Судалгааны дата боловсруулалт, индексжүүлэх	245
6.5. Үр дүнгийн үзүүлэлт	248
6.6. Бүлгийн дүгнэлт	248
ДОЛОО. ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ.....	250
ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ	254



ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 1. Good Governance шалгуур үзүүлэлт.	9
График 2. Гүйцэтгэх чадвар шалгуур G1- G8 үзүүлэлт.	10
График 3. Нийслэлийн бодлого боловсруулах эрх зүйн орчин шалгуур үзүүлэлт	11
График 4. Тогтвортой засаглалын шалгуур гүйцэтгэх чадвар	40
График 5. Тогтвортой засаглалын шалгуур гүйцэтгэх хариуцлага	41
График 6. Хянан шийдвэрлэсэн гэмт хэргийн талаархи гомдол, мэдээлэл (өмнөх оны мөн үетэй харьцуулбал)	129
График 7. Гомдол мэдээлэлд холбогдох албан тушаалтны ангилал	129
График 8. Авлигын хэргийн шийдвэрлэлт (өмнөх оны мөн үетэй харьцуулбал)	129
График 9. Гэмт хэрэгт холбогдон шалгагдсан албан тушаалтан (өмнөх оны мөн үетэй харьцуулбал)	130
График 10. Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрлэсэн хэрэг, төрлөөр	140
График 11. Шийдвэрлэсэн иргэний хэрэг (хуулиар).....	143
График 12. Нийслэлийн “Шударга байдлын үнэлгээ индекс үзүүлэлт”	155
График 13. Баянзүрх дүүргийн “Шударга байдлын үнэлгээ индекс үзүүлэлт”	160
График 14. Сүхбаатар дүүргийн “Шударга байдлын үнэлгээ индекс үзүүлэлт”	164
График 15. Баянгол дүүргийн “Шударга байдлын үнэлгээ индекс үзүүлэлт”	168
График 16. Чингэлтэй дүүргийн “Шударга байдлын үнэлгээ индекс үзүүлэлт”	172
График 17. Хан-Уул дүүргийн “Шударга байдлын үнэлгээ индекс үзүүлэлт”	176
График 18. Сонгинохайрхан дүүргийн “Шударга байдлын үнэлгээ индекс үзүүлэлт”	180
График 19. Багануур дүүргийн “Шударга байдлын үнэлгээ индекс үзүүлэлт”	184
График 20. Налайх дүүргийн “Шударга байдлын үнэлгээ индекс үзүүлэлт”	188
График 21. Багахангай дүүргийн “Шударга байдлын үнэлгээ индекс үзүүлэлт”	192
График 22. Улаанбаатар хотын Эдийн засгийн өрсөлдөх чадварын хувьсал	218

ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. G1.1.Стратегийн чадавх үзүүлэлтийн үнэлгээ	12
Хүснэгт 2. G1.2.Мэргэжилтнүүдийн зөвлөгөө үзүүлэлтийн үнэлгээ	12
Хүснэгт 3. G2.1.Төслийн менежерийн туршлага үзүүлэлтийн үнэлгээ	13
Хүснэгт 4. G2.2.Салбарын байгууллага үзүүлэлтийн үнэлгээ	14
Хүснэгт 5. G2.3.Ажлын хэсэг үзүүлэлтийн үнэлгээ	15
Хүснэгт 6. G2.4.Нийслэлийн харьяа байгууллагын удирдлага, албан тушаалтны хүнд суртал үзүүлэлтийн үнэлгээ	15
Хүснэгт 7. G2.5.Албан бус зохицуулалт үзүүлэлтийн үнэлгээ	16
Хүснэгт 8. G2.6.Нийслэлийн Засаг даргын харьяа байгууллагын шийдвэрийн цахимжуулалт үзүүлэлтийн үнэлгээ	17
Хүснэгт 9. G3.1.Зохицуулалтын нөлөөллийн үнэлгээний хэрэглээ үзүүлэлтийн үнэлгээ	17
Хүснэгт 10. G3.2. Зохицуулалтын үр нөлөөний үнэлгээний үйл явц, чанар үзүүлэлтийн үнэлгээ	18
Хүснэгт 11. G3.3.Тогтвортой байдлын хяналт үзүүлэлтийн үнэлгээ.....	19
Хүснэгт 12. G3.4.Хэрэгжилтийн үнэлгээний чанар үзүүлэлтийн үнэлгээ	20
Хүснэгт 13. G4.1.Олон нийтийн хэлэлцүүлэг үзүүлэлтийн үнэлгээ.....	21
Хүснэгт 14. G5.1.Бодлогын харилцаа холбоо үзүүлэлтийн үнэлгээ.....	21
Хүснэгт 15. Зорилтуудын уялдааг шалгах онооны шалгуур үзүүлэлт	43
Хүснэгт 16. “Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилт” ба “Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван үндсэн чиглэл”-д тусгагдсан зорилго, зорилтын нийцлийг шалгах хүснэгт.	50

Хүснэгт 17. “Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван үндсэн чиглэл”-д Тогтвортой хөгжлийн зорилгод тодорхойлсон зорилтуудын тусгагдсан байдлын үнэлгээ.....	69
Хүснэгт 18. Тогтвортой хөгжлийн зорилго, зорилтод Нийслэлийн хөгжлийн бодлогын зорилго, зорилт тусгагдсан байдал.....	71
Хүснэгт 19. G6.1.Нийслэлийн Засаг даргын үр дүнтэй байдал үзүүлэлтийн үнэлгээ	73
Хүснэгт 20. G6.2.a.Удирдлагын нийцэл үзүүлэлтийн үнэлгээ.....	74
Хүснэгт 21. G6.2.b. Нийслэлийн Засаг даргад хяналт тавих үзүүлэлтийн үнэлгээ	77
Хүснэгт 22. G6.2.c. Нийслэлийн Засаг даргын хяналт үзүүлэлтийн үнэлгээ	78
Хүснэгт 23. G6.3.a. Нийслэлийн төсөв, санхүүжилтийн үнэлгээ	78
Хүснэгт 24. G6.3.b. Нийслэлийн Засаг дарга бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжтой эсэх үзүүлэлтийн үнэлгээ.....	80
Хүснэгт 25. G6.3.c. Нийслэлээс бодлого, төлөвлөлтийг зохих стандартын дагуу боловсруулж, хэрэгжүүлдэг эсэх үзүүлэлтийн үнэлгээ.....	80
Хүснэгт 26. G6.4. Бодлого, төлөвлөгөөг хэрэгжүүлэх үзүүлэлтийн үнэлгээ	81
Хүснэгт 27. G7.1. Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны нийцлийн үзүүлэлтийн үнэлгээ.....	82
Хүснэгт 28. G7.2. Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагаа олон улсын хөтөлбөр, чиг хандлага, үйл ажиллагаанд нийцлийн үзүүлэлтийн үнэлгээ	83
Хүснэгт 29. G8.2. Институцын өөрчлөлтийн үнэлгээ	84
Хүснэгт 30. G9.1 Нийслэлийн бодлогын талаар иргэд мэдээлэл авах боломж	85
Хүснэгт 31. G9.2. Нээлттэй засаглалын үнэлгээ.....	86
Хүснэгт 32. G10.1 Засгийн газрын хяналтын нөөцийн үнэлгээ	86
Хүснэгт 33. G10.2. Бодлого шийдвэрийн баримт бичгийн хяналтын үнэлгээ.....	87
Хүснэгт 34. G10.3. Засаг даргын оролцооны үнэлгээ	88
Хүснэгт 35. G10.4.Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын үнэлгээ.....	89
Хүснэгт 36. G10.5. Нийцэлтэй байдлын үнэлгээ	89
Хүснэгт 37. G11.1.Хэвлэл мэдээллийн байгууллагын оролцооны үнэлгээ	90
Хүснэгт 38. G12.1.Засаг даргын шийдвэр гаргалтын үнэлгээ	91
Хүснэгт 39. G12.2. Бизнес эрхлэгчийн оролцоонд өгөх үнэлгээ.....	92
Хүснэгт 40. G12.3 Төрийн бус байгууллага, холбоодын оролцоо.....	93
Хүснэгт 41. G13.1.Хяналт-шинжилгээг үнэлэх үнэлгээ.....	93
Хүснэгт 42. G13.2.Зөвлөх байгууллагын үнэлгээ	94
Хүснэгт 43. G13.3.Мэдээллийн аюулгүй байдал, нууцлалын үнэлгээ.....	95
Хүснэгт 44. Нийслэлийн бодлогын хэрэгжилтийн шалгуур үзүүлэлтийг үнэлсэн онооны хүснэгт.....	95
Хүснэгт 45. Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн нийт шийдвэрлэсэн хэргийн тоо	127
Хүснэгт 46. Төрийн албан хаагчийн нийт тоо.....	127
Хүснэгт 47. Нийслэл дэх төрийн байгууллагын тоо, байршлаар.....	127
Хүснэгт 48. Төрийн байгууллагын тоо, чиг үүргийн ангилал, байршлаар.....	127
Хүснэгт 49. Төрийн албан хаагчийн тоо, байршил, төрийн албаны ангиллаар.....	127
Хүснэгт 50. Нийслэлийн төрийн байгууллага, түүнд хамаарах төрийн албан хаагчийн тоо, мэдээлэл дүүргээр	128
Хүснэгт 51. ХАСХОМ мэдүүлэг гаргагчийн тоо, нийслэлээр.....	128
Хүснэгт 52. Шүүхээр шийдвэрлэсэн авлигын хэрэг, оноор.....	130
Хүснэгт 53. Дүүргүүдийн ЗДТГ-ын шударга байдлын үнэлгээ.....	130
Хүснэгт 54. Дүүргүүдийн ЗДТГ-ын гадаад шударга байдлын үнэлгээ.....	130
Хүснэгт 55. Дүүргүүдийн ЗДТГ-ын дотоод шударга байдлын үнэлгээ	131
Хүснэгт 56. Бодлогод оролцогчдын шударга байдлын үнэлгээ.....	131

Хүснэгт 57. Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сангийн шүүхээр шийдвэрлэсэн авлигын гэмт хэргийн мэдээлэл.....	131
Хүснэгт 58. Нийслэлийн харьяа байгууллагуудын мэдээллийн хүртээмжтэй байдал	132
Хүснэгт 59. Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрлэсэн хэрэг, төрлөөр.....	139
Хүснэгт 60. Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрлэсэн хэрэг, төрлөөр	140
Хүснэгт 61. Нийслэлийн хэмжээнд цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэмт хэргийн тоо	141
Хүснэгт 62. Нийслэлийн хэмжээнд цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн зөрчлийн хэргийн тоо	141
Хүснэгт 63. Захиргааны хэргийн нийт маргааны төрөл	141
Хүснэгт 64. Захиргааны хэргийн анхан шатны шүүх дэх хэргийн үлдэгдэл.....	142
Хүснэгт 65. Хэргийг давж заалдах шатны шүүхээс анхан шатны шүүхэд хэлэлцүүлэхээр буцаасан үндэслэл.....	142
Хүснэгт 66. Нийслэлийн иргэний хэргийн анхан шатны шүүхүүдийн шийдвэрлэсэн иргэний хэрэг.....	143
Хүснэгт 67. Иргэний хэргийн анхан шатны шүүх дэх хэргийн үлдэгдэл.....	144
Хүснэгт 68. Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгосон үндэслэл	144
Хүснэгт 69. Нийслэлийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүдийн шийдвэрлэсэн иргэний хэрэг.....	145
Хүснэгт 70. Анхан шатны шүүхийн эрүүгийн хэргийн үлдэгдэл.....	145
Хүснэгт 71. Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн хянан шийдвэрлэсэн хэрэг	145
Хүснэгт 72. Heritage Foundation-ийн "Эдийн засгийн эрх чөлөөний индекс"-ийн ангилал .	195
Хүснэгт 73. "Санхүүгийн эрх чөлөөний индекс"-ийн шалгуур үзүүлэлт (Heritage Foundation)	205
Хүснэгт 74. Дүүргүүдийн өрсөлдөх чадварын үндсэн 5 бүлэг, 15 шалгуур үзүүлэлт	207
Хүснэгт 75. Эдийн засгийн өрсөлдөх чадварыг үнэлэх шалгуур үзүүлэлт	207
Хүснэгт 76. Түүврийн зохимжтой хэмжээ	208
Хүснэгт 77. Эдийн засгийн өрсөлдөх чадварын 11 шалгуур үзүүлэлт	210
Хүснэгт 78. Монгол улсын 2023 оны 9 дүгээр сарын Макро эдийн засгийн үзүүлэлтүүд...	212
Хүснэгт 79. Нийслэл Улаанбаатар хотын эдийн засгийн өрсөлдөх чадварын үзүүлэлт	217
Хүснэгт 80. 2021 оны УБ хот болон 9 дүүргийн эдийн засгийн өрсөлдөх байдлын үнэлгээ	219
Хүснэгт 81. "Хөрөнгө оруулалтын эрх чөлөөний индекс"-ийн шалгуур үзүүлэлт	226
Хүснэгт 82. Гадаадын шууд хөрөнгө оруулалт, орох урсгал, улсаар.....	227
Хүснэгт 83. Хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан байгууллага	233
Хүснэгт 84. Монгол Улсын "Хөрөнгө оруулалтын эрх чөлөөний индекс"-ийн оноо	247

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ОХУ	Оросын Холбооны Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
ББСБ	Банк Бус Санхүүгийн Байгууллага
GPCI	Global Power City Index
ЭЗБӨЧСТ	Эдийн засгийн бодлого өрсөлдөх чадварын судалгааны төв
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ТАШН	Түүврийн анхан шатны нэгж
ОУВС	Олон улсын валютын сан
ААНБ	Аж ахуй нэгж, байгууллага
ТХЗ	Тогтвортой Хөгжлийн Зорилт
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
УИХ	Улсын Их Хурал
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
БЗДХ	Бэлгийн замаар дамжих халдвар
ДОХ	Дархлалын олдмол хомсдол
ДТХЗ	Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилтууд
МУЗЗНДНТУТХ	Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсрэгийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
МУНУХЭЗБТХ	Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль
ХБТТУТХ	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль
МУЗГТХ	Монгол Улсын Засгийн газрын тухай хууль
УЕПГ	Улсын Ерөнхий Прокурорын Газар
ОНХСан	Орон нутгийн хөгжлийн сангийн
НУБ	Нэгдсэн Үндэсний Байгууллага
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ОНӨААТҮГ	Орон Нутгийн Өмчит, Аж Ахуйн Тооцоотой Үйлдэвийн Газар
ОНӨТҮГ	Орон Нутгийн Өмчит Төсөвт Үйлдвэрийн Газар
ЭХХША	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа
ХЭҮК	Хүний Эрхийн Үндэсний Комисс
ЖЦХЖТХ	Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль
ХАСХОМ	Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг
НӨАТ	Нэгдсэн Өртгийн Албан Татвар
НИТХ	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ААН	Аж ахуйн нэгж
МУ	Монгол Улс
БОНЗ	Байгаль орчин, нийгэм, засаглал
МУИС	Монгол Улсын Их Сургууль
MNT	Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт-төгрөг
LGBTQ+	lesbian, gay, bisexual, transgender, intersex, queer/questioning, asexual and many other terms
EJI	Environment Justice Index
ATSDR	Agency for Toxic Substances and Disease Registry





CDC	Center for Disease Control
NCAJ	National center for Accessto Justice
GPP	General Population Poll
QRQ	Qualified Respondents' Questionnaires
WJP	World Justice Project
MNB	Mongolian National Broadcaster, Монголын Үндэсний Олон Нийтийн Телевиз
SGI	Sustainable governance indicators
PMO	Project manager office
FB	Facebook
RIA	Regulatory impact assessments
CO2	Carbon dioxide



НЭГ. ТАЙЛАНГИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын “Улаанбаатар ба дагуул хот” есдүгээр бүлгийн хүн төвтэй хот, орчин төвтэй шийдэл, төлөвлөлт төвтэй хөгжил, хотын сайн засаглал гэх 4 үндсэн зорилтыг үндэслэн Бодлогын судалгаа, шинжилгээний төв нь “Хотын хөгжлийн индекс”-ийг 4 бүлэг 86 индекс үзүүлэлттэйгээр судлан боловсруулж байна. Тус индекс нь хотын цаашдын хөгжил, нийслэлийн харьяа байгууллагуудын үйл ажиллагааны уялдааг зөв системтэй болгох замаар нийслэл хотын өмнө тулгамдаад буй авто замын түгжрэл, агаар, хөрсний бохирдол, цэвэр усны хүртээмжгүй байдал, хэт төвлөрөл, хүнсний аюулгүй байдал зэрэг асуудлуудыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр шийдвэрлэхэд дэвшил гаргах ач холбогдолтой юм. Үүнтэй холбогдуулан Хууль зүйн үндэсний хүрээлэн нь “Бодлогын судалгаа, шинжилгээний төв”-ийн захиалгаар “Хотын хөгжлийн индекс”-ийн үзүүлэлтэд хамаарах эрх зүйн зохицуулалтын судалгааг хийж гүйцэтгэлээ.

“Хотын хөгжлийн индекс 2023” судалгаа нь 2023 оны байдлаар Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот болон 9 дүүргийн (“Нийслэлийн бодлого боловсруулах эрх зүйн орчин” индекс үзүүлэлт, “Нийслэлийн бодлого, боловсруулалт, төлөвлөлт, хэрэгжилт” /оновчтой, үр дүн, нөлөөтэй, ил тод/ индекс үзүүлэлт, “Шударга байдлын үнэлгээ” индекс үзүүлэлт, “Хөрөнгө оруулалтын эрх чөлөө” индекс үзүүлэлт, “Эдийн засгийн эрх зүйн орчин”) индекс үзүүлэлтийг тодорхойлж одоогийн нөхцөл байдлыг үнэлэх зорилготой. Тус индекс үзүүлэлтүүд Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын үр дүнг жил бүр тодорхойлж цаашид чиглэл өгөх зорилготой.

1.2. ЗОРИЛГО

Хотын хөгжлийн индексийг тодорхойлох зорилгын хүрээнд Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын өмнө тулгамдаж буй асуудлуудыг хөгжлийн төлөвлөлттэй уялдуулан амьдрах орчны чанарыг олон улсын жишиг аргачлалын дагуу тооцох, цаашид авах арга хэмжээг тодорхойлно.

1.3. ХЭРЭГЖҮҮЛЭГЧ ТАЛ

ХЗДХЯ-ны харьяа Хууль зүйн үндэсний хүрээлэн нь “Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн дүрэм”-д зааснаар хууль зүйн бодлогын болон хавсарга судалгаа хийх, хууль тогтоомжийн төлөв байдал, хандлага, хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах, хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх, эрдэм шинжилгээний зөвлөмж, аргачлалыг боловсруулах, хууль тогтоомжийн төсөлд шинжлэх ухааны санал дүгнэлт өгөх, хууль эрх зүйн сургалт, мэдээллээр үйлчлэх, хууль тогтоомжийн бүртгэл, системчлэл, мэдээлэл, сурталчилгааг зохион байгуулах чиг үүрэг бүхий эрдэм шинжилгээ, сургалт, судалгааны байгууллага бөгөөд Нийслэлийн бодлогын судалгаа, шинжилгээний төвтэй байгуулсан 2023/ХА03 тоот гэрээний дагуу тус судалгааг гүйцэтгэсэн болно.

Хууль зүйн үндэсний хүрээлэн нь Нийслэлийн бодлогын судалгаа, шинжилгээний төвтэй байгуулсан гэрээний дагуу холбогдох хууль тогтоомж, судлаачдын бүтээлд үндэслэн харьцуулах, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, статистикийн аргуудыг ашиглаж нийслэл Улаанбаатар хот болон 9 дүүргийн “Нийслэлийн бодлого боловсруулах эрх зүйн орчин”

индекс үзүүлэлт , “Нийслэлийн бодлого, боловсруулалт, төлөвлөлт, хэрэгжилт” /оновчтой, үр дүн, нөлөөтэй, ил тод/ индекс үзүүлэлт, “Шударга байдлын үнэлгээ” индекс үзүүлэлт” , “Хөрөнгө оруулалтын эрх чөлөө” индекс үзүүлэлт, “Эдийн засгийн эрх зүйн орчин” индекс үзүүлэлтийг үнэлэхийг зорьлоо.

1.4. ОРОЛЦОГЧ ТАЛУУД

Захиалагч тал: Нийслэлийн бодлогын судалгаа, шинжилгээний төв

Гүйцэтгэгч тал: Хууль зүйн үндэсний хүрээлэн

1.5. ҮР ДҮН

Судалгааны үр дүнд дараах хотын хөгжлийн индекс үзүүлэлтүүдийг гаргаж тус аргачлалаар Монгол улсын нийслэл Улаанбаатар хот болон 9 дүүргийн индекс үзүүлэлтийг тооцож гаргасан байна. Үүнд:

1. “Нийслэлийн бодлого боловсруулах эрх зүйн орчин” индекс үзүүлэлт
2. “Нийслэлийн бодлого, боловсруулалт, төлөвлөлт, хэрэгжилт” /оновчтой, үр дүн, нөлөөтэй, ил тод/ индекс үзүүлэлт
3. “Шударга байдлын үнэлгээ” индекс үзүүлэлт”
4. “Хөрөнгө оруулалтын эрх чөлөө” индекс үзүүлэлт
5. “Эдийн засгийн эрх зүйн орчин” индекс үзүүлэлт

ХОЁР. “НИЙСЛЭЛИЙН БОДЛОГО БОЛОВСРУУЛАХ ЭРХ ЗҮЙН ОРЧИН” ИНДЕКС ҮЗҮҮЛЭЛТ

2.1. ЗОРИЛГО

Хотын хөгжлийн индексийг тодорхойлох зорилгын хүрээнд Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын өмнө тулгамдаж буй асуудлуудыг хөгжлийн төлөвлөлттэй уялдуулан амьдрах орчны чанарыг олон улсын жишиг аргачлалын дагуу тооцох, цаашид авах арга хэмжээг тодорхойлно.

Ийнхүү индексийг бий болгосноор Улаанбаатар хотын индексийг дэлхийн бусад өндөр хөгжилтэй хотуудтай харьцуулах, цаашдын өсөлтийн стратеги төлөвлөгөө боловсруулан ажиллахад шаардагдах зөвлөмжийг өгөх боломжтой.

2.2. АРГА ЗҮЙ, ТООЦООЛОЛ

Судалгааны арга зүйн хувьд социологийн судалгааны түгээмэл аргууд болон хууль зүйн шинжлэх ухааны судалгааны аргуудыг хослуулан ашиглалалаа. Ийнхүү ашиглахдаа холбогдох хууль тогтоомж, судлаачдын бүтээлд үндэслэн харьцуулах, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, статистикийн аргуудыг хэрэглэсэн болно.


Ингэхдээ “Нийслэлийн бодлого боловсруулах эрх зүйн орчин” индекс үзүүлэлтийг SGI буюу “Тогтвортой засаглалын үзүүлэлт” (Sustainable governance indicators) -ийн бүрэлдэхүүн хэсэг болох “Сайн засаглал” (Good governance)-ын шалгуур үзүүлэлтэд үндэслэсэн.

Энэхүү SGI шалгуур үзүүлэлтийг Эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага болон Европын холбооны гишүүн 41 улсын тогтвортой засаглалын хүрээнд харьцуулан жил тогтмол гардаг онцлогтой. “Тогтвортой засаглалын үзүүлэлт”-ийн сайн засаглал шалгуур үзүүлэлт нь **гүйцэтгэх чадвар**, /executive capacity/ болон **гүйцэтгэх хариуцлага** /executive accountability/ гэсэн үндсэн хоёр хэсэгт хуваагдана

Гүйцэтгэх чадвар /executive capacity/ нь Удирдах чадвар /steering capability/, Бодлогын хэрэгжилт /policy implementation/, Байгууллагын сургалт /institutional learning/ гэсэн 3 үндсэн ангилалд хуваагдана. **Удирдах чадвар** /steering capability/ үндсэн ангилал нь G1.Стратегийн чадавх /strategic capacity/, G2.Нийслэлийн Засаг даргын харьяа байгууллага хоорондын зохицуулалт /interministerial coordination/, G3.Нотолгоонд суурилсан хэрэгслүүд /Evidence-based Instruments/, G4. Нийгмийн зөвлөгөө /Societal Consultation/, G5.Бодлогын харилцаа холбоо /Policy Communication/ гэсэн 5 дэд үзүүлэлтэд хуваагдана.

Бодлогын хэрэгжилт /policy implementation/ гэсэн хоёр дахь үндсэн ангилал нь G6. Үр дүнтэй хэрэгжилт /effective implementation/, **Байгууллагын сургалт** /institutional learning/ гэсэн гурав дахь үндсэн ангилал нь G7. Дасан зохицох чадвар /Adaptability/, G8. Байгууллагын шинэчлэлийн чадавх /Organizational Reform Capacity/ гэсэн 2 дэд үзүүлэлтэд хуваагдана. Өөрөөр хэлбэл, **Гүйцэтгэх чадвар** /executive capacity/ шалгуур үзүүлэлт нь 3 үндсэн ангилал, G1-G8 гэсэн 8 дэд үзүүлэлтэд хуваагдах бөгөөд эдгээр нь цаашлаад 26 шалгуур үзүүлэлтээр задрах боломжтой.

График 1. Good Governance шалгуур үзүүлэлт.¹



¹ Sustainable Governance Indicators 2022, Codebook, pp.13, https://www.sgi-network.org/docs/2022/basics/SGI2022_Codebook.pdf


График 1-т заасан Сайн засаглал шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэх чадвар /executive capacity/ G1-G8 шалгуур үзүүлэлтийг орчуулсныг Зураг 2-оос үзнэ үү.

График 2. Гүйцэтгэх чадвар шалгуур G1- G8 үзүүлэлт.



Дээрхээс **Гүйцэтгэх чадвар** /executive capacity/ шалгуурын 26 дэд үзүүлэлтээс 14 шалгуур үзүүлэлт буюу G1-G5 нь Нийслэлийн бодлого боловсруулах эрх зүйн орчин шалгуур үзүүлэлтэд хамааруулан үзэх боломжтой байна. (График 3)

График 3. Нийслэлийн бодлого боловсруулах эрх зүйн орчин шалгуур үзүүлэлт



Харин үлдсэн 12 дэд шалгуур буюу G6-G8 үзүүлэлтийг **“Нийслэлийн бодлого, боловсруулалт, төлөвлөлт, хэрэгжилт” /оновчтой, үр дүн, нөлөөтэй, ил тод/ индекс үзүүлэлт**-ийн хүрээнд шалгасан болно.

SGI codebook-д зааснаар G1-G5 шалгуур үзүүлэлтийн 14 дэд хэсгийг дэлгэрүүлэн тайлбарлавал:

G1.Strategic Capacity

G1.1. Стратегийн төлөвлөлт /Strategic Plannig/

Асуулт. Стратегийн төлөвлөлтийн нэгж, байгууллагууд Нийслэлийн Засаг даргын шийдвэрт ямар нөлөө үзүүлдэг вэ ?

Тайлбар: Стратегийн төлөвлөлтийн нэгж, байгууллагууд нийслэлийн шийдвэр гаргахад ямар нөлөө үзүүлдэг вэ? Стратегийн төлөвлөлтийн нэгж байгууллага гэдэгт нийслэлийн харьяа байгууллагууд хамаарна. Стратегийн төлөвлөлтийг үр дүнтэй гэж үзэхийн тулд эдгээр нэгж, байгууллагын бодлого нь хэрэгжих боломжтой байх төдийгүй дэвшүүлсэн шийдлүүд нь урт хугацааны төлөвлөгөөнд нийцсэн байх ёстой. Нөлөөллийн нэг үзүүлэлт нь стратеги төлөвлөлтийн байгууллага ажилтан байгууллагын нийслэлийн Засаг даргатай хийх уулзалтын давтамж байж болно.

Хүснэгт 1. G1.1.Стратегийн чадавх үзүүлэлтийн үнэлгээ

Стратегийн төлөвлөлтийн нэгж, байгууллагууд бодлогын сорилт, бодит шийдлүүдийг урт хугацааны туршид харж, нийслэлийн Засаг даргын шийдвэр гаргахад хүчтэй нөлөө үзүүлдэг.	10
	9
Стратегийн төлөвлөлтийн нэгж, байгууллагууд бодлогын сорилт, бодитой шийдлүүдийг урт хугацаанд авч үздэг. Тэдний нийслэлийн засаг даргын шийдвэр гаргахад үзүүлэх нөлөө нь системтэй боловч асуудлын цар хүрээ, нөлөөллийн хувьд хязгаарлагдмал байдаг.	8
	7
	6
Стратегийн төлөвлөлтийн нэгж, байгууллагууд бодлогын сорилт, бодитой шийдлүүдийг урт хугацаанд авч үздэг. Заримдаа тэд нийслэлийн засаг даргын шийдвэр гаргахад тодорхой хэмжээгээр нөлөөлдөг.	5
	4
	3
Бодлогын сорилт, бодитой шийдлийг урт хугацаанд авч үздэг нэгж, байгууллага байхгүй.	2
	1

G1.2. Мэргэжилтнүүдийн зөвлөгөө /Expert Advice/

Асуулт. Нийслэлийн Засаг даргашийдвэр гаргахдаа мэргэжилтнүүдийн зөвлөгөөг анхаарч үздэг үү?

Тайлбар: Шийдвэр гаргах үйл явцын эхний үе шатанд, өөрөөр хэлбэл үр дүн нь өөрчлөгдөх боломжтой үед мэргэжилтнүүдтэй үр дүнтэй, хууль ёсны зөвлөлдөх уулзалтыг хийх ёстой. Энэхүү уулзалт, хэлэлцүүлэг нь олон нийтэд ил тод байх ёстой. Үнэлгээний үзүүлэлт нь нийслэлийн болон хөндлөнгийн шинжээчдийн уулзалтын давтамж, шинжээчдийн комисс ажиллаж байгаа эсэх байж болно.

Хүснэгт 2. G1.2.Мэргэжилтнүүдийн зөвлөгөө үзүүлэлтийн үнэлгээ

	10
--	----

Бүх тохиолдолд нийслэлийн Засаг дарга шийдвэр гаргахын өмнө төрийн бус байгууллага болон бусад мэргэжилтнүүдтэй ил тод зөвлөдөг.	9
Нийгмийн томоохон төслүүдийн хувьд нийслэлийн засаг дарга шийдвэр гаргахын өмнө төрийн бус байгууллага болон бусад мэргэжилтнүүдтэй ил тод зөвлөдөг.	8
	7
	6
Зарим тохиолдолд нийслэлийн засаг дарга шийдвэр гаргахын өмнө төрийн бус байгууллага болон бусад мэргэжилтнүүдтэй ил тод зөвлөдөг.	5
	4
	3
Нийслэлийн Засаг дарга шийдвэр гаргахын өмнө төрийн бус байгууллага болон бусад мэргэжилтнүүдтэй зөвлөдөггүй, эсвэл одоо байгаа зөвлөгөөнүүд ил тод, нээлттэй биш...	2
	1

G2. Нийслэлийн Засаг даргын харьяа байгууллага хоорондын зохицуулалт /Interministerial Coordination/²

G2.1. Төслийн менежерийн багийн туршлага /PMO³ expertise/

Асуулт. Нийслэлийн засаг даргын харьяа байгууллага нийслэлийн тэргүүлэх чиглэлийн дагуу холбогдох төсөл, шийдвэрийг үнэлэх чадвартай эсэх ?

Тайлбар: Энэ асуулт нь Нийслэлийн Засаг даргын харьяа байгууллага түүний албан хаагч нь Нийслэлийн Засаг даргын тэргүүлэх болон бусад бодлого чиглэл агуулгыг үнэлэх чадамжтай эсэхийг шалгадаг.

Хүснэгт 3. G2.1.Төслийн менежерийн туршлага үзүүлэлтийн үнэлгээ

Төслийн менежерийн баг нь Нийслэлийн Засаг даргын гаргасан аливаа шийдвэрт бие даасан үнэлгээг тогтмол хийдэг.	10
	9
	8

² Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд Interministerial Coordination буюу яам хоорондын зохицуулалтыг үнэлдэг. Үүнийг ийслэл рүү ижил байдлаар хөрвүүлэн Нийслэлийн Засаг даргын харьяа байгууллага хоорондын зохицуулалтыг шалгасан богно

³ Project manager office

Төслийн менежерийн баг нь Нийслэлийн Засаг даргын гаргасан ихэнх шийдвэрт үнэлгээг хийдэг.	7
	6
Төслийн менежерийн багийн туршлагад найдаж болох боловч нь Нийслэлийн Засаг даргын гаргасан зарим шийдвэрийг үнэлдэггүй.	5
	4
	3
Төслийн менежерийн баг салбарын бодлогын талаар мэдлэг хомс. Нийслэлийн засаг даргын аливаа шийдвэрийг цуглуулах, бүртгэх, эргэлтэд оруулах нь хязгаарлагдмал.	2
	1

G2.2. Салбарын байгууллага /Line ministries/

Асуулт. Нийслэлийн засаг дарга бодлогын санал боловсруулахад салбарын байгууллагыг оролцуулдаг эсэх ?

Тайлбар: Нийслэлийн засаг дарга бодлогын санал боловсруулахдаа салбар байгууллагыг эрх зүйн болон практик талаас нь татан оролцуулж байгаа эсэхийг үнэлнэ.

Хүснэгт 4. G2.2.Салбарын байгууллага үзүүлэлтийн үнэлгээ

Нийслэлийн Засаг дарга болон салбарын байгууллагын хоорондоо уялдаа холбоотой ажилладаг.	10
	9
Нийслэлийн Засаг даргын боловсруулж буй саналын талаар салбарын байгууллага тогтмол мэдээлэл авдаг.	8
	7
	6
Бодлогын санал солилцох уулзалт нь албан ёсны бөгөөд уг уулзалтаар техникийн болон төсөл боловсруулах асуудалд төвлөрдөг.	5
	4
	3
	2
Бодлогын санал болн бусад шийдвэрийг бүрэн боловсруулсны дараа салбарын байгууллагатай зөвшилцдөг.	2
	1

G2.3. Ажлын хэсэг /Cabinet committees/

Асуулт. Ажлын хэсэг, хороод Нийслэлийн засаг даргын саналын боловсруулахад хэрхэн оролцдог вэ ?

Тайлбар: Энэ асуулт нь Нийслэлийн Засаг дарга шийдвэр гаргахын өмнө тухайн шийдвэрийг ажлын хэсгээр судалгаанд үндэслэн, үр дүнтэйгээр төслийг боловсруулдаг эсэхийг шалгах учиртай.

Хүснэгт 5. G2.3.Ажлын хэсэг үзүүлэлтийн үнэлгээ

Нийслэлийн Засаг даргын боловсруулж буй шийдвэрийн дийлэнх хувийг ажлын хэсэг, хороод судалгаанд үндэслэн боловсруулдаг.	10
	9
Нийслэлийн Засаг даргын боловсруулсан улс төрийн болон стратегийн ач холбогдол бүхий боловсруулж буй шийдвэрийг ажлын хэсэг, хороод боловсруулдаг.	8
	7
	6
Ажлын хэсэг, хороодын боловсруулах санал Нийслэлийн Засаг даргын шийдвэрийн хувьд бага байдаг.	5
	4
	3
Нийслэлийн Засаг даргын боловсруулж буй шийдвэрт ажлын хэсэг, хороод оролцдоггүй, эсхүл ажлын хэсэг, хороод гэж байдаггүй.	2
	1

G2.4. Нийслэлийн харьяа байгууллагын удирдлага, албан тушаалтны хүнд суртал/ Ministerial Bureaucracy Cabinet/

Асуулт. Нийслэлийн харьяа байгууллага, албан тушаалтны шийдвэрийн уялдаа холбоо болон үр дүнтэй байдлыг шалгана.

Тайлбар: Энэ асуулт нь захиргааны хүнд сурталтад хамаарах бөгөөд тухайн нийслэлийн харьяа байгууллагын удирдлага, албан тушаалтнууд саналыг боловсруулахдаа бусад байгууллагатай санал бодлогын авдаг эсэх, талаарх ажлын үр дүнг шалгадаг. Өөрөөр хэлбэл захиргааны хүнд суртлын хэмжүүр нь санал боловсруулахад бусад байгууллагын оролцоог хангаж буй эсэхээр илэрнэ.

Хүснэгт 6. G2.4.Нийслэлийн харьяа байгууллагын удирдлага, албан тушаалтны хүнд суртал үзүүлэлтийн үнэлгээ

Бүх бодлогын саналыг нийслэлийн харьяа байгууллагын удирдлага, албан тушаалтнууд бусад байгууллагын саналыг үр дүнтэй, уялдаа холбоотойгоор тусгадаг.	10
	9
Бодлогын олонх саналын хувьд нийслэлийн харьяа байгууллагын удирдлага, албан тушаалтнууд бусад байгууллагын саналыг үр дүнтэйгээр тусгадаг.	8
	7
	6
	5

Нийслэлийн харьяа байгууллагын удирдлага, албан тушаалтнууд бодлогын саналыг боловсруулахдаа бусад байгууллагын оролцоог хангаж, уялдаа холбоог сайжруулах эрх зүйн орчин бий.	4
	3
Нийслэлийн харьяа байгууллагын удирдлага, албан тушаалтнууд боловсруулсан саналд бусад байгууллагын саналыг тусгагдаггүй.	2
	1

G2.5. Албан бус зохицуулалт /Informal Coordination/

Асуулт. Албан бус зохицуулалтын механизм Нийслэлийн Засаг дарга болон бусад түвшний байгууллага хоорондын зохицуулалтын албан ёсны механизмыг хэр үр дүнтэй нөхөж байна вэ?

Тайлбар: Энэ асуулт нь Нийслэлийн Засаг дарга болон бусад түвшний байгууллагын шийдвэр гаргахдаа албан бус зохицуулалтын механизмууд (жишээ нь, эвслийн хороод, засгийн газар эсвэл намын бүлгүүдтэй хийх албан бус уулзалт, засгийн газрын түвшинд албан бус уулзалтууд) байгаа эсэхийг шалгадаг.

Хүснэгт 7. G2.5. Албан бус зохицуулалт үзүүлэлтийн үнэлгээ

Албан бус зохицуулалтын механизм нь нийслэлийн засаг даргын шийдвэрийг дэмждэг.	10
	9
Ихэнх тохиолдолд албан бус зохицуулалтын механизм нь нийслэлийн засаг даргын шийдвэрийг дэмждэг.	8
	7
	6
Зарим тохиолдолд албан бус зохицуулалтын механизм нь нийслэлийн засаг даргын шийдвэрийг дэмждэг.	5
	4
	3
Албан бус зохицуулалтын механизмууд нь нийслэлийн засаг даргын шийдвэрийг дэмжихээс илүүтэйгээр сааруулах хандлагатай байдаг.	2
	1

G2.6. Нийслэлийн Засаг даргын харьяа байгууллагын шийдвэрийн цахимжуулалт /Digitization for Interministerial Coordination/

Асуулт. Нийслэлийн Засаг даргын харьяа байгууллагын шийдвэр гаргах үйл ажиллагаанд (бодлого боловсруулах, хяналт тавих) дижитал технологийг өргөн хүрээнд, үр дүнтэй ашиглаж чадаж байна уу?

Тайлбар: Энэ асуултын хүрээнд дижитал технологиудыг Нийслэлийн Засаг даргын харьяа байгууллагын хэмжээнд бодлогын уялдааг хангахад амжилттай ашиглаж чадаж байгаа эсэхийг судалдаг. Ийм технологи нь жишээлбэл, Нийслэлийн Засаг даргын харьяаны бүх эсвэл хэд хэдэн байгууллагад зориулсан мэдээллийн технологийн нийтлэг цахим хуудас, платформ байж болно.

Хүснэгт 8. G2.6.Нийслэлийн Засаг даргын харьяа байгууллагын шийдвэрийн цахимжуулалт үзүүлэлтийн үнэлгээ

Нийслэлийн Засаг даргын харьяа байгууллагын үйл ажиллагаанд (Бодлого боловсруулах, хяналт тавих) дижитал технологийг өргөн, үр дүнтэй ашигладаг.	10
	9
Ихэнх тохиолдолд дижитал технологийг ашигладаг бөгөөд энэ нь дээрх байгууллага хоорондын уялдаа холбоог хангахад дэмжих үр дүнтэй.	8
	7
	6
Нийслэлийн Засаг даргын харьяа байгууллага хоорондын үйл ажиллагааг сайжруулахын тулд дижитал технологийг бага хэмжээгээр, үр нөлөө нь хязгаарлагдмал байдлаар ашигладаг.	5
	4
	3
Нийслэлийн Засаг даргын харьяа байгууллага хоорондын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор дижитал технологийг төдийлөн ашигладаггүй.	2
	1

G3.Нотолгоонд суурилсан хэрэгслүүд /Evidence-based Instruments/

G3.1. Зохицуулалтын нөлөөллийн үнэлгээний хэрэглээ /Regulatory impact assessments application^{4/}

Асуулт. Нийслэлийн Засаг дарга хүчин төгөлдөр мөрдөгдөж буй болон боловсруулж буй эрх зүйн актуудын (зохицуулалтын үр нөлөөний үнэлгээ, RIA) болзошгүй нөлөөллийг үнэлдэг эсэх?

Тайлбар: Зохицуулалтын нөлөөллийн үнэлгээ гэж юу вэ ?. Зохицуулалтын нөлөөллийн үнэлгээ нь санал болгож буй болон одоо мөрдөж буй эрх зүйн зохицуулалтын хувилбаруудын эерэг ба сөрөг нөлөөг шүүмжлэлтэй үнэлэх системчилсэн арга юм.⁵

Хүснэгт 9. G3.1.Зохицуулалтын нөлөөллийн үнэлгээний хэрэглээ үзүүлэлтийн үнэлгээ

Зохицуулалтын нөлөөллийн үнэлгээ нь шинэ болон хүчин төгөлдөр мөрдөгдөж буй бүхий л эрх зүйн актад хамаарна. Зохицуулалтын	10
--	----

⁴ Regulatory impact assessments

⁵Regulatory Impact Analysis: A Tool for Policy Coherence, <https://www.oecd.org/gov/regulatory-policy/ria-tool-for-policy-coherence.htm>

нөлөөллийн үнэлгээний аргачлалаар дээрх бүх дүрэм журмыг үнэлдэг.	9
Зохицуулалтын нөлөөллийн үнэлгээг ихэнх шинэ дүрэм журамд системтэйгээр хэрэглэдэг.	8
	7
	6
Зохицуулалтын нөлөөллийн үнэлгээг зарим тохиолдолд хэрэглэдэг. Хууль, дүрэм, журмын хүрээнд зохицуулалтын нөлөөллийн үнэлгээг хэрэглэх нэгдсэн аргачлал байдаггүй.	5
	4
	3
Зохицуулалтын үр нөлөөний үнэлгээг ашигладаггүй эсхүл ийм үнэлгээ байхгүй.	2
	1

G3.2. Зохицуулалтын үр нөлөөний үнэлгээний үйл явц чанар /Quality of RIA Process/

Асуулт. Зохицуулалтын үр нөлөөний үнэлгээний үйл явц, оролцоо, ил тод байдал, чанарын үнэлгээг баталгаажуулдаг эсэх ?

Тайлбар: Энэ асуулт нь зохицуулалтын үр нөлөөний үнэлгээний процедурын чанарыг үнэлэх зорилготой юм. Шинжилгээний үе шатанд холбогдох оролцогч талуудын оролцоо (зөвшилцөл эсвэл хамтын ажиллагаа) нь зохицуулалтын өөрчлөлттэй холбоотой хүмүүсийн хэрэгцээ, хариу үйлдэл үзүүлэх талаар эмпирик мэдээллээр хангах замаар зохицуулалтын үр нөлөөг нэмэгдүүлдэг. Зохицуулалтын үр нөлөөний үнэлгээний үр дүн бэлэн болмогц тэдний хүртээмж, харилцаа холбоо нь улс төрийн үйл явцтай холбоотой байх болно. Эцэст нь, хараат бус байгууллагаас зохицуулалтын үр нөлөөний үнэлгээний чанарыг (үр дүн, үйл явцын хувьд) сайжруулах боломжийг олгодог. Зохицуулалтын үр нөлөөний үнэлгээ нь гурван зорилготой. Үүнд:

- I. Шийдвэр гаргах үйл явцыг удирдан чиглүүлэх
- II. Зохицуулалтын шийдвэрийн үр ашгийг нэмэгдүүлэх
- III. Зохицуулалтын шийдвэрийн үр ашгийг нэмэгдүүлэх⁶

Хүснэгт 10. G3.2. Зохицуулалтын үр нөлөөний үнэлгээний үйл явц, чанар үзүүлэлтийн үнэлгээ

Зохицуулалтын нөлөөллийн шинжилгээнд оролцогч талуудыг зөвлөлдөх, хамтран ажиллах хэлбэрээр тогтмол оролцуулж, үр дүнг олон нийтэд ил тод мэдээлж, үнэлгээг бие даасан байгууллага тогтмол үр дүнтэй үнэлдэг.	10
	9

⁶GOVERNANCE MANUAL FOR REGULATORY IMPACT ANALYSIS MINISTRY OF INFRASTRUCTURE Regulatory impact assessments, https://www.gov.br/transportes/pt-br/acao-informacao/air/AIRModelodegovernana20210921_English.pdf

Зохицуулалтын нөлөөллийн шинжилгээний үйл явц нь гурван зорилгын аль нэгтэй нь холбоотой дутагдлыг/сул талыг харуулдаг.	8
	7
	6
Зохицуулалтын нөлөөллийн шинжилгээний үйл явц нь гурван зорилгын хоёртой нь холбоотой дутагдалтай/сул талыг харуулдаг.	5
	4
	3
Зохицуулалтын нөлөөллийн шинжилгээ байхгүй эсвэл гурван зорилтын алинд нь ч хүрч чадаагүй.	2
	1

G3.3.Тогтвортой байдлын хяналт /Sustainability Check/

Асуулт. Нийслэлийн Засаг дарга зохицуулалтын үр нөлөөний үнэлгээний хүрээнд тогтвортой, үр дүнтэй хяналтыг хэрэгжүүлдэг үү.

Тайлбар: Энэ асуултаар Тогтвортой Хөгжлийн Зорилтын хэрэгжилтийг зохицуулалтын үр нөлөөний үнэлгээний дагуу судалж, үр дүнг шалгадаг. Тогтвортой байдлын үр дүнтэй хяналт нь дараах гурван шалгуурыг хангасан байх шаардлагатай. Нэгдүгээрт, шийдвэр гаргах нийтлэг үндэслэлийг бий болгохын тулд тэдгээрийг зохицуулалтын үр нөлөөний үнэлгээний дагуу шалгадаг. Хоёрдугаарт, нийгэм (жишээ нь, залуучуудын ажилгүйдэл), эдийн засаг (жишээ нь, улсын өр) болон байгаль орчны (жишээлбэл, CO2 ялгаруулалт) асуудлыг шийдвэрлэх нөлөөллийн шалгуур үзүүлэлтүүдийг ашигладаг байх Гуравдугаарт, богино, дунд, урт хугацаанд эдгээр үзүүлэлтүүдэд үзүүлэх нөлөөллийг судалдаг байх. Энэ ч утгаараа Нийслэлийн Засаг даргаас ТХЗ-д нийцүүлсэн тогтвортой байдлын стратеги бий эсэх, энэхүү стратеги нь ТХЗ-уудтай нийцэж байгаа эсэхийг мөн зааж өгөх нь чухал. Түүнчлэн Нийслэлийн Засаг даргаас ТХЗ-ыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр баталсан эсэх, хэрэгжилтийн явцад хяналт тавьж буй эсэхэд дүгнэлт өгөх нь зүйтэй.

Хүснэгт 11. G3.3.Тогтвортой байдлын хяналт үзүүлэлтийн үнэлгээ

Тогтвортой байдлын хяналт нь зохицуулалтын үр нөлөөний үнэлгээний салшгүй хэсэг юм. Нийслэлийн Засаг дарга бүрэн хэмжээний шалгуур үзүүлэлтүүдийг (тогтвортой байдлын, нийгэм, эдийн засаг, байгаль орчны асуудлуудыг оролцуулан) авч, ойрын болон урт хугацааны нөлөөллийг хянадаг.	10
	9
Тогтвортой байдлын хяналтад гурван шалгуурын аль нэг нь байхгүй.	8
	7
	6
Тогтвортой байдлын хяналтад гурван шалгуурын хоёр нь байхгүй.	5
	4

	3
Тогтвортой байдлын хяналт байхгүй эсвэл дээрх гурван шалгуурыг хангаагүй.	2
	1

G3.4. Хэрэгжилтийн үнэлгээний чанар /Quality of Ex Post Evaluation/

Асуулт. Нийслэлийн Засаг дарга хэрэгжүүлж буй бодлогын үр ашгийг тогтмол үнэлж, үнэлгээний үр дүнг одоо байгаа бодлогыг шинэчлэх, шинэ бодлого боловсруулахад хэр ашигладаг вэ?

Тайлбар: Бодлогыг шинэчлэн боловсруулах эсвэл шинэ бодлого боловсруулахаас өмнө одоо байгаа бодлогын үр нөлөөг системтэйгээр үнэлэхэд хэрэгжилтийн үнэлгээг ашиглаж байгаа эсэхийг үнэлэх нь зүйтэй.

Хүснэгт 12. G3.4.Хэрэгжилтийн үнэлгээний чанар үзүүлэлтийн үнэлгээ

Бүхий л чухал бодлогын шийдвэрт хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хийдэг бөгөөд ерөнхийдөө одоо байгаа бодлогыг шинэчлэх эсвэл шинэ бодлого боловсруулахад ашигладаг.	10
	9
Ихэнх чухал бодлогын хувьд хэрэгжилтийн үнэлгээ хийдэг бөгөөд одоо байгаа бодлогыг шинэчлэх эсвэл шинэ бодлого боловсруулахад ашигладаг.	8
	7
	6
Зөвхөн чухал ач холбогдолтой бодлогын хувьд л хэрэгжилтийн үнэлгээ хийдэг бөгөөд одоо байгаа бодлогыг шинэчлэх эсвэл шинэ бодлого боловсруулахад ашиглах нь ховор.	5
	4
	3
Хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг ерөнхийдөө хийдэггүй бөгөөд одоо байгаа бодлогыг шинэчлэх эсвэл шинэ бодлого боловсруулахад харгалздаггүй.	2
	1

G4. Нийгмийн зөвшилцөл /Societal Consultation/

G4.1.Олон нийтийн хэлэлцүүлэг /Public Consultation/

Асуулт. Төр, нийгмийн зүтгэлтнүүдтэй шударга, олон ургальч үзлийн үүднээс зөвшилцдөг үү?

Тайлбар: Энэхүү асуултаар Нийслэлийн Засаг дарга бодлого боловсруулахдаа Үйлдвэрчний эвлэл, Ажил олгогчдын холбоо, тэргүүлэх бизнесийн холбоод, шашны нийгэмлэг, нийгмийн болон байгаль орчны ашиг сонирхлын бүлгүүд зэрэг нийгмийн оролцогчидтой зөвшилцдөг эсэх, энэхүү зөвшилцөл нь үр дүнтэй эсэхийг үнэлдэг. Амжилттай буюу үр дүнтэй зөвшилцөх нь нийслэлийн бодлогын чанарыг сайжруулж,

нийгмийн оролцогчдыг дэмжихэд түлхэц болохуйц санал, мэдээлэл солилцох (бодлогын хөгжлийн эхний үе шатнаас эхлээд бодлогын хэрэгжилтийг үргэлжлүүлэх)-д ач тустай.

Хүснэгт 13. G4.1.Олон нийтийн хэлэлцүүлэг үзүүлэлтийн үнэлгээ

Төр, нийгмийн зүтгэлтнүүдтэй үргэлж шударга, олон ургальч үзлээр зөвшилцдөг.	10
	9
Нийслэлийн Засаг дарга ихэнх тохиолдолд нийгмийн оролцогчидтой шударга, олон ургальч үзэл баримтлалтайгаар зөвшилцдөг.	8
	7
	6
Нийслэлийн Засаг дарга нийгмийн оролцогчидтой зөвшилцдөг боловч үр дүн багатай.	5
	4
	3
Нийслэлийн Засаг дарга нийгмийн аль нэг оролцогчтой зөвшилцөх нь ховор.	2
	1

G5. Бодлогын уялдаа холбоо /Policy Communication/


G5.1. Ойлгомжтой, уялдаа холбоо /Coherent Communication/

Асуулт. Нийслэлийн Засаг даргын харьяа байгууллагууд хоорондоо хэрхэн харилцаж, бодлогын уялдаа холбоог хангадаг вэ ?

Тайлбар: Энэ асуултын хүрээнд Нийслэлийн Засаг даргын харьяа байгууллага нь нийслэлийн бодлого, стратегитай уялдаа холбоотойгоор харилцаж буй эсэхийг үнэлдэг.

Хүснэгт 14. G5.1.Бодлогын харилцаа холбоо үзүүлэлтийн үнэлгээ

Нийслэлийн Засаг даргын харьяа байгууллагууд харилцаагаа нийслэлийн бодлого, стратегитай уялдуулах тал дээр амжилттай ажиллаж байна.	10
	9
Нийслэлийн Засаг даргын харьяа байгууллагууд харилцаагаа нийслэлийн бодлого, стратегитай уялдуулах тал дээр ихэнх тохиолдолд амжилттай ажиллаж байна.	8
	7
	6
Нийслэлийн Засаг даргын харьяа байгууллагууд харилцаандаа нийслэлийн бодлого, стратегитай уялдуулах тал дээр зөрчилдөөнтэй мэдэгдэл хааяа гаргадаг.	5
	4
	3
Стратегийн харилцаа холбооны төлөвлөлт байхгүй, Нийслэлийн Засаг даргын харьяа байгууллагуудын мэдэгдэл байнга зөрчилддөг. Эсвэл дээрх байгууллагын шийдвэр нь нийслэлийн ерөнхий стратегид нийцэхгүй байх нь элбэг.	2
	1



Тооцооллын хувьд SGI шалгуур нь судлаачийг сонгох боломжийг олгосон байдаг. Тодруулбал, тухайн үзүүлэлтийн үнэлгээг хүснэгтэд тусгасан байдлаар боловсруулдаг. Энэхүү хүснэгтэд шалгуур үзүүлэлтэд хамаарах 4 асуултыг тусгасан байна. Эдгээр асуулт нь үнэлгээний гол чиглэл нь болдог. Гэвч асуултад хариулахдаа хэдэн оноо өгөх нь нээлттэй байдаг. Иймд „Нийслэлийн бодлого боловсруулах эрх зүйн орчин“ шалгуур үзүүлэлтийг оноогоор дүгнэхдээ нээлттэй байдлыг харгалзан авч болох дээд, доод болон дундаж оноог гаргасан.

Мөн хүснэгтэд заасан 9, 10 оноогоор үнэлэх шалгуурын хувьд практикт тогтмол хэрэгжиж хэвшсэн, хүснэгтэд заасан 8, 7, 6 оноогоор үнэлэхэд ихэвчлэн гэдгийг 70-аас дээш хувь, хүснэгтэд заасан 5, 4, 3 оноогоор үнэлэхэд зарим гэдгийг 50-иас дээш хувь, хүснэгтэд заасан 2, 1 оноогоор үнэлэх шалгуурын хувьд практикт тогтмол хэрэгжиж хэвшээгүйг тохиолдлыг авч үзнэ.

2.3. СУДАЛГААНЫ ДАТА/ӨГӨГДӨЛ ЦУГЛУУЛАХ

Нийслэлийн бодлого боловсруулах эрх зүйн орчин шалгуур үзүүлэлтэд Гүйцэтгэх чадвар /executive capacity/ шалгуурын 26 дэд үзүүлэлтээс 14 дэд шалгуур үзүүлэлт нь буюу G1-G5 нь Нийслэлийн бодлого боловсруулах эрх зүйн орчин шалгуур үзүүлэлтэд хамаарна. Дээрх 14 дэд шалгуурт хамаарах судалгааны өгөгдлийг чанарын судалгаа болон баримт бичгийн судалгааны аргад тулгуурлан цуглуулсан. Тодруулбал, “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Нийслэлийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр” зэрэг дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг судалсан болно.

Мөн хууль, эрх зүйн орчны хувьд Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын Нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийг тус тус судалсан. Тухайлбал, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д “Нийслэл нь төрийн дээд байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах, хуулиар тусгайлан олгосон чиг үүргийн хүрээнд эдийн засаг, нийгмийн асуудлаар бие даан шийдвэр гаргах, дүүргүүдийн үйл ажиллагааг зохицуулах, иргэдэд хуульд заасан үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, хууль тогтоомжийн биелэлтийг хангах, хяналтыг хэрэгжүүлэх нэгж мөн” гэж хуульчилсан. Тус зүйлийн 9.2 дахь хэсэгт Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлыг хуулиар тогтоохоор хуульчилсан.

Уг заалтад үндэслэн 2021 оны 07 дугаар сард Улсын Их Хурлаар “Монгол Улсын Нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль”-ийг баталж, тус хуулиар Нийслэл Улаанбаатар хотын чиг үүрэг, хөгжлийн бодлого, удирдлага, зохион байгуулалтын онцлогтой холбогдох харилцааг зохицуулж байна. Түүнчлэн, Нийслэлийн бодлого боловсруулах эрх зүйн орчин шалгуур үзүүлэлтийг тогтоох 14 дэд шалгуур үзүүлэлт тус бүрийг үнэлэхдээ судалгааны холбогдох эх сурвалжийг ишлэсэн/ашигласан болно.

2.4. СУДАЛГААНЫ ӨГӨГДӨЛ БОЛОВСРУУЛАЛТ, ИНДЕКСЖҮҮЛЭХ

G1. Стратегийн чадавхи /Strategic Capacity/

G1.1. Стратегийн төлөвлөлт /Strategic Plannig/



Асуулт. Стратегийн төлөвлөлтийн нэгж, байгууллагууд Нийслэлийн Засаг даргын шийдвэр гаргахад хэр их нөлөө үзүүлдэг вэ ?

Стратегийн төлөвлөлт гэдэг нь байгууллагын удирдлага өөрийн алсын хараа, зорилго, зорилтыг тодорхойлох үйл явц юм. Уг үйл явц нь тухайн байгууллага зорилгодоо хүрэхийн тулд хэрэгжүүлэх шаардлагатай зорилт, түүнийг хэрэгжүүлэх дарааллыг тогтоодог.⁷

Нийслэлийн хувьд энэхүү стратеги төлөвлөлтийг 2021 онд батлагдсан “Монгол Улсын Нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль”-ийн 5 дугаар зүйлд „Нийслэл хотыг хөгжүүлэх бодлого“ нэртэйгээр хуульчилсан. Хуулийн агуулгаас үзвэл нийслэл хот нь нийгэм, соёлын амьдралын бүхий л хүрээнд тэргүүлэх байр суурь эзлэх нөхцөлийг бүрдүүлэх, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах зарчмыг баримтлахаар заасан. Нийслэлийн хөгжлийн бодлого, зарчмыг хэрэгжүүлэх шийдвэр гаргахад Улаанбаатар хотын захирагчийн ажлын алба, Засаг даргын ажлын алба чухал нөлөөтэй. Улаанбаатар хотын захирагчийн ажлын албаны чиг үүргийг “Монгол Улсын Нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль”-ийн 25 дугаар зүйлийн 25.4.1-25.4.5-д⁸, харин Засаг даргын тамгын газрын чиг үүргийг Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1.1-67.1.8-д зааснаас харж болно.⁹

Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны нэгжийн орон тоо, харьяалагдах нэр, ангиллыг Нийслэлийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/16 дугаар захирамжаар шинэчлэн баталсан.¹⁰ Гэвч Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба Нийслэлийн Засаг даргын шийдвэр гаргахад хэрхэн нөлөөлдөг тухайд мэдээлэл хомс байна. Тодруулбал, Улаанбаатар хотын захирагчийн ажлын албаны хэтийн төлөвлөгөөг үзэх

⁷ What is strategic planning?, <https://www.techtarget.com/searchcio/definition/strategic-planning>

⁸ 25.4.1.Улаанбаатар хотын Захирагчид мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх, ажиллах нөхцөлөөр хангах;

25.4.2.Улаанбаатар хотын Захирагчийг шаардлагатай мэдээллээр хангах;

25.4.3.нийслэл хотын аж ахуйн асуудлыг судлах, шийдвэрийн төслийг боловсруулах, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих;

25.4.4.иргэн, хуулийн этгээдэд хотын нийтийн аж ахуйн үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих;

25.4.5.хуульд заасан бусад.

⁹67.1.1.харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратеги төлөвлөлт, хөтөлбөр, төслийг боловсруулах;

67.1.2.Засаг даргын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх, ажиллах нөхцөлөөр хангах;

67.1.3.Хурал, Засаг дарга, доод шатны нутгийн захиргааны байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангах;

67.1.4.хууль тогтоомж, Засгийн газар, Хурал, Засаг даргын шийдвэрийг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах, гүйцэтгэлд нь хяналт тавьж үр дүнг тооцох;

67.1.5.тамгын газрын бичиг хэргийг хөтлөх, байгууллага, иргэдээс ирүүлсэн өргөдөл, санал, гомдлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулах;


67.1.6.төрийн захиргааны ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах;

67.1.7.тухайн шатны Хурлын хэвийн үйл ажиллагааг ханган үйлчлэх;

67.1.8.татварын алба хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан шаардсан мэдээллийг гаргаж өгөх

¹⁰<https://ubservice.ub.gov.mn/wp-content/uploads/2023/09/%D0%91%D2%AF%D1%82%D1%8D%D1%86-%D0%9016-2023-1-2.pdf>





боломжгүй. Мөн тухайн байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийн тайлан 2020 оноос хойш нийтлэгдээгүй, өмнөх онуудын биелэлтийг үзэх боломжгүй байна. Түүнчлэн Улаанбаатар хотын захирагчийн ажлын албаны үндсэн цахим хуудас дээр 2023 оны 5 дугаар сард хамгийн сүүлд мэдээлэл шинэчлэгдсэн бөгөөд сүүлийн 6 сарын хугацаанд шинэ мэдээлэл ороогүй байна.¹¹

Дээрхээс үзвэл Улаанбаатар хотын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн нэгж, байгууллага нь бодлогын сорилт шийдлүүдийг урт хугацаанд авч үздэг болох нь Алсын хараа 2050, Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Нийслэлийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр” зэрэг хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичгээс тодорхой харагдаж байна. Гэвч Улаанбаатар хотын захирагчийн алба, Нийслэлийн Засаг даргын тамгын газрын хувьд Нийслэлийн Засаг даргын шийдвэр гаргах ажиллагаанд ямар хэмжээгээр хэрхэн нөлөө үзүүлдэг эсэх нь тодорхойгүй байна. Монгол Улсын Нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн Улаанбаатар хотын захирагчийн алба, Улаанбаатар хотын засаг даргын тамгын газрын бүрэн эрхэд хамаарах заалтаас үзвэл Улаанбаатар хотын захирагчид „шаардагдах мэдээллээр хангах, төслийг боловсруулах бүрэн эрх“ давамгайлжээ. Иймд **G1.1. Стратегийн төлөвлөлт /Strategic Plannig/ шалгуур үзүүлэлтийн хувьд “Стратегийн төлөвлөлтийн нэгж, байгууллагууд бодлогын сорилт, бодитой шийдлүүдийг урт хугацаанд авч үздэг” гэдэгт хамаарч 3-5 оноогоор үнэлэгдэхээр байна.**

G1.2. Мэргэжилтнүүдийн зөвлөгөө /Expert Advice/

Асуулт. Нийслэлийн Засаг дарга шийдвэр гаргахдаа төрийн бус секторын мэргэжилтнүүдийн зөвлөгөөг анхаарч үздэг үү?

Монгол Улсын Нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1.2-д зааснаас үзвэл Засаг даргын ажлын алба нь Засаг даргын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх, ажиллах нөхцөлөөр хангах үүргийг хүлээсэн.¹² Харин Монгол Улсын Нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.11-д зөвлөх эрх бүхий орон тооны бус мэргэжлийн зөвлөл байгуулах, түүний бүрэлдэхүүн, ажиллах журмыг батлах эрхийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн бүрэн эрх байхаар хуульчилсан.


Төрийн бус байгууллагын хувьд Нийслэлийн Засаг даргын шийдвэр гаргах ажиллагаанд зөвлөгөө өгөхөөс илүүтэйгээр “...Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Улсын дээд шүүх, Үндсэн хуулийн цэц, төрийн захиргааны болон төрийн бусад байгууллага, гадаад улсын Дипломат төлөөлөгчийн газар, олон улсын байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад дэмжлэг үзүүлэх...” -д хамтран ажиллаж байна.¹³

Дээрхээс үзвэл Нийслэлийн Засаг даргын шийдвэрт төрийн бус байгууллагын мэргэжилтнүүдтэй зөвлөх эрх зүйн орчин бүрдсэн, Нийслэлийн Засаг даргад зөвлөх эрх бүхий орон тооны бус мэргэжлийн зөвлөл байгуулах, түүний бүрэлдэхүүн, ажиллах журмыг

¹¹ Улаанбаатар хотын захирагчийн ажлын алба, <http://ubservice.mn/>

¹² Монгол Улсын Нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль, 2021, <https://legalinfo.mn/mn/detail/16230779072091>

¹³ Монгол Улсын Нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийг үзнэ үү.



батлах эрх олгогдсон ч уг зөвлөл болон зөвлөлийн ажиллах журам нь ил тод, нээлттэй биш байна. Иймд **G1.2. Мэргэжилтнүүдийн зөвлөгөө** /Expert Advice/ шалгуур үзүүлэлтийн хувьд “Нийслэлийн Засаг дарга төрийн бус байгууллагын мэргэжилтнүүдтэй зөвлөлддөггүй, эсвэл одоо байгаа зөвлөгөөнүүдэд ил тод нээлттэй байдал дутмаг” гэдэгт хамаарч байна гэж үзэж 1-2 оноогоор дүгнэхээр байна.

G2. Нийслэлийн Засаг даргын харьяа байгууллага хоорондын зохицуулалт /Interministerial Coordination/

G2.1. Төслийн менежерийн багийн туршлага /PMO expertise/

Асуулт. Нийслэлийн Засаг даргын харьяа байгууллага нийслэлийн тэргүүлэх чиглэлийн дагуу холбогдох төсөл, шийдвэрийг үнэлэх чадвартай юу?

Нийслэлийн Засаг даргын харьяа байгууллагын албан хаагч нь Төрийн албаны тухай хуульд заасан төрийн албан хаагчийн ангилалд хамаардаг онцлогтой. Улаанбаатар хотын захирагчийн ажлын албаны бүтцийн хувьд Захиргаа, санхүүгийн хэлтэс, Хотын инженерийн байгууламжийн хэлтэс, Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс, Хотын ногоон байгууламж цэцэрлэгжүүлэлтийн хэлтэс, Дугуйн ба явган хүний зам, тохижилтын хэлтэс, Орчны бохирдол, хог хаягдлын хэлтэс, Хяналт үнэлгээний хэлтэс гэсэн 7 хэлтсээс бүрдэж байна. Эдгээр долоон хэлтэст нийт 65 төрийн албан хаагч ажиллаж байна.

Өөрөөр хэлбэл, Улаанбаатар хотын захирагчийн ажлын албанд Тэргүүн түшмэл 1, Эрхэлсэн түшмэл 3, Дэс түшмэл 57, Төрийн үйлчилгээний 7 албан хаагчид хамаарахаар байна.¹⁴ Тэргүүн түшмэлийн хувьд магистр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй, Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж, төгссөн байх мэргэжлийн шаардлага хангасан, Төрийн албанд 12-оос доошгүй жил, үүнээс эрхэлсэн түшмэлийн албан тушаалд 6-аас доошгүй жил ажилласан байх туршлагатай, удирдан зохион байгуулах, дүн шинжилгээ хийх, асуудал шийдвэрлэх, манлайлах, бусад ур чадварыг тус тус эзэмшсэн байх шаардлага тавигдаж байна.¹⁵

Харин эрхэлсэн түшмэлийн хувьд Яамны хэлтсийн дарга түүнтэй адилтгах бусад албан тушаалд: Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй, Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж, төгссөн байх мэргэжлийн шаардлага хангасан, Төрийн албанд 8-аас доошгүй жил, үүнээс ахлах түшмэлийн албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан туршлагатай, удирдан зохион байгуулах, дүн шинжилгээ хийх, асуудал шийдвэрлэх, манлайлах, бусад ур чадварыг тус тус эзэмшсэн байх шаардлага тавигдаж байна.¹⁶


Дэс түшмэлийн хувьд Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй, Төрийн албан хаагчийн богино хугацааны зорилтот сургалтад хамрагдаж, төгссөн байх, Туслах

¹⁴ Засгийн газрын 2022 оны 487 дугаар тогтоолын хавсралт, Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалт, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16532498091141&showType=1>

¹⁵ Төрийн захиргааны албан тушаалын тэргүүн түшмэл, түүнтэй адилтгах удирдах албан тушаалд тавигдах тусгай шаардлага, Төрийн албаны зөвлөлтийн 2019 оны 02 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=209079&showType=1>

¹⁶ Төрийн захиргааны албан тушаалын тэргүүн түшмэл, түүнтэй адилтгах удирдах албан тушаалд тавигдах тусгай шаардлага, Төрийн албаны зөвлөлтийн 2019 оны 02 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=209079&showType=1>





түшмэлийн албан тушаалд 2-оос доошгүй жил ажилласан байх, удирдан зохион байгуулах, дүн шинжилгээ хийх, асуудал шийдвэрлэх, манлайлах, бусад ур чадварыг тус тус эзэмшсэн байх шаардлага тавигдаж байна.¹⁷

Өөрөөр хэлбэл Нийслэлийн Засаг даргын харьяа байгууллагын албан хаагчийн хувьд төрийн албанд ажилласан жил гол шалгуур болж байна. Харин Нийслэлийн Засаг даргын харьяа байгууллагын албан хаагчийн ур чадварыг ерөнхий байдлаар, тодруулбал, гадаад хэл, мэдээллийн технологийн болон бусад ур чадварын хувьд эзэмших чадварын талаар тусгаагүй. Түүнчлэн менежерийн багийн зүгээс Нийслэлийн Засаг даргын шийдвэрийг үнэлсэн талаар мэдээлэл хомс байна.

Иймд **G2.1. Төслийн менежерийн багийн туршлага /PMO expertise/** шалгуур үзүүлэлтийн хувьд “Төслийн менежерийн багийн туршлагад найдаж болох боловч нь Нийслэлийн Засаг даргын гаргасан зарим шийдвэрийг үнэлдэггүй” гэдэгт хамаарч 3-5 оноо авч байна.

G2.2. Салбарын байгууллага /Line ministries/

Асуулт. Нийслэлийн Засаг даргабодлогын санал боловсруулахад салбарын байгууллагыг хэр оролцуулдаг вэ?

Нийслэлийн хувьд засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж мөн. Энэ ч утгаараа тус нэгж дээр Ерөнхий чиг үүргийн буюу Эдийн засаг, хөгжлийн яам, Гадаад харилцааны яам, Сангийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Чиглэлийн буюу Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Батлан хамгаалах яам, Барилга, хот байгуулалтын яам, Боловсрол, шинжлэх ухааны яам, Зам, тээврийн хөгжлийн яам, Соёлын яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Эрчим хүчний яам, Эрүүл мэндийн яам, нийт 16 төрийн захиргааны төв байгууллагын салбар ажилладаг.¹⁸

Тодруулбал, Монгол Улсын Шадар сайдын хүрээний бодлогын төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохицуулалт болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх 8 чиглэл, Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын хүрээний бодлогын төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохицуулалт болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх 13 чиглэл, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын хүрээний бодлогын төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохицуулалт болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх 9 чиглэл, Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны даргын бодлогын төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохицуулалт болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх 3 чиглэл, Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны даргын бодлогын төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохицуулалт болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх 1 чиглэл, Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны даргын бодлогын төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохицуулалт болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх 4 чиглэл, Гадаад харилцааны сайдын бодлогын төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохицуулалт болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх 9 чиглэл, Сангийн сайдын бодлогын төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохицуулалт болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх

¹⁷ Төрийн захиргааны албан тушаалын тэргүүн түшмэл, түүнтэй адилтгах удирдах албан тушаалд тавигдах тусгай шаардлага, Төрийн албаны зөвлөлтийн 2019 оны 02 дугаар тогтоолын дөрөвдүгээр хавсралт, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=209079&showType=1>

¹⁸ Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, 1993, <https://legalinfo.mn/mn/detail/344>



13 чиглэл, Хууль зүй, дотоод хэргийн сайдын бодлогын төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохицуулалт болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх 16 чиглэл, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын бодлогын төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохицуулалт болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх 12 чиглэл, Батлан хамгаалахын сайдын бодлогын төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохицуулалт болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх 4 чиглэл, Барилга, хот байгуулалтын сайдын 8 чиглэл, Боловсрол, шинжлэх ухааны сайдын бодлогын төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохицуулалт болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх 9 чиглэл, Зам, тээврийн хөгжлийн сайдын бодлогын төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохицуулалт болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх 9 чиглэл, Соёлын сайдын бодлогын төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохицуулалт болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх 5 чиглэл, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 11 чиглэл, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын бодлогын төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохицуулалт болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх 14 чиглэл, Хүнс, хөдөө аж ахуйн, хөнгөн үйлдвэрийн сайдын 16 чиглэл, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын бодлогын төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохицуулалт болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх 11 чиглэл, Эрчим хүчний сайдын бодлогын төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохицуулалт болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх 10 чиглэл, Эрүүл мэндийн сайдын бодлогын төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохицуулалт болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх 8 чиглэлд хамаарах шийдвэр гаргахдаа эдгээр байгууллагын оролцоог хангах ёстой.¹⁹

Өөрөөр хэлбэл, Нийслэлийн Засаг даргын боловсруулсан төсөл нь сайдын бодлогын төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохицуулалт болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх 189 чиглэл, зорилгыг хангахаар ажиллаж буй 16 төрийн захиргааны төв байгууллагын эрх, хууль ёсны ашиг сонирхолд хөндөгдөх, эсхүл хуулиас тусгайлан заасан бүрэн эрх, чиг үүрэгт хамаарч байвал зайлшгүй санал авах шаардлагатай. Практик Нийслэлийн Засаг даргын хувьд боловсруулсан төсөлдөө санал авах ажиллагааг явуулахдаа, Нийслэлийн Засаг даргатөслөө боловсруулан тухайн төслөө байгууллагуудад албан бичгээр хүргүүлэн санал авах ажиллагааг зохион байгуулах замаар саналыг нь авч байна.


Иймд **G2.2. Салбарын байгууллага /Line ministries/** шалгуур үзүүлэлтийн хувьд “Зөвлөлдөх уулзалт нь албан ёсны бөгөөд талуудыг санал оролцоог хангах төсөл асуудалд төвлөрдөг гэдэг хамаарч 3-5 оноо авч байна.

G2.3. Ажлын хэсэг /Cabinet committees/

Асуулт. Ажлын хэсэг, хороод Нийслэлийн Засаг даргын саналыг хэр үр дүнтэй боловсруулдаг вэ?

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4-д Улаанбаатар хотын захирагчийн ажлын албаны үндсэн чиг үүргийг **нэгдүгээрт**, Улаанбаатар хотын Захирагчид мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх, ажиллах нөхцөлөөр хангах; **хоёрдугаарт**, Улаанбаатар хотын Захирагчийг шаардлагатай мэдээллээр хангах; **гуравдугаарт**, нийслэл хотын аж ахуйн асуудлыг судлах, шийдвэрийн төслийг боловсруулах, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих, **дөрөвдүгээрт**, иргэн, хуулийн этгээдэд хотын нийтийн аж ахуйн үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих;

¹⁹ Мөн тэнд 20 дугаар зүйлийг үзнэ үү.



тавдугаарт, хуульд заасан бусад байхаар заасан.²⁰ Уг Улаанбаатар хотын захирагчийн ажлын албаны 5 үндсэн чиг үүргийн 4 чиг үүрэг зохион байгуулалтын шинжтэй, үлдсэн нэг чиг үүрэг нь нэмэлтээр бусад чиг үүргийг тодруулсан шинжтэй байна.

Өөрөөр хэлбэл, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Монгол Улсын Нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 8.3-д заасан Нийслэлийн хотын бусад чиг үүрэгт хамаарах 16 асуудлын хүрээнд тооцоо судалгаа, бүхий шийдвэрийн төсөл боловсруулах үед Улаанбаатар хотын захирагчийн ажлын алба мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх, ажиллах нөхцөлөөр хангах, шаардлагатай мэдээллийг хангах үндсэн чиг үүрэгтэй юм.

Гэвч Улаанбаатар хотын захирагчийн ажлын алба Монгол Улсын Нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 25.4.1-25.4.5-д заасан үндсэн чиг үүргийн биелэлтийн талаарх хязгаарлагдмал байна. Тухайлбал, Нийслэлийн Засаг даргын өргөн мэдүүлсэн төсөлд Улаанбаатар хотын захирагчийн ажлын албанаас боловсруулсан судалгаа, түүний үр дүнгийн талаарх мэдээллийг ил тод, нээлттэй болгох шаардлага тулгарч байна. Өмнө дурдсанчлан Улаанбаатар хотын захирагчийн ажлын албаны цахим хуудас 2023 оны 05 сараас хойш шинэчлэгдээгүй.

Иймд **G2.3. Ажлын хэсэг/Cabinet committees/** шалгуур үзүүлэлтийн хувьд Монгол Улсын Нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулиар Нийслэлийн Засаг даргын өргөн мэдүүлсэн төслийн судалгааг хийх үндсэн чиг үүргийн хуульчилсан, энэхүү төслийн судалгааны нийтэд ил тод нээлттэй биш тул “Ажлын хэсэг, хороодын боловсруулсан санал Нийслэлийн Засаг даргын өргөн мэдүүлсэн саналын хувьд бага буюу хязгаарлагдмал гэдэгт хамаарч 3-5 оноо авч байна.

G2.4. Нийслэлийн харьяа байгууллага удирдлага, албан тушаалтны хүнд суртал/ Ministerial Bureaucracy Cabinet/


Асуулт. Нийслэлийн харьяа байгууллага, албан тушаалтны бодлогын санал үр дүнтэй, болон уялдаа холбоог шалгана.

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд нийслэлийн харьяа байгууллагын удирдлага, албан тушаалтнууд саналыг боловсруулахдаа бусад байгууллагатай санал бодлогын авдаг эсэх ажлын үр дүнг шалгах ёстой. Өөрөөр хэлбэл, нийслэлийн харьяа байгууллага хүнд сурталгүй ажиллаж буйг тухайн байгууллагын ажилтнууд бодлогын саналыг боловсруулахдаа хэрхэн хандаж буйгаар тодорхойлдог.

Өмнө дурдсанчлан нийслэлийн нь засаг захиргааны нэгжийн бүрэлдэхүүн хэсэг тул бодлогын санал боловсруулах төрийн захиргааны төв болон, төрийн бусад байгууллагын саналыг авах зайлшгүй шаардлага тулгардаг. Энэ нь нийслэлийн харьяа байгууллагад мөн хамааралтай ойлголт юм.

Нийслэлийн харьяа байгууллагын зүгээс өөрийн боловсруулсан төсөлд хамаарах асуудлаар төрийн байгууллагын оролцоог хангахдаа албан бичиг явуулах, хурал зөвлөгөөн зохион байгуулах замаар оролцуулж ирсэн. Тухайлбал, Орон нутгийн хөгжлийн сан /ОНХС/-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний талаарх иргэдийн саналыг ухаалаг

²⁰ Монгол Улсын Нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль, 2021, <https://legalinfo.mn/mn/detail/16230779072091>



утасны Smart UB аппликейшн ашиглан авах ажил энэ оны 04 дүгээр сарын 08-наас эхлэн нэг сарын хугацаанд зохион байгуулж байсан.²¹

Мөн 2021 онд буюу Ковид цар тахлын хүнд хэцүү цаг үед Нийслэл онцгой комиссын Шуурхай штабын 1800-1200 дугаар утсан дээр 24 цагийн турш ажиллаж Callcenter-т иргэдээс ирж буй хүсэлт, гомдлыг хүлээн авч, цаашдын үйл ажиллагаанд энэхүү саналыг харгалзан үзсэн.²²

2021 онд Монгол Улсын Нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгатай уялдуулан, Хотын дүрмийг боловсруулах асуудал хөндөгдсөн. Энэхүү хотын дүрмийн төсөлд иргэдийн саналыг авах ажлыг нийслэлээс зохион байгуулж буй талаар яригдсан.²³ Энэ мэтээр нийслэлийн иргэдээс санал авах эрх зүйн орчин хөгжиж байна.

Иймд **G2.4.Нийслэлийн харьяа байгууллага удирдлага, албан тушаалтны хүнд суртал/ Ministerial Bureaucracy Cabinet/** шалгуур үзүүлэлтийн хувьд Нийслэлийн харьяа байгууллагын удирдлага, албан тушаалтнууд бодлогын саналыг боловсруулах иргэдийн оролцоог хангах замаар боловсруулсан төслийн уялдаа холбоог сайжруулах эрх зүйн орчин гэдэгт хамаарч 3-5 оноо авч байна.

G2.5. Албан бус зохицуулалт /Informal Coordination/

Асуулт. Албан бус зохицуулалтын механизм нь Нийслэлийн Засаг даргахоорондын зохицуулалтын албан ёсны механизмыг хэр үр дүнтэй нөхөж байна вэ?

Албан бус зохицуулалт гэдэг нь Нийслэлийн Засаг даргаиргэдтэй харилцах нэмэлт боломжийг хэлдэг. Тухайлбал, үүнд иргэд нийслэлийн засаг даргатай хамтран ажиллах, аливаа үйл ажиллагааг зохион байгуулах аргыг хэлнэ. Жишээлбэл, Нийслэлийн Засаг даргын хуульд заасан бүрэн эрхээс илүүтэйгээр цахим орчинд өөрийн санал бодлыг илэрхийлэх замаар нийслэлийн тулгамдаж буй асуудал, иргэдийн үзэл бодол нөлөөлөх явдал байж болно. Энэхүү нөлөөлөл нь эерэг болон сөрөг үр дагавартай байж болно.

Мөн нийслэл Улаанбаатар хотын хувьд ulaanbaatar.mn цахим хуудсаар дамжуулан иргэдэд нийслэлийн хотын тухай мэдээ мэдээлэл, захирамж шийдвэр, харьяа байгууллагууд, шинэлэн данс, нийслэлийн бонд, зэрэг өргөн хэмжээний мэдээллийг өгч байна. Зөвхөн ulaanbaatar.mn веб хуудсаар дамжуулан цагийн үеийн мэдээлэл, Live, дүрстэй мэдээ, харьяа газрын мэдээ, ярилцлага, подкаст, зар мэдээ зэргийг авах боломжтой. Энэхүү цахим хуудасны хандалтын хувьд үзвэл сард 20357 иргэнээс мэдээлэл авч байна.

Энэхүү веб хуудсаар дамжуулан иргэдийн хувьд нийслэлд тулгамдаж буй асуудлаар санал өгөх боломжтой. Жишээлбэл Урт цагааны төлөвлөлтийг өөрчлөх асуудал цахим орчинд маргаан дэгдээж байгаа бөгөөд үүнтэй холбогдуулан иргэн санал өгөх боломжтой.²⁴

²¹ Иргэд амьдарч буй орчноо камержуулах санал гаргажээ, 2019, <https://itoim.mn/article/HohlR/16822>

²² иргэдийн санал, гомдлыг сонсож, шийдвэрлэж байна, https://m.facebook.com/niisleliinmedeee/posts/2853281171615510/?locale2=en_GB

²³ НЗДТГ-ын Хэвлэл мэдээлэлтэй харилцах хэлтэс, Хотын дүрэм боловсруулахад иргэдээс санал авна, <https://ikon.mn/n/2axj>

²⁴ <https://vote.ulaanbaatar.mn/home>

Түүнчлэн иргэдийн хувьд Нийслэлийн санхүү, төсвийн өнөөгийн байдал, 2024 оны төсвийн төсөлтэй танилцаж, санал өгөх боломжтой. Тодруулбал, Монгол Улсын Их Хурал 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар нийслэлийн 2024 оны төсвийн суурь орлогыг 1,919.7 тэрбум төгрөг, суурь зарлагыг 1,152.1 тэрбум төгрөг, Төсвийн тухай хуулийн 56 дугаар зүйлд заасны дагуу нийслэлийн төсвөөс 230.3 тэрбум төгрөгийг Улсын төсөвт татан төвлөрүүлэх, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас нийслэлд 47.8 тэрбум төгрөг хуваарилахаар Монгол улсын 2024 оны төсвийн тухай хуулийг баталсан.²⁵ Нийслэлд оршин суугаа иргэний хувьд оршин суугаа дүүрэг, хороогоо бичиж хорооныхоо цаашдын хөгжилд шаардлагатай гэж үзэж байгаа хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээнд саналаа илэрхийлэх боломжтой.²⁶ Энэхүү хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээ төрлийг авч үзвэл дараах төрөлтэй байна. Үүнд:

- Гэр хорооллын дахин төлөвлөлт
- Нийтийн тээвэр
- Үерийн хамгаалалтын барилга
- Авто зам барих, засварлах
- Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх
- Нийтийн эзэмшлийн зам, талбайн тохижилт
- Гэр хорооллын айл өрхийн цахилгаан хангамж
- Орон сууцны дээвэр, цахилгаан шатны засвар
- Ус түгээх байр
- Бусад²⁷

Иймд **G2.5. Албан бус зохицуулалт /Informal Coordination/** шалгуур үзүүлэлтийн хувьд нийслэлийн хувьд ulaanbaatar.mn веб хуудсаар дамжуулан нийслэлийн шийдвэр гаргах үйл ажиллагаанд иргэдийн оролцуулж байна. Энэ нь “Зарим тохиолдолд албан бус зохицуулалтын механизм нь яам хоорондын зохицуулалтын албан ёсны механизмыг дэмждэг” гэдэгт хамаарч 3-5 оноо авч байна.

G2.6. Нийслэлийн Засаг даргын харьяа байгууллагын шийдвэрийг цахимжуулах /Digitization for Interministerial Coordination/

Асуулт. Нийслэлийн Засаг даргын харьяа байгууллагын шийдвэрийг (бодлого боловсруулах, хяналт тавихад) дижитал технологийг өргөн хүрээнд, үр дүнтэй ашиглаж чадаж байна уу?


Нийслэлийн Засаг даргын харьяа байгууллагын шийдвэрийг цахимжуулалтыг өргөн хүрээнд ашиглаж байна. Үүнд: Ulaanbaatar.mn, Нийслэлийн мэдээ FB хуудас, Нийслэлийн мэдээ youtube суваг, дижитал сити зэргийг дурдаж болно.²⁸ Уг цахим хуудсаар дамжуулан иргэдийн хувьд Нийслэлийн Архивын газар, Нийслэлийн Байгаль орчны газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, ЦЕГ-ын Мэдээлэл Дүн Шинжилгээ Шуурхай Удирдлагын

²⁵ Нийслэлийн 2024 оны төсвийн төслийн санал асуулга <https://docs.google.com/forms/d/e/1faipqlsf0totwyyarhv0bfojnmh0e1vpvjy1jxbysidq37iexhlkyua/viewform>

²⁶ Нийслэлийн санхүү, төсвийн өнөөгийн байдал, 2024 оны төсвийн төсөлд санал өгөх, <https://ulaanbaatar.mn/home>, Сүүлд хандсан огноо. 2023.11.27

²⁷ <https://docs.google.com/forms/d/e/1FAIpQLSf0T0twYyaRHV0BfoJNMh0E1VPVJy1JXbySidQ37iexHIKYUA/viewform>, Сүүлд хандсан огноо. 2023.11.27.

²⁸ <https://ulaanbaatar.mn/home>



шийдвэрийг харах боломжтой. Түүнчлэн уг цахим хуудсаар дамжуулан Архивын лавлагаа, Согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөл, Согтууруулах ундаагаар үйлчлэх тухай зөвшөөрөл, Хот байгуулалт, хөгжлийн газрын үйлчилгээний төлбөр төлөх, Гүйцэтгэлийн байрзүйн зургийг хот байгуулалтын мэдээллийн санд бүртгэх зэрэг үйлчилгээ авч байна.

Мөн Нийслэлийн Засаг даргабөгөөд Улаанбаатар хотын захирагчийн хувьд өөрийн гаргасан шийдвэрийг цахимжуулж байна. Тухайлбал, ажлын хэсэг байгуулах тухай 2023 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн А/1321 дугаарт захирамжийг дурдаж болно. Энэхүү ажлын хэсэг байгуулах тушаалаар Хотын нийтийн ахуйн нэгдмэл байдлыг хангах, чиг үүргийн хамаарлыг оновчтой хуваарилах зорилтын хүрээнд Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны хариуцаж байсан зарим чиг үүргийг дүүрэгт шилжүүлэх санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар байгуулжээ.²⁹

Иймд **G2.6. Нийслэлийн Засаг даргын харьяа байгууллагын шийдвэрийг цахимжуулах /Digitization for Interministerial Coordination/** шалгуур үзүүлэлтийн хувьд Нийслэлийн Засаг даргын харьяа байгууллага ихэнх тохиолдолд дижитал технологийг ашигладаг бөгөөд энэ нь дээрх байгууллага хоорондын уялдаа холбоог хангахад дэмжих үр дүнтэй гэдэг хамаарч 6-8 оноо авч байна.

G3.Нотолгоонд суурилсан хэрэгслүүд /Evidence-based Instruments/

G3.1.Эрх зүйн зохицуулалтын үр нөлөөний үнэлгээний хэрэглээ /Regulatory impact assessments application/

Асуулт. Нийслэлийн Засаг даргахүчин төгөлдөр мөрдөгдөж буй болон бэлтгэсэн эрх зүйн актуудын (Эрх зүйн зохицуулалтын үр нөлөөний үнэлгээ, RIA) болзошгүй нөлөөллийг үнэлдэг эсэх?


Эрх зүйн зохицуулалтын үр нөлөөний үнэлгээ гэдэг нь Нийслэлийн Засаг даргын зүгээс санал болгож буй шинэ төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээс өмнө болзошгүй нөлөөллийг үнэлэх арга юм. Энэ нь хууль тогтоомжийн тухай хуулийн зорилгод хууль, тогтоомж санаачлан боловсруулах, хууль тогтоомжийн төсөлд тавигдах шаардлагыг тодорхойлох, олон нийтийн оролцоог хангах, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэхтэй төстэй юм.³⁰

Гэвч хууль тогтоомжийн тухай хуулиар хууль болон улсын их хурлын тогтоолд тодорхой шаардлага тавьдаг. Тухайлбал, тус хуулийн 8 дугаар зүйлээс 35 зүйл хүртэл хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажлын үе шат, хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажлыг зохион байгуулах хэлбэр, хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажлыг санхүүжүүлэх, Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах, Хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалын төсөл боловсруулах, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах, Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх, Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцох, Засгийн газрын санаачилсан хууль тогтоомжийн төсөлд санал авах, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх, Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүний санаачилсан хууль тогтоомжийн төсөлд Засгийн газрын санал

²⁹ Нийслэл засаг дарга, Улаанбаатар хотын захирагчийн дугаар А/1321 захирамж, <https://ulaanbaatar.mn/rule/655eeca8eaca082574cb5322>

³⁰ Хууль тогтоомжийн тухай хууль, 2015, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=11119>





дүгнэлтийг авах, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх зэрэг цогц харилцааг хуульчилсан.³¹

Өөрөөр хэлбэл, хууль тогтоомжийн төсөл боловсруулах, Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах, Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх, Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцох судалгааг зайлшгүй хийдэг.

Харин Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулах харилцааг мөн хуулийн 35 дугаар зүйлээс 41 дүгээр зүйлд хуульчилсан. Ингэхдээ их хурлын тогтоолын төслийн хувьд хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлал, болон танилцуулга, хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг тандан судалсан, эсхүл хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн, хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлсэн, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийсэн тайлан байхыг шаарддаг.³²

Харин Нийслэлийн Засаг даргын боловсруулсан захирамжийн хувьд хууль тогтоомжийн болзошгүй нөлөөллийг үнэлдэг эсэх нь тодорхойгүй. Хууль тогтоомжийн тухай хуулийн үйлчлэлд “Энэ хууль нь хууль тогтоомжийг санаачлан боловсруулах, олон нийтийн оролцоог хангах, эрх зүйн дүгнэлт хийх, өргөн мэдүүлэх, батлагдсан хууль тогтоомжийг нийтлэх, олон нийтэд сурталчлах, түүний хэрэгжилтийг зохион байгуулах болон хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийхтэй холбогдсон харилцааг зохицуулж” байсныг хүчингүй болгосон. Иймд тус хуулийн дагуу хийгддэг захирамжийн хэрэгцээ, шаардлагыг тандан судалсан, өмнөх захирамжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн, захирамжийн үр нөлөөг үнэлсэн, захирамжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоотой холбоотой судалгааг шаардах боломжтой.

Иймд, **G3.1.Эрх зүйн зохицуулалтын үр нөлөөний үнэлгээний хэрэглээ /Regulatory impact assessments application/** шалгуур үзүүлэлтийн хувьд Нийслэлийн Засаг даргын захирамжийг үнэлдэггүй. Гэвч хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу захирамжийн хэрэгцээ, шаардлагыг тандан судалсан, өмнөх захирамжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн, захирамжийн үр нөлөөг үнэлсэн, захирамжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоонд хамаарах судалгааг хийх боломжтой тул 3-5 оноо авлаа.

G3.2.Эрх зүйн зохицуулалтын үр нөлөөний үнэлгээний үйл явц чанар /Quality of Ria Process/

Асуулт. Эрх зүйн зохицуулалтын үр нөлөөний үнэлгээний үйл явц, оролцоо, ил тод байдал, чанарын үнэлгээг баталгаажуулдаг эсэх ?

Эрх зүйн зохицуулалтын үр нөлөөний үнэлгээний үйл явц чанарын хувьд тус үнэлгээний процедурын чанарыг үнэлэх зорилготой юм. Эрх зүйн зохицуулалтын үр нөлөөний үнэлгээний үр дүн тэдний хүртээмж, харилцаа холбоо нь улс төрийн холбогддог.

G3.1.Эрх зүйн зохицуулалтын үр нөлөөний үнэлгээний хэрэглээ /Regulatory impact assessments application/-ний шалгуур үзүүлэлтэд дурдсанчлан Нийслэлийн Засаг даргын хувьд тус үнэлгээг хийдэггүй. Иймд **G3.2.Эрх зүйн зохицуулалтын үр нөлөөний**

³¹ Мөн тэнд,

³² Хууль тогтоомжийн тухай хуулийн 40.1.2 дахь заалтыг үзнэ үү.
<https://legalinfo.mn/mn/detail?lawId=11119>



үнэлгээний үйл явц чанар /Quality of Ria Process/ -ын үнэлгээний хувьд “зохицуулалтын нөлөөллийн шинжилгээ байхгүй” гэдэгт хамаарч 1-2 оноо авч байна.

G3.3.Тогтвортой байдлын шалгалт /Sustainability Check/

Асуулт. Нийслэлийн Засаг даргаЭрх зүйн зохицуулалтын үр нөлөөний үнэлгээний дагуу хүрээнд тогтвортой, үр дүнтэй шалгалт хийдэг үү.

Тогтвортой байдлын шалгалт нь гурван шалгуурыг хангадаг. Нэгдүгээрт, шийдвэр гаргах нийтлэг үндэслэлийг бий болгохын тулд тэдгээрийг Эрх зүйн зохицуулалтын үр нөлөөний үнэлгээнд нэгтгэдэг. Хоёрдугаарт, нийгэм (жишээ нь, залуучуудын ажилгүйдэл), эдийн засаг (жишээ нь, улсын өр) болон байгаль орчны (жишээлбэл, CO2 ялгаруулалт) асуудлыг шийдвэрлэх нөлөөллийн шалгуур үзүүлэлтүүдийг ашигладаг. Гуравдугаарт, богино, дунд, урт хугацаанд ийм үзүүлэлтүүдэд үзүүлэх нөлөөллийг судалдаг. Энэ ч утгаараа нийслэлийн засаг даргаас ТХЗ-д нийцүүлсэн тогтвортой байдлын стратеги байгаа эсэх, энэ стратеги нь ТХЗ-уудтай нийцэж байгаа эсэхийг мөн зааж өгөх нь чухал. Мөн нийслэлийн засаг даргаас ТХЗ-ыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр баталсан эсэх, хэрэгжилтийн явцдаа хяналт тавьж байгаа эсэхэд дүгнэлт өгөх нь зүйтэй.

Нийслэлийн Засаг даргын шийдвэрт G3.1.Эрх зүйн зохицуулалтын үр нөлөөний үнэлгээ хийдэггүй талаар өмнө дурдсан. Иймд **G3.3.Тогтвортой байдлын шалгалт /Sustainability Check/**-ын үнэлгээний хувьд “тогтвортой байдлын шалгалт байхгүй” гэдэгт хамаарч 1-2 оноо авч байна.

G3.4. Хэрэгжилтийн үнэлгээчанар /Quality of Ex Post Evaluation/

Асуулт. Нийслэлийн Засаг даргахэрэгжүүлж буй бодлогын үр ашгийг тогтмол үнэлж, үнэлгээний үр дүнг одоо байгаа бодлогыг шинэчлэх, шинэ бодлого боловсруулахад хэр ашигладаг вэ?

G3.4. Хэрэгжилтийн үнэлгээ чанар /Quality of Ex Post Evaluation/ шалгуур үзүүлэлтийн хүрээнд бодлого шинэчлэн боловсруулах эсвэл шинэ бодлого боловсруулахаас өмнө нийслэлийн засаг даргаас одоо байгаа бодлогын үр нөлөөг системтэйгээр үнэлэхэд өмнөх үнэлгээг ашиглаж байгаа эсэхийг үнэлдэг. Гэвч Нийслэлийн Засаг даргын шийдвэрт G3.1.Эрх зүйн зохицуулалтын үр нөлөөний үнэлгээ хийдэггүй. Иймд **G3.4. Хэрэгжилтийн үнэлгээчанар /Quality of Ex Post Evaluation/** үнэлгээний хувьд “өмнөх дараах үнэлгээг хийдэггүй” гэдэг шалгуурт хамаарч 1-2 оноо авч байна.


G4. Нийгмийн зөвшилцөл/Societal Consultation/

G4.1.Олон нийтийн хэлэлцүүлэг /Public Consultation/

Асуулт. Нийгмийн зүтгэлтнүүдтэй шударга, олон ургалч үзлийн талаар зөвшилцдөг үү?

Нийслэл засаг даргын шийдвэр гаргах, бодлого боловсруулахад бусад этгээдийн тэр дундаа үйлдвэрчний эвлэл, ажил олгогчдын холбоо, бизнесийн холбоод, шашны нийгэмлэг, нийгэм, байгаль орчны ашиг сонирхлын бүлгүүд зэрэг нийгмийн оролцогчидтой зөвшилцдөг эсэх, энэхүү зөвшилцөх эсэхийг үнэлдэг.





Манай Улсын хувьд нийтийн өргөдөл, гомдлын системг хөгжүүлж байна. Уг системд хандаж, нийгэмд тулгамдаж буй асуудлын хүрээнд өргөдөл боловсруулах боломжтой. Нийтийн өргөдөл, гомдлын системд одоогоор төлбрөтэй бүс, гэр хорооллыг газрыг албадан хураах хуулийг эсэргүүцэх, Ковидын төсвийн задаргааны сонсголыг өргөн хүрээнд хийх, Цэцэрлэг сургуулийн хүүхдийн үдийн хоолны төсөв нэмэх тухай, Улс төрийн намуудыг заавал шилэн данс хөтлөх үүрэгтэй болгож ил тод байдлаар хангах зэрэг өргөдөлд санал авч байна.³³

Түүнчлэн Нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварын шимтгэлийг 50% бууруулах, цалинтай ээж гэж нэрлэгдэж буй 50.000₮ -ийг нэмэхийг дэмжих, Нэмэгдсэн өртгийн буцаан олголтын 2 хувийг 5 хувь болгож нэмэгдүүлэхийг дэмжиж зэрэг нь 100.000 дээш хүний санал авж дэмжигдсэн.³⁴ Харин электрон тамхийг хуульчилж, зөвхөн насанд хүрсэн хүнд худалдаалдаг болгох нь зөв үү?, УИХ гишүүнийг цахим санал хураалтаар сонгогчид нь эргүүлэн татах хууль санаачлах, 5 дугаар цахилгаан станцыг барьж эхлүүлэх зэрэг саналыг дэмждээгүй.³⁵

Өөрөөр хэлбэл, улсын хэмжээнд хамаарах асуудлаар нийтийн өргөдөл, гомдлын системээр дамжуулан иргэд өргөдөл, гомдлын санал гаргаж байна. Нийслэлийн Засаг даргын шийдвэр, бодлогын хувьд дээрх систем хөгжөөгүй байна. Гэвч Нийслэлийн Засаг даргын шийдвэр бодлогод иргэдийн оролцоог хангаж байна.

Дээрхээс үзвэл, **G4.1.Олон нийтийн хэлэлцүүлэг /Public Consultation/** шалгуур үзүүлэлтийн хүрээнд олон нийтийн хэлэлцүүлэг өрнүүлдэг боловч, хэлэлцүүлгийн үр дүн тодорхойгүй. Иймд **G4.1.** шалгуурын хүрээнд Нийслэлийн Засаг дарганийгмийн оролцогчидтой зөвшилцдөг” гэдэгт хамаарч 3-5 оноо авч байна.

G5. Бодлогын уялдаа холбоо /Policy Communication/

G5.1. Ойлгомжтой, уялдаа холбоо /Coherent Communication/

Асуулт. Нийслэл засаг даргын харьяа байгууллага хоорондоо хэрхэн харилцаж, бодлогын уялдаа холбоог хангадаг вэ ?

Нийслэлийн хүрээнд Нийслэлийн Архивын газар,, Нийслэлийн Бизнес хөгжлийн газар, Нийслэл дэх Улсын бүртгэлийн газар, Нийслэлийн Дотоод Аудитын алба, Нийслэлийн Статистикийн газар, Нийслэлийн Татварын газар, Нийслэлийн Хүнс хөдөө аж ахуйн газар, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар, Нийслэлийн Цагдаагийн удирдах газар, Нийслэлийн Цахим хөгжил, мэдээллийн технологийн газар, Нийслэлийн Мал эмнэлгийн газар, Нийслэлийн Онцгой байдлын газар, Нийслэлийн Өмчийн харилцааны газар, Нийслэлийн аялал жуулчлалын газар, Нийслэлийн Боловсролын газар, Нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Нийслэлийн Нийгмийн даатгалын газар, Нийслэлийн Соёл, урлагийн газар, Нийслэлийн Хөдөлмөр, халамжийн газар, Улаанбаатар хотын Нийтийн төв номын сан, Улаанбаатар хотын музей, Соёлын төв өргөө, Нийслэлийн Аддиктологийн төв, Нийслэлийн Амгалан амаржих газар, Нийслэлийн хүрээ амаржих газар, Нийслэлийн Өргөө амаржих газар, Нийслэлийн түргэн тусламжийн төв, Нийслэлийн Шүд эрүү нүүрний зөв, Нийслэлийн Хүүхдийн сэргээн засах эрүүл үрс төв, Сэргээн засах

³³ Нийтийн өргөдөл, гомдлын систем, <https://petition.parliament.mn/>

³⁴ <https://petition.parliament.mn/?searchtype=Completed>

³⁵ <https://petition.parliament.mn/?searchtype=NotDoneCompleted>



клиник эмнэлэг, Уламжлалт ухааны элэг судлалын клиник төв, Энэрэл эмнэлэг, Хүүхдийн сэргээн засах Хан Туул төв, Ахмадын хороо, Улаанбаатар хотын захирагчийн ажлын алба, Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газар, Нийслэлийн Байгаль орчны газар, Нийслэл Дагуул хот, эдийн засгайн тусгай бүсийн хөгжлийн газар, Нийслэлийн замын хөгжлийн газар, Нийслэлийн Нийтийн тээврийн газар, Нийслэлийн Орон сууцны бодлогын газар, Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газар, Нийслэлийн Хотын стандарт, хяналтын газар зэрэг 43 албан газар, Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар 17, Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар 15, Олон улсын худалдаа логистиктийн төв ХК, Нийслэлийн Орон сууцны корпораци ХК, Улаанбаатар хотын хөгжлийн корпораци ХК, Улаанбаатарын шинэ бүтээн байгуулалт ХХК, Таван толгой түлш ХХК, Улаанбаатар хотын хийн сүлжээ ХХК, Улаанбаатар хотын Тогтвортой авто зам, тээврийн төслийн нэгж, Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөв хэрэгжүүлэх нэгж, Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төсөл, Улаанбаатар хотын орлогод нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл салбарын төсөл, Улаанбаатар хотын хүнсний хог хаягдлыг дахин боловсруулах төсөл, Улаанбаатар хотын хатуу хог хаягдлаын байгууламжийг шинэчлэх төслийн нэгж, гэр хорооллын нийтийн тээврийн үйлчилгээг сайжруулах төсөл, Улаанбаатар хотын нийтийн аж ахуйг сайжруулах хоёр дахь төслийг удирдах нэгж зэрэг зэрэг нийт 88 байгууллага үйл ажиллагаа явуулж байна.³⁶

Дээрх 88 байгууллага нь үндсэн болон дэд чиг үүрэгтэй. Жишээлбэл, Улаанбаатар хотын Тогтвортой авто зам тээврийн төслийн нэгжийн хувьд үндсэн 6, дэд 17 чиг үүрэгтэй.³⁷ Энэ мэтээр 88 байгууллагын үндсэн болон дэд чиг үүрэг, стратеги төлөвлөгөөг нэгтгэх цаашлаад нийслэлд үйл ажиллагаа явуулж буй 88 байгууллагыг цөөлөх, давхардсан чиг үүргийг тодорхойлох шаардлага тулгарч байна.

Иймд, **G5.1.Ойлгомжтой, уялдаа холбоо /Coherent Communication/** шалгуур үзүүлэлтийн Нийслэлийн Засаг даргын харьяа байгууллагын харилцаа, нийслэлийн бодлого стратегитай уялдуулахад зөрчилдөөн үүсдэг” гэдэг хамаарч 3-5 оноо авч байна.


2.5. ҮР ДҮНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

“Нийслэлийн бодлого боловсруулах эрх зүйн орчин” индекс үзүүлэлтийг SGI буюу (Sustainable governance indicators) “Тогтвортой засаглалын үзүүлэлт”-ийн бүрэлдэхүүн хэсэг болох болох “Good governance”, “сайн засаглал”-ын шалгуур үзүүлэлтэд үндэслэсэн. Энэхүү SGI шалгуур үзүүлэлт нь Эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага болон Европын холбооны гишүүн 41 улсын тогтвортой засаглалын хүрээнд харьцуулан жил тогтмол гардаг онцлогтой.

Манай улсын 1992 оны Үндсэн хуулийн Хоёрдугаар зүйлийн 1-т Монгол Улс төрийн байгууламжийн хувьд нэгдмэл, мөн зүйлийн 2-т Монгол Улсын нутаг дэвсгэр зөвхөн засаг захиргааны нэгжид хуваагдахаар хуульчилсан. Энэ заалтад үндэслэн органик хууль болох Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулиар нэгжийг асуудлыг нарийвчилан тогтоосон.

³⁶ 2023.10.02-ны өдрөөс 10.04-ний хүртэлх өдрийн танилцуулга, Хангарьд ордон.

³⁷ Нийслэлийн бодлогын судалгаа шинжилгээний төвөөс ирүүлсэн нийслэлийн харьяа байгууллагын нэгдсэн чиг үүргийн тодорхойлсон хүснэгт.



Гэвч 1992 оны Монгол Улсын хувьд Үндсэн хуулийн Арван гуравдугаар зүйл, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь заалтад үндэслэж Нийслэлийн эрх зүйн байдлыг бие даасан хуулиар тогтоодог онцлогтой. Энэ ч утгаараа нийслэлийн бодлого боловсруулах эрх зүйн орчин шалгуур үзүүлэлтийн хүрээнд Монгол Улсын нийслэл улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн хэм хэмжээг тусгайлан судалсан. Өөрөөр хэлбэл, нийслэлийн бодлого боловсруулах эрх зүйн орчин болон дүүргийн бодлого боловсруулах эрх зүйн орчин нь хоорондоо ялгаатай бөгөөд тусдаа хуулиар зохицуулагдаж байна.

Түүнчлэн, сайн засаглал шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэх чадвар /executive capacity/ шалгуурын 26 дэд үзүүлэлтээс 14 дэд шалгуур үзүүлэлт буюу G1-G5 нь Нийслэлийн бодлого боловсруулах эрх зүйн орчин шалгуур үзүүлэлтэд хамруулсан. Иймд, дүүргийн бодлого боловсруулах эрх орчинг сайн засаглалын 14 дэд шалгуур үзүүлэлтэд тулгуурлан дахин судлах нь зүйтэй.

2.6. БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

Нийслэлийн бодлого боловсруулах эрх зүйн орчныг 14 дэд шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж дараах дүгнэлтийг өгж байна.

G1. Стратегийн чадавхи /Strategic Capacity/ шалгуур үзүүлэлтийн хүрээнд 4-7 оноо.

G1.1. Стратегийн төлөвлөлт /Strategic Plannig/ шалгуур үзүүлэлтийн хүрээнд 3-5 оноо.

G1.2. Мэргэжилтнүүдийн зөвлөгөө /Expert Advice/ шалгуур үзүүлэлтийн хүрээнд 1-2 оноо.

G2. Нийслэлийн Засаг даргын харьяа байгууллага хоорондын зохицуулалт /Interministerial Coordination/ шалгуур үзүүлэлийн хүрээнд 21-33 оноо.

G2.1. Төслийн менежерийн багийн туршлага /PMO expertise/ шалгуур үзүүлэлтийн хүрээнд 3-5 оноо.

G2.2. Салбарын байгууллага /Line ministries/ шалгуур үзүүлэлтийн хүрээнд 3-5 оноо,


G2.3. Ажлын хэсэг /Cabinet committees/ шалгуур үзүүлэлтийн хүрээнд 3-5 оноо,

G2.4. Нийслэлийн харьяа байгууллага удирдлага, албан тушаалтны хүнд суртал/ Ministerial Bureaucracy Cabinet/ шалгуур үзүүлэлтийн хүрээнд 3-5 оноо,

G2.5. Албан бус зохицуулалт /Informal Coordination/ шалгуур үзүүлэлтийн хүрээнд 3-5 оноо,

G2.6. Нийслэлийн Засаг даргын харьяа байгууллагын шийдвэрийг цахимжуулах /Digitization for Interministerial Coordination/ шалгуур үзүүлэлтийн хүрээнд 6-8 оноо авсан.

G3.Нотолгоонд суурилсан хэрэгслүүд /Evidence-based Instruments/ шалгуур үзүүлэлтийн хүрээнд 6-11 оноо.



G3.1.Эрх зүйн зохицуулалтын үр нөлөөний үнэлгээний хэрэглээ /Regulatory impact assessments application/ шалгуур үзүүлэлтийн хүрээнд 3-5 оноо,

G3.2.Эрх зүйн зохицуулалтын үр нөлөөний үнэлгээний үйл явц чанар /Quality of Ria Process/ шалгуур үзүүлэлтийн хүрээнд 1-2 оноо,

G3.3.Тогтвортой байдлын шалгалт /Sustainability Check/ шалгуур үзүүлэлтийн хүрээнд 1-2 оноо,

G3.4. Хэрэгжилтийн үнэлгээ чанар /Quality of Ex Post Evaluation/ шалгуур үзүүлэлтийн хүрээнд 1-2 оноо авсан.

G4. Нийгмийн зөвшилцөл /Societal Consultation/ шалгуур үзүүлэлтийн хүрээнд 3-5 оноо.

G4.1.Олон нийтийн хэлэлцүүлэг /Public Consultation/ шалгуур үзүүлэлтийн хүрээнд 3-5 оноо авсан.

G5. Бодлогын уялдаа холбоо /Policy Communication/ шалгуур үзүүлэлтийн хүрээнд 3-5 оноо


G5.1. Ойлгомжтой уялдаа холбоо /Coherent Communication/ шалгуур үзүүлэлтийн хүрээнд 3-5 оноо авсан.

Дээрх 14 дэд шалгуур үзүүлэлтэд тулгуурлан Нийслэлийн бодлого боловсруулах эрх зүйн орчны индекс үзүүлэлтийг гаргавал тус шалгуур үзүүлэлтийн боломжит дээд оноо нь 4.35, бага оноо нь 2.64, дунджаар 3.5 оноотой байна. Иймд цаашид нийслэлийн бодлого боловсруулах эрх зүйн орчин шалгуур үзүүлэлтийг сайжруулах чиглэлээр дараах зөвлөмжийг өгж байна.

G1. Стратегийн чадавхи /Strategic Capacity/ шалгуур үзүүлэлтийн үнэлгээг сайжруулахын тулд Нийслэлийн Засаг даргын шийдвэр гаргахад стратегийн төлөвлөлтийн нэгж, байгууллагын үзүүлэх нөлөө сайжруулах шаардлагатай. Ингэхдээ стратеги төлөвлөлтийн нэгжийн үйл ажиллагааг нийтэд ил тод болгох нь зүйтэй. Мөн Нийслэлийн засаг даргад зөвлөх эрх бүхий орон тооны бус мэргэжлийн зөвлөл байгуулах, түүний бүрэлдэхүүн, ажиллах журмыг батлах, практик бодитоор хэрэгжүүлэх шаардлагатай.

G2. Нийслэлийн Засаг даргын харьяа байгууллага хоорондын зохицуулалт шалгуур үзүүлэлтийн үнэлгээг сайжруулахын Нийслэлийн Засаг даргын харьяа байгууллагын албан хаагчийг чадавхийг сайжруулах, Нийслэлийн Засаг даргын бодлогын санал боловсруулахад оролцсон салбарын байгууллагын оролцоог нийтэд, ил тод болгох, ажлын хэсэг хороодын засаг даргын саналыг боловсруулахад хэрхэн оролцсон болохыг баталгаажуулж, цаг тухай бүрд иргэд, олон нийтэд мэдээллэх, албан бус зохицуулалтын арга хэлбэрийг нэмэгдүүлэх, нийслэлийн засаг даргын харьяа байгууллагын цахимжиж буй шийдвэрийг төрлийг олшруулах зэрэг ажлыг зохион байгуулах нь зүйтэй.

G3.Нотолгоонд суурилсан хэрэгслүүд /Evidence-based Instruments/ шалгуур үзүүлэлтийн үнэлгээг сайжруулахын тулд Нийслэлийн Засаг даргын шийдвэрт зохицуулалтын нөлөөний үнэлгээг хууль тогтоомжийн тухай хуультай уялдуулан хийх, энэхүү зохицуулалтын нөлөөний үнэлгээний үйл явц чанарыг үйл явц, оролцоо, ил тод байдлыг



нэмэгдүүлэх, Нийслэлийн Засаг даргын шийдвэрийг тасралтгүй, тогтвортой, түргэн шуурхай үнэлэх шаардлагатай.

G4. Нийгмийн зөвшилцөл /Societal Consultation/ шалгуур үзүүлэлтийн үнэлгээг сайжруулахын тулд Нийслэлийн Засаг даргын шийдвэр гарахын өмнө олон нийтээр хэлэлцүүлэх, нийтийн өргөдөл, гомдлыг системг нийслэлийн хүрээнд хөгжүүлэх замаар, нийслэлийн иргэдийн оролцоог нэмэгдүүлэх нь зүйтэй.

G5. Бодлогын уялдаа холбоо /Policy Communication/ шалгуур үзүүлэлтийн үнэлгээг сайжруулахын тулд нийслэлийн засаг даргын харьяа 88 гаруй байгууллагын чиг үүрэг давхцалыг судлах, энэхүү хэт данхар бүтцийг цомхотгох, харьяа байгууллагын хоорондын харилцаа, уялдаа холбоонд хамаарах мэдээ мэдээллийг тогтмол иргэд олон нийтэд мэдээллэх шаардлагатай.



ГУРАВ. “НИЙСЛЭЛИЙН БОДЛОГО, БОЛОВСРУУЛАЛТ, ТӨЛӨВЛӨЛТ, ХЭРЭГЖИЛТ” /ОНОВЧТОЙ, ҮР ДҮН, НӨЛӨӨТЭЙ, ИЛ ТОД/ ИНДЕКС ҮЗҮҮЛЭЛТ

3.1. ЗОРИЛГО

Нийслэлийн бодлого боловсруулалт, төлөвлөлт, хэрэгжилтийг үнэлэх индексийг бусад улс орны жишиг болон судлаачдын боловсруулсан арга зүйд үндэслэн тодорхойлох ба тухайн шалгуур үзүүлэлт нь нийслэлийн бодлого боловсруулалт, төлөвлөлт, хэрэгжилт нь оновчтой, үр дүнтэй байгаа эсэхийг үнэлэхэд чиглэгдэнэ. Цаашлаад, уг шалгуур үзүүлэлт нь Улаанбаатар хотын өмнө тулгамдаж буй асуудлуудыг хөгжлийн төлөвлөлттэй уялдуулан амьдрах орчны чанарыг олон улсын жишиг аргачлалын дагуу тооцоход туслах нэгж бүрэлдэхүүн болно.

Дээрх зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Бодлого боловсруулалт, төлөвлөлтийг үнэлэх аргачлалыг дэвшүүлэх. Нийслэлийн үндсэн бодлогын баримт бичигт дүн шинжилгээ хийх;
2. Бодлогын хэрэгжилтийг үнэлэх индексийг тодорхойлох, тус индексийн хүрээнд Улаанбаатар хотын одоогийн нөхцөл байдлыг үнэлэх.

3.2. АРГА ЗҮЙ, ТООЦООЛОЛ

Нийслэлийн бодлого боловсруулалт ба төлөвлөлт хэсгийг үнэлэхдээ “Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д дэвшүүлсэн зорилго, зорилтуудыг үндсэн шалгуур болгон авч үзэх бөгөөд тус баримт бичиг нь нийслэлийн өмнө тулгамдаж буй асуудлуудыг хэсэгчлэн болон бүрэн шийдвэрлэх оновчтой, үр дүн нөлөөтэй арга зам эсэхэд дүн шинжилгээ хийнэ. Үүний тулд, “Дэлхийн тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”-ын 17 зорилго нь “Нийслэлийн хөгжлийн бодлого”-д хэрхэн тусгагдсаныг шалгаж үнэлгээ өгнө. ДТХҮБ-2030 хөтөлбөр нь тогтвортой хөгжлийг цогцоор нь харж, дэлхийн түвшинд зорилтуудыг гаргасан бөгөөд улс орон бүр эдгээр зорилтуудыг үндэсний хөгжлийн төлөвлөлтийн үйл явц, бодлого, стратегитэй уялдуулж буй тул харьцуулах баримт бичгээр сонгосон болно.

Бодлогын зорилтуудын хоорондын уялдаа болон үзүүлэх нөлөөг шинжлэхийн тулд чанарын өгөгдлийг эмхэлж, цэгцлэх матрицын шинжилгээний аргыг ашиглана. Тус аргыг Швед Улсын Стокгольмын байгаль орчны хүрээлэнгийн эрдэмтэд Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалтын уялдааг шинжлэхэд ашигласан ба матриц нь тоон мэдээллийн шинжилгээний хүснэгттэй төстэй боловч өгөгдөл нь тоон биш өгүүлбэрийн хэлбэртэй байна.

Нийслэлийн бодлогын хэрэгжилт хэсгийн хүрээнд, SGI буюу (Sustainable governance indicators) "Тогтвортой засаглалын үзүүлэлтүүд"-ийг шалгуур үзүүлэлт болгон ашиглана. SGI нь үр дүнтэй бодлого боловсруулалтын сайн жишгийг тодорхойлох, дэмжих зорилготой улс хоорондын харьцуулсан судалгаа бөгөөд Эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага болон Европын холбооны гишүүн 41 улсыг тогтвортой засаглалын хүрээнд харьцуулан жил бүр судалгаа гаргадаг төсөл юм. SGI нь бодлогын хэрэгжилт, ардчилал, засаглал гэсэн 3 үндсэн цогц ойлголтод тулгуурладаг ба "Нийслэлийн бодлого боловсруулалт, төлөвлөлт, хэрэгжилт" сэдвийг засаглал ангиллын холбогдох дэд шалгуур үзүүлэлтээр үнэлэх нь



тохиромжтой байна. Энэ индекс нь шийдвэрлэх үзүүлэлт дээр төвлөрдөг буюу улс үндэстэн тулгамдсан асуудлаа тодорхойлж, стратегийн шийдэл боловсруулж чадаж байгаа эсэхийг үнэлэх зорилготой. Тогтвортой засаглалыг “Гүйцэтгэх чадвар” болон “Гүйцэтгэх хариуцлага” гэсэн 2 үндсэн бүлэгт хуваан авч үздэг. Тус индексийн эхний хэсэг нь “Гүйцэтгэх чадвар” гэсэн ангилалд хамаарна. Энэ нь тухайн улсын стратегийн төлөвлөлт, төрийн бодлого боловсруулахдаа талуудын оролцоог хангаж буй байдал болон бодлого хэрэгжүүлэх, суралцах чадавхийг үнэлдэг. “Гүйцэтгэх хариуцлага” хэсэгт иргэд, сонирхлын бүлгүүд, хэвлэл мэдээллийн хэрэгслүүд төрийн бодлого, шийдвэрт хяналт тавих, санал, хүсэлтээ илэрхийлэх, хариуцлага тооцох чадавхийг үнэлдэг. Нийслэлийн бодлогын хэрэгжилтийг үнэлэхийн тулд, тогтвортой засаглалын Гүйцэтгэх чадвар хэсгийн G6-G8 үзүүлэлт болон Гүйцэтгэх хариуцлага хэсгийн G9-G13 шалгуур үзүүлэлтийг авч үзэх болно

График 4. Тогтвортой засаглалын шалгуур гүйцэтгэх чадвар





График 5. Тогтвортой засаглалын шалгуур гүйцэтгэх хариуцлага




SGI-ийн “Тогтвортой Засаглал” хэсэг нь гүйцэтгэх чадвар болон гүйцэтгэх хариуцлага гэсэн 2 үндсэн хэсэгт тус бүр 50 оноогоор үнэлэгдэнэ. Тогтвортой засаглалын индекс нь засгийн газрууд хэр үр дүнтэй ажиллаж байгааг судалдаг ба хэмжих үзүүлэлт бүр нь практик нотолгоонд буюу чанарын 40 үзүүлэлт дээр үндэслэн гаргадаг. Засгийн газар үйл ажиллагааныхаа хариуцлагыг хүлээх (“Гүйцэтгэх хариуцлага”) хэсэгт иргэд, хууль тогтоох байгууллага, нам, холбоод, хэвлэл мэдээлэл буюу засгийн газрын үйл ажиллагааг хянадаг оролцогчдод тулгуурладаг бол гүйцэтгэх чадавхийн хэмжигдэхүүн нь удирдах чадвар, бодлогын хэрэгжилт, институцийн сургалт гэсэн ангилалд тулгуурладаг. Бодлогын хэрэгжилтийн талаарх асуултууд нь засгийн газрын сайд, агентлаг холбогдох газруудад үүрэг даалгаврыг үр дүнтэй биелүүлэх чадварыг үнэлдэг. Гүйцэтгэх хариуцлагын хэмжүүр нь иргэд төрийн бодлогын талаар хэр мэдээлэлтэй байгаа, хууль тогтоох байгууллага нь гүйцэтгэх засаглалыг үнэлж, “шалгах” чадвартай эсэх зэргийг шалгах зорилготой. Уг тогтвортой засаглалын шалгуур үзүүлэлт нь улсын хэмжээнд үнэлдэг тул судлаачийн зүгээс нийслэлийг үнэлэх зорилгод нийцүүлэн асуултуудыг хөрвүүлэн ашигласан болно. Түүнчлэн гүйцэтгэх чадвар ангиллын “Удирдах чадвар” хэсэг нь бодлого боловсруулах эрх зүйн орчинтой хамааралтай байх тул энэ хэсэгт тус хэсгийн үнэлгээ болох G1-G5 ийг дурдахгүй болно.

3.3. СУДАЛГААНЫ ДАТА ЦУГЛУУЛАХ

Нийслэлийн бодлого боловсруулалт, төлөвлөлт

Нийслэлийн бодлого боловсруулалт, төлөвлөлт нь оновчтой, үр дүн нөлөөтэй эсэхийг үнэлэхийн тулд “Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван үндсэн чиглэл”-ийн зорилго, зорилтуудыг нэн тэргүүнд авч үзэх бөгөөд эдгээр нь нийслэлийн өмнө тулгамдаж буй нийгэм, эдийн засаг, хөгжлийн асуудлуудыг хэсэгчлэн болон бүрэн шийдвэрлэх арга зам





мөн эсэхэд дүн шинжилгээ хийх шаардлагатай. Тус баримт бичиг нь Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Хөгжлийн зорилтот хөтөлбөр болон нийслэлийн онцлогт тулгуурласан дунд хугацааны төлөвлөлтийн баримт бичиг юм.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 6.3.-т Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг нь дунд болон богино хугацааны бодлого, төлөвлөлтийн үндэс байна” гэж заасан буюу “Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван үндсэн чиглэл” нь “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-д тулгуурлан боловсруулагджээ. Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ын үр дүнг илэрхийлэх үзүүлэлтүүд, Монгол Улсын тогтвортой хөгжлийн зорилтууд нь агуулгаараа “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын хавсралтад тусгагдсан билээ. Дээрх бодлогын баримт бичгүүдийн уялдааг харвал, “Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван үндсэн чиглэл” болох дунд хугацааны төлөвлөлтийн баримт бичиг нь “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын зорилгыг биелүүлэхэд, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого” нь дэлхийн тогтвортой хөгжлийн 17 зорилго, 169 зорилтыг биелүүлэхэд тус тус чиглэсэн байна.

Олон улсын туршлагаас үзэхэд урт болон дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлт нь үр дүнд суурилсан байх гол шалгуурыг хангахад чиглэгддэг. Үр дүнд суурилсан бодлого, төлөвлөлт нь зорилго, зорилтуудыг юуны түрүүнд харилцан уялдаа холбоотой, оновчтой тодорхойлсон байхаас эхэлдэг. Иймд, нийслэлийн бодлого боловсруулалт, төлөвлөлт нь оновчтой, үр дүн нөлөөтэй эсэхийг үнэлэхийн тулд дээрх бодлогын баримт бичгүүдийн зорилго, зорилтуудын уялдаа холбоог дүгнэх шаардлагатай болж байна. Үүнийг шалгахын гол ач холбогдол нь бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтууд нь зорилгынхоо хүрээнд оновчтой, үр дүнтэй тусгагдсан эсэх буюу зорилгоо биелүүлэхэд чиглэгдэж буй эсэхийг шалгах үндсэн алхам болно. Үнэлэхдээ, Швед Улсын Стокгольмын байгаль орчны хүрээлэнгийн судлаачдын боловсруулсан “Тогтвортой хөгжлийн зорилтын уялдаа холбоо, нөлөөллийг үнэлэх- Матрицын арга”-ыг ашиглана. Уг аргачлал нь 2017 онд Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилтууд хоорондын уялдаа холбоог шалгахад ашигласан аргачлал бөгөөд улс орнууд тогтвортой хөгжлийн 17 зорилтыг өөрийн бодлогын баримт бичигтээ боловсруулан хэрэгжүүлэхэд явцад үүсч буй хийдэл, давхардал, нөлөөллийг тодорхойлоход зориулагдсан болно. Тус матрицын шинжилгээний аргын онцлог нь тоон мэдээллийн хүснэгттэй төстэй боловч үр дүн өгүүлбэрээр илэрхийлэгдэнэ. Энэхүү аргачлалыг Монгол Улсын үндэсний хөгжлийн газар 2018 онд Дэлхийн тогтвортой хөгжлийн үзэл баримтлал болон “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ын уялдааг хянахад ашигласан байна. Манай тохиолдолд, Дэлхийн тогтвортой хөгжлийн үзэл баримтлал болон “Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван үндсэн чиглэл”-ийн уялдааг хянах зорилгоор ашиглах болно. Учир нь бодлого хоорондын залгамж уялдаа, зорилтыг шалгахын тулд түүнийг боловсруулах шаардлага, хэрэгцээ буюу үндэслэл болсон эх баримт бичигтэй харьцуулалт хийх нь илүү үр дүнтэй, оновчтой болно.

Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилтууд болон “Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван үндсэн чиглэл”-ийн бодлогын зорилтуудын уялдааг харуулахад дээр дурдсан судлаачдын боловсруулсан дараах 7 түвшинтэй, эерэг болон сөрөг нөлөөллийн хүчийг хэмжих оноог ашиглана. Ингэснээр нийслэлийн бодлогод, тогтвортой хөгжлийн зорилтууд хэрхэн тусгагдсан эсхүл тусгагдаагүй болох, нийслэлийн бодлогоор тогтвортой хөгжлийн ямар зорилтуудыг хэрэгжүүлэх боломжтой эсхүл боломжгүй тухай мэдээллийг боловсруулах, түүнд дүн шинжилгээ хийх нөхцөл бүрдэнэ.



Хүснэгт 15. Зорилтуудын уялдааг шалгах онооны шалгуур үзүүлэлт

Оноо	Онооны агуулга
+3	Харьцуулж буй зорилтын хэрэгжилтэд шууд хүчтэй нөлөөтэй, уялдаатай.
+2	Харьцуулж буй зорилтыг хэрэгжүүлэхэд тус болно.
+1	Харьцуулж буй зорилтыг хэрэгжүүлэхэд яваандаа тус болно.
0	Эерэг болон сөрөг ямар нэг нөлөөг үзүүлэхгүй.
-1	Харьцуулж буй зорилтыг хэрэгжүүлэх сонголтуудыг хязгаарлана
-2	Харьцуулж буй зорилтуудыг хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлнө.
-3	Харьцуулж буй зорилтыг хэрэгжүүлэх боломжгүй болгоно, хүчтэй эсрэг нөлөөтэй.

Эх сурвалж: Nina Weitz, Hencik Carlsen, Mans Nilsson Kristain Skanberg , *Toward systematic and contextual priority setting for implementation the 2030 Agenda*, 2017.

Нийслэлийн бодлогын хэрэгжилт

Нийслэлийн бодлогын хэрэгжилт хэсгийн хүрээнд, SGI буюу (Sustainable governance indicators) "Тогтвортой засаглалын үзүүлэлтүүд"-ийг шалгуур үзүүлэлт болгон ашиглана. SGI нь үр дүнтэй бодлого боловсруулалтын сайн жишгийг тодорхойлох, дэмжих зорилготой улс хоорондын харьцуулсан судалгаа бөгөөд Эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага болон Европын холбооны гишүүн 41 улсыг тогтвортой засаглалын хүрээнд харьцуулан жил бүр судалгаа гаргадаг төсөл юм. SGI нь бодлогын хэрэгжилт, ардчилал, засаглал гэсэн 3 үндсэн цогц ойлголтод тулгуурладаг ба "Нийслэлийн бодлого боловсруулалт, төлөвлөлт, хэрэгжилт" сэдвийг засаглал ангиллын холбогдох дэд шалгуур үзүүлэлтээр үнэлэх нь тохиромжтой байна.

SGI нь шалгуур үзүүлэлт тус бүрээр 10 хүртэлх онооны үнэлгээ өгөхөд зориулсан асуулттай ба судлаачийн хариултаас хамааран өндөр буюу 9-10, дунд буюу 6-8, бага буюу 3-5, маш бага буюу 1-2 ангиллуудад хуваагдана. Иймд нийслэлийн бодлогын хэрэгжилтийг үнэлэхдээ, хүснэгтэд заасан 9,10 оноо өгөх шалгуурыг практикт тогтмол хэрэгжиж хэвшсэн, 8, 7, 6 оноог ихэвчлэн буюу 70-с дээш хувь, 5, 4, 3 оноог зарим тохиолдолд буюу 50-с дээш хувь, 2, 1 оноог практикт тогтмол хэрэгжиж хэвшээгүй тохиолдол гэж үзэн тус тус үнэлсэн болно.

SGI-ийн "Тогтвортой Засаглал" хэсэг нь гүйцэтгэх чадвар болон гүйцэтгэх хариуцлага гэсэн 2 үндсэн хэсэгт тус бүр 50 оноогоор үнэлэгдэнэ. Тогтвортой засаглалын индекс нь засгийн газрууд хэр үр дүнтэй ажиллаж байгааг судалдаг ба хэмжих үзүүлэлт бүр нь практикт нотолгоонд буюу чанарын 40 үзүүлэлт дээр үндэслэн гаргадаг. Засгийн газар үйл ажиллагааныхаа хариуцлагыг хүлээх ("Гүйцэтгэх хариуцлага") хэсэгт иргэд, хууль тогтоох байгууллага, нам, холбоод, хэвлэл мэдээлэл буюу засгийн газрын үйл ажиллагааг хянадаг оролцогчдод тулгуурладаг бол гүйцэтгэх чадавхийн хэмжигдэхүүн нь удирдах чадвар, бодлогын хэрэгжилт, институцийн сургалт гэсэн ангилалд тулгуурладаг. Бодлогын хэрэгжилтийн талаарх асуултууд нь засгийн газрын сайд, агентлаг холбогдох газруудад үүрэг даалгаврыг үр дүнтэй биелүүлэх чадварыг үнэлдэг. Гүйцэтгэх хариуцлагын хэмжүүр нь иргэд төрийн бодлогын талаар хэр мэдээлэлтэй байгаа, хууль тогтоох байгууллага нь гүйцэтгэх засаглалыг үнэлж, "шалгах" чадвартай эсэх зэргийг шалгах зорилготой. Уг тогтвортой засаглалын шалгуур үзүүлэлт нь улсын хэмжээнд үнэлдэг тул судлаачийн зүгээс нийслэлийг үнэлэх зорилгод нийцүүлэн асуултуудыг нийслэлийг үнэлэх үнэлгээнд хөрвүүлэн ашигласан болно. Тус үнэлгээний аргачлал нь дараах асуултад хариулах замаар нийт үнэлгээг өгөх үе шаттай.



Гүйцэтгэх чадварын үнэлгээ-33.345%

Нийслэлийн бодлогын хэрэгжилтийг үр дүнг үнэлэх G6 шалгуур- 16.665%

G6.1. Нийслэлийн Засаг даргын үр дүнтэй байдал /Government Effectiveness/

Асуулт: Нийслэлийн Засаг дарга бодлогын зорилтыг үр дүнтэй биелүүлж чадаж байна уу.

Тайлбар: Энэ асуултын хүрээнд Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хэрэгжилтийн гүйцэтгэлийг дүгнэхийг зорино. Тиймээс үнэлгээ нь Нийслэлийн Засаг даргаас тодорхойлсон бодлогын тэргүүлэх чиглэлүүдэд төвлөрч, зарласан зорилтууд хэрэгжиж байгаа эсэхийг шалгах ёстой.

Тус шалгуурын оноо нь нийт онооны 4.2% байна.

G6.2.a. Удирдлагын нийцэл /Ministerial Compliance/

Асуулт: Нийслэлийн Засаг даргын харьяа байгууллагын удирдлага нь Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааг хэрхэн дэмждэг вэ?

Тайлбар: Нийслэлийн Засаг даргын харьяа байгууллагын удирдлагын механизмид боловсон хүчин, бодлого, бүтэц зэрэг хүчин зүйлийг авч үздэг багтана.

Тус шалгуурын оноо нь нийт онооны 1.4% байна.

G6.2.b. Нийслэлийн Засаг даргад хяналт тавих /Monitoring Ministries

Асуулт: Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагаанд хэр үр дүнтэй хяналт тавьдаг вэ?

Тайлбар: Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь Нийслэлийн Засаг даргын бодлого боловсруулах, бодлого хэрэгжүүлэх үйл ажиллагаанд бодитойгоор хяналт тавьж ажиллаж байгаа эсэхийг энэхүү шалгуурын хүрээнд үнэлнэ.

Тус шалгуурын оноо нь нийт онооны 1.4% байна.

G6.2.c. Нийслэлийн Засаг даргын хяналт /Monitoring Agencies/Bureaucracies/


Асуулт: Нийслэлийн Засаг дарга харьяа байгууллагын үйл ажиллагаанд үр дүнтэй хяналт тавьдаг эсэх ?

Тайлбар: Нийслэлийн Засаг даргын зүгээс харьяа байгууллагын үйл ажиллагаанд үр дүнтэй хяналт тавих эрх зүйн орчин бүрдсэн эсэхийг энэхүү үзүүлэлтээр шалгадаг. Нийслэлийн Засаг дарганы хяналт тавихдаа хувийн ашиг сонирхлоос илүүтэй нийтийн ашиг сонирхлыг чухалчлах бөгөөд ингэснээр ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх эерэг үр нөлөөтэй.

Тус шалгуурын оноо нь нийт онооны 1.4% байна.

G6.3.a. Нийслэлийн төсөв, санхүүжилт /Task Funding/





Асуулт: Нийслэлийн бодлого, төлөвлөлтийг хэрэгжүүлэхэд зарцуулах төсвийг хэрхэн зохицуулдаг вэ?

Тайлбар: Нийслэлийн баталсан бодлого, төлөвлөлтийг биелүүлэхүйц хэмжээний төсвийг тухай бүр төсөвлөдөг эсэхийг үнэлнэ.

Тус шалгуурын оноо нь нийт онооны 1.4% байна.

G6.3.b. Нийслэлийн Засаг дарга бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжтой эсэх /Constitutional Discretion/

Асуулт: Нийслэлийн Засаг дарга бусад төрийн байгууллага, албан тушаалтны аливаа зөвшөөрлийг авахгүйгээр хуульд заасан чиг үүрэг/бүрэн эрхээ бие даан хэрэгжүүлэх боломжтой эсэх

Тайлбар: Нийслэлийн Засаг дарга хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхээ аливаа албан тушаалтнаас хараат бусаар хэрэгжүүлэх байдлыг энэхүү хэсэгт үнэлнэ.

Тус шалгуурын оноо нь нийт онооны 1.4% байна.

G6.3.c. Нийслэлээс бодлого, төлөвлөлтийг зохих стандартын дагуу боловсруулж, хэрэгжүүлдэг эсэх /National Standards/

Асуулт: Нийслэлээс бодлого, төлөвлөлтийг боловсруулах, батлахдаа хууль тогтоомжоор баталсан зохих стандартыг баримталдаг эсэх

Тайлбар: Энэхүү шалгуурын хүрээнд Нийслэлийн бодлого, төлөвлөлтийг боловсруулах, батлахдаа хууль тогтоомжид заасан бодлого боловсруулах аргачлал, стандартыг мөрддөг эсэхийг үнэлнэ.

Тус шалгуурын оноо нь нийт онооны 1.4% байна.

G6.4. Бодлого, төлөвлөгөөг хэрэгжүүлэх /Effective Regulatory Enforcement/

Асуулт: Нийслэлийн бодлого, төлөвлөгөөг үр дүнтэйгээр, бодитоор хэрэгжүүлж чадаж байгаа эсэх

Тайлбар: Энэхүү шалгуурын хүрээнд Нийслэлийн бодлого, төлөвлөгөөг холбогдох хугацааны дотор зохих ёсоор, бодитоор хэрэгжүүлж чадаж байгаа эсэхийг үнэлнэ.


Тус шалгуурын оноо нь нийт онооны 4.2% байна.

Үйл ажиллагааны нийцлийг үнэлэх G7 шалгуур-8.34%

G7.1. Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны нийцэл /Domestic Adaptability/

Асуулт: Нийслэлийн Засаг дарга төрийн эрх бүхий байгууллага, дээд шатны захиргааны байгууллагаас баталсан хөтөлбөр, бодлогын баримт бичигт өөрийн үйл ажиллагаа, баримт бичгийг нийцүүлж байгаа эсэх.





Тайлбар: Нийслэлийн Засаг дарга төрийн эрх бүхий байгууллага, дээд шатны захиргааны байгууллагаас баталсан хөтөлбөр, бодлогын баримт бичигт үйл ажиллагаагаа нийцүүлж чадаж байгаа эсэхийг үнэлнэ.

Тус шалгуурын оноо нь нийт онооны 4.15% байна.

G7.2. Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагаа олон улсын хөтөлбөр, чиг хандлага, үйл ажиллагаанд нийцэх /International Coordination/

Асуулт: Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагаа (бодлого, төлөвлөлт) нь олон улсын хөтөлбөр, үйл ажиллагаанд нийцэж байгаа эсэх

Тайлбар: Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагаа нь олон улсын хөтөлбөр, хамтын ажиллагааны хүрээнд Монгол Улсын зүгээс хэрэгжүүлж буй арга хэмжээний хүрээнд бодлого, төлөвлөлтөө нийцүүлж чадаж байгаа эсэхийг үнэлнэ.

Тус шалгуурын оноо нь нийт онооны 4.15% байна.

Институцийн өөрчлөлтийг үнэлэх G8 шалгуур-8.34%

G8. Бүтцийн өөрчлөлт хийх чадвар /Organizational Reform Capacity/

G8.1. Бүтцэд хяналт тавих /Self-monitoring/

Асуулт: Нийслэлийн Засаг дарга нь хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зохих бүтэц бүхий алба, агентлагтай эсэхэд хяналт тавих эрх бүхий байгууллага байгаа эсэх

Тайлбар: Нийслэлийн Засаг даргын харьяа агентлаг, байгууллага нь хуулиар хүлээсэн чиг үүргээ үр дүнтэйгээр хэрэгжүүлэх байдлаар зохион байгуулагдсан эсэхийг үнэлдэг эрх бүхий байгууллага байдаг эсэх, тус байгууллагаас тогтмол хяналт шалгалт хийж, тайлан, зөвлөмжийг холбогдох албан тушаалтанд хүргүүлж ажилладаг эсэхийг авч үзнэ.

Тус шалгуурын оноо нь нийт онооны 4.15% байна.

G8.2. Институцын өөрчлөлт

Асуулт: Нийслэлийн Засаг дарга засаглах арга хэлбэрээ тухай бүр шинэчилэн ажиллаж байгаа эсэх

Тайлбар: Нийслэлийн Засаг дарга бодлого, төлөвлөлтөд тусгасан зорилго, зорилтод хүрэхийн тулд өөрийн бүрэн эрхээ хэрэгжүүлэх, засаглах арга хэлбэрээ (императив, диспозитив зэрэг) тухай бүр шинэчилж чадаж байгаа эсэхийг энэхүү шалгуурын хүрээнд үнэлнэ.

Тус шалгуурын оноо нь нийт онооны 4.15% байна.

Гүйцэтгэх хариуцлагын үнэлгээ 50%

Иргэдийн оролцооны чадамжийг үнэлэх G9 шалгуур -12.5%

G9.1 Иргэдийн мэдээлэл авах боломж

Асуулт: Иргэд нийслэлийн бодлогын талаар мэдээлэл авах боломжтой эсэх

Тайлбар: Энэ асуултаар иргэд нийслэлийн бодлогын талаар мэдээлэл авах боломж хэр байгааг үнэлдэг. Иргэд бодлогын талаар өндөр түвшний мэдээлэлтэй байх ёстой. Тухайлбал, нийслэлийн бодлогын сэдэл, зорилго, үр нөлөө, үр дагаврыг иргэд ойлгох чадвартай байхыг хэлнэ.

Тус шалгуурын оноо нь нийт онооны 6.3% байна.

G9.2 Нээлттэй засаглал

Асуулт: Нийслэлийн захиргаа нь бодлогын хэрэгжилт, үр дүнгийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгдөг эсэх (тус мэдээллийг үндэслэн иргэд холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар хандах боломжтой эсэх)?

Тайлбар: Энэхүү асуултын хүрээнд нийслэл нь мэдээ, мэдээллийг иргэдэд хэрхэн хүргэж байгааг (жишээ нь: мэдээллийн олон талт байдал, нарийвчилсан байдал, нийтэлсэн цаг хугацаа, хүртээмжтэй эсэх, эрэлт хэрэгцээтэй байгаа эсэх) үнэлж байна. Мөн иргэдэд ээлтэй байдлаар (жишээ нь: мэдээ, мэдээллийн өгөгдлийн формат, мэдээлэлд хялбар хандах боломж, баримт бичигтэй танилцах зааварчилгаа, мэдээллийг үзэхэд ач холбогдолгүй, шаардлагагүй асуултуудгүй байх) байгаа эсэхийг үнэлнэ.

Тус шалгуурын оноо нь нийт онооны 6.2% байна.

Засгийн газрын хяналтын нөөцийг үнэлэх G10 шалгуур-12.5%

G10.1 Засгийн газрын хяналтын нөөц

Асуулт: Нийслэлийн бодлого үр дүнтэй хэрэгжиж буй эсэхэд хяналт тавих бие даасан нэгж, бүтэц Засгийн газарт байна уу?

Тайлбар: Нийслэлийн үйл ажиллагаанд үр дүнтэй хяналт тавихын тулд Засгийн газар хяналт, шинжилгээг хэрэгжүүлэх бие даасан нөөц, бүтэцтэй байх ёстой. Энэ нэгж, бүтэц нь нийслэлийн бодлогын хэрэгжилтийг үнэлэхэд шаардлагатай мэдээ, мэдээллээр Засгийн газрыг хангах хараат бус, бие даасан шинжтэй байна.

Тус шалгуурын оноо нь нийт онооны 2.5% байна.

G10.2. Бодлого, шийдвэрийн баримт бичигт хяналт тавих

Асуулт: Засгийн газар нийслэлээс баталсан бодлогын баримт бичгийг олж авахаар шаардах боломжтой юу?

Тайлбар: Засгийн газар нийслэлийн бодлогын баримт бичгийг хууль зүйн хувьд болон бодитойгоор олж авахад Засгийн газрын эрхийг хязгаарласан зохицуулалт бий эсэхийг үнэлнэ.

Тус шалгуурын оноо нь нийт онооны 2.5% байна.

G10.3. Засаг даргын оролцоо

Асуулт: Ерөнхий сайд Засгийн газрын хуралдаанд Засаг даргыг дуудаж сонсгол хийх боломж бий эсэх?

Тайлбар: Засаг даргыг Засгийн газрын хуралдаанд оролцуулж сонсгол хийх боломжтой эсэхийг хууль эрх зүйн хувьд болон практикийн хувьд үнэлнэ. Энэ асуудалд зөвхөн Засгийн газрыг авч үзэх бөгөөд тодорхой ажлын хэсгийн хуралдааныг авч үзэхгүй болно.

Тус шалгуурын оноо нь нийт онооны 2.5% байна.

G10.4. Мэргэжилтний оролцоог хангах

Асуулт: Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдаанаас шийдвэр гаргахад судлаач, мэргэшсэн шинжээч оролцуулах боломжтой юу?

Тайлбар: Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдаан хууль эрх зүйн хувьд судлаач, мэргэшсэн шинжээчдийг хуралдаанд оролцуулдаг эсэхийг дүгнэнэ. Энэ асуудалд зөвхөн Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлыг үнэлэх бөгөөд хурлын хороодыг үнэлэхгүй.

Тус шалгуурын оноо нь нийт онооны 2.5% байна.

G10.5. Нийцэлтэй байдал

Асуулт: Засаг дарга өөрийн харьяа агентлаг, байгууллагуудын чиг үүрэг, үйл ажиллагаанд үр дүнтэй хяналт тавих тогтолцоо бий эсэх?

Тайлбар: Засаг даргын харьяа агентлаг, байгууллагуудын үндсэн чиглэлийн уялдаа холбоог хянах, үйл ажиллагаа нь үр дүнтэй хэрэгжиж буй эсэхийг үнэлэх тогтвортой механизм бий эсэхийг үнэлнэ. Ингэж үнэлэхдээ, Засаг даргын харьяа агентлаг, байгууллагуудын үйл ажиллагааг үнэлэх, хяналт шинжилгээ, мониторинг хийх бүтэц, нэгж бий эсэхийг авч үзнэ. Энэ асуудалд зөвхөн байнгын үйл ажиллагаатай нэгжийг авч үзэх бөгөөд тодорхой асуудлыг шалгахар байгуулсан түр нэгжийг авч үзэхгүй.

Тус шалгуурын оноо нь нийт онооны 2.5% байна.

Хэвлэл мэдээллийн байгууллагын оролцоог үнэлэх G11 шалгуур-6.3%

G11.1. Хэвлэл мэдээллийн байгууллагын оролцоо

Асуулт: Хэвлэл мэдээллийн байгууллагууд Нийслэлийн бодлогын үндэслэл, нөлөөллийн талаар хэр дүн шинжилгээ хийдэг вэ?

Тайлбар: Энэхүү асуулт нь хэвлэл мэдээллийн хэрэгслээр цаг тухайд нь, нөхцөл байдалд нийцүүлсэн мэдээлэл, дүн шинжилгээ, суурь мэдээллээр олон нийтэд нийслэлийн бодлогын үндэслэл, үр нөлөөг шүүмжлэлтэй үнэлэх боломжийг хангаж байгаа эсэхийг үнэлэхийг зорьдог.

Тус шалгуурын оноо нь нийт онооны 6.3% байна.



Харилцаа холбоог үнэлэх G12 шалгуур-6.3%

G12.1. Нийслэлийн Засаг даргын шийдвэр гаргалт

Асуулт: Нийслэлийн Засаг дарга шийдвэр гаргах үйл явц хэр хүртээмжтэй, нээлттэй байна вэ?

Тайлбар: Нийслэлийн Засаг дарга өөрийн эрх хэмжээний хүрээнд хууль тогтоомжид нийцүүлэн бодлого боловсруулах, батлахдаа иргэд, олон нийтэд нээлттэй байж чаддаг эсэхийг энэхүү шалгуурын хүрээнд үнэлнэ.

Тус шалгуурын оноо нь нийт онооны 2.1% байна.

G12.2. Бизнес эрхлэгчийн оролцоо

Асуулт: Бизнес эрхлэгч буюу ашгийн төлөө үйл ажиллагаа явуулж буй иргэн, хуулийн этгээд өөрийн эдийн засгийн ашиг сонирхлын хүрээнд бодлогын төсөл боловсруулан Нийслэлийн Засаг даргад уламжлах боломжтой эсэх

Тайлбар: Нийслэлд үйл ажиллагаа явуулж буй бизнес эрхлэгч, сонирхлын бүлгээс өөрийн эдийн засгийн ашиг сонирхлын хүрээнд бодлогын төсөл боловсруулж, түүнийгээ Нийслэлийн Засаг даргад уламжлах чадвар хууль тогтоомжоор олгогдсон эсэхийг үнэлнэ.

Тус шалгуурын оноо нь нийт онооны 2.1% байна.

G12.3. Төрийн бус байгууллага/олон нийтийн байгууллагын оролцоо

Асуулт: Төрийн бус байгууллага/олон нийтийн байгууллага тодорхой асуудлаар бодлогын төсөл томьёолж, эрх бүхий этгээдэд уламжлах боломжтой эсэх

Тайлбар: Нийслэлийн чиг үүргийн хүрээнд нийгмийн бүлэг, байгаль орчны бүлэг эсхүл шашны бүлгээс тодорхой чиглэлээр бодлого томьёолж, Нийслэлд уламжлах эрх зүйн боломжтой эсэхийг энэхүү шалгуурын хүрээнд үнэлнэ.

Тус шалгуурын оноо нь нийт онооны 2.1% байна.

Бие даасан, хараат бус хяналтын байгууллагуудыг үнэлэх G13 шалгуур-12.5%

G13.1. Хяналт-шинжилгээ, үнэлгээ

Асуулт: Нийслэлийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх хараат бус, хөндлөнгийн бие даасан аудитын бүтэц байдаг уу?

Тайлбар: Энэ асуултын хүрээнд нийслэлийн үйл ажиллагааг хянах, үнэлэх систем бий эсэхийг үнэлнэ. Үүнд нийслэлийн хөрөнгө, бодлого, төсөвтэй холбоотойгоос гадна холбогдох байгууллагын үйл ажиллагаа хууль тогтоомж, гэрээнд нийцэж байгаа эсэхэд хяналт-шинжилгээ хийх хамаарна.

Тус шалгуурын оноо нь нийт онооны 4.2% байна.

G13.2. Зөвлөх байгууллага



Асуулт: Нийслэлийн Засаг даргын шийдвэр гаргалтад зөвлөх чиг үүрэг бүхий бие даасан байгууллагын бүтэц байдаг эсэх?

Тайлбар: Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэх чиг үүргийн хүрээнд иргэдээс ирүүлсэн санал, хүсэлтийг хүлээн авч, түүнийг олон нийтэд нээлттэй танилцуулах, хүсэлтийг шийдвэрлэх ажиллагааг эхлүүлэх эрх бүхий байгууллага Нийслэлийн Засаг даргын зохион байгуулалтын бүтцэд байгаа эсэхийг авч үзнэ.

Тус шалгуурын оноо нь нийт онооны 4.2% байна.

G13.3. Мэдээллийн аюулгүй байдал, нууцлал

Асуулт: Мэдээллийн хамгаалалт, нууцлалын асуудлыг үр дүнтэй хариуцдаг бие даасан эрх бүхий байгууллага бий эсэх?

Тайлбар: Нийслэлийн хэрэгжүүлэхээр төлөвлөж буй үйл ажиллагаа, бодлого, шийдвэртэй холбоотой нууцын зэрэглэл бүхий мэдээлэл, өгөгдлийг хамгаалах, шийдвэрийг нууцлах газар байгаа эсэхийг үнэлнэ.

Тус шалгуурын оноо нь нийт онооны 4.2% байна.

3.4. СУДАЛГААНЫ ДАТА БОЛОВСРУУЛАЛТ, ИНДЕКСЖҮҮЛЭХ

Нийслэлийн бодлого боловсруулалт, төлөвлөлт

Хүснэгт 16. “Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилт” ба “Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван үндсэн чиглэл”-д тусгагдсан зорилго, зорилтын нийцлийг шалгах хүснэгт.

“НИЙСЛЭЛИЙГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ҮНДСЭН ЧИГЛЭЛ”-Д ТУСГАГДСАН ЗОРИЛГО		
Зорилгын хүрээнд дэвшүүлсэн зорилт	Хүрэх үр дүн	Үнэлгээ/ Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилт
НЭГ. ҮНДСЭНИЙ НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛ		
Зорилго.1 Хүмүүнлэг, оюунлаг иргэдийг бэлтгэн хотын соёлыг түгээн дэлгэрүүлэх		
Зорилт 1.1. Үндэсний эв нэгдэл, Монгол өв соёлыг сурталчилсан соёлын олон талт ажил зохион байгуулна.	1.1.1. Урлагийн төрөл зүйлийг хөгжүүлэх замаар, иргэд, олон нийт болон гадаадын жуулчдад сурталчлан таниулах ажлыг эрчимжүүлж, үндэсний агуулга шингэсэн бүтээлийн тоог нэмэгдүүлсэн байна. 1.1.2. Нийслэлийн нутаг дэвсгэрт байгаа түүх, соёлын дурсгалт зүйлсийг хамгаалалтад авч, сэргээн засварласан байна. 1.1.3. Нийслэлийн нутаг дэвсгэрт байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалуудыг QR кодоор танилцуулах аппликэйшн бүтээж, хэрэглээнд нэвтрүүлсэн байна. 1.1.4. Улаанбаатар хотын нийтийн төв номын сан, салбар номын сангуудын хүртээмж нэмэгдсэн байна.	+2 Зорилт 11.4 Дэлхийн соёлын болон байгалийн өвийг хадгалан хамгаалах арга хэмжээг сайжруулах

<p>Зорилт 1.2. Хүмүүнлэг, оюунлаг хотын иргэдийг бэлтгэхэд боловсрол, соёлын байгууллагын хамтын ажиллагааг өрнүүлж, “Хотын соёл”-ыг төлөвшүүлнэ.</p>	<p>1.2.1. Хотын соёлыг төлөвшүүлэх нөлөөллийн ажлуудыг зохион байгуулсан байна.</p>	<p>+2 Зорилт 4.7 2030 он гэхэд тогтвортой хөгжлийн мэдлэг, тогтвортой амьдралын хэв маяг, хүний эрх, жендерийн тэгш байдал, энх тайван болон хүч үл хэрэглэх соёлыг төлөвшүүлэх, дэлхийн иргэн байх, соёлын олон янз байдал болон тогтвортой хөгжилд соёлын оруулж буй хувь нэмрийг ойлгуулах мэдүүлэх замаар тогтвортой хөгжлийг хөхүүлэх дэмжихэд шаардлагатай мэдлэг, ур чадварыг бүх суралцагчдад олгох.</p>
<p>ХОЁР.ХУВЬ ХҮНИЙ ХӨГЖИЛ</p> <p>Зорилго.2 Хүн амыг эрүүл сайхан амьдрах нөхцөлөөр ханган, чанартай боловсролыг тэгш хүртээмжтэй хүргэж, зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжин, өндөр мэдлэг чадвартай, ёс суртахуунтай хариуцлагатай, тогтмол орлоготой, бүтээлч, нийслэлийн иргэдийг төлөвшүүлнэ.</p>		
<p>Зорилт 2.1. Ерөнхий боловсролын сургууль болон сургуулийн өмнөх боловсролын байгууллагыг мэргэжлийн багшаар бүрэн хангана.</p>	<p>2.1.1. Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багшлах боловсон хүчний нөөцийн судалгааг нарийвчлан гаргаж, багшийг мэргэшүүлэх, давтан сургах замаар ур чадварыг дээшлүүлсэн байна. 2.1.2. Багшийн хөгжлийг дэмжин ажлын үр дүнгээр индексийн урамшуулал олгоно. 2.1.3. Боловсролын байгууллагын өөрийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, дэмжих, багш, ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх бодлого баримтална.</p>	<p>+2 Зорилт 4.1 2030 он гэхэд бүх эрэгтэй, эмэгтэй хүүхдүүд үнэ төлбөргүй, тэгш, чанартай бага болон дунд шатны боловсролыг эзэмшиж, холбогдох, үр дүнтэй эрдэм мэдлэгтэй болсон байх. Зорилт 4.с 2030 он гэхэд хөгжиж буй орнууд, ялангуяа нэн буурай хөгжилтэй болон жижиг арлын хөгжиж буй улс орнуудад багш бэлтгэх сургалтын чиглэлийн олон улсын хамтын ажиллагаагаар дамжуулан дадлага туршлагатай багш нарын хангамжийг нэмэгдүүлэх.</p>
<p>Зорилт 2.2. Хүүхэд бүрийг сургуулийн өмнөх боловсролд хамрагдах, бага боловсрол эзэмшихэд бэлтгэх нөхцөлөөр хангана.</p>	<p>2.2.1. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын барилга, байгууламжийг үе шаттай нэмэгдүүлэх замаар бүлэг дүүргэлтийг стандарт хэмжээнд хүргэсэн байна.</p>	<p>+1 Зорилт 4.2 2030 он гэхэд бүх эрэгтэй, эмэгтэй хүүхдүүдийг бага боловсролд бэлтгэж бага насны хүүхдүүдийг хөгжүүлэх чанартай үйлчилгээ, тусламж, сургуулийн өмнөх боловсролоор хангах</p>

<p>Зорилт 2.3. Хүүхэд бүрийг төлбөргүй, тэгш, чанартай бага болон суурь боловсрол эзэмших нөхцөлөөр хангана.</p>	<p>2.3.1. Ерөнхий боловсролын сургуулийн барилга, байгууламжийг үе шаттай нэмэгдүүлж, бүлэг дүүргэлтийг стандарт түвшинд хүргэсэн байна. 2.3.2. Сургууль дээрх болон хичээлээс гадуурх сургалтын үйл ажиллагааг дэмжих замаар хүүхдийн авьяас, чадварыг хөгжүүлсэн байна. 2.3.3. Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн агуулгын хүрээнд цахим хичээлийн иж бүрэн сан бүрдүүлж, зайн сургалтын үйл ажиллагааг дэмжинэ.</p>	<p>+1 Зорилт 4.1 2030 он гэхэд бүх эрэгтэй, эмэгтэй хүүхдүүд үнэ төлбөргүй, тэгш, чанартай бага болон дунд шатны боловсролыг эзэмшиж, холбогдох, үр дүнтэй эрдэм мэдлэгтэй болсон байх.</p>
<p>Зорилт 2.4. Боловсролын байгууллагуудыг хүүхэд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ээлтэй, жендэрийн мэдрэмжтэй болгон хөгжүүлж, хүн бүрийг аюулгүй, хүртээмжтэй, үр дүнтэй суралцах орчин нөхцөлөөр хангана.</p>	<p>2.4.1. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын харилцан адилгүй байдал, ялгаатай хэрэгцээг тодорхойлж, сурагчдад зориулсан түгээмэл загвар, тохирох хэрэглэгдэхүүн бүхий орчин нөхцөл бүрдүүлсэн байна. 2.4.2. Ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийг эрүүл баталгаат хоол, хүнсээр хангах нөхцөлийг бүрдүүлсэн байна. 2.4.3. Мэргэжлийн байгууллагатай хамтран суралцагчдыг зам тээврийн осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ.</p>	<p>+1 Зорилт 4.а Хүүхэд, хөгжлийн бэрхшээл, жендэрийн мэдрэмжтэй боловсролын байгууллагыг бэхжүүлэн сайжруулж, хүн бүрийг аюулгүй, хүртээмжтэй, үр дүнтэй суралцах орчноор хангах. Зорилт 3.6 2020 он гэхэд замын хөдөлгөөний ослын улмаас нас барсан, гэмтэж бэртсэн хүний тоог хоёр дахин бууруулах</p>
<p>Зорилт 2.5. Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, эмчлэх замаар халдварт бус өвчнөөс үүдэлтэй нас баралтын хувийг бууруулна.</p>	<p>2.5.1. Халдварт бус өвчний эрт илрүүлэг, оношилгоо, эмчилгээ сайжирсан байна. 2.5.2. Дүүрэг бүрд эрэгтэйчүүдийн кабинет байгуулагдсан байна. 2.5.3. Эрүүл мэндийг дэмжих төвийг 8 дүүрэгт байгуулсан байна.</p>	<p>+1 Зорилт 3.4 2030 он гэхэд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, түүнийг эмчлэх замаар халдварт өвчнөөс үүдэлтэй цаг бусаар нас барах явдлыг гуравны нэгээр бууруулах</p>
<p>Зорилт 2.6. Халдварт өвчнөөс сэргийлэх, илрүүлэх, хянах, тандах, эмчлэх үйл ажиллагааг сайжруулан, өвчлөлийг бууруулна.</p>	<p>2.6.1. БЗДХ/ДОХ, сүрьеэ, халдварт гепатит болон бусад халдварт өвчний илрүүлэлтийг нэмэгдүүлж, эмчилгээнд бүрэн хамруулсан байна. 2.6.2. Товлолт дархлаажуулалтын хувийг нэмэгдүүлэх замаар тарилгаар сэргийлэгдэх халдварт өвчний тохиолдол буурсан байна.</p>	<p>+1 Зорилт 3.3 2030 он гэхэд ДОХ, сүрьеэ, хумхаа өвчний тархалтыг дарах, элэгний үрэвсэл, усаар дамжин халдварладаг өвчин, бусад халдварт өвчинтэй тэмцэх</p>
<p>Зорилт 2.7. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тогтолцоог бий болгоно.</p>	<p>2.7.1. Дүүрэг бүрд “Нийгмийн эрүүл мэндийн төв”-ийг байгуулсан байна</p>	<p>+1 Зорилт 3.8 Хүн бүрт эрүүл мэндийн үйлчилгээ, түүний дотор санхүүгийн эрсдэлийн хамгаалалт, нэн шаардлагатай чанартай эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, аюулгүй, үр дүнтэй, чанартай,</p>

		боломжийн үнэтэй нэн шаардлагатай эм, вакциныг хүртээмжтэй хүргэх.
Зорилт 2.8. Эх, хүүхдийн эндэгдлийг бууруулна.	2.8.1. Эх, хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, эндэгдлийг бууруулна.	+1 Зорилт 3.1 2030 он гэхэд 100,000 амьд төрөлт тутамд эхийн эндэгдлийн түвшнийг 70-аас доош болгон бууруулах Зорилт 3.2 2030 он гэхэд урьдчилан сэргийлэх боломжтой нялхсын болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг арилгах
Зорилт 2.9. Гэр бүл төлөвлөлт, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүн бүрд хүргэнэ.	2.9.1. Өсвөр насны хүүхдийн урьдчилан сэргийлэх үзлэгийг сайжруулж, эрүүлжүүлнэ. 2.9.2. Нөхөн үржихүйн насны зорилтот бүлгийн эмэгтэйчүүдийн жирэмснээс сэргийлэх арга хэрэглээг нэмэгдүүлэх, гэр бүлийн боловсрол олгох ажлыг эрчимжүүлнэ.	+1 Зорилт 3.7 2030 он гэхэд гэр бүл төлөвлөлт, мэдээлэл, мэдлэг өгөх, нөхөн үржихүйн эрүүл мэндийн асуудлыг үндэсний бодлого, хөтөлбөр тусгах зорилгоор бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүн бүрт хүргэх
Зорилт 2.10. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын бэлэн байдал, хариу арга хэмжээний тогтолцоог бэхжүүлнэ	2.10.1. Шаардлагатай хүний болон эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн нөөц, бэлэн байдал хангагдсан байна.	+1 Зорилт 3.8 Хүн бүрт эрүүл мэндийн үйлчилгээ, түүний дотор санхүүгийн эрсдэлийн хамгаалалт, нэн шаардлагатай чанартай эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, аюулгүй, үр дүнтэй, чанартай, боломжийн үнэтэй нэн шаардлагатай эм, вакциныг хүртээмжтэй хүргэх.
Зорилт 2.11. Хотын хүн амыг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, тэр дундаа нэн шаардлагатай эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг чанартай хүргэж, аюулгүй, үр дүнтэй, нэн хэрэгцээтэй эм, вакцинаар ханган, эрүүл мэндийн даатгалд бүрэн хамруулна.	2.11.1. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлсэн байна. 2.11.2. Стандартын шаардлага хангасан байртай өрхийн эрүүл мэндийн төвийн тоог нэмэгдүүлж, үйлчилгээний хүртээмж, хүчин чадлыг сайжруулна.	+1 Зорилт 3.8 Хүн бүрт эрүүл мэндийн үйлчилгээ, түүний дотор санхүүгийн эрсдэлийн хамгаалалт, нэн шаардлагатай чанартай эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, аюулгүй, үр дүнтэй, чанартай, боломжийн үнэтэй нэн шаардлагатай эм, вакциныг хүртээмжтэй хүргэх.
Зорилт 2.12. Гэр бүлийн боловсрол, хөгжил, төлөвлөлтийг хийж, гэр бүлийн тогтвортой байдлыг хангана.	2.12.1. Гэр бүлийн боловсрол, хөгжлийг дэмжих замаар эцэг эхийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлж, гэр бүлийн тогтвортой байдлыг хангасан байна	+1 Зорилт 3.7 2030 он гэхэд гэр бүл төлөвлөлт, мэдээлэл, мэдлэг өгөх, нөхөн үржихүйн эрүүл мэндийн асуудлыг үндэсний бодлого,



		хөтөлбөр тусгах зорилгоор бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүн бүрт хүргэх
Зорилт 2.13. Эмэгтэйчүүд, охидыг ялгаварлан гадуурхах болон хууль бус наймаа, бэлгийн мөлжлөг зэрэг хүчирхийллийн бүх хэлбэрийг устгана.	2.13.1. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх олон талт хамтын ажиллагааг өргөжүүлж, гэр бүлийн хүчирхийллийг бууруулсан байна	+1 Зорилт 5.1 Бүх эмэгтэйчүүд, охидыг ялгаварлан гадуурхах явдлыг таслан зогсоох. Зорилт 5.2 Албан болон хувийн хүрээнд бүх эмэгтэйчүүд, охидыг хүчирхийлэх, түүний дотор хүний хулгай наймаанд өртөх, бэлгийн болон бусад хэлбэрээр дарлах мөлжих явдлыг таслан зогсоох Зорилт 16.1 Хүчирхийллийн бүх хэлбэр, нас баралтын холбогдолтой түвшнийг үлэмж хэмжээгээр бууруулах
Зорилт 2.14. Хүүхдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрийг зогсооно.	2.14.1. Хүүхдийн эрхийг хангахад эцэг, эх, олон нийтийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлж, хяналтыг сайжруулсан байна. 2.14.2. Хүүхэд ажиллуулахыг хориглосон ажлын байранд хүүхэд ажиллуулахыг таслан зогсооно. 2.14.3. Эцэг, эхийн хараа хяналт сул, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг эрт илрүүлэх, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний хяналтыг сайжруулсан байна. 2.14.4. Урьдчилан сэргийлэх замаар хүүхдийн эсрэг хүчирхийллийг бууруулсан байна. 2.14.5. Улаанбаатар хотын хүүхдэд ээлтэй байдлын индексийг тогтоож, индексийн үзүүлэлтийг сайжруулсан байна.	+1 Зорилт 16.2 Хүүхэдтэй зэрлэгээр харьцах, тэднийг мөлжих, наймаалах, тамлан зовоох, хүүхдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрийг зогсоох устгах. Зорилт 8.7 Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг хориглох, устгахад чиглэлээр шуурхай, үр дүнтэй арга хэмжээ авч, албадан хөдөлмөр хийлгэх явдлыг арилгаж, бүх хэлбэрийн хүүхдийн хөдөлмөр, түүний дотор хүүхдийг цэрэг болгон элсүүлэх, ашиглах явдлыг 2025 он гэхэд эцэс болгох
Зорилт 2.15. Хотын хүн амыг зохистой ажлын байраар ханган бүрэн хөдөлмөр эрхлэлтэд хамруулж, адил үнэлэмжтэй ажилд адил цалин хөлс олгох, хөдөлмөр, боловсрол, сургалтад хамрагдах залуучуудын хувийг нэмэгдүүлнэ.	2.15.1. Шинээр ажлын байр бий болгосон ажил олгогчдыг дэмжин, иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлсэн байна. 2.15.2. “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв”-ийг олон улсын жишигт нийцүүлж, бүсчилсэн байдлаар хөгжүүлж, хөдөлмөр эрхлэлтийн цогц үйлчилгээг хүргэсэн байна. 2.15.3. Хөдөлмөр эрхлэлтийн сургалт, мэргэжлийн болон давтан сургалтыг бүрэн дунд, түүнээс доош	+1 Зорилт 8.5 2030 он гэхэд эрэгтэй, эмэгтэй бүх хүн, түүний дотор залуу болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бүрэн, бүтээмжтэй ажил, зохистой хөдөлмөр эрхлүүлж, адил үнэ цэнэтэй ажилд адилхан цалин хөлс олгох



	боловсролтой, мэргэжилгүй, ажлын туршлагагүй залуу ажиллах хүчинд чиглүүлэн зохион байгуулсан байна.	
Зорилт 2.16. Угийн бичиг хөтлөлтийг дэлгэрүүлэн таниулна.	2.16.1. Нийслэлийн айл өрхүүдийн угийн бичиг хөтлөлтийг нэмэгдүүлсэн байна.	-
ГУРАВ.АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА		
Зорилго.3 Нийгмийн хамгааллын үйлчилгээг зорилтот бүлэгт чиглүүлж, албан бус салбарт ажиллагсдыг албан салбарт шилжүүлж, нийгмийн даатгалын тогтолцооны шинэчлэлтийг хэрэгжүүлэн ажиллана.		
Зорилт 3.1. Өрхийн амьжиргааны түвшинг тогтоох шинэчилсэн аргачлалын дагуу өрхийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж, үр дүнд тулгуурлан нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт чиглүүлнэ.	3.1.1. Зорилтот өрхийг оновчтой тодорхойлж, халамжийн үйлчилгээнд хамруулсан байна..	+2 Зорилт 1.3 Үндэсний онцлогт тохирсон нийгэм хамгааллын тогтолцоо, бүх хүнд зориулсан нийгэм хамгааллын арга хэмжээ, түүний дотор нийгэм хамгааллын үндсэн үйлчилгээг нэвтрүүлж, түүнд ядуу, эмзэг бүлгийн дийлэнх хэсгийг 2030 он гэхэд хамруулах
Зорилт 3.2. Нийгмийн харилцаанаас тусгаарлагдаж болзошгүй иргэдийг нийгмийн хамгааллын суурь үйлчилгээнд хамруулан, орлогын эх үүсвэртэй болох нөхцөлийг бүрдүүлнэ	3.2.1. Нийгмийн харилцаанаас тусгаарлагдаж болзошгүй иргэдийг амьдралын зөв дадал хэвшилд сургаж, нийгмийн суурь үйлчилгээнд хамруулсан байна.	+2 Зорилт 1.3 Үндэсний онцлогт тохирсон нийгэм хамгааллын тогтолцоо, бүх хүнд зориулсан нийгэм хамгааллын арга хэмжээ, түүний дотор нийгэм хамгааллын үндсэн үйлчилгээг нэвтрүүлж, түүнд ядуу, эмзэг бүлгийн дийлэнх хэсгийг 2030 он гэхэд хамруулах
Зорилт 3.3. Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжин цагийн ажлын тогтолцоог бий болгоно.	3.3.1. Оюутан, залуучуудын цагийн ажил хийх нөхцөлийг бүрдүүлсэн байна. 3.3.2. Залуучуудыг бизнес эрхлэх сургалт, арга хэмжээнд хамруулан, гарааны бизнес эрхлэлтийг дэмжинэ. 3.3.3. Залуучуудын хөгжлийн төвөөр дамжуулан хувь хүний хөгжлийг дэмжиж, амьдрах ухааны чадвар эзэмшүүлнэ.	+2 Зорилт 4.4 2030 он гэхэд ажил эрхлэх, зохистой хөдөлмөр, хувийн бизнес эрхлэх холбогдох ур чадвартай, түүний дотор техник, мэргэжлийн ур чадвартай залуучууд, насан хүрэгсдийн тоог нэмэгдүүлэх
Зорилт 3.4. Бүтээмжтэй үйл ажиллагаа, зохистой ажлын байр, инновацийг дэмжин санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх замаар аж ахуй, бичил, жижиг, дунд бизнесүүдийг албан хэвшилд шилжүүлж, өсөлтийг дэмжинэ.	3.4.1. Бичил бизнес эрхлэгчдийг жижиг бизнес эрхлэгч болгох суурь нөхцөл бүрдсэн байна. 3.4.2. Албан бус эдийн засгийн салбарт ажиллагсдыг албан салбарт шилжүүлж зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн байна. 3.4.3. Тогтвортой үйл ажиллагаа эрхэлж, ажлын байраа хадгалсан, шинэ ажлын байр бий болгосон бичил, жижиг, дунд үйлдвэр эрхлэгч, ажил олгогчдыг дэмжин, үйл ажиллагааг өргөжүүлэн	+1 Зорилт 8.3 Бүтээмжтэй үйл ажиллагаа, зохистой ажлын байр бий болгох, аж ахуй эрхлэх, бүтээлч байдал, инновацийг дэмждэг хөгжлийн чиг баримжаатай бодлогыг хөхүүлэн дэмжиж, санхүүгийн үйлчилгээг хүртээмжтэй болгох замаар бичил, жижиг, дунд



	ажилласан байна. 3.4.4. Бичил, жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг гадаад, дотоодын зах зээлд гаргахад дэмжлэг үзүүлэн, борлуулалтын зах зээлийг өргөтгөх, нэмэгдүүлэхэд хамтран ажилласан байна.	бизнесийг албан ёсны болгож, тэдгээрийн өсөлтийг дэмжих
Зорилт 3.5. Биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцөлийг сайжруулж, иргэдэд үзүүлэх үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.	3.5.1. Нийслэлийн хүн амд үзүүлэх биеийн тамир, спортын үйлчилгээний чанар сайжирсан байна. 3.5.2. Дүүрэг, хороод болон шинэ дагуул хот, шинэ дэд төвүүдэд биеийн тамир, спортын барилга байгууламжийг норм, стандартын дагуу барьж байгуулсан байна. 3.5.3. Нийслэлийн иргэдийн дунд биеийн тамир, спортын арга хэмжээнүүдийг зохион байгуулснаар оролцоог нэмэгдүүлсэн байна. 3.5.4. Нийслэлд спортын төрлүүдийг хөгжүүлж, тамирчдын залгамж халааг тасралтгүй бэлтгэдэг болсон байна. 3.5.5. Нийслэл Улаанбаатар хотноо олон улсын спортын наадмыг зохион байгуулж дэлхийд сурталчлан, таниулах ажлыг шат дараатай зохион байгуулсан байна	-
ДӨРӨВ. ЭДИЙН ЗАСАГ		
Зорилго. 4 Инновацид тулгуурласан өрсөлдөх чадвартай үйлдвэрлэл, үйлчилгээ, хөрөнгө оруулалт, оюуны бөөгнөрлийг дэмжиж, бүтээлч, бие даасан, тогтвортой, эдийн засагтай хот болох суурийг бэлдэнэ		
Зорилт 4.1. Нийслэлийн орлогын эх үүсвэрүүдийг нэмэгдүүлж, эрсдэл даах чадвартай бие даасан эдийн засгийг бүрдүүлнэ.	4.1.1. Нийслэлийн өмчийн хөрөнгийг эргэлтэд оруулж, өмч ашиглалтын үр өгөөжийг нэмэгдүүлсэн байна. 4.1.2. Хөрөнгө оруулалтын сан байгуулах, үнэт цаас гаргах ажлыг хэрэгжүүлсэн байна. 4.1.3. Төсвийн хөрөнгийг эдийн засаг, нийгмийн хөгжилд чиглүүлсэн, үр ашигтай, хариуцлагатай төлөвлөж, сахилга батыг сайжруулсан байна. 4.1.4. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн оновчтой хэлбэрт тулгуурлан, эрх ашгийг хамгаалж, хувийн хэвшлийн санаачилгыг дэмжиж ажилласан байна. 4.1.5 Төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан дотоодод үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний худалдан авалтыг дэмжсэн байна. 4.1.6. Татвар ногдуулах, хураах үйл ажиллагаанд технологийн дэвшил нэвтрүүлэн, хялбаршуулсан байна. 4.1.7. Олон улсын байгууллага, хөгжлийн түншлэгч орон, олон улсын банк санхүүгийн байгууллагатай хамтран хэрэгжүүлж буй хотын	+2 Зорилт 8.2 Эдийн засгийг төрөлжилт, технологийн шинэчлэл, инновациар дамжуулан, түүний дотор өндөр өртөг шингэсэн, ажиллах хүч ихээр шаарддаг салбаруудад голлон анхаарч эдийн засгийн бүтээмжийн өндөр түвшинд хүрэх Зорилт 12.7 Үндэсний бодлого, тэргүүлэх чиглэлтэй нийцүүлэн тогтвортой байдалд чиглэсэн төрийн худалдан авах ажиллагааг дэмжих Зорилт 11.а Үндэсний болон бүс нутгийн хөгжлийн төлөвлөлтийг сайжруулах замаар хот, хагас суурин газар, хөдөө орон нутгийн хооронд эдийн засаг, нийгэм, байгаль орчны үр



	хөгжлийн томоохон төсөл, хөтөлбөрүүдийн ил тод, үр ашигтай хамтын ажиллагааг өргөжүүлсэн байна.	дүнтэй уялдаа холбоо дэмжих. Зорилт 8.2 Эдийн засгийг төрөлжилт, технологийн шинэчлэл, инновациар дамжуулан, түүний дотор өндөр өртөг шингэсэн, ажиллах хүч ихээр шаарддаг салбаруудад голлон анхаарч эдийн засгийн бүтээмжийн өндөр түвшинд хүрэх
Зорилт 4.2. Инновацыг хотын тогтвортой хөгжлийн үндсэн хүчин зүйлсийн нэг болгон хөгжүүлнэ.	4.2.1. Инновац, энтрепренёршипт оролцох боломжийг нэмэгдүүлсэн байна. 4.2.2. Салбар дундын хамтын ажиллагааг өргөжүүлж, инновацыг дэмжих дэд бүтцийг хөгжүүлсэн байна. 4.2.3. Инновацын судалгаа, хөгжүүлэлтийг эдийн засгийн хөшүүргээр дэмжихэд санаачилга гарган ажилласан байна. 4.2.4. Нийслэлийн тулгамдсан асуудлыг шийдэхэд иргэдийн дэвшүүлсэн инновацлаг санааг дэмжиж, оролцоог нэмэгдүүлсэн байна.	+2 Зорилт 9.5 Бүх улс орнууд, ялангуяа хөгжиж буй орнуудын технологийн чадавхыг дээшлүүлэх, шинжлэх ухааны судалгаа шинжилгээний ажлыг сайжруулах, түүний дотор 2030 он гэхэд инновацийг дэмжих, 1 сая хүн ногдох судалгаа-хөгжлийн ажилтны тоог нэмэгдүүлэх, судалгаа-хөгжилд зарцуулах төр, хувийн хэвшлийн зардлыг өсгөх
Зорилт 4.3. Эдийн засгийн бүтцийг төрөлжүүлж, бүтээлч эдийн засгийг хөгжүүлнэ.	4.3.1. Үндэсний онцлог бүхий аялал жуулчлалыг хөгжүүлж, олон улсын аялал жуулчлалын зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлсэн байна. 4.3.2. Мэдээллийн технологийн салбарыг дэмжиж, эдийн засагт оруулах хувь нэмрийг нэмэгдүүлсэн байна. 4.3.3. Эдийн засгийн хөгжлийг дэмжсэн инженерийн дэд бүтцийг хөгжүүлэн, дэвшилтэт технологи бүхий үйлдвэрлэл, технологийн паркуудыг байгуулж, ажлын байрыг нэмэгдүүлсэн байна.	+2 Зорилт 11.а Үндэсний болон бүс нутгийн хөгжлийн төлөвлөлтийг сайжруулах замаар хот, хагас суурин газар, хөдөө орон нутгийн хооронд эдийн засаг, нийгэм, байгаль орчны үр дүнтэй уялдаа холбоо дэмжих
Зорилт 4.4. Бизнес, үйлчилгээ эрхлэхэд таатай орон зайг хөгжүүлнэ.	4.4.1. Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах “Эдийн засгийн чөлөөт бүс” байгуулах ажлыг шат дараалалтай хэрэгжүүлсэн байна. 4.4.2. Цахим зайн ажлын байр, ажлын уян хатан цагийг дэмжих замаар ажиллах хүчний нөөцийг татсан байна.	+2 Зорилт 9.б Бодлогын таатай орчныг хангах, тухайлбал аж үйлдвэрийн төрөлжилт, бараа бүтээгдэхүүнд нэмүү өртөг шингээх замаар хөгжиж буй орнуудын дотоодын технологийн хөгжил, судалгаа шинжилгээ, инновацийг дэмжих
Зорилт 4.5. Хариуцлагатай, тогтвортой хэрэглээ	4.5.1. Технологи нутагшуулах, лаборатори, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх замаар стандартын шаардлага хангасан хүнсний	+2 Зорилт 9.3 Жижиг хэмжээний аж үйлдвэрийн болон бусад салбарын аж

<p>болон үйлдвэрлэлийг дэмжинэ.</p>	<p>үйлдвэрлэлийг нэмэгдүүлсэн байна. 4.5.2. Дагуул, хаяа хот, тосгодоод хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагааг бодлогоор дэмжиж, эрчимжсэн мал аж ахуйг төрөлжүүлэн хөгжүүлсэн байна. 4.5.3. Хотын стратегийн хүнсний улирлын нөөцийг эрэлт, нийлүүлэлттэй уялдуулан хувийн хэвшлийн оролцоотойгоор бүрдүүлсэн байна. 4.5.4. Үйлдвэрлэл, үйлчилгээний менежментийг сайжруулж стандартад нийцүүлсэн байна</p>	<p>ахуй нэгжүүд, ялангуяа хөгжиж буй орнуудын эдгээр аж ахуй нэгжүүдийн санхүүгийн үйлчилгээ авах, түүний дотор хямд зээл авах, үйлдвэрлэл, зах зээл нэвтрэх боломжийг нэмэгдүүлэх. Зорилт 9.2 Хүртээмжтэй, тогтвортой аж үйлдвэржилтийг хөхүүлэн дэмжиж, 2030 он гэхэд үндэсний нөхцөл байдалтай уялдуулан ДНБ-нд аж үйлдвэрийн салбарын ажлын байрны эзлэх хувийг үлэмж хэмжээгээр нэмэгдүүлж, нэн буурай хөгжилтэй орнуудад энэ хувийг хоёр дахин өсгөх.</p>
<p>Зорилт 4.6. Олон улсын хотуудтай харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлж, хөрөнгө оруулалт, худалдаа, эдийн засгийн харилцааг нэмэгдүүлнэ.</p>	<p>4.6.1. Бүс нутгийн хотуудтай харилцан ашигтай худалдаа, эдийн засаг болон олон талт хамтын ажиллагааг өргөжүүлсэн байна.</p>	<p>+1 Зорилт 11.а Үндэсний болон бүс нутгийн хөгжлийн төлөвлөлтийг сайжруулах замаар хот, хагас суурин газар, хөдөө орон нутгийн хооронд эдийн засаг, нийгэм, байгаль орчны үр дүнтэй уялдаа холбоо дэмжих</p>
<p>ТАВ. ЗАСАГЛАЛ</p>		
<p>Зорилго.5 Хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлж, иргэдийн оролцоог хангасан, авлигаас ангид, үр нөлөөтэй, хариуцлагатай, мэргэшсэн тогтвортой засаглалыг төлөвшүүлнэ.</p>		
<p>Зорилт 5.1. Нийслэлийн эрх зүйн орчныг эрх мэдэл захиргааны төвлөрлийг сааруулж, тогтвортой, хяналттай засаглалыг төлөвшүүлэх замаар сайжруулна.</p>	<p>5.1.1. Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль, Нийслэл хотын албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлтүүд орсон байна. 5.1.2. Аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шат дарааллыг бууруулах, зөвшөөрөл олгох үйл ажиллагааг цахимжуулсан байна.</p>	<p>+1 Зорилт 16.5 Авлига, хээл хахуулийн бүх хэлбэрийг үлэмж хэмжээгээр багасгах Зорилт 16.6 Бүх түвшинд үр дүнтэй, хариуцлагатай, ил тод үйл ажиллагаатай институтийг хэвшүүлэх</p>
<p>Зорилт 5.2. Нийслэл хотын хяналт удирдлагын цогц систем бий болгож, нийслэлийн мэдээллийн сан, өгөгдлийн бүрэн байдал, аюулгүй байдлыг хангаж, нэг эх сурвалж бүхий мэдээлэл, нээлттэй өгөгдлийг бий болгосон байна.</p>	<p>5.2.1. Нийслэлийн алслагдсан 3 дүүргийг цахим мэдээллийн нэгдсэн сан, сүлжээнд холбож, дэд бүтэц сайжирсан байна. 5.2.2. “Нэг иргэн-Нэг бүртгэл” хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байна. 5.2.3. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын мэдээллийн аюулгүй байдлыг хангасан байна. 5.2.4. Улаанбаатар хотын алслагдсан гэр хороолол болон хүн ам ихээр цуглардаг тодорхой бүсүүдийг үе шаттайгаар утасгүй интернетжүүлэх төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ.</p>	<p>+2 Зорилт 16.7 Бүх түвшинд хурдан шуурхай, бүх талын оролцоог хангасан, оролцооны аргад тулгуурласан, төлөөллийн шийдвэр гаргадаг болох</p>

Зорилт 5.3. Мэргэшсэн, чадварлаг, иргэндээ үйлчилдэг, тогтвортой төрийн албыг бэхжүүлж, төрийн үйлчилгээний үр дүн, үр нөлөөг дээшлүүлнэ.	5.3.1. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад болон олон улсын чанарын менежментийн тогтолцоо, стандартыг нэвтрүүлсэн байна. 5.3.2. Иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлсэн байна. 5.3.3. Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн үйл ажиллагаанд үйлчилгээний стандартыг нэвтрүүлж, иргэдийн итгэлийг хүлээсэн үйлчилгээний соёлыг төлөвшүүлнэ.	+2 Зорилт 16.6 Бүх түвшинд үр дүнтэй, хариуцлагатай, ил тод үйл ажиллагаатай институтийг хэвшүүлэх
Зорилт 5.4. Хүнийг эрхийг хамгаалах чиглэлд иргэн, төр, хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлж, оролцоог хангана.	5.4.1. Бүх нийтийн оролцоог хангасан, үр нөлөөтэй, хариуцлагатай, чадварлаг, институцийг бүх шатанд бий болгож, иргэдийг аюулгүй, амар тайван амьдрах нөхцөлөөр хангана.	+2 Зорилт 16.7 Бүх түвшинд хурдан шуурхай, бүх талын оролцоог хангасан, оролцооны аргад тулгуурласан, төлөөллийн шийдвэр гаргадаг болох
Зорилт 5.5. Шударга ёсыг эрхэмлэн бэхжүүлэх замаар авлига, албан тушаалын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлийн гэмт хэргийг бууруулна.	5.5.1. Шударга, хариуцлагатай, ил тод, нийтийн албыг бэхжүүлж, авлигын бүх хэлбэрийг таслан зогсоож, хяналтыг нэмэгдүүлнэ. 5.5.2. Төрийн байгууллага, албан тушаалтныг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангана	+1 Зорилт 16.5 Авлига, хээл хахуулийн бүх хэлбэрийг үлэмж хэмжээгээр багасгах Зорилт 16.6 Бүх түвшинд үр дүнтэй, хариуцлагатай, ил тод үйл ажиллагаатай институтийг хэвшүүлэх
ЗУРГАА. НОГООН ХӨГЖИЛ Зорилго. 6 Байгалийн ногоон нөөцийг хамгаалж, экологийн тэнцвэрт байдлыг хангах замаар хүрээлэн буй орчны доройтлыг бууруулж уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицно.		
Зорилт 6.1. Байгалийн нөөцийг хадгалж, хамгаалан, нөхөн сэргээнэ.	6.1.1. Орон нутгийн хамгаалалттай газар нутгийн хэмжээг нэмэгдүүлсэн байна. 6.1.2. Нийслэлийн ногоон бүсийн ойн сангийн хомсдол, доройтлыг бууруулна. 6.1.3. Амьтан, ургамлын төрөл зүйлийг нутагшуулан хамгаалж, нөхөн сэргээсэн байна. 6.1.4. Байгаль хамгааллын үйл ажиллагаанд иргэдийн оролцоо нэмэгдсэн байна.	+2 Зорилт 6.6 2020 он гэхэд устай холбоотой экосистем, түүний дотор уул, ой, намагшсан газар, гол мөрөн, уст давхарга, нуурыг хамгаалах, сэргээх
Зорилт 6.2. Орчны бохирдлыг багасгаж, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулна.	6.2.1. Нийслэлийн гэр хорооллын айл өрхийг сайжруулсан түлшээр бүрэн хангаж, агаарын бохирдлыг бууруулсан байна. 6.2.2. Агаарын чанарын хяналтыг сайжруулсан байна. 6.2.3. Улаанбаатар хотын хог хаягдлыг ангилан ялгаж, цуглуулж тээвэрлэх дэвшилтэт цогц арга, технологийг нэвтрүүлж, дахин боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих замаар төвлөрсөн цэгт дарж булагдах хог хаягдлын хэмжээг бууруулна. 6.2.4. Хог хаягдлын төвлөрсөн цэгүүдийн нөхцөлийг сайжруулж, олон жил хог	+2 Зорилт 11.6 2030 он гэхэд агаарын чанар, хотын болон хог хаягдлын менежментийн асуудалд онцгой анхаарлаа хандуулах замаар хотуудын нэг хүнд ногдох байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулах. Зорилт 12.5 2030 он гэхэд хог хаягдлаас сэргийлэх, түүнийг бууруулах дахин боловсруулах, дахин хэрэглэх замаар хог хаягдал

	<p>дарж булсан ландфилын талбайг үе шаттайгаар хэсэгчлэн хааж, нөхөн сэргээлт хийнэ. 6.2.5. Хог хаягдлын үйлчилгээний төлбөр, хураамж төлөх нээлттэй ил тод хялбаршуулсан цахим системийг нэвтрүүлнэ. 6.2.6. Аюултай хог хаягдлыг бүртгэлжүүлж, ангилан ялгаж, тээвэрлэх, түр хадгалах, саармагжуулан устгах тогтолцоог бий болгоно. 6.2.7. Хүнсний хог хаягдлыг дахин боловсруулж, өдөрт 2,000 кг бордоо үйлдвэрлэх хүчин чадал бүхий үйлдвэрийг ашиглалтад оруулсан байна. 6.2.8. “Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г боловсруулж, хэрэгжүүлсэн байна. 6.2.9. Гэр хорооллын айл өрхүүдэд эдийн засгийн дэмжлэг үзүүлэх замаар стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийг үе шаттайгаар нэмэгдүүлж, бохир цуглуулж, тээвэрлэх, байгальд ээлтэй аргаар устгах арга технологийг нэвтрүүлнэ. 6.2.10. Нийслэлийн нутаг дэвсгэр дэх оршуулгын үйлчилгээний зохистой менежментийг бий болгож, оршуулгын газруудыг нөхөн сэргээж, ойжуулна. 6.2.11. Байгалийн баялгийн олборлолтоос эвдэрсэн талбайд нөхөн сэргээлт хийсэн байна.</p>	<p>бий болгож буй хэмжээг үлэмж хэмжээгээр бууруулах. Зорилт 6.b Усны болон ариун цэврийн байгууламжийн менежментийг боловсронгуй болгох чиглэлээр орон нутгийн хамт олны оролцоог дэмжих, бэхжүүлэх Зорилт 15.3 2020 гэхэд цөлжилттэй тэмцэх, эвдэрч, талхлагдсан газар, хөрс, түүний дотор цөлжилт, ган, үерийн улмаас доройтсон газрыг сэргээх, газрын доройтлыг саармагжуулсан ертөнцийг бий болгохыг эрмэлзэх</p>
<p>Зорилт 6.3. Усны нөөцийг хамгаална.</p>	<p>6.3.1. Ундны усны нөөцийг судалж, усны эх үүсвэрийн эрүүл ахуйн хязгаарлалтын бүс, тэжээгдлийн мужийг тогтоож, хамгаалалтад авна. 6.3.2. Гадаргын усыг хуримтлуулж, ашиглалтыг нэмэгдүүлсэн байна.</p>	<p>+2 Зорилт 6.3 2030 он гэхэд дэлхийн түвшинд бохирдлыг бууруулах, хог хаях ажиллагааг халах, аюултай химийн бодис, материалыг гаргах явдлыг хамгийн бага түвшинд хүргэх, цэвэрлэгдээгүй бохир ус хувь хэмжээг хоёр дахин бууруулах, усыг дахин боловсруулж, цэвэршүүлэн хэрэглэх явдлыг нэмэгдүүлэх замаар усны чанарыг сайжруулах</p>
<p>Зорилт 6.4. Улаанбаатар хотын цэцэрлэгжүүлэлтийн мастер төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.</p>	<p>6.4.1. Дүүрэг бүрд цэцэрлэгт хүрээлэн байгуулж, нийтийн эзэмшлийн зам талбайн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, нягтруулах замаар нэг хүнд ногдох ногоон байгууламжийг нэмэгдүүлсэн байна. 6.4.2. Сэлбэ, Дунд гол, Туул голын эрэг орчмын газрыг нийтийн зориулалттай ногоон байгууламж, спортын төрөлжсөн</p>	<p>+2 Зорилт 11.7 2030 он гэхэд хүн бүрийг, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхдүүд, өндөр настнууд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг аюулгүй, бүх талын оролцоог хангасан, хүртээмжтэй, ногоон болон</p>

	талбай бүхий байгалийн төрхийг хадгалсан, амралт зугаалгын бүс болгон тохижуулсан байна.	нийтийн эзэмшлийн талбайгаар хангах
ДОЛОО. АМАР ТАЙВАН, АЮУЛГҮЙ НИЙГЭМ		
Зорилго.7 Иргэдийг аюулгүй, амар тайван, гамшгийн эрсдэлгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.		
Зорилт 7.1. Цагдаагийн байгууллагын чадавхыг бэхжүүлж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагаа, иргэдэд үзүүлэх үйлчилгээний хүртээмжийг сайжруулна.	7.1.1. Цагдаагийн байгууллагын хэлтэс, хэсгийн байруудыг шинээр барьж, төрийн үйлчилгээг хүртээмжтэй болгоно. 7.1.2. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангахад шаардлагатай автомашин, техник хэрэгслийн хангамжийг нэмэгдүүлсэн байна. 7.1.3. Эрүүлжүүлэх, саатуулах төвийн барилгыг шинэчлэн барьж, үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг сайжруулсан байна.	-
Зорилт 7.2. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, гэмт хэргийн гаралтын түвшинг бууруулна.	7.2.1. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, цагийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, хамтран ажилласан байна. 7.2.2. Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, эрсдэлд өртөхөөс хамгаалах “Хүүхэд хамгаалагч” төслийг хэрэгжүүлж, хүүхдийг гэмт хэрэгт өртөх, хохирогч болох эрсдэл бууруулсан байна. 7.2.3. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, хохирогчийг хамгаалалтад авах, аюулгүй байдлыг хангах түр хамгаалах байрыг шинэчилж, барьсан байна.	+2 Зорилт 16.4 2030 он гэхэд санхүүгийн болон галт зэвсгийн хууль бус урсгалыг үлэмж хэмжээгээр багасгаж, хулгайлагдсан эд хөрөнгийг буцаан олгох, нөхөн төлөх ажлыг сайжруулах, зохион байгуулалттай гэмт хэргийн бүх хэлбэртэй тэмцэх
Зорилт 7.3. Гудамж, зам талбайг хянах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор камерын нэгдсэн хяналтын системийг бий болгоно.	7.3.1. Нийслэлийн удирдлага, хяналтын цогц системийг байгуулж хэрэглээнд нэвтрүүлсэн байна. 7.3.2. Бичлэг болон зурган мэдээллээс үл давтагдах өгөгдлөөр программ хангамжийг нэвтрүүлэх, гэмт хэргийн цахим зураглал /Griemmar, Compstat/-ыг цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбох ажлуудыг хийж, Улаанбаатар хотын хэмжээнд ашиглагдаж буй хяналтын камерыг “Камерын удирдлагын нэгдсэн төв”-тэй холбож, гудамж, зам талбайн хяналт, гэмт хэрэг илрүүлэлт сайжруулж, гэмт хэргийн гаралт бууруулсан байна.	+2 Зорилт 16.4 2030 он гэхэд санхүүгийн болон галт зэвсгийн хууль бус урсгалыг үлэмж хэмжээгээр багасгаж, хулгайлагдсан эд хөрөнгийг буцаан олгох, нөхөн төлөх ажлыг сайжруулах, зохион байгуулалттай гэмт хэргийн бүх хэлбэртэй тэмцэх
Зорилт 7.4. Гамшгаас авран хамгаалах, иргэдэд үзүүлэх үйлчилгээний хүртээмжийг сайжруулна	7.4.1. Онцгой байдлын байгууллагын гамшигтай тэмцэх техник, хэрэгслийн хангамжийг нэмэгдүүлж, хүн амын нягтрал ихтэй байршлуудад гал түймэр унтраах, аврах анги байгуулж, иргэдийг аюул, ослоос авран,	+2 Зорилт 11.b 2020 он гэхэд бүх талын оролцоог хангах, хөрөнгө баялгийг үр ашигтай ашиглах, уур амьсгалын өөрчлөлтийг

	хамгаалах чадавхыг сайжруулсан байна.	бууруулах, дасан зохицох, гамшгийг даван туулах чадварыг бэхжүүлэхэд чиглэсэн нэгдсэн бодлого, төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх.
НАЙМ. БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ		
Зорилго.8 Хүн амын нутагшилт, суурьшлын оновчтой тогтолцоог бүрдүүлж бүс орон нутгийн хөгжлийн уялдааг хангуулна.		
Зорилт 8.1. Монгол Улсын үндэсний түвшний хөгжлийн бодлоготой нийслэлийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийг уялдуулж, дагуул, хаяа хот, тосгодын хөгжлийг эрчимжүүлж хотын төвлөрлийг сааруулах бодлогыг боловсруулна.	8.1.1. "Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл", "Бүсийн хөгжлийн хөтөлбөр"-ийн төсөлд нийслэлийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийг уялдуулсан байна. 8.1.2. "Шинэ Зуунмод", "Майдар" шинэ дагуул хотын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хилийн цэсийг өөрчлөх ажлыг холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хамтран зохион байгуулсан байна. 8.1.3. Төв аймагтай хамтран ажиллах эдийн засгийн болон нийгмийн хөгжлийн чиглэлийг тодорхойлж, хамтын ажиллагааг нэмэгдүүлсэн байна. 8.1.4. Богд уулыг тойрсон "Хөгжлийн алтан тойрог" төсөл, Улаанбаатар хотын дагуул хотуудыг түшиглэн ачаа тээврийн логистик төв байгуулах техник, эдийн засгийн үндэслэл, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулсан байна. 8.1.5. Улаанбаатар хотын дагуул, хаяа хот, тосгодын хөгжлийн төлөвлөлтийн баримт бичгүүдийг боловсруулж дуусгана. 8.1.6. "Барилгын материалын бөөний худалдааны төв"-ийн техник, эдийн засгийн үндэслэл, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг батлуулж, ажлыг эхлүүлсэн байна. 8.1.7. Улаанбаатар хотод сөрөг нөлөө үзүүлж байгаа үйлдвэр, аж ахуйн нэгжийг хотоос шилжүүлэх бодлого боловсруулж, хэрэгжүүлж эхэлсэн байна. 8.1.8. Зарим их, дээд сургуулиудыг мэргэжлийн чиглэл, салбараар төрөлжүүлж, дагуул хотууд болон бусад аймгуудад шилжүүлэх асуудлыг шийдвэрлүүлсэн байна.	+2 Зорилт 11.3 2030 он гэхэд бүх улс орнуудад хамтын оролцооны, нэгдсэн, тогтвортой хүн амын суурьшлын төлөвлөлт, менежментийн чадавх, бүх талын оролцоог хангасан, тогтвортой хот байгуулалтыг сайжруулах
ЕС. УЛААНБААТАР БА ДАГУУЛ ХОТ		
Зорилго.9 Орон зайн оновчтой төлөвлөлтийн хүрээнд хотын төвлөрлийг задалж, орон сууц, дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлэн хот байгуулалтын үйл ажиллагаанд ухаалаг технологийн шинэчлэл хийнэ.		
Зорилт 9.1. Улаанбаатар хотын 2040 он хүртэлх	9.1.1. Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий	+2

<p>хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулна.</p>	<p>төлөвлөгөөний дагалдан гарах зураг төсөл, баримт бичгийг боловсруулж, хэрэгжүүлж эхэлсэн байна. 9.1.2. Хүн амын тооцоот нягтралаас хэтэрсэн байршлын судалгааг гаргаж, хүн ам, барилгажилтын нягтралыг хориглох бүсийг тогтооно. 9.1.3. Гэр хорооллыг хөгжүүлэх стратеги төлөвлөгөө боловсруулан, хэрэгжүүлсэн байна.</p>	<p>Зорилт 11.1 2030 он гэхэд хүрэлцэхүйц, аюулгүй, хямд үнэтэй орон сууц, суурь үйлчилгээгээр хүн бүрийг хангаж, ядуусын хорооллыг сайжруулах</p>
<p>Зорилт 9.2. Төр захиргаа, мэдээлэл технологи, бизнес санхүү, соёл, боловсрол, худалдаа үйлчилгээ, орон сууц, нийгмийн болон инженерийн дэд бүтцийн хангамж бүхий хотын шинэ төв, дэд төв, олон нийтийн төвүүдийг байгуулж, хотын хэт төвлөлийг бууруулна.</p>	<p>9.2.1. “Яармаг” хотын шинэ төвийн ерөнхий төлөвлөгөө /Нисэх, Яармаг орчмын орон сууцны хорооллын ерөнхий төлөвлөгөөний тодотгол/ шинэчлэн боловсруулагдаж, төлөвлөлтийн дагуу бүтээн байгуулалт хэрэгжих боломжийг бүрдүүлсэн байна. 9.2.2. “Баянхошуу”, “Сэлбэ”, “Дамбадаржаа”, “Дэнжийн 1000”, “Толгойт”, “Шархад” дэд төвүүдийг байгуулна.</p>	<p>+2 Зорилт 11.3 2030 он гэхэд бүх улс орнуудад хамтын оролцооны, нэгдсэн, тогтвортой хүн амын суурьшлын төлөвлөлт, менежментийн чадавх, бүх талын оролцоог хангасан, тогтвортой хот байгуулалтыг сайжруулах</p>
<p>Зорилт 9.3. Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн үйл ажиллагаанд ухаалаг технологийг нэвтрүүлж, нийслэлийн хот байгуулалтын дундын мэдээллийн санг өргөжүүлэн, иргэд, олон нийтэд нээлттэй болгоно.</p>	<p>9.3.1. Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд суурилсан газар олгох, барилга барих зөвшөөрлийг иргэд, олон нийтэд нээлттэй болгосон байна. 9.3.2. Улсын кадастрын мэдээллийн нэгдсэн системд холбогдож, хэрэглээнд нэвтрүүлэн, гудамж, зам талбай, үл хөдлөх эд хөрөнгийн хаягийг шинэчлэн, хэрэглээнд нэвтрүүлсэн байна. 9.3.3. Нийслэлийн нутаг дэвсгэрийг том масштабын байр зүйн тоон зургаар бүрэн зурагжуулсан байна. 9.3.4. Замын бүртгэл мэдээллийн нэгдсэн санг цахим хэлбэрт шилжүүлсэн байна.</p>	<p>+2 Зорилт 11.3 2030 он гэхэд бүх улс орнуудад хамтын оролцооны, нэгдсэн, тогтвортой хүн амын суурьшлын төлөвлөлт, менежментийн чадавх, бүх талын оролцоог хангасан, тогтвортой хот байгуулалтыг сайжруулах</p>
<p>Зорилт 9.4. Нийслэлийн газрын харилцааны бодлогыг шинэчлэн, цахим системийг нэвтрүүлж, стандартыг хангуулна.</p>	<p>9.4.1. Нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. 9.4.2. Гэр хорооллын мухар гудамж, зуслангийн бүсийн орц, гарц, орон сууцны хороолол дундах газар, нийтийн эзэмшлийн зам, талбайн газрын зөрчлийн асуудлыг бүрэн шийдвэрлэж, түргэн тусламж, гал унтраах, аврах ажиллагааг шуурхай хүргэх, нэвтрэх боломжийг бүрдүүлсэн байна. 9.4.3. Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй бүтээн байгуулалтын ажлын нөлөөлөлд өртсөн иргэн, хуулийн этгээдэд хуулийн дагуу нөхөн олговрыг олгох, газар чөлөөлөх ажлыг зохион байгуулсан байна. 9.4.4. Ойн, голын,</p>	<p>+2 Зорилт 11.3 2030 он гэхэд бүх улс орнуудад хамтын оролцооны, нэгдсэн, тогтвортой хүн амын суурьшлын төлөвлөлт, менежментийн чадавх, бүх талын оролцоог хангасан, тогтвортой хот байгуулалтыг сайжруулах. Зорилт 11.4 Дэлхийн соёлын болон байгалийн өвийг хадгалан хамгаалах арга хэмжээг сайжруулах Зорилт 11.7 2030 он гэхэд хүн бүрийг, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхдүүд, өндөр настнууд, хөгжлийн</p>

	<p>усан сан бүхий газрын, үер, цэвэрлэх байгууламж, өндөр хүчдэл, түүх соёл, дурсгалт зүйлийн хамгаалалтын бүс болон төлөвлөж буй экологийн коридор, хотын суурьшлын бүс /тиг гортиг/-ийн гадна байгаа суурьшлыг чөлөөлж, нүүлгэн шилжүүлэх менежментийн төлөвлөгөөг боловсруулсан байна.</p> <p>9.4.5. Газрын мониторингийн цахим системээр дамжуулан газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгаа хийгдэнэ.</p> <p>9.4.6. Нийслэлийн нутаг дэвсгэрт нийтийн эзэмшлийн амралт, зугаалга, биеийн тамирын зориулалттай газар, цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, нийтээр зүй зохистой ашиглах, хамгаалах зорилгоор нийтийн эдэлбэр газрын байршлыг тогтоож, холбогдох шийдвэрийг гаргуулан, бүртгэлжүүлэх, хамгаалах ажлыг зохион байгуулна.</p>	<p>бэрхшээлтэй хүмүүсийг аюулгүй, бүх талын оролцоог хангасан, хүртээмжтэй, ногоон болон нийтийн эзэмшлийн талбайгаар хангах.</p>
<p>Зорилт 9.5. Нийслэлийн хэмжээнд иргэдийн эрүүл, ая тухтай амьдрах орчны аюулгүй байдлыг хангахад чиглэсэн хотын стандарт, норм, дүрмийг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулж, мөрдүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.</p>	<p>9.5.1. Хот төлөвлөх, байгуулах үйл ажиллагаанд болон нийгмийн үйлчилгээний барилгуудад стандартыг мөрдүүлдэг тогтолцоог бий болгоно.</p> <p>9.5.2. Ногоон барилгын стандарт боловсруулж, нэвтрүүлсэн байна.</p> <p>9.5.3. Хотын стандартын дагуу орчны аюулгүй байдлын хяналт, шалгалтыг сайжруулж, иргэдийн амьдрах орчны эрсдэлийг бууруулсан байна.</p>	<p>+2</p> <p>Зорилт 11.3 2030 он гэхэд бүх улс орнуудад хамтын оролцооны, нэгдсэн, тогтвортой хүн амын суурьшлын төлөвлөлт, менежментийн чадавх, бүх талын оролцоог хангасан, тогтвортой хот байгуулалтыг сайжруулах</p>
<p>Зорилт 9.6. Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн, барилгажуулах, гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах төслүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, инженерийн болон нийгмийн дэд бүтцээр хангагдсан, орчны бохирдлыг бууруулсан нийтийн болон амины орон сууцны хороолол болгон хөгжүүлнэ.</p>	<p>9.6.1. Төвийн бүсийн гэр хорооллыг дахин төлөвлөн барилгажуулж, инженерийн болон нийгмийн дэд бүтцээр хангагдсан орон сууцыг ашиглалтад оруулсан байна.</p> <p>9.6.2. Дундын бүсийн гэр хороололд хэсэгчилсэн инженерийн хангамжийг нэвтрүүлэх “Дэд бүтцийн төв” төслийг хэрэгжүүлнэ.</p> <p>9.6.3. Захын бүсийн алслагдмал гэр хорооллын бүсэд бие даасан сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр бүхий технологийг нэвтрүүлсэн байна.</p> <p>9.6.4. Төвлөрсөн шугам сүлжээнд холбогдох боломжтой гэр хорооллын бүсэд иргэдийн газрыг орон сууцаар солино.</p>	<p>+2</p> <p>Зорилт 11.1 2030 он гэхэд хүрэлцэхүйц, аюулгүй, хямд үнэтэй орон сууц, суурь үйлчилгээгээр хүн бүрийг хангаж, ядуусын хорооллыг сайжруулах</p>
<p>Зорилт 9.7. Түрээсийн олон төрөлт болон орлогод нийцсэн орон сууц төслүүдийг хэрэгжүүлж, нийслэлийн</p>	<p>9.7.1. Түрээсийн олон төрөлт орон сууцыг нэмэгдүүлсэн байна.</p> <p>9.7.2. Улаанбаатар хотын дэд төвүүдэд орлогод нийцсэн ногоон орон сууцны төсөл, Баянголын амны орон сууцны төсөл, төр хувийн хэвшлийн хамтын</p>	<p>+2</p> <p>Зорилт 11.1 2030 он гэхэд хүрэлцэхүйц, аюулгүй, хямд үнэтэй орон сууц, суурь үйлчилгээгээр хүн бүрийг</p>



зорилтот өрхүүдийг орон сууцаар хангана.	ажиллагааны орон сууцны төслүүдийг тус тус хэрэгжүүлсэн байна. 9.7.3. Шинэ суурьшлын бүсэд инженерийн болон нийгмийн дэд бүтэц бүхий орон сууцны хорооллын бүтээн байгуулалтын ажлыг хэрэгжүүлсэн байна.	хангаж, ядуусын хорооллыг сайжруулах
Зорилт 9.8. Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барилгажуулж, нийтийн зориулалттай орон сууцыг засварлан иргэдийн эрүүл, аюулгүй таатай орчинд амьдрах эрхийг хангана.	9.8.1. Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барилгажуулсан байна. 9.8.2. Нийтийн зориулалттай орон сууцны барилгын дээврийг засварласан байна. 9.8.3. Нийтийн зориулалттай орон сууцны барилгын ашиглалтын шаардлага хангахгүй цахилгаан шатыг шинэчилсэн байна. 9.8.4. Угсармал орон сууцны барилгыг дулаалсан байна. 9.8.5. Ашиглалтын хугацаа дууссан шугамыг шинэчилж, ус, дулаан дамжуулах төвүүдийг нэгдсэн теле хяналтын системд холбох болон зэв шүүх төхөөрөмж суурилуулан ашиглалтын зардлыг бууруулсан байна.	+2 Зорилт 11.1 2030 он гэхэд хүрэлцэхүйц, аюулгүй, хямд үнэтэй орон сууц, суурь үйлчилгээгээр хүн бүрийг хангаж, ядуусын хорооллыг сайжруулах
Зорилт 9.9. Хотын барилга байгууламжийг паспортжуулан, газар хөдлөлтөд тэсвэрлэх чадварт хянан баталгаажуулалт хийнэ.	9.9.1. 2002 оноос өмнө баригдсан орон сууц болон олон нийтийн зориулалттай барилга, байгууламжийн бат бэх, найдваржилтын төлөв байдалд мэргэжлийн дүгнэлт гарган, паспортжуулах ажлыг хийж дууссан байна. 9.9.2. Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, олон нийтийн барилгын хүчитгэлийн зураг, гамшгийн эрсдэлд тэсвэртэй амины сууцны загвар зургийг боловсруулсан байна.	+2 Зорилт 11.1 2030 он гэхэд хүрэлцэхүйц, аюулгүй, хямд үнэтэй орон сууц, суурь үйлчилгээгээр хүн бүрийг хангаж, ядуусын хорооллыг сайжруулах.
Зорилт 9.10. Эрчим хүчний ашиглалтын үр ашгийг өсгөж, дэд бүтцийг өргөжүүлэн, технологийн шинэчлэл хийж, хүн амыг тогтвортой эрчим хүчээр хангана.	9.10.1. Цахилгааны шугам сүлжээг шинэчлэн, хүчин чадлыг нэмэгдүүлж, гэрэл цахилгаангүй болон хүчдэлийн уналттай айл өрхийг цахилгаан эрчим хүчээр бүрэн хангана. 9.10.2. Эрчим хүчний цэнэг хураагуурын станц шинээр ашиглалтад оруулсан байна.	+2 Зорилт 7.b 2030 он гэхэд хөгжиж буй орнууд, ялангуяа нэн буурай хөгжилтэй болон жижиг арлын хөгжиж буй орнуудын иргэдийг орчин үеийн, тогтвортой эрчим хүчний үйлчилгээгээр хангах дэд бүтцийг өргөжүүлж, технологийг шинэчлэх
Зорилт 9.11. Гудамж, зам талбайн гэрэлтүүлгийг нэмэгдүүлнэ.	9.11.1. Гудамж, зам, талбайн гэрэлтүүлгийг үе шаттай нэмэгдүүлж, нэгдсэн удирдлагын автомат системд холбосон байна.	-
Зорилт 9.12. Дулааны эрчим хүчний дотоодын хэрэгцээг бүрэн хангах	9.12.1. Дулааны станцын хүчин чадал, гол магистраль шугамын дулаан нэвтрүүлэх чадвар нэмэгдсэн байна.	+2 Зорилт 7.1 2030 он гэхэд боломжийн, найдвартай,

<p>эх үүсвэрийн чадлын нөөцийг бий болгоно.</p>	<p>9.12.2. Амгалан дулааны станц болон 3 дугаар цахилгаан станцын өргөтгөл шинэчлэлтийн ажилтай уялдуулан, төрийн өмчийн халаалтын зуухнуудыг үе шаттайгаар төвлөрсөн дулаанд холбосон байна. 9.12.3. Хийн түлшний дулааны эх үүсвэрүүдийг барьж байгуулна. 9.12.4. Төвлөрсөн дулаан хангамжид холбогдох боломжгүй аж ахуйн нэгж, байгууллагын хатуу түлшний халаалтын зуухнуудыг хийн түлшинд шилжүүлсэн байна.</p>	<p>орчин үеийн эрчим хүчний үйлчилгээгээр хүн бүрийг хангах.</p>
<p>Зорилт 9.13. Мэдээлэл, холбооны электрон автомат телефон станц, мэдээлэл холбооны нэгдсэн төвийн барилгуудыг холбож, нэгдсэн том сүлжээ үүсгэн, зохион байгуулалтыг сайжруулна.</p>	<p>9.13.1. Мэдээлэл, холбооны нэгдсэн төвийн барилга, худаг сувагчлалын байгууламж шинээр барьж, мэдээлэл холбооны нэгдсэн сүлжээ бий болгосон байна.</p>	<p>+2 Зорилт 9.с 2020 он гэхэд мэдээлэл, холбооны технологийн хүртээмжийг үлэмж хэмжээгээр нэмэгдүүлж, нэн буурай хөгжилтэй орнуудын хүн амыг хямд үнэтэй интернетээр хангахыг эрмэлзэх</p>
<p>Зорилт 9.14. Инженерийн бэлтгэл арга хэмжээний барилга байгууламжийг барьж, иргэдийг үер, усны аюулаас урьдчилан сэргийлэн, амьдрах орчныг сайжруулна.</p>	<p>9.14.1. Инженерийн бэлтгэл арга хэмжээний баримт бичиг, зураг төсөл боловсруулсан байна. 9.14.2. Үерийн хамгаалалтын далан, суваг, шугам сүлжээг шинээр барих болон өргөтгөн, шинэчилсэн байна. 9.14.3. Далан суваг, шугам сүлжээний цэвэрлэгээ, үйлчилгээ, засварт шаардлагатай машин, механизмаар хангана.</p>	<p>+2 Зорилт 2.4 2030 он гэхэд хүнс үйлдвэрлэлийн тогтвортой системийг бий болгож, бүтээмж, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, экосистемийн тэнцвэрийг хангаж чадах, цаг уурын өөрчлөлт, эрс тэс цаг агаар, ган зуд, үер, бусад гамшигт үзэгдэлд дасан зохицох чадавхыг бэхжүүлэх, газар хөрсний чанарыг тасралтгүй сайжруулах хөдөө аж ахуйн уян хатан арга туршлагыг нэвтрүүлэх</p>
<p>Зорилт 9.15. Ус хангамжийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх болон усны алдагдлыг бууруулж, шугам доторлох төслийг үргэлжлүүлж дуусгана.</p>	<p>9.15.1. Хотын баруун хэсэгт ус хангамжийн шинэ эх үүсвэр барьж, төв цэвэрлэх байгууламжийн хаягдал усыг гүн цэвэршүүлэн, дулаан, цахилгааны станцуудад техникийн усны зориулалтаар дахин ашиглана 9.15.2. Туул усан цогцолборын техник, эдийн засгийн үндэслэлийг эцэслэн дуусгаж, барилга угсралтын ажлын зураг төслийг боловсруулсан байна. 9.15.3. Ундны усны эх үүсвэрийн гүний худаг, тоолуургүй айл өрхийг тоолууржуулж усны бодит хэрэглээг тооцож, усны лабораторийн хүчин чадлыг өргөтгөн шинэчилсэн байна.</p>	<p>+2 Зорилт 6.3 2030 он гэхэд дэлхийн түвшинд бохирдлыг бууруулах, хог хаях ажиллагааг халах, аюултай химийн бодис, материалыг гаргах явдлыг хамгийн бага түвшинд хүргэх, цэвэрлэгдээгүй бохир ус хувь хэмжээг хоёр дахин бууруулах, усыг дахин боловсруулж, цэвэршүүлэн хэрэглэх явдлыг нэмэгдүүлэх замаар усны чанарыг сайжруулах.</p>

<p>Зорилт 9.16. Улаанбаатар хотод ус хангамжийн усан сан, шугам сүлжээг шинээр болон өргөтгөн барьж, цэвэр усны түгээлт, хүртээмжийг сайжруулна.</p>	<p>9.16.1. Ус хангамжийн усан сан, шугам сүлжээг шинээр барьж, байгуулсан байна. 9.16.2. Одоо байгаа ус хангамжийн усан сан, шугам сүлжээг өргөтгөн, шинэчилсэн байна. 9.16.3. Ус хангамжийн шугамыг шуудуу ухалгүй доторлох төслийг хэрэгжүүлж, зөөврийн ус түгээх байруудыг төвлөрсөн шугам сүлжээнд холбож, ухаалаг төхөөрөмж суурилуулсан байна.</p>	<p>+2 Зорилт 6.а 2030 он гэхэд ус, ариун цэврийн байгууламжтай холбоотой үйл ажиллагаа, хөтөлбөр, түүний дотор ус хураах, цэвэршүүлэх, усны үр ашиг, бохир усыг цэвэрлэх, дахин ашиглах технологийн чиглэлээр хөгжиж буй орнуудад үзүүлдэг олон улсын хамтын ажиллагаа, чадавх бэхжүүлэх дэмжлэг туслалцааг өргөжүүлэх</p>
<p>Зорилт 9.17. Шинээр цэвэрлэх байгууламж барьж, хуучин байгууламжуудад техник технологийн шинэчлэлт хийж, эрүүл ахуйн хамгаалалтын бүсийг баталгаажуулна.</p>	<p>9.17.1. Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламж болон лаг хатаах байгууламжийг ашиглалтад оруулсан байна. 9.17.2. Буянт-Ухаа орон сууцны хорооллын бохир ус цэвэрлэх байгууламжийн гадна дулааны шугамын нэмэлт ажлуудыг ашиглалтад оруулсан байна.</p>	<p>+2 Зорилт 6.а 2030 он гэхэд ус, ариун цэврийн байгууламжтай холбоотой үйл ажиллагаа, хөтөлбөр, түүний дотор ус хураах, цэвэршүүлэх, усны үр ашиг, бохир усыг цэвэрлэх, дахин ашиглах технологийн чиглэлээр хөгжиж буй орнуудад үзүүлдэг олон улсын хамтын ажиллагаа, чадавх бэхжүүлэх дэмжлэг туслалцааг өргөжүүлэх.</p>
<p>Зорилт 9.18. Орон сууц нийтийн аж ахуйн үйлчилгээний байгууллагуудад шаардлагатай машин механизм, тоног төхөөрөмжөөр хангана.</p>	<p>9.18.1. Цэвэр, бохир усны зөөврийн болон шугам сүлжээний засвар үйлчилгээний машин механизмаар хангалт хийж, шугам сүлжээний засвар үйлчилгээнд зарцуулах хугацааг багасгаж, ус түгээх үйлчилгээний хүртээмжийг сайжруулсан байна.</p>	<p>+2 Зорилт 6.1 2030 он гэхэд хүн бүрийг ундны аюулгүй, боломжийн үнэтэй усаар хангах</p>
<p>Зорилт 9.19. Авто зам, дугуйн зам, явган замын нөхцөлийг сайжруулан, гол, туслах гудамж болон хорооллын доторх замыг өргөтгөн, шинэчилж, авто замыг шинээр барьж, үндсэн сүлжээг нэмэгдүүлэн, хөгжүүлнэ.</p>	<p>9.19.1. Авто замын сүлжээний уртыг нэмэгдүүлсэн байна. 9.19.2. Гол болон туслах гудамж замын техник ашиглалтын түвшинг сайжруулж, өргөтгөн, шинэчилсэн байна. 9.19.3. Дугуйн замын сүлжээг нэмэгдүүлсэн байна. 9.19.4. Сул шороон хөрсийг явган зам, талбай болгон тохижуулна</p>	<p>+2 Зорилт 11.2 2030 он гэхэд эмзэг бүлгийн хүн ам, эмэгтэйчүүд, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй болон өндөр настай хүмүүсийн хэрэгцээ шаардлагыг онцгой анхааран замын аюулгүй байдал, тухайлбал нийтийн тээврийг өргөжүүлэн сайжруулах замаар аюулгүй, хямд үнэтэй, хүртээмжтэй, тогтвортой тээврийн системийг хүн бүрт хүргэх</p>
<p>Зорилт 9.20. Авто замын хөдөлгөөний төлөвлөлтийг оновчтой түвшинд төлөвлөж, авто</p>	<p>9.20.1. Замын хөдөлгөөний ачааллыг бууруулах цогц арга хэмжээ авч хотын хэсгийн тээврийн хэрэгслийн дундаж хурдыг нэмэгдүүлнэ. 9.20.2. "Нийслэл</p>	<p>+2 Зорилт 11.2 2030 он гэхэд эмзэг бүлгийн хүн ам, эмэгтэйчүүд, хүүхэд,</p>

<p>замын хөдөлгөөний ачааллыг бууруулна.</p>	<p>хотын замын хөдөлгөөн, тээврийн ухаалаг систем” төслийг бүрэн хэрэгжүүлсэн байна.</p>	<p>хөгжлийн бэрхшээлтэй болон өндөр настай хүмүүсийн хэрэгцээ шаардлагыг онцгой анхааран замын аюулгүй байдал, тухайлбал нийтийн тээврийг өргөжүүлэн сайжруулах замаар аюулгүй, хямд үнэтэй, хүртээмжтэй, тогтвортой тээврийн системийг хүн бүрт хүргэх</p>
<p>Зорилт 9.21. Улаанбаатар хотод олон төрөлт тээврийн оновчтой сүлжээг төлөвлөн, хөгжүүлнэ.</p>	<p>9.21.1. Нийтийн тээврийн мастер төлөвлөгөө боловсруулж, нийтийн тээврийн төлөвлөлт оновчтой төлөвлөгдсөн байна. 9.21.2. Зорчигч тээврийн урсгалаас хамаарч дагуул, хаяа хот, тосгод нийтийн тээврийн сүлжээнд холбогдсон байна. 9.21.3. Нийтийн тээврийн үйлчилгээнд олон төрөлт, ухаалаг зорчигч тээврийн төрөл нэмэгдсэн байна.</p>	<p>+2 Зорилт 11.2 2030 он гэхэд эмзэг бүлгийн хүн ам, эмэгтэйчүүд, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй болон өндөр настай хүмүүсийн хэрэгцээ шаардлагыг онцгой анхааран замын аюулгүй байдал, тухайлбал нийтийн тээврийг өргөжүүлэн сайжруулах замаар аюулгүй, хямд үнэтэй, хүртээмжтэй, тогтвортой тээврийн системийг хүн бүрт хүргэх</p>
<p>Зорилт 9.22. Зорчигчдын ариун цэвэр, аюулгүй байдлыг хангасан, ая тухтай зорчих нөхцөлийг бүрдүүлсэн, нийтийн тээврийн хэрэгсэл, зогсоолтой болно.</p>	<p>9.22.1. Нийтийн тээврийн үйлчилгээнд байгаль орчинд ээлтэй автобусаар парк шинэчлэлт хийсэн байна. 9.22.2. Цахилгаан тээврийн хэрэгслийг цахилгаан эх үүсвэрээр цэнэглэх цэгийг байгуулсан байна. 9.22.3. Зорчигч тээврийн үйлчилгээний зогсоолыг сайжруулж, стандартын дагуу байгуулна.</p>	<p>+2 Зорилт 11.2 2030 он гэхэд эмзэг бүлгийн хүн ам, эмэгтэйчүүд, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй болон өндөр настай хүмүүсийн хэрэгцээ шаардлагыг онцгой анхааран замын аюулгүй байдал, тухайлбал нийтийн тээврийг өргөжүүлэн сайжруулах замаар аюулгүй, хямд үнэтэй, хүртээмжтэй, тогтвортой тээврийн системийг хүн бүрт хүргэх</p>
<p>Зорилт 9.23. Улаанбаатар хотод ачаа тээврийн логистик, зорчигчдын ая тухтай зорчих нөхцөлийг хангасан зорчигч тээврийн нэгдсэн терминал байгуулна.</p>	<p>9.23.1. Улаанбаатар хотын зүүн, баруун хэсэгт ачаа тээврийн логистик, зорчигч тээврийн нэгдсэн терминал байгуулсан байна.</p>	<p>+2 Зорилт 11.2 2030 он гэхэд эмзэг бүлгийн хүн ам, эмэгтэйчүүд, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй болон өндөр настай хүмүүсийн хэрэгцээ шаардлагыг онцгой анхааран замын аюулгүй байдал, тухайлбал нийтийн тээврийг өргөжүүлэн</p>

		сайжруулах замаар аюулгүй, хямд үнэтэй, хүртээмжтэй, тогтвортой тээврийн системийг хүн бүрт хүргэх
--	--	--

Хүснэгт 17. “Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван үндсэн чиглэл”-д Тогтвортой хөгжлийн зорилгод тодорхойлсон зорилтуудын тусгагдсан байдлын үнэлгээ

Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн таван чиглэл		Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилго, зорилтуудтай холбогдох уялдаа		
		Шууд тусгагдсан -1	Агуулгын хувьд уялдсан-2	Хамааралгүй-0
Нэг. Үндэсний нэгдмэл зүйл	Зорилт.1	2	0	0
Хоёр. Хүний хөгжил	Боловсрол	3	1	0
	Эрүүл мэнд	7	0	0
	Гэр бүл	3	0	0
	Хөдөлмөрийн зах зээл	1	0	0
	Угийн бичиг	0	0	1
Гурав. Амьдралын чанар ба дундаж давхарга	Нийгмийн хамгаалал	0	2	0
	Хөдөлмөр эрхлэлт ба гарааны бизнес	1	1	0
	Эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг	0	0	1
Дөрөв. Эдийн засаг	Олон тулгуурт, бие даасан эдийн засаг	0	1	0
	Инновац, энтрепренёршип	0	1	0
	Эдийн засгийн тэргүүлэх чиглэл	0	1	0
	Эдийн засгийн орон зай	0	1	0
	Хариуцлагатай, эрсдэл даах үйлдвэрлэл, үйлчилгээ	0	1	0
	Бүс нутгийн хамтын ажиллагаа	1	0	0
Тав. Хамтын ажиллагаа	Ухаалаг засаглал	1	0	0
	Цахим монгол (иргэн, төр, хувийн хэвшлийн нэгдсэн систем)	0	1	0
	Чадварлаг, ёс зүйтэй төрийн алба	0	1	0
	Хүний эрхийг дээдэлсэн нийгэм	0	1	0

	Авлигагүй засаглал	0	1	0
Зургаа. Ногоон хөгжил	Экосистем	0	1	0
	Хүрээлэн буй орчин	0	1	0
	Усан орчин	0	1	0
	Тохижилт, ногоон байгууламж	0	1	0
Долоо. Амар тайван аюулгүй нийгэм	Зорилт.1	0	0	1
	Зорилт.2	0	1	0
	Зорилт.3	0	1	0
	Зорилт.4	0	1	0
Найм. Бүс орон нутгийн хөгжил	Зорилт.1	0	1	0
Ес. Улаанбаатар ба дагуул хот	Хотын орон зайн оновчтой төлөвлөлт	0	2	0
	Ухаалаг технологи	0	1	0
	Газрын харилцаа	0	1	0
	Хотын стандарт	0	1	0
	Дахин төлөвлөлт	0	1	0
	Орон сууцны бодлого	0	3	0
	Цахилгаан хангамж	0	1	1
	Дулаан хангамж	0	1	0
	Мэдээлэл холбоо	0	1	0
	Инженерийн бэлтгэл арга хэмжээ	0	1	0
	Ус хангамж, ариутгах татуурга	0	4	0
	Авто зам, нийтийн тээвэр	1	4	0
Зорилтуудын нийт эзлэх хувь 9 зорилго, 66 зорилт,		20	42	4

Дээрх хүснэгтээс үзвэл, “Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван үндсэн чиглэл”-д дэвшүүлсэн 20 зорилт буюу зорилтуудын 30.3 хувь нь “Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилтууд”-аас шууд тусгасан шинжтэй, 42 зорилт буюу 63.6 хувь нь ДТХЗ-той агуулгын хувьд уялдсан, 4 зорилт буюу 6 хувь нь тус баримт бичигтэй хамааралгүй гэсэн үнэлгээ гарч байна. Үүнийг илүү нарийвчлан, “Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван үндсэн чиглэл”-д тусгасан зорилтууд нь Тогтвортой хөгжлийн зорилтуудын хэдэн хувийг хангах, уг баримт бичгийн ямар зорилтыг нийслэл түлхүү хэрэгжүүлэхээр тусгасан, ямар зорилтууд нь

төлөвлөгдөөгүй байгааг дүгнэхийн тулд зорилтуудын тоон харьцуулалтыг гаргана. Нийслэлийн бодлогод, тогтвортой хөгжлийн 169 зорилтоос хэд нь тусгагдсан тухай тоогоор илэрхийлнэ.

Хүснэгт 18. Тогтвортой хөгжлийн зорилго, зорилтод Нийслэлийн хөгжлийн бодлогын зорилго, зорилт тусгагдсан байдал

Зорилго	Тогтвортой хөгжлийн зорилгын нэр	Зорилт	Үзүүлэлт	Нийслэлийн бодлогод тусгагдсан байдал
1	Ядуурлыг устгах	7	14	1
2	Өлсгөлөнг зогсоох	8	13	1
3	Эрүүл мэндийг дэмжих	13	27	6
4	Чанартай боловсролыг дэмжих	10	11	6
5	Жендэрийн эрх, тэгш байдлыг хангах	9	14	2
6	Баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах	8	11	5
7	Сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх	5	6	2
8	Эдийн засгийн өсөлт, баталгаат ажлын байрыг бий болгох	12	17	2
9	Инноваци болон дэд бүтцийн нэмэгдүүлэх	8	12	5
10	Тэгш бус байдлыг бууруулах	10	11	-
11	Ээлтэй хот, иргэдийн оролцоог дэмжих	10	15	7
12	Хариуцлагатай хэрэглээг дэмжих	11	13	2
13	Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах	5	8	-
14	Далай, тэнгисийн нөөцийг хамгаалах	10	10	Нийслэлд хамаарахгүй
15	Хуурай газрын эко системийг хамгаалах	12	14	2
16	Энх тайван, шударга ёсыг цогцлоох	12	23	4
17	Хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэх	19	25	2
Бүгд		169	244	47

Хүснэгтээс дүгнэвэл, нийслэлийг хөгжүүлэх бодлого нь ТХЗ-ын 244 зорилтоос 44-ийг хэрэгжүүлэх буюу 19.26 хувийг хангаж байна. Гэсэн хэдий ч тус бодлого нь Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх дунд хугацааны төлөвлөлтийн баримт бичиг тул дээрх үзүүлэлт нь 100 хувиар үнэлэгдэх шаардлагагүй бөгөөд хүснэгтийн гол зорилго нь дэвшүүлсэн зорилтуудын тоон харьцаанд дүн шинжилгээ хийх юм. Гэвч нийслэлийн бодлогын баримт бичиг нь дунд хугацааны төлөвлөлтийн баримт бичиг болохын хувьд, тогтвортой хөгжлийн зорилтуудыг зохих ёсоор тусгах нь нийслэлд тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх буюу Монгол Улсын хүн амын 47 гаруй хувьд хүрч үйлчилнэ гэсэн үг юм. Цаашилбал, тогтвортой хөгжлийн үзүүлэлтээр Монгол Улсын түвшин ахихад чухал нөлөө үзүүлэхээр байна.

Тогтвортой хөгжлийн зорилттой харьцуулан авч үзвэл, нийслэлийн бодлогод, эрүүл мэндийг дэмжих болон чанартай боловсролыг дэмжих чиглэлийн зорилтууд түлхүү тусгагдсан байна. Гэвч ядуурлыг устгах, өлсгөлөнг зогсоох чиглэлээр тусгасан зорилт хангалтгүй байх бөгөөд тэгш бус байдлыг бууруулах болон уур амьсгалын өөрчлөлтийн үр

нөлөөг багасгах чиглэлээр зорилт дэвшүүлээгүй байна. Тогтвортой хөгжлийн зорилтын Тэгш бус байдлыг бууруулах 10 дугаар зорилтын 10.7-д “Төлөвлөлт, зохицуулалт сайтай шилжилт хөдөлгөөний бодлого хэрэгжүүлэх замаар хүмүүсийн зохион байгуулалттай, аюулгүй, байнгын, хариуцлагатай шилжилт хөдөлгөөнийг дэмжих”, Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах 13 дугаар зорилтын 13.1-д “Улс орнуудад тулгарч буй цаг ууртай холбоотой аюул осол, байгалийн гамшгийг даван туулах, тэдгээрт зохицох чадавхыг бэхжүүлэх” зэрэг чухал зорилтуудыг дэвшүүлсэн байна. Гэвч нийслэлийн бодлогод, дээрх зорилгуудын хүрээнд дэвшүүлсэн зорилт байхгүй байна. Энэ нь тус зорилгуудын хүрээнд цаашид хэрэгжих шаардлагатай үйл ажиллагаанд болон нийслэлийн өмнө тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд саад учруулж болох бөгөөд Тогтвортой хөгжлийн зорилтоос үндэслэн боловсруулсан баримт бичгүүдийн бодлогын залгамж, уялдаа алдагдсан гэж дүгнэхээр байна. Хэдийгээр нийслэлийн бодлого нь зорилт тус бүрийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг нарийвчлан тогтоосон давуу талтай байх боловч бодлогын уялдааг сайжруулах, хийдэл давхардлыг урьдчилан шалгахад анхаарах нь зүйтэй гэж дүгнэлээ. Зарим улсын хувьд, бодлогын баримт бичгийг боловсруулах явцад дараах дүн шинжилгээ хийдэг байна. Үүнд,

1. Нөхцөл байдлын дүн шинжилгээ
2. Оролцогч талуудын дүн шинжилгээ
3. Асуудлын дүн шинжилгээ
4. Зорилгуудын дүн шинжилгээ
5. Хувилбаруудын дүн шинжилгээ³⁸

Дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийг талуудын оролцоотой боловсруулах ба оролцогч нар нь хөгжлийн бодлого, төлөвлөлт болон хууль, эрх зүйн орчны талаар өндөр мэдлэг, туршлагатай байхын зэрэгцээ бодлого боловсруулах явцад үндсэн 6 асуудлыг заавал авч үзэх шаардлагатай байдаг байна. Үүнд:

1. Улс орны хууль, эрх зүйд нийцсэн байх;
2. Байгаль орчны бохирдол, доройтлыг бууруулах;
3. Байгалийн баялгийн хомсдлыг бууруулах;
4. Жендэрийн тэгш байдлыг хангах;
5. Орлогыг шударга хуваарилах, ядуурлыг бууруулах;
6. Бүс нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах.³⁹

II. Нийслэлийн бодлогын хэрэгжилтийн үнэлгээ

G6. Үр дүнтэй хэрэгжилт /Effective Implementation

G6.1. Нийслэлийн Засаг даргын үр дүнтэй байдал /Government Effectiveness/

Асуулт: Нийслэлийн Засаг дарга бодлогын зорилтыг үр дүнтэй биелүүлж чадаж байна уу.

Тайлбар: Энэ асуултын хүрээнд Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хэрэгжилтийн гүйцэтгэлийг дүгнэхийг зорино. Тиймээс үнэлгээ нь Нийслэлийн Засаг даргаас тодорхойлсон бодлогын тэргүүлэх чиглэлүүдэд төвлөрч, зарласан зорилтууд хэрэгжиж байгаа эсэхийг шалгах ёстой

³⁸ An Introduction to the Policy Process: Theories, Concepts, and Model of Public Policy Making/ Third Edition, Thomas A. Birkland.

³⁹ Мөн тэнд,

Хүснэгт 19. Г6.1.Нийслэлийн Засаг даргын үр дүнтэй байдал үзүүлэлтийн үнэлгээ

Нийслэлийн Засаг дарга өөрийн бодлогын зорилтоо үндсэндээ хэрэгжүүлж чадаж байгаа.	10
	9
Нийслэлийн Засаг дарга бодлогын зорилгоо зарим талаараа амжилттай хэрэгжүүлж байгаа эсвэл зарим бодлогын зорилтоо хэрэгжүүлж чадаж байгаа.	8
	7
	6
Нийслэлийн Засаг дарга тавьсан зорилтоо хэсэгчлэн хэрэгжүүлээгүй, эсвэл хэд хэдэн бодлогын зорилтоо хэрэгжүүлээгүй.	5
	4
	3
Нийслэлийн Засаг дарга бодлогын зорилтоо хэрэгжүүлээгүй.	2
	1

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 02/10 дугаар тогтоолоор “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр” -ийг баталсан. Нийслэлийн Засаг даргын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн А/1076 дугаар захирамжаар байгуулагдсан Ажлын хэсэг, 6 Дэд ажлын хэсэг нь “Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны сонгуульд Нийслэлийн Монгол Ардын намын хорооноос дэвшүүлсэн мөрийн хөтөлбөртэй уялдуулан, “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, “Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” дунд хугацааны төлөвлөлтийн баримт бичигт тусгасан зорилт, арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэх, нийслэлийн хүн ам, нийгэм, эдийн засгийн хөгжил, байгаль орчны тэнцвэртэй байдал, засаглалыг сайжруулахад чиглэсэн, нэгдмэл цогц, харилцан уялдаатай, давхардалгүй, хүртээмжтэй, бүх нийтийн оролцоог хангасан байх зарчмуудыг баримтлан “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр” төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулсан байна. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө нь Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 онд дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлж, Нийслэлийг бие даан хөгжих, орон зайн оновчтой төлөвлөлт, ухаалаг шийдэл, амьдралын таатай орчин бүхий ногоон хот болгон хөгжүүлэх суурийг бүрдүүлэхэд чиглэсэн 6 бүлэг, 22 тэргүүлэх зорилт, 132 зорилтуудыг дэвшүүлсэн байна. Тус 6 бүлэг нь:

1. Ковид-19 халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлого,
2. Хүний хөгжлийн бодлого,
3. Эдийн засгийн бодлого,
4. Засаглалын бодлого,
5. Ногоон хөгжлийн бодлого,
6. Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого гэсэн байна.

“Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө” нь нийт 410 арга хэмжээ, 399 хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинтэй бөгөөд нийт 10.4 их наяд төгрөгөөр санхүүжүүлэн хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. Уг төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, биелэлт хэрэгжилт, үр дүнгийн явцын талаар тайлагнан ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт Засаг дарга үүрэг болгожээ. Засаг даргын тамгын газрын вэб сайтад уг хөтөлбөр болон нийслэлийг хөгжүүлэх 2022 оны төлөвлөгөө зэрэг баримт бичгүүд байх боловч уг төлөвлөгөөний биелэлт буюу

түүнд хяналт шинжилгээ хийсэн тайланг ил тод байршуулаагүй байна. Энэ нь дээрх шалгуур үзүүлэлтийг үнэлэхэд бэрхшээл учруулж байхаас гадна нийслэлийн мэдээ, мэдээлэл ил тод байршдаг эсэх талаар үнэлж буй G9.2 дахь үзүүлэлтэд нөлөөлж буйг дурдах нь зүйтэй. Түүнчлэн Нийслэлийн Засаг даргын харьяа агентлаг, байгууллагууд нь жилийн эцсийн тайланг Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний баримт бичигт нийцүүлэн тайлагнасан, цахим хуудсандаа нийтэлсэн байх боловч Нийслэлийн Засаг даргын тамгын газраас нэгтгэж үнэлсэн буюу түүнд хяналт шинжилгээ хийсэн бодит үнэлгээ биш учир судлаач ашиглахад тохиромжгүй байна. Тус үндэслэлээр Нийслэлийн Засаг дарга бодлогын зорилтыг үр дүнтэй биелүүлж чадаж байгаа эсэх? асуултад хариулах боломжгүй байх тул энд үнэлгээг тэгээр тооцох болно.

G6.2.а. Удирдлагын нийцэл /Ministerial Compliance


Асуулт: Нийслэлийн Засаг даргын харьяа байгууллагын удирдлага нь Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааг хэрхэн дэмждэг вэ?

Тайлбар: Нийслэлийн Засаг даргын харьяа байгууллагын удирдлагын механизмид боловсон хүчин, бодлого, бүтэц зэрэг хүчин зүйлийг авч үздэг багтана.

Хүснэгт 20. G6.2.а.Удирдлагын нийцэл үзүүлэлтийн үнэлгээ

Нийслэлийн Засаг даргын харьяа байгууллагын удирдлага нь Нийслэлийн Засаг даргын тодорхой чиг үүргийг хэрэгжүүлэх хүчтэй механизмыг амжилттай бүрдүүлж өгсөн.	10
	9
Нийслэлийн Засаг даргын харьяа байгууллагын удирдлага нь Нийслэлийн Засаг даргын тодорхой чиг үүргийг хэрэгжүүлэх зарим механизмыг бүрдүүлсэн.	8
	7
	6
Нийслэлийн Засаг даргын харьяа байгууллагын удирдлага нь Нийслэлийн Засаг даргын тодорхой чиг үүргийг хэрэгжүүлэх механизм сул байна.	5
	4
	3
Нийслэлийн Засаг даргын харьяа байгууллагын удирдлага нь Нийслэлийн Засаг даргын тодорхой чиг үүргийг хэрэгжүүлэх механизмыг бүрдүүлээгүй.	2
	1

Тус асуултад хариулахын тулд Нийслэлийн Засаг даргын харьяа агентлаг, байгууллагууд болон чиг үүргийн хувьд нийслэлтэй уялдаж үйл ажиллагаа хэрэгжүүлж буй байгууллагуудыг авч үзлээ. Доор дурдсанаар нийт Нийслэлийн Засаг даргын тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас бусад 96 нэгж газар байна. МУЗЗНДНТУтХ, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль болон холбогдох харьяа байгууллага, агентлагын дүрмийг үзвэл, Нийслэлийн Засаг даргын зохион байгуулалтын бүтэц нь босоо тогтолцоотой удирдлагын системийг хэрэгжүүлж байна. Энэхүү босоо тогтолцоотой удирдлагын системийн хүрээнд доод шатны байгууллагын албан тушаалтнууд дээд шатны буюу Нийслэлийн Засаг даргын баталсан бодлого, хөтөлбөр, төлөвлөлтийг үйл ажиллагаандаа дагаж мөрдөх үүрэг хүлээнэ. Нийслэлийн Засаг даргын харьяа агентлаг, байгууллагууд нь эрүүл мэнд, эдийн засаг, дэд бүтэц, нийгэм, боловсрол, засаглалын чиглэлээр тус бүр тодорхой чиг үүрэгтэй байх боловч тус байгууллагуудыг Засгийн газрын тогтоол эсхүл Нийслэлийн Засаг даргын захирамжаар байгуулсан нь чиг үүрэг болон удирдлагын системийн хувьд давхардал үүсгэж данхар бүтцийг бий болгож байна. Нийслэлийн байгууллагууд нь Нийслэлийн Засаг даргын тодорхой чиг үүргийг хэрэгжүүлэх механизмыг бүрдүүлсэн боловч Улаанбаатар хотын




удирдлага, зохион байгуулалт, чиг үүргийн хуваарилалтыг оновчтой бус байгаа үндэслэлээр энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд 6 оноо өгөх үндэслэлтэй байна.

Нийслэлийн Засаг даргын харьяанд дараах агентлагууд байна.

1. Агаар, орчны бохирдолтой тэмцэх газар;
2. Архивын газар;
3. Аялал жуулчлалын газар;
4. Байгаль орчны газар (Зуслангийн товчоотой);
5. Бизнес инновац хөгжлийн газар;
6. Дотоод аудитын алба;
7. Замын хөгжлийн газар;
8. Биеийн тамир, спортын газар;
9. Боловсролын газар;
10. Газар зохион байгуулалтын алба;
11. Хот байгуулалт, хөгжлийн газар;
12. Орон сууцны бодлогын газар;
13. Цахим хөгжил, мэдээллийн технологийн газар;
14. Нийтийн тээврийн газар;
15. Дагуул хот, эдийн засгийн тусгай бүсийн хөгжлийн газар;
16. Өмчийн харилцааны газар;
17. Соёл, урлагийн газар;
18. Худалдан авах ажиллагааны газар;
19. Хүнс, хөдөө аж ахуйн газар;
20. Эрүүл мэндийн газар;
21. Хотын стандарт, хяналтын газар;
22. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар;
23. Мал эмнэлгийн газар;
24. Нийгмийн даатгалын газар;
25. Хөдөлмөр, халамжийн газар;
26. Нийтлэг үйлчилгээний газар;
27. Улсын бүртгэлийн газар;
28. Онцгой байдлын газар (нөөцийн албатай);
29. Статистикийн газар;
30. Татварын газар;
31. Цагдаагийн удирдах газар;
32. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар.

Нийслэлийн Засаг даргын харьяа Орон нутгийн болон нийслэлийн өмчит тооцоот үйлдвэрийн газрууд

1. Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ
2. Нийслэлийн Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих төв ОНӨТҮГ
3. Нийслэлийн Төр захиргааны автобааз ОНӨТҮГ
4. Багануур дүүргийн үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ
5. Багахангай дүүргийн Үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ
6. Эмээлт эко аж үйлдвэрийн парк НӨААТҮГ
7. Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк ОНӨААТҮГ
8. Монгол наадам ОНӨТҮГ
9. Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ

- 
10. Улаанбаатар театр ОНӨТҮГ
 11. Хүүхэд залуучуудын сургалт хүмүүжлийн тусгай цогцолбор ОНӨТҮГ
 12. Монголын хүүхдийн ордон ОНӨТҮГ
 13. Монголын хүүхдийн урлан бүтээх төв ОНӨТҮГ
 14. Нийгмийн хамгааллын тусгай төв ОНӨТҮГ
 15. Асгат ОНӨААТҮГ
 16. Багачууд хүнс ОНӨААТҮГ
 17. Хүнс хангамж ОНӨААТҮГ
 18. Өсвөр үе хүнс ОНӨААТҮГ
 19. Гэрлэх ёслолын ордон ОНӨААТҮГ
 20. Замын хөдөлгөөний удирдлагын төв ОНӨТҮГ
 21. Улаанбаатар лифт ОНӨТҮГ
 22. Улаанбаатар хотын шуурхай, удирдлага, зохицуулалтын төв
 23. Үндэсний цэцэрлэгт хүрээлэн ОНӨТҮГ
 24. Үртсэн шахмал түлшний үйлдвэр ОНӨААТҮГ
 25. Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ
 26. Зорчигч тээврийн гурав ОНӨААТҮГ
 27. Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ
 28. Геофизи усны барилга, байгууламжийн газар ОНӨААТҮГ

Нийслэлийн Засаг даргын харьяа бусад байгууллага, төв

1. Улаанбаатар хотын нийтийн төв номын сан
2. Улаанбаатар хотын музей
3. Соёлын төв өргөө
4. Нийслэлийн Аддиктологийн төв
5. Нийслэлийн Амгалан амаржих газар
6. Нийслэлийн Өргөө амаржих газар
7. Нийслэлийн Хүрээ амаржих газар
8. Нийслэлийн түргэн тусламжийн төв
9. Нийслэлийн шүд, эрүү, нүүрний төв
10. Нийслэлийн хүүхлийн сэргээн засах эрүүл үрс төв
11. Сэргээн засах клиник эмнэлэг
12. Соёлын төв өргөө
13. Гэрлэх ёслолын ордон
14. Уламжлалт анагаах ухааны элэг судлалын клиник төв
15. Энэрэл эмнэлэг
16. Хүүхдийн сэргээн засах Хан туул төв
17. Ахмадын хороо
18. Орон сууц нийтийн аж ахуйн газар
19. Улаанбаатар зам засвар арчлалтын газар
20. Улаанбаатар хотын Ус сувгийн удирдах газар
21. Хот тохижилтын газар
22. Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдамжийн газар

Нийслэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд туслах чиг үүрэгтэй хамтран оролцогч компаниуд

1. Нийслэлийн орон сууцны корпораци ХК
2. Улаанбаатар шинэ бүтээн байгуулалт ХХК

3. Тавантолгой түлш ХХК
4. Улаанбаатар хотын хийн сүлжээ ХХК
5. Улаанбаатар хотын хөгжлийн корпораци ХК
6. Олон улсын худалдаа логистикийн төв ХК

Улаанбаатар хотын хүрээнд хэрэгжиж буй төслүүд

1. Улаанбаатар хотын тогтвортой авто зам, тээвэр төслийн нэгж
2. Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж
3. Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төсөл
4. Улаанбаатар хотын орлогод нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл салбарын төсөл
5. Улаанбаатар хотын хүнсний хог хаягдлыг дахин боловсруулах төсөл
6. Улаанбаатар хотын хатуу хог хаягдлын байгууламжийг шинэчлэх төслийн нэгж
7. Гэр хорооллын нийтийн тээврийн үйлчилгээг сайжруулах төсөл
8. Улаанбаатар хотын нийтийн аж ахуйг сайжруулах хоёр дахь төслийн удирдах нэгж

G6.2.b. Нийслэлийн Засаг даргад хяналт тавих /Monitoring Ministries

Асуулт: Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагаанд хэр үр дүнтэй хяналт тавьдаг вэ?

Тайлбар: Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь Нийслэлийн Засаг даргын бодлого боловсруулах, бодлого хэрэгжүүлэх үйл ажиллагаанд бодитойгоор хяналт тавьж ажиллаж байгаа эсэхийг энэхүү шалгуурын хүрээнд үнэлнэ.

Хүснэгт 21. G6.2.b. Нийслэлийн Засаг даргад хяналт тавих үзүүлэлтийн үнэлгээ

Нийслэлийн Засаг даргын бодлого боловсруулах, хэрэгжүүлэхтэй холбоотой бүхий л үйл ажиллагаанд хяналт тавьж ажилладаг.	10
	9
Нийслэлийн Засаг даргын бодлого боловсруулах, хэрэгжүүлэхтэй холбоотой ихэнх үйл ажиллагаанд хяналт тавьж ажилладаг.	8
	7
	6
Нийслэлийн Засаг даргын бодлого боловсруулах, хэрэгжүүлэхтэй холбоотой хууль тогтоомжид заасан тодорхой үйл ажиллагаанд хяналт тавьж ажилладаг.	5
	4
	3
Нийслэлийн Засаг даргын бодлого боловсруулах, хэрэгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагаанд хяналт тавьдаггүй	2
	1

МУЗЗНДНТУТХ-ийн 35.1.5, 35.1.6-д заасны дагуу Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг баталж, тус хурлын шийдвэрийн хэрэгжилтийн талаар Засаг даргын тайланг сонсож, түүнд дүгнэлт өгөх бүрэн эрхтэй байна. Харин тус хурлын дарга нь МУЗЗНДНТУТХ-ийн 52.1.8-д заасны дагуу Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлийн биелэлтэд хяналт тавьж ажиллаж байна. Тиймээс энэхүү хуулийн дагуу Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал нь Засаг даргын бодлого боловсруулах, хэрэгжүүлэхтэй холбоотой бүхий л үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах тул 9 оноо өглөө.

G6.2.c. Нийслэлийн Засаг даргын хяналт /Monitoring Agencies/Bureaucracies/

Асуулт: Нийслэлийн Засаг дарга харьяа байгууллагын үйл ажиллагаанд үр дүнтэй хяналт тавьдаг эсэх ?

Тайлбар: Нийслэлийн Засаг даргын зүгээс харьяа байгууллагын үйл ажиллагаанд үр дүнтэй хяналт тавих эрх зүйн орчин бүрдсэн эсэхийг энэхүү үзүүлэлтээр шалгадаг. Нийслэлийн Засаг дарга нь хяналт тавихдаа хувийн ашиг сонирхлоос илүүтэй нийтийн ашиг сонирхлыг чухалчлах бөгөөд ингэснээр ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зэрэг үр нөлөөтэй.

Хүснэгт 22. G6.2.с. Нийслэлийн Засаг даргын хяналт үзүүлэлтийн үнэлгээ

Нийслэлийн Засаг даргын зүгээс харьяа бүх салбар байгууллагын үйл ажиллагаанд үр дүнтэй хяналт тавьдаг.	10
	9
Нийслэлийн Засаг даргын зүгээс харьяа ихэнх салбар байгууллагын үйл ажиллагаанд үр дүнтэй хяналт тавьдаг.	8
	7
	6
Нийслэлийн Засаг даргын зүгээс харьяа зарим салбар байгууллагын үйл ажиллагаанд үр дүнтэй хяналт тавьдаг	5
	4
	3
Нийслэлийн Засаг даргын зүгээс харьяа зарим салбар байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьдаггүй.	2
	1

Нийслэлийн Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн А/91 тоот захирамжийн хавсралтаар Нийслэлийн Дотоод аудитын албаны дүрмийг баталсан байна. Тус дүрмийн дагуу Дотоод аудитын алба нь Нийслэлийн Засаг даргын харьяа агентлаг, болон холбогдох байгууллагын үйл ажиллагаа, төсвийн хөрөнгө зарцуулалт нь хууль тогтоомж, гэрээнд нийцэж байгаа эсэхэд хяналт шинжилгээ хийх чиг үүрэгтэй байна.

Өөрөөр хэлбэл, Дотоод аудитын алба нь энэхүү шалгуур үзүүлэлтэд дурдсан асуудлаар холбогдох харьяа байгууллага, агентлагын үйл ажиллагаанд аудит хийж, дүгнэлт гаргах тул Нийслэлийн Засаг дарга нь үр дүнтэй хяналт тавьдаг буюу 9 оноо өглөө.

G6.3.а. Нийслэлийн төсөв, санхүүжилт /Task Funding/

Асуулт: Нийслэлийн бодлого, төлөвлөлтийг хэрэгжүүлэхэд зарцуулах төсвийг хэрхэн зохицуулдаг вэ?

Тайлбар: Нийслэлийн баталсан бодлого, төлөвлөлтийг биелүүлэхүйц хэмжээний төсвийг тухай бүр төсөвлөдөг эсэхийг үнэлнэ.

Хүснэгт 23. G6.3.а. Нийслэлийн төсөв, санхүүжилтийн үнэлгээ

Нийслэлийн төсвөөс бодлого, төлөвлөлтийг бүрэн биелүүлэхүйц хэмжээний төсвийг төсөвлөж өгдөг	10
	9
Нийслэлийн төсвөөс бодлого, төлөвлөлтийн ихэнх хэсгийг биелүүлэхүйц хэмжээний төсвийг төсөвлөж өгдөг	8
	7
	6
Нийслэлийн төсвөөс бодлого, төлөвлөлтийн цөөн хэсгийг биелүүлэхүйц хэмжээний төсвийг төсөвлөж өгдөг	5
	4
	3

Нийслэлийн төсвөөс бодлого, төлөвлөлтийг хэрэгжүүлэхэд хангалттай төсвийг төсөвлөдөггүй.	2
	1

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу Нийслэл нь өөрийн бие даасан төсөвтэй байхаар зохицуулсан. Энэхүү төсвийн хүрээнд нийслэл хотын хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтыг улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр зохицуулжээ.

Ийнхүү санхүүжүүлэх хувь хэмжээг эрх баригч намын бодлого, лобби зэргээс шалтгаалан тогтоох бөгөөд улсын төсвөөс санхүүжүүлэх хувийг хуулиар хязгаарлаагүй байна. Улмаар Нийслэлийн 2022 оны эхний 10 сарын байдлаар хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлд олгосон санхүүжилт авч үзье.

№	Эх үүсвэр	Ажлын тоо	Төсөвт өртөг	2022 онд санхүүжих дүн	Олгосон санхүүжилт	Олгосон санхүүжилтийн хувь
1	Нийслэлийн төсөв /2022 он/	387	1,236,379.4	575,433.4	220,031.2	38.2%
2	Нийслэлийн төсөв /2021-2022 он/	235	117,833.8	18,970.4	6,695.7	35.3%
ДҮН		622	1,354,213.2	594,403.8	226,726.9	38.1%
3	Нийслэлийн замын сан /2022 он/	156	126,602.9	67,992.3	32,417.7	16.6%
4	Нийслэлийн замын сан /2021-2022 он/	63	35,963.4	17,000.9	7,401.1	23.6%
ДҮН		219	162,566.3	84,993.2	39,818.7	46.8%
5	ОНХСАН /2022 он/	77	15,403.8	14,648.1	5,332.8	36.0%
6	ОНХСАН /2021-2022 он/	172	18,250.9	13,757.8	2,462.9	18.0%
ДҮН		249	33,654.6	28,405.9	7,795.7	27.0%
НИЙТ ДҮН		1090	1,550,434.2	707,802.8	274,341.3	39.0%

Дээрхээс үзвэл, Нийслэлийн зүгээс төсөлд олгох санхүүжилтыг төслийн хэрэгжилтийн үе шаттай уялдуулан олгож байна. Түүнчлэн тухайн жилийн төсөвт тодотгол хийх байдлаар тодорхой төрлийн төслийн санхүүжилтийн төсвийг хасах эрх хуулиар олгогдсон байна. Тиймээс дээрх нөхцөл байдлыг харгалзан энэхүү шалгуурын хүрээнд 5 оноо өгөх үндэслэлтэй байна.

G6.3.b. Нийслэлийн Засаг дарга бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжтой эсэх /Constitutional Discretion/

Асуулт: Нийслэлийн Засаг дарга бусад төрийн байгууллага, албан тушаалтны аливаа зөвшөөрлийг авахгүйгээр хуульд заасан чиг үүрэг/бүрэн эрхээ бие даан хэрэгжүүлэх боломжтой эсэх

Тайлбар: Нийслэлийн Засаг дарга хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхээ аливаа албан тушаалтнаас хараат бусаар хэрэгжүүлэх байдлыг энэхүү хэсэгт үнэлнэ.

Хүснэгт 24. G6.3.b. Нийслэлийн Засаг дарга бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжтой эсэх үзүүлэлтийн үнэлгээ

Нийслэлийн Засаг дарга бүрэн эрхээ бие даан бүхэлд нь хэрэгжүүлэх боломжтой байдаг	10
	9
Нийслэлийн Засаг дарга дийлэнх бүрэн эрхээ бие даан бүхэлд нь хэрэгжүүлэх боломжтой байдаг	8
	7
	6
Нийслэлийн Засаг дарга цөөн бүрэн эрхээ бие даан бүхэлд нь хэрэгжүүлэх боломжтой байдаг	5
	4
	3
Нийслэлийн Засаг дарга бүрэн эрхээ бусад захиргааны байгууллагын зөвшөөрлийн үндсэн дээр хэрэгжүүлнэ	2
	1

МУЗЗНДНТУТХ, МУНУХЭЗБТХ болон бусад хууль тогтоомжийн дагуу Нийслэлийн Засаг дарга нь өөрт олгогдсон бүрэн эрхээ дээд болон доод шатны байгууллагын зөвшөөрөл, саналгүйгээр бие даан хэрэгжүүлэх боломжтой байна. Харин нутгийн өөрөө удирдах ёсны зарчмын дагуу Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал Засаг даргын үйл ажиллагаанд хяналт тавьж, чиглэл өгөх бүрэн эрхтэй болохыг дурдах нь зүйтэй. Тиймээс энэхүү шалгуурын хүрээнд 8 оноо өгөх үндэслэлтэй байна.

G6.3.c. Нийслэлээс бодлого, төлөвлөлтийг зохих стандартын дагуу боловсруулж, хэрэгжүүлдэг эсэх /National Standards/

Асуулт: Нийслэлээс бодлого, төлөвлөлтийг боловсруулах, батлахдаа хууль тогтоомжоор баталсан зохих стандартыг баримталдаг эсэх

Тайлбар: Энэхүү шалгуурын хүрээнд Нийслэлийн бодлого, төлөвлөлтийг боловсруулах, батлахдаа хууль тогтоомжид заасан бодлого боловсруулах аргачлал, стандартыг мөрддөг эсэхийг үнэлнэ.

Хүснэгт 25. G6.3.c. Нийслэлээс бодлого, төлөвлөлтийг зохих стандартын дагуу боловсруулж, хэрэгжүүлдэг эсэх үзүүлэлтийн үнэлгээ

Нийслэлээс бодлого, төлөвлөлтийг зохих стандартын дагуу боловсруулж, баталдаг	10
	9
Нийслэлээс ихэнх тохиолдолд бодлого, төлөвлөлтийг зохих стандартын дагуу боловсруулж, баталдаг	8
	7
	6
Нийслэлээс цөөн тохиолдолд бодлого, төлөвлөлтийг зохих стандартын дагуу боловсруулж, баталдаг	5
	4
	3
Нийслэлээс бодлого, төлөвлөлтийг зохих стандартын дагуу боловсруулж, баталдаггүй.	2
	1

“Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2020 оны 06 дугаар сараас мөрдөгдөж эхэлсэн. Уг хуульд “Монгол Улсын урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгийг үндэслэн аймаг, нийслэлийн дунд болон богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулна” гэж заасан. Нийслэлийн хувьд дунд хугацааны хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг нь “Нийслэлийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, богино хугацааны хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг нь “Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр” байна. Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр нь нийслэлийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхэд чиглэнэ. Ингэхдээ нийслэл болон түүний харьяа байгууллагууд Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан зорилго, зорилтыг хэрэгжүүлэх арга замыг тодорхойлсон стратеги төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллана гэж” Нийслэлийн 2021-2024 оны стратеги төлөвлөгөөнд тусгасан байна. ХБТТУХ-д заасан шаардлагын хүрээнд, “Нийслэлийг 2021-2025 онд хагжүүлэх таван үндсэн чиглэл” Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, Нийслэлийн 2021-2024 оны стратеги төлөвлөгөө зэрэг бодлогын баримт бичгүүд боловсруулагдсан байх тул уг шалгуур үзүүлэлтийг 9 оноогоор дүгнэж байна.

G6.4. Бодлого, төлөвлөгөөг хэрэгжүүлэх /Effective Regulatory Enforcement/

Асуулт: Нийслэлийн бодлого, төлөвлөгөөг үр дүнтэйгээр, бодитоор хэрэгжүүлж чадаж байгаа эсэх

Тайлбар: Энэхүү шалгуурын хүрээнд Нийслэлийн бодлого, төлөвлөгөөг холбогдох хугацааны дотор зохих ёсоор, бодитоор хэрэгжүүлж чадаж байгаа эсэхийг үнэлнэ.

Хүснэгт 26. G6.4. Бодлого, төлөвлөгөөг хэрэгжүүлэх үзүүлэлтийн үнэлгээ

Нийслэлийн Засаг дарга өөрийн бодлогын зорилтоо үндсэндээ хэрэгжүүлж чадаж байгаа.	10
	9
Нийслэлийн Засаг дарга бодлогын зорилгоо зарим талаараа амжилттай хэрэгжүүлж байгаа эсвэл зарим бодлогын зорилтоо хэрэгжүүлж чадаж байгаа.	8
	7
	6
Нийслэлийн Засаг дарга тавьсан зорилтоо хэсэгчлэн хэрэгжүүлээгүй, эсвэл хэд хэдэн бодлогын зорилтоо хэрэгжүүлээгүй.	5
	4
	3
Нийслэлийн Засаг дарга бодлогын зорилтоо хэрэгжүүлээгүй.	2
	1

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 19.2-д заасны дагуу Нийслэлийн засаг дарга нь дунд хугацааны хөгжлийн бодлогыг батлахдаа Монгол Улсын урт хугацааны бодлого, Монгол Улсын хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Хөгжлийн зорилтот хөтөлбөрт суурилж бодлогыг баримтлах үүрэгтэй байна. Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын дагуу Нийслэлийг хөгжүүлэх таван үндсэн чиглэл, Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэл хотыг хөгжүүлэх жилийн төлөвлөгөөний явцын тайланг жил тутам Засгийн газрын хэрэг эрхлэх газарт тайлагнахаар байна. Уг тайлан, гүйцэтгэлийн үнэлгээг нийтэд ил тод байршуулаагүй боловч уг шалгуурт



бодлого, төлөвлөгөөг холбогдох хугацааны дотор зохих ёсоор, бодитоор хэрэгжүүлж чадаж байгаа эсэхийг үнэлж байгаа тул уг шалгуур үзүүлэлтийг 9 оноогоор үнэлж байна.

G7. Нийцэл /Adaptability/

G7.1. Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны нийцэл /Domestic Adaptability/

Асуулт: Нийслэлийн Засаг дарга төрийн эрх бүхий байгууллага, дээд шатны захиргааны байгууллагаас баталсан хөтөлбөр, бодлогын баримт бичигт өөрийн үйл ажиллагаа, баримт бичгийг нийцүүлж байгаа эсэх

Тайлбар: Нийслэлийн Засаг дарга төрийн эрх бүхий байгууллага, дээд шатны захиргааны байгууллагаас баталсан хөтөлбөр, бодлогын баримт бичигт үйл ажиллагаагаа нийцүүлж чадаж байгаа эсэхийг үнэлнэ.

Хүснэгт 27. G7.1. Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны нийцлийн үзүүлэлтийн үнэлгээ

Нийслэлийн засаг дарга өөрийн бодлогоо холбогдох эрх зүйн баримт бичигт нийцүүлж баталдаг	10
	9
Нийслэлийн засаг дарга өөрийн бодлогоо холбогдох эрх зүйн баримт бичигт дийлэнх тохиолдолд нийцүүлж баталдаг	8
	7
	6
Нийслэлийн засаг дарга өөрийн бодлогоо холбогдох эрх зүйн баримт бичигт цөөн тохиолдолд нийцүүлж баталдаг	5
	4
	3
Нийслэлийн засаг дарга өөрийн бодлогоо холбогдох эрх зүйн баримт бичигт нийцүүлдэггүй	2
	1

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”- 6.7. “Засгийн газрын гишүүнээс аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт, стратеги төлөвлөгөө, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг үнэлэхдээ бодлогын баримт бичиг үнэлэх аргачлал, байгууллагын ил тод байдлыг хангах талаар хэрэгжүүлсэн үйл ажиллагааг үнэлэхдээ хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн үнэлгээ тооцдог аргачлалыг тус тус баримтална” гэж заажээ. Энэ хүрээнд, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Хөгжлийн зорилтот хөтөлбөр, Төрөөс баримтлах бодлого, Үндэсний хөтөлбөр, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний баримт бичгүүдэд нийцүүлэн Нийслэлийг хөгжүүлэх таван үндсэн чиглэл, Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэл хотыг хөгжүүлэх жилийн төлөвлөгөөний тайланг гаргах ёстой байна. Нийслэлийн тус бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө бүр нь дээд шатны бодлогын баримт бичиг бүртэй хэрхэн уялдаж, зорилтыг хангаж буй талаар тайлагнадаг эсэх нь тодорхойгүй байна. Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 1 дүгээр хавсралтад мөн энэ талаар тайлагнах тухай заагаагүй байна. Иймд, бодлогын баримт бичгийн нийцлийн үнэлгээний шалгуурт 5 оноо өгөх үндэслэлтэй байна.



G7.2. Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагаа олон улсын хөтөлбөр, чиг хандлага, үйл ажиллагаанд нийцэх /International Coordination/

Асуулт: Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагаа (бодлого, төлөвлөлт) нь олон улсын хөтөлбөр, үйл ажиллагаанд нийцэж байгаа эсэх

Тайлбар: Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагаа нь олон улсын хөтөлбөр, хамтын ажиллагааны хүрээнд Монгол Улсын зүгээс хэрэгжүүлж буй арга хэмжээний хүрээнд бодлого, төлөвлөлтөө нийцүүлж чадаж байгаа эсэхийг үнэлнэ.

Хүснэгт 28. G7.2. Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагаа олон улсын хөтөлбөр, чиг хандлага, үйл ажиллагаанд нийцлийн үзүүлэлтийн үнэлгээ

Нийслэлийн бодлого, төлөвлөлт нь Монгол Улсын нэгдэн орсон олон улсын хамтын ажиллагаа, хөтөлбөрт нийцдэг	10
	9
Нийслэлийн бодлого, төлөвлөлт нь Монгол Улсын нэгдэн орсон олон улсын хамтын ажиллагаа, хөтөлбөрт дийлэнх тохиолдолд нийцдэг	8
	7
	6
Нийслэлийн бодлого, төлөвлөлт нь Монгол Улсын нэгдэн орсон олон улсын хамтын ажиллагаа, хөтөлбөрт цөөн тохиолдолд нийцдэг	5
	4
	3
Нийслэлийн бодлого, төлөвлөлт нь Монгол Улсын нэгдэн орсон олон улсын хамтын ажиллагаа, хөтөлбөрт нийцдэггүй	2
	1

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.2.2.-д "дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлагад нийцсэн байх зарчим" гэж олон улсын гэрээ, конвенцоор хүлээсэн үүргийн дагуу дэлхий нийтийн хөгжлийн зорилго, чиг хандлагыг үндэсний онцлогт нийцүүлэн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт уялдуулан тусгахыг" гэж заасан. Үүний дагуу "Нийслэлийг хөгжүүлэх таван үндсэн чиглэл" нь дунд хугацааны төлөвлөлтийн баримт бичиг болохын тулд тус зарчим үйлчилнэ. Шалгуурын хүрээнд, Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагаа нь олон улсын хөтөлбөр, хамтын ажиллагаанд бодлого, төлөвлөлтөө нийцүүлж чадаж байгаа эсэхийг үнэлж байгаа тул нийслэлийн бодлогыг олон улсын бодлогын үзэл баримтлалтай уялдуулсан, харьцуулсан түүнд дүн шинжилгээ судалгаа, мэдээлэл байхгүй байна. Тиймээс энэхүү нөхцөл байдлыг харгалзан 5 оноо өгч байна.

G8. Бүтцийн өөрчлөлт хийх чадвар /Organizational Reform Capacity/

G8.1. Бүтцэд хяналт тавих /Self-monitoring/

Асуулт: Нийслэлийн Засаг дарга нь хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зохих бүтэц бүхий алба, агентлагтай эсэхэд хяналт тавих эрх бүхий байгууллага байгаа эсэх

Тайлбар: Нийслэлийн Засаг даргын харьяа агентлаг, байгууллага нь хуулиар хүлээсэн чиг үүргээ үр дүнтэйгээр хэрэгжүүлэх байдлаар зохион байгуулагдсан эсэхийг үнэлдэг эрх бүхий байгууллага байдаг эсэх, тус байгууллагаас тогтмол хяналт шалгалт хийж, тайлан, зөвлөмжийг холбогдох албан тушаалтанд хүргүүлж ажилладаг эсэхийг авч үзнэ.

Хүснэгт 25. G8.1. Бүтцэд хяналт тавих үзүүлэлтийн үнэлгээ

	10
--	----

Нийслэлийн Засаг даргын харьяа байгууллагын бүтэц, зохион байгуулалтад эрх бүхий байгууллага тогтмол хяналт тавьдаг	9
Нийслэлийн Засаг даргын харьяа байгууллагын бүтэц, зохион байгуулалтад эрх бүхий байгууллага ихэнх хяналт тавьдаг	8
	7
	6
Нийслэлийн Засаг даргын харьяа байгууллагын бүтэц, зохион байгуулалтад эрх бүхий байгууллага шаардлагатай тохиолдолд хяналт тавьдаг	5
	4
	3
Нийслэлийн Засаг даргын харьяа байгууллагын бүтэц, зохион байгуулалтад хяналт тавих эрх бүхий байгууллага байдаггүй	2
	1

Нийслэлийн зохион байгуулалтын бүтцийн хүрээнд тус байгууллагын харьяа байгууллага, агентлагуудын чиг үүргийн давхардал зэрэгт тогтмол хяналт тавих чиг үүрэг бүхий дотоод хяналтын байгууллага байхгүй байна. Харин Нийслэлийн Засаг даргын 2023 оны 10 сарын 18-ны өдрийн А/1218 тоот захирамжаар “Нийслэлийн нутгийн захиргааны болон харьяа байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийн хуваарилалтыг оновчтой болгох, ажлын уялдаа холбоог хангах, бүтээмжийг дээшлүүлэх, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд ажлын байрны дүн шинжилгээг ажлын хэсэг байгуулан хийлгэж байна. Тиймээс энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд 1 оноо өгөх үндэслэлтэй байна.

G8.2. Институцын өөрчлөлт

Асуулт: Нийслэлийн Засаг дарга засаглах арга хэлбэрээ тухай бүр шинэчилэн ажиллаж байгаа эсэх

Тайлбар: Нийслэлийн Засаг дарга бодлого, төлөвлөлтөд тусгасан зорилго, зорилтод хүрэхийн тулд өөрийн бүрэн эрхээ хэрэгжүүлэх, засаглах арга хэлбэрээ (императив, диспозитив зэрэг) тухай бүр шинэчилж чадаж байгаа эсэхийг энэхүү шалгуурын хүрээнд үнэлнэ.

Хүснэгт 29. G8.2. Институцын өөрчлөлтийн үнэлгээ

Нийслэлийн Засаг дарга бодлого, төлөвлөлтийн зорилго, зорилтоо хэрэгжүүлэхдээ засаглалын арга хэлбэрээ тухай бүр шинэчилж чаддаг	10
	9
Нийслэлийн Засаг дарга бодлого, төлөвлөлтийн зорилго, зорилтоо хэрэгжүүлэхдээ засаглалын арга хэлбэрээ ихэнх тохиолдолд шинэчилж чаддаг	8
	7
	6
Нийслэлийн Засаг дарга бодлого, төлөвлөлтийн зорилго, зорилтоо хэрэгжүүлэхдээ засаглалын арга хэлбэрээ цөөн тохиолдолд шинэчилж чаддаг	5
	4
	3
Нийслэлийн Засаг дарга бодлого, төлөвлөлтийн зорилго, зорилтоо хэрэгжүүлэхдээ засаглалын арга хэлбэрээ шинэчилж чаддаггүй	2
	1

Нийслэлийн Засаг дарга холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн асуудал/маргааныг императив эсхүл диспозитив (зөвшилцөх замаар) оновчтой байдлаар шийдвэрлэж байгаа эсэхийг авч үзье. Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлгээ өгөхөд Нийслэлийн Засаг даргын шийдвэртэй холбогдох маргаан он онуудад өссөн, буурсан эсэхийг авч үзэх шаардлагатай. Гэтэл Шүүхийн ерөнхий зөвлөл, Нийслэлийн Засаг даргын тамгын газар



болон холбогдох бусад эрх бүхий байгууллагаас дээрх асуудлаар судалгаа хийж, статистик тоон үзүүлэлт гаргаагүй байна. Иймд уг нөхцөлийг практик тодорхойгүй гэсэн шалтгаанаар 0 оноогоор үнэлсэн болно.

G9.1 Иргэдийн мэдээлэл авах боломж

Асуулт: Иргэд нийслэлийн бодлогын талаар мэдээлэл авах боломжтой эсэх

Тайлбар: Энэ асуултаар иргэд нийслэлийн бодлогын талаар мэдээлэл авах боломж хэр байгааг үнэлдэг. Иргэд бодлогын талаар өндөр түвшний мэдээлэлтэй байх ёстой. Тухайлбал, нийслэлийн бодлогын сэдэл, зорилго, үр нөлөө, үр дагаврыг иргэд ойлгох чадвартай байхыг хэлнэ.

Хүснэгт 30. G9.1 Нийслэлийн бодлогын талаар иргэд мэдээлэл авах боломж

Иргэд нийслэлийн бодлогын талаар өргөн хүрээний маш сайн мэдээлэлтэй авах боломжтой байдаг	10
	9
Иргэдийн дийлэнх нь нийслэлийн бодлогын талаар мэдээлэл авах боломжтой байдаг	8
	7
	6
Цөөн тооны иргэд нийслэлийн бодлогын талаар мэдээлэл авах боломжтой байдаг	5
	4
	3
Нийслэлийн бодлогын талаарх мэдээлэл хаалттай, хязгаарлагдмал байдаг.	2
	1

Нийслэлийн Засаг даргын тамгын газар нь Нийслэлийн Засаг даргын 2023 оны 05 сарын 03-ний өдрийн А/439 дугаартай дүрмийн 4.3-д заасны дагуу “хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийг бүртгэн, захирамжийг албажуулах, бүртгэх, мэдээлэх... төрийн үйлчилгээг чанартай, ил тод, шуурхай хүргэх, хүртээмжийг нэмэгдүүлэх, бичиг хэргийг эрхлэн хөтлөх” чиг үүрэгтэй байна. Энэхүү чиг үүргийн хүрээнд Нийслэлийн Засаг даргын баталсан бодлогын баримт бичгийг www.ulaanbaatar.mn вебсайтад нийтэд ил тод, нээлттэй байршуулдаг. Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаас баталсан бодлогын баримт бичиг нь тус байгууллагын албан ёсны вебсайт болох www.khural.ulaanbaatar.mn -д тухай бүр нээлттэй, ил тод байршиж байна.

Харин дээрх байгууллагууд нь бодлогын баримт бичгийг нийтэд сурталчилдаг эсэхийг авч үзвэл, Нийслэлийн Засаг даргын тамгын газар нь Хэвлэл мэдээлэлтэй харилцах хэлтэстэй байна. Тус байгууллага нь олон нийт, хэвлэл мэдээллийн хэрэгслээр бодлогын баримт бичгийг сурталчлах үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Тиймээс Нийслэлийн бодлогын баримт бичиг нь олон нийтэд нээлттэй, хүртээмжтэй байгаа тул 10 оноо өгөх үндэслэлтэй байна.

G9.2 Нээлттэй засаглал

Асуулт: Нийслэлийн захиргаа нь бодлогын хэрэгжилт, үр дүнгийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгдөг эсэх (тус мэдээллийг үндэслэн иргэд холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар хандах боломжтой эсэх)?

Тайлбар: Энэхүү асуултын хүрээнд нийслэл нь мэдээ, мэдээллийг иргэдэд хэрхэн хүргэж байгааг (жишээ нь: мэдээллийн олон талт байдал, нарийвчилсан байдал, нийтэлсэн цаг хугацаа, хүртээмжтэй эсэх, эрэлт хэрэгцээтэй байгаа эсэх) үнэлж байна. Мөн иргэдэд ээлтэй байдлаар (жишээ нь: мэдээ, мэдээллийн өгөгдлийн формат, мэдээлэлд хялбар хандах боломж, баримт бичигтэй танилцах зааварчилгаа, мэдээллийг үзэхэд ач холбогдолгүй, шаардлагагүй асуултуудгүй байх) байгаа эсэхийг үнэлнэ.

Хүснэгт 31. G9.2. Нээлттэй засаглалын үнэлгээ

Нийслэл мэдээ, мэдээллийг иж бүрэн, цаг алдалгүй, иргэдэд ээлтэй байдлаар нийтэлдэг.	10
	9
Нийслэл ихэнх тохиолдолд мэдээ, мэдээллийг иж бүрэн, цаг алдалгүй, иргэдэд ээлтэй байдлаар нийтэлдэг.	8
	7
	6
Нийслэл мэдээ, мэдээллийг цаг тухайд нь бус, хязгаарлагдмал байдлаар нийтэлдэг	5
	4
	3
Нийслэл холбогдох мэдээллийг бараг нийтэлдэггүй.	2
	1

Нийслэл нь Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагаатай холбоотой өдөр тутмын мэдээллийг тухай бүр www.ulaanbaatar.mn вебсайтаар нийтэд мэдээлдэг. Гэхдээ бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг тухай бүр хэвлэлийн хурал зарлах эсхүл холбогдох бусад арга хэрэгслээр нийтэд мэдээлдэггүй. Тус вебсайт дээр байршуулсан мэдээлэл нь бодлогын хэрэгжилт, үр дүнгийн талаар ерөнхий мэдээлэл байна.

Тиймээс Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэлтэй харилцах хэлтэс нь мэдээллийг тухай бүр нийтлэдэг боловч нийтэд хүргэж буй мэдээллийн агуулга, нийтэд хүргэх хэлбэр нь нийт иргэдэд хүрэх нөхцөл байдлыг хязгаарлаж байна гэж үзэх үндэслэлтэй. Өөрөөр хэлбэл, иргэд тус мэдээлэлтэй танилцаад ямар албан тушаалтан албан үүргээ зохих ёсоор сайн биелүүлсэн эсхүл биелүүлээгүй болохыг мэдэх боломжгүй байна. Үүнийг үндэслэн энэхүү шалгуурын хүрээнд 6 оноо өглөө.

G10.1 Засгийн газрын хяналтын нөөц

Асуулт: Нийслэлийн бодлого үр дүнтэй хэрэгжиж буй эсэхэд хяналт тавих бие даасан нэгж, бүтэц Засгийн газарт байна уу?

Тайлбар: Нийслэлийн үйл ажиллагаанд үр дүнтэй хяналт тавихын тулд Засгийн газар хяналт, шинжилгээг хэрэгжүүлэх бие даасан нөөц, бүтэцтэй байх ёстой. Энэ нэгж, бүтэц нь нийслэлийн бодлогын хэрэгжилтийг үнэлэхэд шаардлагатай мэдээ, мэдээллээр Засгийн газрыг хангах хараат бус, бие даасан шинжтэй байна.

Хүснэгт 32. G10.1 Засгийн газрын хяналтын нөөцийн үнэлгээ

Засгийн газар нийслэлийн хэрэгжүүлж буй бүхий л үйл ажиллагааг үр дүнтэй хянах бие даасан механизмтай.	10
	9
Засгийн газар нийслэлийн томоохон үйл ажиллагаанд хяналт тавихад тохирсон механизмтай.	8
	7
	6
Засгийн газар нийслэлийн зарим үйл ажиллагааг сонгон хянахад тохирсон механизмтай.	5
	4

	3
Засгийн газар нийслэлийн үйл ажиллагаанд хяналт тавих бие даасан механизмгүй.	2
	1

МУЗЗНДНТУТХ-д заасны дагуу Нийслэлийн Засаг дарга нь үйл ажиллагаагаа Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Монгол Улсын Засгийн газрын өмнө тайлагнадаг. Тус хуульд дараах байдлаар зохицуулжээ.

63.1.4.нийслэлийн төсвийн төсөл, түүний тодотголын төслийг боловсруулах, хэлэлцүүлэх, батлуулах, төсвийн гүйцэтгэлийг зохион байгуулж, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнах;

71.1.1.жил бүр үйл ажиллагааныхаа тайланг Засгийн газарт хүргүүлэх бөгөөд Засгийн газар уг тайланг хуралдаанаараа хэлэлцэж үнэлэлт, дүгнэлт өгөх;

Гэхдээ эдгээр байгууллагуудын бүтцэд өөрт нь тайлагнадаг байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий бие даасан байнгын үйл ажиллагаатай бүтэц байхгүй байна (МУЗЗНДНТУТХ, МУЗГТХ). Харин тус байгууллагын ажлын алба/хэрэг эрхлэх газар нь тус чиг үүргийг дам болон дам бусаар хэрэгжүүлж байна. Тиймээс энэхүү шалгуурын хүрээнд 1 оноо өгөх үндэслэлтэй байна.

G10.2. Бодлого, шийдвэрийн баримт бичигт хяналт тавих

Асуулт: Засгийн газар нийслэлээс баталсан бодлогын баримт бичгийг олж авахаар шаардах боломжтой юу?

Тайлбар: Засгийн газар нийслэлийн бодлогын баримт бичгийг хууль зүйн хувьд болон бодитойгоор олж авахад Засгийн газрын эрхийг хязгаарласан зохицуулалт бий эсэхийг үнэлнэ.

Хүснэгт 33. G10.2. Бодлого шийдвэрийн баримт бичгийн хяналтын үнэлгээ

Засгийн газар нийслэлийн боловсруулсан бүх баримт бичигт шууд хяналт тавих боломжтой. Нийслэл нь бодлого боловсруулж хэрэгжүүлэхийн өмнө Засгийн газарт мэдэгдэх ба Засгийн газраас санал өгөх боломжит хугацаанд баримт бичгийг хүргүүлдэг.	10
	9
Засгийн газар нийслэлийн зарим баримт бичгийг шаардах, хянахад тодорхой үе шаттай байхаар хязгаарлалт тогтоосон. Засгийн газарт баримт бичигт санал өгөх, хориг тавих зэрэг боломжит хугацаа байдаггүй.	8
	7
	6
Засгийн газар нийслэлийн зарим баримт бичгийг шаардах, хянахад хууль болон бусад эрх зүйн актаар хязгаарлалт тогтоосон. Засгийн газарт баримт бичигт санал өгөх, хориг тавих зэрэг боломжит хугацаа байдаггүй.	5
	4
	3
Засгийн газар нийслэлийн баримт бичгийг шаардах эрхгүй.	2
	1

МУЗЗНДНТУТХ-ийн 50-р зүйлд заасны дагуу Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэрт тухайн шатны Засаг дарга, түүний дээд шатны байгууллага эсхүл Ерөнхий сайд хориг тавих эрхтэй байна. Харин Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагаанд Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь МУЗЗНДНТУТХ-ийн 35.1.15-д заасны дагуу

хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлнэ. Түүнчлэн, Засгийн газраас Нийслэлийн Засаг даргын шийдвэр нь хуульд нийцээгүй гэж үзвэл, түүнийг хүчингүй болгох бүрэн эрхтэй байна.

Харин төрийн байгууллага хооронд мэдээлэл, баримт бичиг солилцоход хуулиар тодорхой хязгаарлалт тогтоогоогүй байна. Тиймээс Нийслэлийн Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас тодорхой бодлого боловсруулахаас өмнө Засгийн газарт мэдэгдэх үүргийг хуулиар хүлээлгээгүй. Мөн заавал Засгийн газрын саналыг авахаар зохицуулаагүй байна. Тиймээс Засгийн газраас санал өгөх эрхгүй хэдий ч, Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэрт хориг тавих эрхтэй байх тул энэхүү шалгуурын хүрээнд 6 оноог өглөө.

G10.3. Засаг даргын оролцоо

Асуулт: Ерөнхий сайд Засгийн газрын хуралдаанд Засаг даргыг дуудаж сонсгол хийх боломж бий эсэх?

Тайлбар: Засаг даргыг Засгийн газрын хуралдаанд оролцуулж сонсгол хийх боломжтой эсэхийг хууль эрх зүйн хувьд болон практикийн хувьд үнэлнэ. Энэ асуудалд зөвхөн Засгийн газрыг авч үзэх бөгөөд тодорхой ажлын хэсгийн хуралдааныг авч үзэхгүй болно.

Хүснэгт 34. G10.3. Засаг даргын оролцооны үнэлгээ

Засгийн газрын хуралдаанд оролцуулж болох ба Засаг даргыг уг хуралдаанд оролцохыг үүрэг болгосон.	10
	9
Засгийн газрын хуралдаанд оролцуулж болох тохиолдлыг хуульчилсан буюу үүнээс бусад тохиолдолд хязгаарлагдмал. Засаг дарга хуралд оролцохоос татгалзаж болно.	8
	7
	6
Засгийн газрын хуралдаанд оролцуулж болох тохиолдлыг хуульчлаагүй бөгөөд Засаг дарга хуралдаанд оролцохоос татгалзах эрхгүй.	5
	4
	3
Засгийн газрын хуралдаанд оролцуулж болохгүй.	2
	1

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 12.7-д “Аймаг, нийслэлийн Засаг даргаас бүрэн эрхээ хэрэгжүүлж байгаа байдлыг хянан шалгаж, тэдгээрийн үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангана” гэж заасан. Гэхдээ энэхүү хяналт шалгалтыг хийхдээ Засаг даргыг Засгийн газрын хуралдаанд оролцуулах болон Засаг дарга хуралдаанд заавал оролцохыг үүрэггүй байна. Харин тодорхой асуудлаар Засгийн газар тогтоол гаргаж, тогтоолд дурдсан асуудлыг танилцуулах зэргээр Нийслэлийн Засаг даргыг хуралдаанд оролцуулж байна.

МУЗЗНДНТУТХ-ийн 35.1.5-д заасны дагуу Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь мөн Засаг даргын үйл ажиллагаанд хяналт тавьж, хэрэгжилт үнэлэлт дүгнэлт өгөх бүрэн эрхтэй. Гэхдээ тус хуулийн 47.1-д заасны дагуу Засаг дарга нь тодорхой асуудал хуралдаанд оруулж шийдвэрлүүлэх эрхтэй. Харин хуралдаанд заавал орох үүрэг хүлээгээгүй байна. Тиймээс дээрх нөхцөл байдлыг харгалзан энэхүү шалгуурт 5 оноо өглөө.

G10.4. Мэргэжилтний оролцоог хангах

Асуулт: Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдаанаас шийдвэр гаргахад судлаач, мэргэшсэн шинжээч оролцуулах боломжтой юу?

Тайлбар: Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдаан хууль эрх зүйн хувьд судлаач, мэргэшсэн шинжээчдийг хуралдаанд оролцуулдаг эсэхийг дүгнэнэ. Энэ асуудалд зөвхөн Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлыг үнэлэх бөгөөд хурлын хороодыг үнэлэхгүй.

Хүснэгт 35. G10.4. Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын үнэлгээ

Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдаанд шинжээч, судлаач, мэргэжилтэн оролцуулах боломжтой.	10
	9
Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдаанд шинжээч, судлаач, мэргэжилтэн хязгаарлагдмал байдаг.	8
	7
	6
Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдаанд шинжээч, судлаач, мэргэжилтэн оролцуулах нь зөвхөн тодорхой тохиолдлуудад боломжтой.	5
	4
	3
Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын гишүүдээс бусад этгээдийг оролцохыг хязгаарласан.	2
	1

Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдаанд тухайн асуудлаар мэргэжлийн шинжээч, судлаач оруулах асуудлыг МУЗЗНДНТУтХ болон Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны дэгээр нарийвчлан зохицуулаагүй байна. Харин тус хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлыг хариуцсан ажлын хэсэгт орсон судлаач, мэргэжилтэн тухайн асуудлыг хэлэлцэх үед хуралдаанд оролцох боломжтой байна. Тиймээс хэдийгээр хууль тогтоомжоор мэргэжилтэн, судлаач оролцохыг хязгаарлаагүй боловч тодорхой тохиолдлуудад оролцох боломжтой байх тул энэхүү шалгуурт 3 оноо өглөө. Учир нь хууль тогтоомжид тодорхой тохиолдол бүрийг нэрлэн заагаагүй байна.

G10.5. Нийцэлтэй байдал

Асуулт: Засаг дарга өөрийн харьяа агентлаг, байгууллагуудын чиг үүрэг, үйл ажиллагаанд үр дүнтэй хяналт тавих тогтолцоо бий эсэх?

Тайлбар: Засаг даргын харьяа агентлаг, байгууллагуудын үндсэн чиглэлийн уялдаа холбоог хянах, үйл ажиллагаа нь үр дүнтэй хэрэгжиж буй эсэхийг үнэлэх тогтвортой механизм бий эсэхийг үнэлнэ. Ингэж үнэлэхдээ, Засаг даргын харьяа агентлаг, байгууллагуудын үйл ажиллагааг үнэлэх, хяналт шинжилгээ, мониторинг хийх бүтэц, нэгж бий эсэхийг авч үзнэ.

Энэ асуудалд зөвхөн байнгын үйл ажиллагаатай нэгжийг авч үзэх бөгөөд тодорхой асуудлыг шалгахар байгуулсан түр нэгжийг авч үзэхгүй.

Хүснэгт 36. G10.5. Нийцэлтэй байдлын үнэлгээ

Засаг даргын харьяа агентлаг, байгууллагуудын чиг үүрэг болон бүтэц хоорондын уялдаа холбоонд хяналт тавих бүтцийн нэгжтэй.	10
	9
Засаг даргын харьяа агентлаг, байгууллагуудын чиг үүрэг болон бүтэц хоорондын уялдаа холбоо нь хяналт тавихад бэрхшээлтэй боловч хэрэгжүүлэх боломжтой.	8
	7
	6
Засаг даргын харьяа агентлаг, байгууллагуудын чиг үүрэг болон бүтэц хоорондын уялдаа холбоонд хэсэгчлэн хяналт тавих боломжтой.	5
	4
	3
Засаг даргын харьяа агентлаг, байгууллагуудын чиг үүрэг болон бүтэц хоорондын уялдаа холбоонд нь үр дүнтэй хяналт тавихад тохирохгүй.	2
	1

Нийслэлийн Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн А/91 тоот захирамжийн хавсралтаар Нийслэлийн Дотоод аудитын албаны дүрмийг баталсан байна. Тус дүрмийн дагуу Дотоод аудитын алба нь Нийслэлийн Засаг даргын харьяа агентлаг, болон холбогдох байгууллагын үйл ажиллагаа, төсвийн хөрөнгө зарцуулалт нь хууль тогтоомж, гэрээнд нийцэж байгаа эсэхэд хяналт шинжилгээ хийх чиг үүрэгтэй байна. Тиймээс энэхүү шалгуурын хүрээнд Засаг даргын харьяа агентлаг, байгууллагын үйл ажиллагааг уялдуулах, хяналт тавих чиг үүрэг бүхий бүтцийн нэгж байгаа тул 10 оноо өглөө.

G11.1. Хэвлэл мэдээллийн байгууллагын оролцоо

Асуулт: Хэвлэл мэдээллийн байгууллагууд Нийслэлийн бодлогын үндэслэл, нөлөөллийн талаар хэр дүн шинжилгээ хийдэг вэ?

Тайлбар: Энэхүү асуулт нь хэвлэл мэдээллийн хэрэгслээр цаг тухайд нь, нөхцөл байдалд нийцүүлсэн мэдээлэл, дүн шинжилгээ, суурь мэдээллээр олон нийтэд нийслэлийн бодлогын үндэслэл, үр нөлөөг шүүмжлэлтэй үнэлэх боломжийг хангаж байгаа эсэхийг үнэлэхийг зорьдог. Асуулт нь тухайн улсын хамгийн чухал 10 олон нийтийн мэдээллийн хэрэгсэл (хэвлэмэл сонин, сэтгүүл, телевиз, сайт, радио) -д хамаарна. Нийслэлийн Засаг даргын захирамж, шийдвэрт (нийслэлийн үйл ажиллагааны явцыг ерөнхийд нь биш) голлон анхаардаг. Бодлогын асуудалд шүүмжлэлтэй хандах боломжийг олон нийтэд олгохын тулд хэвлэл мэдээллийн хэрэгслүүд Засгийн газар, Засаг дарга, Нийслэлийн иргэдийн төлөөлөгчийн хурал, иргэдийн төлөөлөл, төрийн бус байгууллага, хувийн хэвшил, тухайн захирамж шийдвэрийн нөлөөлөлд өртөж буй гол оролцогч талуудын байр суурийг тодруулан, талуудын оролцоог тэгш хангахад анхаарч, мэдээллийг бэлтгэхдээ үйл явцын талаар ерөнхий бус мэргэжилтний байр сууриас хандаж нарийвчилсан мэдээллээр хангах ёстой.

Хүснэгт 37. G11.1.Хэвлэл мэдээллийн байгууллагын оролцооны үнэлгээ

Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн 70 буюу түүнээс дээш хувь нь нийслэлийн бодлогын үндэслэл, үр нөлөөг задлан шинжилдэг өндөр чанартай мэдээллийн контентыг бэлтгэдэг.	10
	9
Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн 50 буюу түүнээс дээш хувь нь нийслэлийн бодлогын үндэслэл, үр нөлөөг задлан шинжилдэг өндөр чанартай мэдээллийн контент бэлтгэдэг. Үлдсэн хэсэг нь мэдээллийг папарацци, шуугиан болгох зорилгоор нийтэлдэг.	8
	7
	6
Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн 50-с доош хувь нь нийслэлийн бодлогын үндэслэл, үр нөлөөг задлан шинжилдэг. Үлдсэн хэсэг нь мэдээллийг папарацци, шуугиан болгох зорилгоор нийтэлдэг.	5
	4
	3
Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн 70 буюу түүнээс дээш хувь нь мэдээллийг папарацци, шуугиан болгох зорилгоор нийтэлдэг.	2
	1

Нийслэл нь Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагаатай холбоотой өдөр тутмын мэдээллийг тухай бүр www.ulaanbaatar.mn вебсайтаар нийтэд мэдээлдэг. Гэхдээ бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг тухай бүр хэвлэлийн хурал зарлах эсхүл холбогдох бусад арга хэрэгслээр нийтэд мэдээлдэггүй. Тус вебсайт дээр байршуулсан мэдээлэл нь бодлогын хэрэгжилт, үр дүнгийн талаар ерөнхий мэдээлэл байна.

Тиймээс Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэлтэй харилцах хэлтэс нь мэдээллийг тухай бүр нийтлэдэг боловч нийтэд хүргэж буй мэдээллийн агуулга, нийтэд хүргэх хэлбэр нь хязгаарлагдмал. Харин хэвлэл мэдээллийн хэрэгслээр Нийслэлийн бодлогын хэрэгжилтийн хүрээнд судалгаа хийж, мэдээлэл бэлтгэдэг эсэх талаар өнөөдрийн байдлаар хийгдсэн асуулга, судалгааны материал байхгүй байх тул энэхүү асуултын хүрээнд бодитой үнэлгээ өгөх боломжгүй байна.

Судлаачын хувьд MNB, Eagle, Ikon, Монгол тв зэрэг хэвлэл мэдээллийн байгууллагын сүүлийн 6 сарын хугацаанд Нийслэлийн бодлоготой холбоотой нийтэлсэн мэдээг авч үзэхэд, бодлогын үндэслэл, үр нөлөөг задлан шинжилж үзээгүй, төрийн байгууллагын хэвлэл мэдээллийн хуралд дурдсан статистик тоо баримтыг давтан нийтэлсэн шинжтэй байна. Тиймээс энэхүү шалгуурын хүрээнд 3 оноо өглөө.

G12.1. Нийслэлийн Засаг даргын шийдвэр гаргалт

Асуулт: Нийслэлийн Засаг дарга шийдвэр гаргах үйл явц хэр хүртээмжтэй, нээлттэй байна вэ?

Тайлбар: Нийслэлийн Засаг дарга өөрийн эрх хэмжээний хүрээнд хууль тогтоомжид нийцүүлэн бодлого боловсруулах, батлахдаа иргэд, олон нийтэд нээлттэй байж чаддаг эсэхийг энэхүү шалгуурын хүрээнд үнэлнэ.

Хүснэгт 38. G12.1.Засаг даргын шийдвэр гаргалтын үнэлгээ

Нийслэлийн Засаг даргын шийдвэр нь олон нийтэд нээлттэй, ил тод байдаг.	10
	9
Нийслэлийн Засаг даргын шийдвэр нь дийлэнх тохиолдолд олон нийтэд нээлттэй, ил тод байдаг.	8
	7
	6
Нийслэлийн Засаг даргын хурлын шийдвэр нь цөөн тохиолдолд олон нийтэд нээлттэй, ил тод байдаг.	5
	4
	3
Нийслэлийн Засаг даргын хурлын шийдвэр нь олон нийтэд нээлттэй байдаггүй.	2
	1

Нийслэлийн Засаг даргын тамгын газар нь Нийслэлийн Засаг даргын 2023 оны 05 сарын 03-ний өдрийн А/439 дугаартай дүрмийн 5.3-д заасны дагуу “хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийг бүртгэн, захирамжийг албажуулах, бүртгэх, мэдээлэх...” чиг үүрэгтэй байна. Энэхүү чиг үүргийн хүрээнд Нийслэлийн Засаг даргын гаргасан захирамжийг www.ulaanbaatar.mn вебсайтад нийтэд ил тод, нээлттэй байршуулдаг.

Түүнчлэн, тодорхой иргэн, хуулийн этгээдийн ашиг сонирхол хөндөгдөж болох асуудлаар шийдвэр гаргахаас өмнө Захиргааны ерөнхий хуулийн 26.1-д заасны дагуу сонсох ажиллагаа явуулах үүрэг хүлээдэг. Тиймээс дээрх нөхцөл байдлыг харгалзан энэхүү шалгуурын хүрээнд 10 оноо өгөх үндэслэлтэй байна.

Түүнчлэн, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.2.2-д “Төрийн байгууллага, албан тушаалтныг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангана” гэх зорилтыг дэвшүүлсэн болохыг дурдах нь зүйтэй.

G12.2. Бизнес эрхлэгчийн оролцоо

Асуулт: Бизнес эрхлэгч буюу ашгийн төлөө үйл ажиллагаа явуулж буй иргэн, хуулийн этгээд өөрийн эдийн засгийн ашиг сонирхлын хүрээнд бодлогын төсөл боловсруулан Нийслэлийн Засаг даргад уламжлах боломжтой эсэх

Тайлбар: Нийслэлд үйл ажиллагаа явуулж буй бизнес эрхлэгч, сонирхлын бүлгээс өөрийн эдийн засгийн ашиг сонирхлын хүрээнд бодлогын төсөл боловсруулж, түүнийгээ Нийслэлийн Засаг даргад уламжлах чадвар хууль тогтоомжоор олгогдсон эсэхийг үнэлнэ.

Хүснэгт 39. G12.2. Бизнес эрхлэгчийн оролцоонд өгөх үнэлгээ

Бизнес эрхлэгчийн 70 буюу түүнээс дээш хувь нь өөрийн эдийн засгийн ашиг сонирхлын хүрээнд бодлогын төсөл боловсруулж, Нийслэлийн Засаг даргад уламжлах боломжтой байдаг	10
	9
Бизнес эрхлэгчийн 70 буюу түүнээс дээш хувь нь өөрийн эдийн засгийн ашиг сонирхлын хүрээнд бодлогын төсөл боловсруулж, Нийслэлийн Засаг даргад уламжлах боломжтой байдаг	8
	7
	6
Бизнес эрхлэгчийн 70 буюу түүнээс дээш хувь нь өөрийн эдийн засгийн ашиг сонирхлын хүрээнд бодлогын төсөл боловсруулж, Нийслэлийн Засаг даргад уламжлах боломжтой байдаг	5
	4
	3
Бизнес эрхлэгчийн 70 буюу түүнээс дээш хувь нь өөрийн эдийн засгийн ашиг сонирхлын хүрээнд бодлогын төсөл боловсруулж, Нийслэлийн Засаг даргад уламжлах боломжтой байдаг	2
	1

Нийслэлийн Засаг даргын зохион байгуулалтын бүтцэд тухайлсан төрийн бус байгууллага, олон нийтийн байгууллагаас ирүүлсэн бодлогын томъёоллыг хүлээн авах, холбогдох албан тушаалтанд уламжлах чиг үүрэг бүхий нэгж, алба, агентлаг байхгүй байна. Харин Нийслэлийн Засаг даргын тамгын газар нь МУЗЗНДНТУтХ-ийн 67.1.5-д заасны дагуу “тамгын газрын бичиг хэргийг хөтлөх, байгууллага, иргэдээс ирүүлсэн өргөдөл, санал, гомдлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулах” чиг үүрэгтэй байна. Энэхүү чиг үүргээ Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн хүрээнд хэрэгжүүлж байна. Тус хуулийн 4.2, 16.2-д тус тус заасны дагуу иргэн, хуулийн этгээдээс төрийн байгууллага, албан тушаалтаны үйл ажиллагааг сайжруулах, шинэчлэх агуулга бүхий саналыг уламжлах боломжтой байна. Гэхдээ ийнхүү санал/өргөдөл гаргах агуулгыг хуулиар хязгаарлаагүй, ерөнхий байдлаар томъёолсон тул төрийн бус байгууллага, олон нийтийн байгууллагаас Нийслэлийн Засаг даргад бодлогын төсөл уламжлах боломжтой байна. Дээрх нөхцөл байдлаас гадна эрх зохицуулалтын хувьд тухайлсан бодлого, шийдвэртэй холбоотой саналыг шийдвэрлэх нарийвчилсан журам зэрэг байхгүй, төрийн байгууллагаас энэ талаар сурталчилдаггүй тул энэхүү шалгуурт 9 оноо өгөх үндэслэлтэй байна.

G12.3. Төрийн бус байгууллага/олон нийтийн байгууллагын оролцоо

Асуулт: Төрийн бус байгууллага/олон нийтийн байгууллага тодорхой асуудлаар бодлогын төсөл томъёолж, эрх бүхий этгээдэд уламжлах боломжтой эсэх

Тайлбар: Нийслэлийн чиг үүргийн хүрээнд нийгмийн бүлэг, байгаль орчны бүлэг эсхүл шашны бүлгээс тодорхой чиглэлээр бодлого томъёолж, Нийслэлд уламжлах эрх зүйн боломжтой эсэхийг энэхүү шалгуурын хүрээнд үнэлнэ.

Хүснэгт 40. G12.3 Төрийн бус байгууллага, холбоодын оролцоо

Төрийн бус байгууллагын 70%-аас дээш хувь нь бодлогын төсөл боловсруулж уламжлах боломжтой байдаг	10
	9
Төрийн бус байгууллагын 50%-аас дээш хувь нь бодлогын төсөл боловсруулж уламжлах боломжтой байдаг	8
	7
	6
Төрийн бус байгууллагын 30%-аас дээш хувь нь бодлогын төсөл боловсруулж уламжлах боломжтой байдаг	5
	4
	3
Төрийн бус байгууллага бодлогын төсөл боловсруулж уламжлах боломжгүй байдаг	2
	1

Нийслэлийн Засаг даргын зохион байгуулалтын бүтцэд тухайлсан төрийн бус байгууллага, олон нийтийн байгууллагаас ирүүлсэн бодлогын томъёоллыг хүлээн авах, холбогдох албан тушаалтанд уламжлах чиг үүрэг бүхий нэгж, алба, агентлаг байхгүй байна. Харин Нийслэлийн Засаг даргын тамгын газар нь МУЗЗНДНТУтХ-ийн 67.1.5-д заасны дагуу “тамгын газрын бичиг хэргийг хөтлөх, байгууллага, иргэдээс ирүүлсэн өргөдөл, санал, гомдлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулах” чиг үүрэгтэй байна. Энэхүү чиг үүргээ Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн хүрээнд хэрэгжүүлж байна. Тус хуулийн 4.2, 16.2-д тус тус заасны дагуу иргэн, хуулийн этгээдээс төрийн байгууллага, албан тушаалтаны үйл ажиллагааг сайжруулах, шинэчлэх агуулга бүхий саналыг уламжлах боломжтой байна. Гэхдээ ийнхүү санал/өргөдөл гаргах агуулгыг хуулиар хязгаарлаагүй, ерөнхий байдлаар томъёолсон тул төрийн бус байгууллага, олон нийтийн байгууллагаас Нийслэлийн Засаг даргад бодлогын төсөл уламжлах боломжтой байна. Дээрх нөхцөл байдлаас гадна эрх зохицуулалтын хувьд тухайлсан бодлого, шийдвэртэй холбоотой саналыг шийдвэрлэх нарийвчилсан журам зэрэг байхгүй, төрийн байгууллагаас энэ талаар сурталчилдаггүй тул энэхүү шалгуурт 9 оноо өгөх үндэслэлтэй байна.

G13.1. Хяналт-шинжилгээ, үнэлгээ

Асуулт: Нийслэлийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх хараат бус, хөндлөнгийн бие даасан аудитын бүтэц байдаг уу?

Тайлбар: Энэ асуултын хүрээнд нийслэлийн үйл ажиллагааг хянах, үнэлэх систем бий эсэхийг үнэлнэ. Үүнд нийслэлийн хөрөнгө, бодлого, төсөвтэй холбоотойгоос гадна холбогдох байгууллагын үйл ажиллагаа хууль тогтоомж, гэрээнд нийцэж байгаа эсэхэд хяналт-шинжилгээ хийх хамаарна.

Хүснэгт 41. G13.1.Хяналт-шинжилгээг үнэлэх үнэлгээ

Хяналт-шинжилгээ, үнэлгээг үр дүнтэй хэрэгжүүлэх чиг үүрэгтэй хараат бус аудитын бүтэц байдаг.	10
	9
Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх хараат бус аудитын бүтэцтэй боловч үр дүнтэйгээр чиг үүргээ хэрэгжүүлдэггүй	8
	7
	6
Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх хараат бус аудитын бүтэцтэй боловч үр дүнтэйгээр чиг үүрэг нь хязгаарлагдмал.	5
	4
	3
Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аудитын бүтэц байдаггүй.	2
	1



Нийслэлийн Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн А/91 тоот захирамжийн хавсралтаар Нийслэлийн Дотоод аудитын албаны дүрмийг баталсан байна. Тус дүрмийн дагуу Дотоод аудитын алба нь Нийслэлийн Засаг даргын харьяа агентлаг, болон холбогдох байгууллагын үйл ажиллагаа, төсвийн хөрөнгө зарцуулалт нь хууль тогтоомж, гэрээнд нийцэж байгаа эсэхэд хяналт шинжилгээ хийх чиг үүрэгтэй байна.

Дотоод аудитын алба нь хараат бусаар үйл ажиллагаа явуулж чадах эсэх тухайд, тус албаны даргыг Нийслэлийн Засаг дарга томилно. Үүний дагуу томилогдсон албаны дарга аудиторудыг Төрийн албаны тухай хууль тогтоомжид нийцүүлэн томилох, чөлөөлөх, сахилгын шийтгэл оногдуулах зэрэг бүрэн эрхтэй байна. Мөн Дотоод аудитын албаны ажлаа Нийслэлийн Засаг даргын өмнө хариуцна. Тиймээс дээрх нөхцөл байдлуудыг харгалзан 10 оноо өгөх үндэслэлтэй байна.

G13.2. Зөвлөх байгууллага

Асуулт: Нийслэлийн Засаг даргын шийдвэр гаргалтад зөвлөх чиг үүрэг бүхий бие даасан байгууллагын бүтэц байдаг эсэх?

Тайлбар: Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэх чиг үүргийн хүрээнд иргэдээс ирүүлсэн санал, хүсэлтийг хүлээн авч, түүнийг олон нийтэд нээлттэй танилцуулах, хүсэлтийг шийдвэрлэх ажиллагааг эхлүүлэх эрх бүхий байгууллага Нийслэлийн Засаг даргын зохион байгуулалтын бүтцэд байгаа эсэхийг авч үзнэ.

Хүснэгт 42. G13.2.Зөвлөх байгууллагын үнэлгээ

Бие даасан зөвлөх байгууллага үр дүнтэйгээр үйл ажиллагаа явуулдаг.	10
	9
Бие даасан зөвлөх байгууллага байгаа боловч үр дүнтэйгээр үйл ажиллагаа явуулдаггүй.	8
	7
	6
Бие даасан зөвлөх байгууллага байгаа боловч үйл ажиллагааны хүрээ нь хязгаарлагдмал.	5
	4
	3
Бие даасан зөвлөх байгууллага байхгүй	2
	1

Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал нь МУЗЗНДНТУТХ-ийн 35-р зүйлд заасны дагуу Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг батлах, түүний үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлдэг. Хэдий тийм боловч, засаг даргын өдөр тутмын үйл ажиллагаанд иргэдийн санал, хүсэлтийг уламжлах, шийдвэрлүүлэх боломжгүй байна.

Харин Нийслэлийн Засаг даргын зохион байгуулалтын бүтцэд иргэдийн санал, хүсэлтийг хүлээн авч, түүнийг Засаг даргад уламжлах чиг үүрэг бүхий бие даасан зөвлөл, хороо зэрэг зохион байгуулалтын нэгж байхгүй байна. Гэхдээ Нийслэлийн Засаг даргын тамгын газар, харьяа агентлаг зэрэг байгууллагууд нь тус тусын чиг үүргийн хүрээнд иргэдийн санал, хүсэлтийг хүлээн авч ажиллаж байгааг дурдах нь зүйтэй.

Дээрх нөхцөл байдлыг харгалзан энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд 2 оноо өгөх үндэслэлтэй байна.



G13.3. Мэдээллийн аюулгүй байдал, нууцлал

Асуулт: Мэдээллийн хамгаалалт, нууцлалын асуудлыг үр дүнтэй хариуцдаг бие даасан эрх бүхий байгууллага бий эсэх?

Тайлбар: Нийслэлийн хэрэгжүүлэхээр төлөвлөж буй үйл ажиллагаа, бодлого, шийдвэртэй холбоотой нууцын зэрэглэл бүхий мэдээлэл, өгөгдлийг хамгаалах, шийдвэрийг нууцлах газар байгаа эсэхийг үнэлнэ.

Хүснэгт 43. G13.3.Мэдээллийн аюулгүй байдал, нууцлалын үнэлгээ

Мэдээлэл хамгаалах эрх бүхий байгууллага нь бие даасан шинжтэй ба үр дүнтэйгээр үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх боломжтой.	10
	9
Мэдээлэл хамгаалах эрх бүхий байгууллага нь бие даасан боловч эрх, үүрэг нь тодорой тохиолдлуудад хязгаарлагдмал байдаг.	8
	7
	6
Мэдээлэл хамгаалах эрх бүхий байгууллагатай боловч түүний бие даасан байдал, үр нөлөө нь маш хязгаарлагдмал байдаг.	5
	4
	3
Мэдээлэл хамгаалах эрх бүхий, бие даасан байгууллага байхгүй.	2
	1

Нийслэлийн Засаг даргын 2022 оны 01 сарын 28-ны өдрийн А/100 тоот захирамжын хавсралтаар Нийслэлийн цахим хөгжил, мэдээллийн технологийн газрын дүрмийг баталсан. Тус дүрэмд заасны дагуу дээрх Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг нь дурдсан шалгуурын хүрээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр заасан байна. Үүнд:

“4.1.7.төрийн болон албаны нууц, хувь хүний нууцтай холбоотой төлбөртэй болон төлбөргүй мэдээллийг холбогдох хууль, журмын дагуу дамжуулах, байршуулах, хадгалах;

4.1.9.нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын компьютер, техник, хангамжийн найдвартай ажиллагаа, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, сургалт зохион байгуулах”

Үүнээс үзвэл, Нийслэлийн хүрээнд мэдээлэл хамгаалах эрх бүхий байгууллага үйл ажиллагаа явуулж байх бөгөөд тус байгууллагын чиг үүргийг тодорхой тусгаж өгсөн байна. Тиймээс энэхүү шалгуурын хүрээнд 10 оноо өгөх үндэслэлтэй байна.

II. Үнэлгээ

Дээрх үзүүлэлт тус бүрээр үнэлсэн оноо нь “Гүйцэтгэх хариуцлага” хэсгийн 50 онооны дэд хэсгүүдэд хувьчлан хуваагдсан бөгөөд Улаанбаатар хотын хувьд нийт оноогоор **33.28** гэж үнэлэгдэж байна. Гүйцэтгэх чадварын хэсэгт **13.38** хувь гэж үнэлэгдэж байна.

Хүснэгт 44. Нийслэлийн бодлогын хэрэгжилтийн шалгуур үзүүлэлтийг үнэлсэн онооны хүснэгт

Дэд гарчиг	Бүрэлдэхүүн хэсэг	Дэд шалгуур	Дэд шалгуурын асуулт	УБ
------------	-------------------	-------------	----------------------	----

	16.665% Бодлогын хэрэгжилт	4.2% Нийслэлийн Засаг даргын ажлын үр дүнтэй байдал	Нийслэлийн засаг дарга бодлогын зорилтыг үр дүнтэй биелүүлж чадаж байна уу?	0	
		1.4% Удирдлагын нийцэл	Нийслэлийн Засаг даргын харьяа байгууллагын удирдлага нь Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааг хэрхэн дэмждэг вэ?	0.8	
		1.4% Нийслэлийн Засаг даргад хяналт тавих	Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагаанд хэр үр дүнтэй хяналт тавьдаг вэ?	1.26	
		1.4% Нийслэлийн Засаг даргын хяналт	Нийслэлийн Засаг дарга харьяа байгууллагын үйл ажиллагаанд үр дүнтэй хяналт тавьдаг эсэх ?	1.26	
		1.4% Нийслэлийн төсөв, санхүүжилт	Нийслэлийн бодлого, төлөвлөлтийг хэрэгжүүлэхэд зарцуулах төсвийг хэрхэн зохицуулдаг вэ?	0.7	
		1.4% Нийслэлийн Засаг дарга бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжтой эсэх	Нийслэлийн Засаг дарга бусад төрийн байгууллага, албан тушаалтны аливаа зөвшөөрлийг авахгүйгээр хуульд заасан чиг үүрэг/бүрэн эрхээ бие даан хэрэгжүүлэх боломжтой эсэх	1.1	
		1.4% Нийслэлээс бодлого, төлөвлөлтийг зохих стандартын дагуу боловсруулж, хэрэгжүүлдэг эсэх	Нийслэлээс бодлого, төлөвлөлтийг боловсруулах, батлахдаа хууль тогтоомжоор баталсан зохих стандартыг баримталдаг эсэх	1.4	
		4.2% Бодлого, төлөвлөгөөг хэрэгжүүлэх	Нийслэлийн бодлого, төлөвлөгөөг үр дүнтэйгээр, бодитоор хэрэгжүүлж чадаж байгаа эсэх	1.26	
		8.34% Нийцэл	4,15% Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны нийцэл	Нийслэлийн Засаг дарга төрийн эрх бүхий байгууллага, дээд шатны захиргааны байгууллагаас баталсан хөтөлбөр, бодлогын баримт бичигт өөрийн үйл ажиллагаа, баримт бичгийг нийцүүлж байгаа эсэх?	2
			4,15% Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагаа олон улсын хөтөлбөр, чиг хандлага, үйл ажиллагаанд нийцэх	Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагаа (бодлого, төлөвлөлт) нь олон улсын хөтөлбөр, үйл ажиллагаанд нийцэж байгаа эсэх	2
Executive Capacity /50-33.345/ Гүйцэтгэх чадвар	8.34% Институцийн өөрчлөлт	4.15% Бүтцэд хяналт тавих	Нийслэлийн Засаг дарга нь хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зохих бүтэц бүхий алба,	0.4	

			агентлагтай эсэхэд хяналт тавих эрх бүхий байгууллага байгаа эсэх?	
		4.15% Институцийн өөрчлөлт	Нийслэлийн Засаг дарга засаглах арга хэлбэрээ тухай бүр шинэчилэн ажиллаж байгаа эсэх?	1.2
Нийт				13.38
50% Гүйцэтгэх хариуцлага	12.5% Иргэдийн оролцооны чадамж	6.3% Иргэдийн мэдээлэл авах боломж	Иргэд нийслэлийн бодлогын талаар мэдээлэл авах боломжтой эсэх?	6.3
		6.2% Нээлттэй засаглал	Нийслэлийн захиргаа нь бодлогын хэрэгжилт, үр дүнгийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгдөг эсэх (тус мэдээллийг үндэслэн иргэд холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар хандах боломжтой эсэх)?	3.72
	12.5% Засгийн газрын хяналтын нөөц	2.5% Засгийн газрын хяналтын нөөц	Нийслэлийн бодлого үр дүнтэй хэрэгжиж буй эсэхэд хяналт тавих бие даасан нэгж, бүтэц Засгийн газарт байна уу?	0.25
		2.5% Бодлого, шийдвэрийн баримт бичигт хяналт тавих	Засгийн газар нийслэлээс баталсан бодлогын баримт бичгийг олж авахаар шаардах боломжтой юу?	1.5
		2.5% Засаг даргын оролцоо	Ерөнхий сайд Засгийн газрын хуралдаанд Засаг даргыг дуудаж сонсгол хийх боломж бий эсэх?	1.25
		2.5% Мэргэжилтний оролцоог хангах	Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдаанаас шийдвэр гаргахад судлаач, мэргэшсэн шинжээч оролцуулах боломжтой юу?	0.75
		2.5% Нийцэлтэй байдал	Засаг дарга өөрийн харьяа агентлаг, байгууллагуудын чиг үүрэг, үйл ажиллагаанд үр дүнтэй хяналт тавих тогтолцоо бий эсэх?	2.5
	6.3% Хэвлэл мэдээлэл	6.3% Хэвлэл мэдээллийн байгууллагын оролцоо	Хэвлэл мэдээллийн байгууллагууд Нийслэлийн бодлогын үндэслэл, нөлөөллийн талаар хэр дүн шинжилгээ хийдэг вэ?	1.89
	6.3% Харилцаа Холбоо	2.1% Нийслэлийн Засаг даргын шийдвэр гаргалт	Нийслэлийн Засаг дарга шийдвэр гаргах үйл явц хэр хүртээмжтэй, нээлттэй байна вэ?	2.1
		2.1% Бизнес эрхлэгчийн оролцоо	Бизнес эрхлэгч буюу ашгийн төлөө үйл ажиллагаа явуулж буй иргэн, хуулийн этгээд өөрийн эдийн засгийн ашиг сонирхлын хүрээнд бодлогын төсөл боловсруулан Нийслэлийн Засаг даргад уламжлах боломжтой эсэх?	1.89

		2.1% Төрийн бус байгууллага/олон нийтийн байгууллагын оролцоо	Төрийн бус байгууллага/олон нийтийн байгууллага тодорхой асуудлаар бодлогын төсөл томьёолж, эрх бүхий этгээдэд уламжлах боломжтой эсэх?	1.89
	12.5 % Бие даасан хяналтын байгууллагууд	4,2% Хяналт-шинжилгээ үнэлгээ	Нийслэлийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх хараат бус, хөндлөнгийн бие даасан аудитын бүтэц байдаг уу?	4.2
		4,2% Зөвлөх байгууллага	Нийслэлийн Засаг даргын шийдвэр гаргалтад зөвлөх чиг үүрэг бүхий бие даасан байгууллагын бүтэц байдаг эсэх?	0.84
		4.2% Мэдээллийн аюулгүй байдал нууцлал	Мэдээллийн хамгаалалт, нууцлалын асуудлыг шийдвэрлэхэд төрийн байгууллагуудыг үр дүнтэй хариуцдаг бие даасан байгууллага бий юу?	4.2
Нийт оноо				

Дээрх шалгуур үзүүлэлтэд нийслэлийн авсан оноог үндэслэн нийслэлийн бодлогын хэрэгжилтийг сайжруулахад зориулан дараах зөвлөмжийг хүргэж байна.

Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хэрэгжилтийн гүйцэтгэлийг дүгнэхийг зорьсон боловч Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагаа төлөвлөгөөний биелэлт буюу жил бүрийн гүйцэтгэлийн үнэлгээг нийтэд ил тод байршуулаагүй байна. Түүнчлэн Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон Нийслэлийн Засаг даргын харьяа агентлаг, байгууллагууд нь вэб хуудсандаа байгууллагын стратеги төлөвлөгөөний биелэлтээ тайлагнасан байгаа нь хэлбэрийн хувьд иргэдийн мэдэх эрхийг хангаж байх боловч иргэнд ойлгоход хялбар, хүртээмжтэй байдлаар байршуулаагүй байна. Энэ нь иргэдийн бодлого төлөвлөлт, хэрэгжилтэд оролцох, түүнд дүн шинжилгээ хийх, хяналт тавих, санал хүсэлтээ илэрхийлэхэд хүндрэлтэй болгосон буюу иргэний шүүмжтэй хандах эрхэд хязгаарлалт болжээ байна. Иймд, Нийслэлийн Засаг даргын харьяа агентлаг, байгууллагууд нь тайлан, төлөвлөгөөг нийслэлд зориулан нийтлэх бус иргэнд ойлгомжтой хүртээмжтэй агуулга, форматаар нийтлэх нь зүйтэй. Нийслэлийн тайлан, мэдээлэлтэй танилцах боломж олгох нь иргэдийг идэвх, оролцоог сайжруулж, нийслэлийн үйл ажиллагаанд эерэг нөлөө үзүүлнэ.

Нийслэлийн Засаг даргын харьяа агентлаг, байгууллага нь хуулиар хүлээсэн чиг үүргээ үр дүнтэйгээр хэрэгжүүлэх байдлаар зохион байгуулагдсан эсэхийг үнэлдэг эрх бүхий байгууллага байдаг эсэх, тус байгууллагаас тогтмол хяналт шалгалт хийж, тайлан, зөвлөмжийг холбогдох албан тушаалтанд хүргүүлж ажилладаг эсэхийг авч үзсэн. Энэ хүрээнд нийслэлд, уг асуудлыг тухайлан хариуцсан чиг үүрэгтэй, байнгын үйл ажиллагаатай байгууллага байхгүй байна. Иймд нийслэл нь харьяа агентлаг, байгууллагуудын чиг үүргийг сайжруулах, давхцалыг арилгах, бүтээмжийг нэмэгдүүлэх, иргэдэд үзүүлэх үйлчилгээг сайжруулахын тулд тогтмол дүн шинжилгээ хийх, уялдааг хангахад тухайлан чиглэсэн бүтэц, нэгжийг үүсгэх нь зүйтэй байна. Түүнчлэн эрх бүхий байгууллагаас Нийслэлийн Засаг даргын шийдвэртэй холбогдох маргаан он онуудад өссөн, буурсан эсэхийг судалсан дүн шинжилгээ болон статистик тоон үзүүлэлт байхгүй байна. Нийслэлийн Засаг даргын чиг үүрэг, нийслэлийн үйл ажиллагаатай холбоотойгоор иргэдийн гаргасан өргөдөл гомдол,

шүүхийн маргаанд дүн шинжилгээ хийх нь бүтэц, чиг үүргийн алдааг хянахад туслахаар байна.

3.5. ҮР ДҮНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

I Нийслэлийн бодлого боловсруулалт, төлөвлөлт хэсгийн хүрээнд,

Нийслэлийн бодлогыг тогтвортой хөгжлийн зорилттой харьцуулан авч үзвэл, эрүүл мэндийг дэмжих болон чанартай боловсролыг дэмжих чиглэлийн зорилтууд түлхүү тусгагдсан байна. Гэвч ядуурлыг устгах, өлсгөлөнг зогсоох чиглэлээр тусгасан зорилт хангалтгүй байх бөгөөд тэгш бус байдлыг бууруулах болон уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах чиглэлээр зорилт дэвшүүлээгүй байна. Тогтвортой хөгжлийн зорилтын Тэгш бус байдлыг бууруулах 10 дугаар зорилтын 10.7-д “Төлөвлөлт, зохицуулалт сайтай шилжилт хөдөлгөөний бодлого хэрэгжүүлэх замаар хүмүүсийн зохион байгуулалттай, аюулгүй, байнгын, хариуцлагатай шилжилт хөдөлгөөнийг дэмжих”, Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах 13 дугаар зорилтын 13.1-д “Улс орнуудад тулгарч буй цаг ууртай холбоотой аюул осол, байгалийн гамшгийг даван туулах, тэдгээрт зохицох чадавхыг бэхжүүлэх” зэрэг чухал зорилтуудыг дэвшүүлсэн байна. Гэвч нийслэлийн бодлогод, дээрх зорилгуудын хүрээнд дэвшүүлсэн зорилт байхгүй байна. Энэ нь тус зорилгуудын хүрээнд цаашид хэрэгжих шаардлагатай үйл ажиллагаанд болон нийслэлийн өмнө тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд саад учруулж болох бөгөөд Тогтвортой хөгжлийн зорилтоос үндэслэн боловсруулсан баримт бичгүүдийн бодлогын залгамж, уялдаа алдагдсан гэж дүгнэхээр байна. Хэдийгээр нийслэлийн бодлого нь зорилт тус бүрийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг нарийвчлан тогтоосон давуу талтай байх боловч бодлогын уялдааг сайжруулах, хийдэл давхардлыг урьдчилан шалгахад анхаарах нь зүйтэй гэж дүгнэлээ.

II Нийслэлийн бодлогын хэрэгжилтийг үнэлэх хүрээнд,

Нийслэлийн бодлогын хэрэгжилтийг үнэлэх хүрээнд, SGI-ийн дараах 26 шалгуур үзүүлэлтийг ашиглан үнэлгээ хийсэн болно. Тус үнэлгээгээр, нийслэлийн гүйцэтгэх чадвар болон хариуцлагын хувь хэмжээг үнэлсэн. Үр дүнгээр, бусад оролцогч талуудын оролцоо хангалтгүй буюу иргэд, сонирхлын бүлгүүд, хэвлэл мэдээллийн хэрэгслүүд бодлого, шийдвэрт дүн шинжилгээ хийх, бодлого санаачлах, өргөн мэдүүлэх оролцоо нь хамгийн бага үнэлгээ авсан байна. Түүнчлэн нийслэлийн бодлогын хэрэгжилтэд нийслэлээс хараат бусаар хөндлөнгийн үнэлгээ хийх бие даасан бүтэц нэгжийн үзүүлэлт дээр хангалтгүй үнэлэгдсэн байна.

Гүйцэтгэх чадварын үнэлгээ-33.345%

G6.1. Нийслэлийн Засаг даргын үр дүнтэй байдал /Government Effectiveness/

G6.2.a. Удирдлагын нийцэл /Ministerial Compliance/

G6.2.b. Нийслэлийн Засаг даргад хяналт тавих /Monitoring Ministries/

G6.2.c. Нийслэлийн Засаг даргын хяналт /Monitoring Agencies/Bureaucracies/

G6.3.a. Нийслэлийн төсөв, санхүүжилт /Task Funding/

G6.3.b. Нийслэлийн Засаг дарга бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжтой эсэх /Constitutional Discretion/

G6.3.c. Нийслэлээс бодлого, төлөвлөлтийг зохих стандартын дагуу боловсруулж, хэрэгжүүлдэг эсэх /National Standards/

G6.4. Бодлого, төлөвлөгөөг хэрэгжүүлэх /Effective Regulatory Enforcement/

G7.1. Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны нийцэл /Domestic Adaptability/

G7.2. Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагаа олон улсын хөтөлбөр, чиг хандлага, үйл ажиллагаанд нийцэх /International Coordination/



G8.1. Бүтцэд хяналт тавих /Self-monitoring/

G8.2. Институцын өөрчлөлт

Хүрээлэн буй орчны шударга ёсны индексийн загвар нь хуваарилалтын болон процедурын шударга ёс болон шударга бус байдлын хуримтлагдсан байдал нь эрүүл мэнд, сайн сайхан байдалд нөлөөлөх талаар хамаарах хүчин зүйлсийг судалдаг. EJI-ийн шинжилгээний нэгж нь тооллогын хуудас юм. Тооллогын хуудас нь АНУ-ын Хүн амын тооллогын товчооноос гаргадаг мужуудын статистикийн мэдээлэл бөгөөд ихэвчлэн газар нутаг дээр суурилсан эпидемиологийн судалгаан дахь хөршүүд болон бусад орон зайн индексүүд, скринингийн хэрэгслийг ашигладаг. EJI нь АНУ-ын 71,000 гаруй хүрээлэн буй орчны шударга бус байдлын хуримтлагдсан нөлөөллийг тодорхойлохын тулд АНУ-ын Хүн амын тооллогын товчоо, АНУ-ын Байгаль орчныг хамгаалах агентлаг, АНУ-ын Уурхайн аюулгүй байдал, эрүүл мэндийн алба, АНУ-ын Өвчний хяналт, урьдчилан сэргийлэх төвүүдийн мэдээллийг ашигладаг. EJI нь товхимол бүрийг байгаль орчин, нийгэм, эрүүл мэндийн 36 хүчин зүйлээр эрэмбэлж, гурван үндсэн модуль, арван өөр домэйн болгон бүлэглэдэг. EJI-ийн ерөнхий оноонд хүрээлэн буй орчны ачааллын модуль, нийгмийн эмзэг байдлын модуль, эрүүл мэндийн эмзэг байдлын модуль гэсэн гурван модулийн эрэмбэлсэн оноог нэгтгэн тооцдог. Энэ оноог ашиглан эцсийн EJI зэрэглэлийг гаргадаг.

Шалгуур үзүүлэлтүүд:

CDC/ATSDR буюу хорт бодис, өвчний бүртгэлийн агентлагаас “хүрээлэн буй орчны шударга ёс”-ны индексийг боловсруулахдаа дараах шалгуур үзүүлэлтүүдэд үндэслэдэг байна⁵².

Нийгмийн эмзэг байдлын модуль	Арьсны өнгө/Угсаатны цөөнхийн байдал
	Нийгэм эдийн засгийн байдал: Ядуурал
	Нийгэм эдийн засгийн байдал: Их сургуулийн дипломгүй байдал
	Нийгэм эдийн засгийн байдал: Ажилгүйдэл
	Нийгэм эдийн засгийн байдал: Орон сууцны ашиглалт
	Нийгэм эдийн засгийн байдал: Орон сууцны ачаалал, бага орлоготой өрх
	Нийгэм эдийн засгийн байдал: Эрүүл мэндийн даатгалын хүртээмжгүй байдал
	Нийгэм эдийн засгийн байдал: Интернэтийн хүртээмжгүй байдал
	Өрхийн мэдээлэл: 65-аас дээш насны иргэд
	Өрхийн мэдээлэл: 17-оос доош насны иргэд
	Өрхийн мэдээлэл: Хөгжлийн бэрхшээлтэй иргэд
	Өрхийн мэдээлэл: Англи хэлээр муу ярьдаг иргэд
	Өрхийн хэлбэр: Нийтийн байр
	Өрхийн хэлбэр: Явуулын байр
Хүрээлэн буй орчны ачааллын модуль	Агаарын бохирдол: Озон
	Агаарын бохирдол: ПМ2.5
	Агаарын бохирдол: Дизель түлшний тоосонцор
	Агаарын бохирдол: Агаарын бохирдлоос үүдэх хавдрын эрсдэл
	Аюултай, хортой байж болзошгүй газрууд: Үндэсний жагсаалтад орсон газрууд
Аюултай, хортой байж болзошгүй газрууд: Хорт бодис ялгаруулах бараа материалын талбай	

⁵¹ Environmental Justice Index, <https://www.atsdr.cdc.gov/placeandhealth/eji/index.html>

⁵² Environmental Justice Index Indicators, <https://www.atsdr.cdc.gov/placeandhealth/eji/indicators.html>

	Аюултай, хортой байж болзошгүй газрууд: Цэвэрлэх, хадгалах, устгах байгууламжууд	
	Аюултай, хортой байж болзошгүй газрууд: Эрсдэлийн төлөвлөгөөт газрууд	
	Аюултай, хортой байж болзошгүй газрууд: Нүүрсний уурхай	
	Аюултай, хортой байж болзошгүй газрууд: Хар тугалганы уурхай	
	Амралт зугаалгын газрын хүрэлцээтэй байдал	
	1980 оноос өмнө баригдсан орон сууц	
	Явган явах боломжгүй газар	
	Эзлэхүүн ихтэй зам	
	Төмөр зам	
	Нисэх буудлууд	
	Гадаргуугийн усны бохирдол	
	Эрүүл мэндийн эмзэг байдлын модуль	Астма өвчний тархалт
		Хорт хавдрын тархалт
Цусны даралт ихсэх өвчний тархалт		
Чихрийн шижин өвчний тархалт		
Сэтгэцийн хомсдлын тархалт		

Давуу тал:

- Олон талын нөхцөл байдлыг харгалзан шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон. Тухайлбал, эрүүл мэнд, хүрээлэн буй орчны асуудлууд

Сул тал:

- АНУ-ын хэмжээнд үр дүн гаргадаг.
- Зөвхөн хүрээлэн буй орчин, эрүүл мэндийн асуудалд анхаарлаа хандуулдаг.

Олон улсын “Шударга ёс”-ны индекс

Олон улсын шударга ёсны индекс нь Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Фудан дахь Нийгмийн шинжлэх ухааны гүнзгийрүүлсэн судалгааны хүрээлэнгээс хэрэгжүүлж буй олон жилийн судалгааны төсөл юм. Энэ нь олон улсын шударга ёсыг тогтооход улс орон бүрийн оруулсан хувь нэмрийг үнэлдэг. 2010-2019 оны олон улсын шударга ёсны индексийн тайлан, 2020 оны олон улсын шударга ёсны индексийн тайлан, 2021 оны олон улсын шударга ёсны индексийн тайлан одоогоор нийтлэгдсэн байна⁵³.

Судалгааны арга:

Тус олон улсын шударга ёсны индексийг гаргахдаа индексийн шалгуур үзүүлэлт бүрээр тусдаа арга зүйг ашигладаг ба улс бүрээр, эрэмбэлсэн байдлаар гаргадаг байна.

Шалгуур үзүүлэлтүүд:

Олон улсын шударга ёсны индекс нь нийтдээ 10 хүчин зүйл болон түүнд хамаарах дараах дэд хүчин зүйлүүдээс бүрддэг⁵⁴.

Цаг уурын өөрчлөлт	Энерги зарцуулалт
	Цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэл

⁵³ Global Justice Index Report 2022, https://globaljustice.fudan.edu.cn/attached/UploadFile/202307/02143316_1839.pdf

⁵⁴ Global Justice Index Report 2022, https://globaljustice.fudan.edu.cn/attached/UploadFile/202307/02143316_1839.pdf

	Хүчилтөрөгчийн хэмжээ
	Ой модны хэмжээ
Энх тайванч байдал	Цэрэг, цагдаагийн хэмжээ
	Хандивын хэмжээ
Хүмүүнлэгийн тусламж	Хоол, орон сууц, эрүүл мэнд, ус, түргэн тусламж, эрт нөхөн сэргээлт, боловсрол, хамгаалалт, хөдөө аж ахуй гэх мэт
Терроризмын эсрэг болон зэвсэгт мөргөлдөөн	Зөрчилдөөн
	Зөрчилдөөний талаар зөвшилцсөн байдал
	Терроризм
Үндэстэн дамнасан эрүүгийн цагдаагийн хамтын ажиллагаа	Ерөнхий байдал
	Мансууруулах бодис ба сэтгэцэд нөлөөт бодисууд
	Авилгал
	Хүнийг барьцаанд авах
	Үндэстэн дамнасан эрүүгийн цагдаагийн газарт хандив өгсөн байдал
	НҮБ-ийн хар тамхи, гэмт хэрэгтэй тэмцэх газарт хандив өгсөн байдал
	ФАТФ-ын гишүүн болсон эсэх
Дүрвэгсэд	Дүрвэгсдийн хэмжээ
	Дүрвэгсдийн статусыг тодорхойлох ажлыг хэрэгжүүлсэн байдал
	Олон улсын дүрвэгсдийн засаглалд оролцох байдал
	Дүрвэгсдийн асуудлаарх үндэсний бодлого
	Амьдрах стандарт
Ядуурлын эсрэг байдал	Ядуурлын түвшинг бууруулах (5.5 ам. доллар, хүн амын жин)
	Ядуурлын зөрүү (5.5 доллар)
Боловсрол	Анхан шатны боловсрол
	Хоёрдахь шатны боловсрол
	Засгийн газрын боловсролын зардал
Эрүүл мэнд	Насжилтын хэмжээ
	Ёс суртахуун
	Нийгмийн эрүүл мэндийн дэд бүтэц
	Гол өвчин
	Зардал
Хүүхэд, эмэгтэйчүүдийн хамгаалал	Эрүүл мэнд, хүн ам зүй
	Эдийн засгийн байдал
	Улс төрийн байдал
	Хүүхдийн эрүүл мэнд, хүн ам зүй
	Хүүхдийн боловсрол (эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн боловсролын ялгаа)

Давуу тал:

- Олон улсын хэмжээнд тулгамдаж буй асуудлууд дээр төвлөрдөг;
- Олон төрлийн шалгуур үзүүлэлтийг хамардаг. Тухайлбал, хүмүүнлэгийн салбарыг анхаарч үздэг.

Сул тал:

- Зөвхөн нэг улс буюу БНХАУ-аас хэрэгжүүлж буй төсөл;
- Тухайн улсын шударга байдлын индексэд тулгуурлахгүй хоорондын хамтын ажиллагааг авч үздэг.

Нийгмийн “Шударга ёс”-ны индекс

Адасинагийн нийгмийн шударга ёсны индекс нь нийгмийн шударга ёсны үр дүнд хамаарах олон нийтийн тэгш эрхийн байдлалд суурилсан нийгмийн шударга ёсыг харуулсан үзүүлэлт юм. Индексийн өөрчлөлт хөдөлгөөнийг оролцооны стандартын (Адасинагийн нийгмийн шударга ёсны оролцооны шалгуур) дагуу шалгадаг ба ийнхүү шалгахдаа үнэт цаасны зах зээлийн мэдээлэлд тулгуурладаг. Оролцооны шалгуур нь арьсны өнгө, хүйс, эдийн засаг, цаг уурын шударга ёс гэсэн дөрвөн бүлэг асуудалд төвлөрдөг⁵⁵.

Судалгааны арга:

Индексийн түвшинг ажлын өдөр бүр индексийн бүрэлдэхүүн хэсгүүдийн бүртгэлтэй тус тусын биржийн үнэд үндэслэн тооцдог. Шинэчлэлт бүрийн хувьд бүх индексийн бүрэлдэхүүн хэсгүүдийн хамгийн сүүлийн үнийг ашигладаг. Индексийн мөнгөн тэмдэгтэд ороогүй индексийн бүрэлдэхүүн хэсгүүдийн үнийг WM London 1600 ханшийг ашиглан Refinitiv-аас иш татсан гадаад валютын спот ханшаар хөрвүүлдэг. Өдөр тутмын индексийн хаалтын утгыг Лондонгийн цагаар 16:00 цагаас эхлэн Refinitiv-ийн Elektron сүлжээний хаалтын спот ханшийг ашиглан тооцдог. Хэрэв Refinitiv дээр одоогийн үнэ байхгүй бол тооцоололд хамгийн сүүлийн үнэ эсвэл өмнөх арилжааны өдрийн Refinitiv дээрх арилжааны үнийг ашиглана. Индекс амралтын өдөр үнэ тооцдоггүй. Индексийг SET-ийн өглөөний 9:00 цагаас оройн 22:30 цаг хүртэл 15 секунд тутамд тооцдог. АНУ-ын зах зээл хаагдсаны дараахан индексүүд хаагдана. Өдрийн индексийн файлуудыг Refinitiv SFTP серверт нийтэлдэг. Refinitiv эсвэл үнийн үйлчилгээнд өгөгдөл өгөх боломжгүй тохиолдолд индексийг тараах боломжгүй. Аливаа буруу тооцоог буцаан авч үзээд засдаг⁵⁶.

Шалгуур үзүүлэлтүүд:

Адасинагийн нийгмийн шударга ёсны оролцооны шалгуурт үндэслэн компаниудыг дараах ангилалд оруулах эсвэл хасах байдлаар индексийг гаргадаг⁵⁷.

Арьс өнгөний шударга ёс	Шоронд хамаарах үйл ажиллагаа эрхлэхгүй байх
	Шоронгийн хөрөнгө оруулалт хийхгүй байх
	Шоронгийн хөдөлмөрт оролцохгүй бай
	Мөнгөний барьцаанд оролцохгүй байх
	Цагаачдыг саатуулах ажиллагаанд оролцохгүй бай
	Иргэн ба цагаачдын ажиглалтад оролцохгүй байх
	Эзлэгдсэн нутаг дэвсгэртэй холбоотой үйл ажиллагаа эрхлэхгүй байх
	Уугуул иргэдийн эрхэд халдахгүй байх
	Олон талт байдал ба түүнд хамруулах бодлогод оролцохгүй байх
	Ашгийн төлөө нийгэмлэгийн үйл ажиллагаанд оролцохгүй байх
	Бэлгийн дарамтгүй байх
Жендэрийн шударга ёс	Нөхөн үржихүйн эрхийг хамгаалах
	Удирдах зөвлөлийн төлөөлөл
	LGBTQ+ тэгш хөдөлмөр эрхлэх боломж
Эдийн засгийн шударга ёс	Ажилчдын цалингийн доод хэмжээ

⁵⁵ ADASINA SOCIAL JUSTICE INDEX, <https://eqmindexes.com/social-justice-index-summary/>

⁵⁶ ADASINA SOCIAL JUSTICE INDEX Methodology Guide, <https://eqmindexes.com/wp-content/uploads/2023/08/Guideline-Adasina-Social-Justice-Index-v2.03.pdf>

⁵⁷ ADASINA SOCIAL JUSTICE INDEX CRITERIA, <https://eqmindexes.com/social-justice-index-criteria/>



	Албадан хөдөлмөр, хүүхдийн хөдөлмөр
	Ажилчдын хамгаалалт ба эрх
	Ажлын нөхцөл
	Гүйцэтгэх ажилтны хэт их цалин
	Зээл
Цаг уурын шударга ёс	Чулуужсан түлш
	Чулуужсан түлшний санхүүжилт
	Хөдөө аж ахуйн олборлолт
	Эрчим хүчний хэрэглээ
	Ойн сан, түүний хомсдол
	Нүүрстөрөгчийн ялгарал
	Уул уурхай
	Бохирдол
	Усны менежмент
	Бүтээгдэхүүний хаягдал
Бусад үзүүлэлт	Үслэг, арьсан бүтээгдэхүүн
	Эмнэлгийн бус амьтны шинжилгээ
	Амьтанд хүмүүнлэг хандах
	Тамхи
	Зэвсэг ба галт хэрэгсэл
	Нийгмийн консерватизм ба улс төрийн дэмжлэг
	Компанийн засаглал
	Нягтлан бодох бүртгэл ба менежмент
	Хэрэглэгчийн нөлөө
	Өгөгдлийн нууцлал ба аюулгүй байдал

Даеуу тал:

- Шалгуур үзүүлэлтийг арилжааны бүтээгдэхүүнд үндэслэн өргөнөөр тодорхойлдог;
- Худалдааны чиглэлийн асуудал дээр суурилдаг.

Сул тал:

- Зөвхөн биржийн мэдээлэлд үндэслэн үнээр тооцоог гаргадаг;
- Улс бүрт тохирох боломж нь хязгаарлагдмал байна.

Дэлхийн хотуудын чансааны индекс

Дэлхийн хотуудын хотуудын чансааны индекс (Global Power City index, GPCI) нь олон улсын хэмжээний хотууд хоорондын өрсөлдөөнд хүн хүч болон аж ахуй нэгжүүдийг хотдоо татах хүч бол тухайн хотуудын хүчин чадлаас төрөн гарна гэсэн бодолд үндэслэн хийгдсэн. GPCI-д дэлхийн томоохон хотуудын чансааг Эдийн засаг, Судалгаа хөгжүүлэлт, Соёл болон соёлын солилцоо, Амьдралын бололцоо, Хүрээлэн буй орчин, Хүртээмж гэсэн 6 төрлөөр олон талаас нь үнэлж, эрэмбэлсэн болно.

2008 оноос хойш танилцуулж байгаа дэлхийн хотуудын энэ чансаанд дэлхийд танигдсан Сан Питер Холлыг ахлах зөвлөхөөр урьж, энэ чиглэлээр олон улсын тэргүүлэх мэргэжилтнүүдээс бүрдсэн гүйцэтгэх хорооны удирдлаган дор нарийвчилсан дүн шинжилгээ хийж байна. Чансааны үйл явц, үр дүнгийн шударга байдлыг хангахын тулд хоёр гуравдагч талын шинжээчид үнэлгээ дүгнэлт хийж, сайжруулах зөвлөмжийг өгдөг.

GPCI нь зөвхөн чансаанд дүн шинжилгээ хийгээд дуусдаггүй, чансааны бүрэлдэхүүн хэсгүүдэд дүн шинжилгээ хийснээр бага багаар өөрчлөгдөж буй дэлхийд хотуудын хүчтэй тал болон сул тал, тулгараад буй асуудлуудын талаар илүү нарийн ойлголттой болдог⁵⁸.

Судалгааны арга:

1. Зорилтот хотуудыг сонгох

Уг чансаанд дэлхийн томоохон 48 хотыг үнэлгээнд хамруулсан. Доорх нөхцөлүүдээс дор хаяж 1 нөхцөлийг нь хагах хотыг судалгаанд хамруулахаар сонгодог.

А. Global Cities Index, Cities of opportunity, The Global Financial Centres Index зэрэг нөлөө бүхий хотуудын харьцуулалт, зэрэглэлд эхний 20-д орсон хот байх.

Б. Нөлөө бүхий олон улсын өрсөлдөх чадварын зэрэглэлээр (Дэлхийн эдийн засгийн форум, Олон улсын менежментийн хөгжлийн хүрээлэнгээс гаргасан) хамгийн өрсөлдөх чадвартай эхний 20-д багтсан хот байх.

В. Уг чансааг гаргаж байгаа гүйцэтгэх хороо болон ажлын хорооноос судалгаанд хамруулах нь зөв гэж шийдвэсэн хот байх.

2. Чансааг тогтоох арга зүй

А. Судалгааны дата цуглуулах

Судалгааны дата нь ихэвчлэн статистикт суурилсан тоон датаг ашигласан. Мөн 9 индикаторт Моригийн дурсгалын сангаас явуулсан оршин суугчдын санал асуулгын дүнг оруулсан. Тоон датаг цуглуулах арга болон санал асуулгын судалгааг хийсэн аргачлалыг доор дурьдав.

а. Тоон дата

Холбогдох бүлэгт заасан индикатор бүрийн тодорхойлолтод үндэслэн мэдээлэл цуглуулдаг. Цуглуулсан мэдээллийн эх сурвалжийг бүлэгт жагсаан бичнэ.

б. Санал асуулгын судалгаа (Нийт 9 индикатор)

Судалгааны арга:Цахим судалгаа

Судалгаанд хамрагдсан:Сонгогдсон 48 хотын 18-с дээш насны иргэд

Нийт хамрагдсан:Нийт 9599 хүн (Хот бүрээс 200 орчим)

Судалгааны хугацаа:2022.07-2022.08

Судалгааны агуулга:Амьдарч буй хот эсвэл очиж үзсэн хотуудын талаарх чанарын болон тоон үнэлгээ

Судалгааг авсан байгууллага: Pollfish, QuestionPro

Б. Судалгааны датаг индексжүүлэх

Индикатор бүрийг нийтлэг стандартаар үнэлэхийн тулд цуглуулсан датаны хамгийн их утгыг 100, хамгийн бага утгыг 0 гэсэн индекс болгон хөрвүүлсэн. Харин бохирдол, эрсдэл зэрэг үзүүлэлтүүдийн хувьд өгөгдлийн утга өндөр байх тусам үнэлгээ бага байх ёстой бөгөөд датаны хамгийн их утгыг 0, хамгийн бага утгыг 100 гэж тогтоосон.

В. Оноожуулалт

⁵⁸ The Global Power City Index YEARBOOK 2022, pp.8, <https://mori-m-foundation.or.jp/english/ius2/gpci2/index.shtml>

70 индикатор бүрийг индексжүүлсний дараа, индикаторуудыг агуулах 26 индикатор групп тус бүрт дундаж утгыг гаргаж индикатор групп тус бүрийн оноо болгосон. Дараа нь индикатор групп тус бүрийн онооны нийлбэрийг гаргаж салбар тус бүрийн оноог гаргадаг. Хамгийн сүүлд салбар тус бүрийн оноог нэмэн хот тус бүрийн нийлбэр оноог гаргадаг⁵⁹.

Шалгуур үзүүлэлтүүд:

Дэлхийн хотуудын хотуудын чансааны индекс (Global Power City index, GPCI)-ийн 70 индикатор буюу индексүүдийн 46-т байх “Нийгмийн эрх чөлөө ба тэгш байдал” гэх индексийг дараах шалгуур үзүүлэлтээр хэмждэг.

Тоон утгад шилжүүлсэн дараах датаны дундаж утга:

1. Transparency international-ийн “Авлигын талаарх ойлголтын индекс” дэх тухайн улсын оноо
2. Freedom house-ийн “Дэлхийн эрх чөлөө”-ний тухайн улсын оноо
3. Reporter without Borders-ийн “Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний индекс” дэх тухайн улсын тоо
4. Economic forum-ийн “Дэлхийн жөндөрийн ялгааны тайлан” дахь тухайн улсын оноо⁶⁰

Давуу тал:

- Хотуудын хүрээнд хөгжлийн, чансааны индексийг өргөн хүрээний нарийвчлагдсан шалгуур үзүүлэлтэд үндэслэн тооцдог.
- Судалгааны арга зүй нь нарийвчлагдсан тодорхой байдаг.

Сул тал:

- Бусад олон улсын байгууллагын тухайн улсад өгсөн индексийн оноог үндэслэдэг;
- Шалгуур үзүүлэлтийг нийгмийн эрх чөлөө, тэгш байдал гэж тодорхойлсон нь шударга байдлын ойлголтоос явцуу хүрээнд тодоорхойлогдсон.

Монгол Улсын шүүхийн индекс


Нээлттэй Нийгэм Форум 2008 онд шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх хөтөлбөрөө эхлүүлж, салбарын анхны хараат бус, хөндлөнгийн үнэлгээ хийж, шүүхэд тулгамдаж буй асуудлыг илрүүлэн оношлох оролдлого хийсэн нь 2012 оны шүүхийн шинэтгэлийн үйл явцад зохих хувь нэмрээ оруулсан. Энэхүү шинэтгэлээр шүүхийг нээлттэй, ил тод болгох чиглэлд бодитой ахиц дэвшил гарч, бие даасан шүүхийн захиргааг бий болгон, шүүхийг тойргийн журмаар зохион байгуулж, шүүхийн иргэдийн төлөөлөгч, тахар зэрэг чухал институтыг бий болгон тусгайлан хуулиар зохицуулах болсон нь энэхүү шинэтгэлийн онцлог байсан.

Улмаар 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт, түүний мөрөөр 2021 онд баталсан Монгол Улсын шүүхийн тухай хууль нь шүүхийн шинэтгэлд томоохон алхам болсог. Өмнөх шинэтгэлийн адил олон нийт, хуульчдын дунд нэг талаас ихээхэн хүлээлт, нөгөө талаас багагүй шүүмж дагуулсан энэхүү хуулийн хэрэгжилт 2022 оноос л эхэлж байна. Нээлттэй Нийгэм Форум өнгөрсөн хугацаанд шүүхийн салбарт хэрэгжүүлсэн судалгаа

⁵⁹ The Global Power City Index YEARBOOK 2022, pp.13-14, <https://mori-m-foundation.or.jp/english/ius2/gpci2/index.shtml>

⁶⁰ The Global Power City Index YEARBOOK 2022, pp.297, <https://mori-m-foundation.or.jp/english/ius2/gpci2/index.shtml>





шинжилгээний туршлагад үндэслэн шүүхийн шинэтгэлийн үйл явцад тогтмол, бодитой үнэлгээ өгөх, ирээдүйн чиг хандлагыг тодорхойлох зорилгоор Монгол Улсын шүүхийн индексийг хоёр жил тутамд гаргаж шүүхийн салбарын бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх үйл явцад бодитой хувь нэмэр оруулахыг зорьж байна. Монгол Улс Дэлхийн шударга ёсны төслийн Эрх зүйт ёсны индексэд 2015 оноос, Дэлхийн эдийн засгийн форумын Өрсөлдөх чадварын индексэд 2007 оноос эхлэн оролцож, манай шударга ёсны салбар дэлхийн улсуудтай харьцуулахад ямар түвшинд байгаа талаар мэдээлэл авч ирлээ. Эдгээр олон улсын индекс нь арга зүйн хувьд эрх зүйн тогтолцоо, хөгжлийн түвшин харилцан адилгүй олон улсыг харьцуулах боломжтой байх үүднээс бүгдэд хамаарах маш ерөнхий асуумжаар, цөөн эх сурвалжид үндэслэн үнэлдэг тул хууль зүйн салбараас тухайлан шүүхийн салбарын тулгамдаж байгаа тодорхой асуудлыг нарийвчлан харахад хүндрэлтэй байдаг.

Монгол Улсын шүүхийн индекс нь тухайлан шүүхийн салбарт өрнөж буй шинэтгэлийн үр нөлөөг хараат бусаар үнэлж, аливаа ухралтаас сэргийлэх, хэрэгжилтийн шатанд эрчимжүүлэх шаардлагатай асуудлыг тодорхойлох, олон улстай харьцуулах гэхээс илүү гарч буй өөрчлөлтийг хоёр жил тутамд хэмжих боломжтой болох юм. Монгол Улсын шүүхийн тухай хууль шинэчлэн батлагдсан 2021 онд анхдагч судалгааг хийж байгаа нь цаашид энэхүү хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр нөлөөг индексээр дамжуулан үнэлэх ач холбогдолтой.

Дүгнэж хэлбэл, шүүхийн индекс нь (1) шүүхийн үйл ажиллагааны төлөв байдлыг олон талаас бодитойгоор үнэлэх; (2) шалгуур үзүүлэлтийн оноонд үндэслэн шүүхийн тулгамдсан асуудал, хүндрэл, бэрхшээлийг тодорхойлох; (3) төлөв байдал, тулгамдсан асуудлын үндсэн дээр шүүхийн хүрээнд цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ, чиг хандлагыг тодорхойлоход чухал хэрэгсэл болно гэж үздэг⁶¹.

Судалгааны арга:

1. Өгөгдөл цуглуулах

Индекс тооцоход шаардлагатай өгөгдлийг захиргааны мэдээлэл, олон нийтийн төсөөллийн санал асуулга, мэргэжилтнүүдийн санал асуулга гэсэн 3 төрлийн эх сурвалжаар цуглуулна. Санал асуулгын асуулт бүрийн хариултыг урьдчилж тоон утгаар кодлосон байна. Бүх асуултын хариултыг бага утгаас (шүүхийн үйл ажиллагаа сул) их утга (шүүхийн үйл ажиллагаа сайн) хүртэл нэгдсэн дараалалд оруулан нормализаци хийх шатанд бэлтгэнэ. Асуултын агуулгаас хамаарч зарим асуултын хариултыг урвуу дараалалд оруулна.

2. Өгөгдлийг цэвэрлэх, нормализаци хийх

Дутуу бөглөсөн, асуултад нэгээс илүү хариулт өгсөн, эсвэл “мэдэхгүй” гэж хариулт өгсөн асуулгыг хүчингүйд тооцон индекс боловсруулалтанд хамруулахгүй.

Өгөгдлийн санг үр ашигтайгаар зохион байгуулах, хэмжигдэхүүн хоорондын утгыг нэгдсэн байдлаар харьцуулах боломжийг бий болгох зорилгоор хариулт бүрийг 0-ээс 1 хүртэлх утгын хооронд нормализаци (min-max normalization) хийнэ.

3. Шалгуур үзүүлэлтийн оноо тооцох

Өгөгдлийг нормализаци хийсний дараа шалгуур үзүүлэлт бүрийн дундаж утгыг тооцно. Шалгуур үзүүлэлтийн дундаж утгыг 0-100 хүртэлх индексийн оноонд хөрвүүлнэ.

4. Дэд хэмжигдэхүүний оноо тооцох

⁶¹ Нээлттэй нийгэм форум, Оюуны инноваци ТББ, “Монгол улс шүүхийн индекс 2021” судалгааны тайлан, УБ, 2021, 12 дахь тал, http://judindex.forum.mn/uploads/courtindex_2021.pdf



Дэд хэмжигдэхүүний оноог тооцохдоо шалгуур үзүүлэлт бүрийн холбогдох жинг харгалзан дундаж оноог тооцно.

5. Үндсэн хэмжигдэхүүний оноо тооцох

Үндсэн хэмжигдэхүүний оноог тооцохдоо дэд хэмжигдэхүүн бүрийн холбогдох жинг харгалзан дундаж оноог тооцно.

6. Индексийн ерөнхий оноо тооцох

Үндсэн хэмжигдэхүүн бүрийн холбогдох жинг харгалзан дундаж оноог тооцсоноор индексийн ерөнхий оноог гарган авна⁶².

Шалгуур үзүүлэлтүүд:

Шүүхийн индекс нь үндсэн хэмжигдэхүүн, дэд хэмжигдэхүүн, шалгуур үзүүлэлт гэсэн 3 түвшний бүтэцтэй. Шүүхийн индексийн хүрээнд 6 үндсэн хэмжигдэхүүн, 42 дэд хэмжигдэхүүнд хуваагдсан 108 шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон. Үндсэн хэмжигдэхүүн, дэд хэмжигдэхүүн, шалгуур үзүүлэлт тус бүрийг 0-ээс 100 оноогоор үнэлсэн бөгөөд 0 нь хамгийн сул, 100 нь хамгийн сайн гэсэн утгатай. Өөрөөр хэлбэл, индекс нь шүүх засаглалын өнөөгийн байдал хамгийн сулаас хамгийн сайн хувилбар хүртэлх зайд хэр хол байгааг хэмжих бөгөөд энэ удаагийн индексийн үр дүн нь дараагийн жилүүдэд тооцогдох индексийн үр дүнтэй харьцуулагдсанаар илүү тодорхой үнэлгээ болно. Дараах шалгуур үзүүлэлтийн дагуу индексийг тооцдог⁶³.

№	Үндсэн хэмжигдэхүүн	Дэд хэмжигдэхүүний тоо	Шалгуур үзүүлэлтийн тоо
1.	Шүүхийн эрх хэмжээ, бие даасан байдал	7	27
2.	Шүүхийн нээлттэй, ил тод байдал	9	16
3.	Шүүхэд итгэх олон нийтийн итгэл	6	19
4.	Шүүхийн дэд бүтэц, нөөц	7	15
5.	Шүүгчийн ёс зүй ба хариуцлага	6	12
6.	Шүүхийн үр ашигтай үйл ажиллагаа	7	19
	Нийт	42	108

Нээлттэй нийгэм форум, Оюуны инноваци ТББ, “Монгол улс шүүхийн индекс 2021” судалгааны тайлангаас хэсэгчлэн авав. http://judindex.forum.mn/uploads/courtindex_2021.pdf

Үндсэн хэмжигдэхүүн болон дэд хэмжигдэхүүнийг дараах байдлаар мөн тодорхойлсон байна.

Шүүхийн эрх хэмжээ, бие даасан байдал	Хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх
	Хууль тогтоох эрх мэдэлд тавих шүүхийн хяналт
	Гүйцэтгэх эрх мэдэлд тавих шүүхийн хяналт
	Шүүхийн бие даасан байдал
	Шүүгчийн хараат бус байдал
	Шүүхийн ерөнхий зөвлөл

⁶² Нээлттэй нийгэм форум, Оюуны инноваци ТББ, “Монгол улс шүүхийн индекс 2021” судалгааны тайлан, УБ, 2021, 32 дахь тал, http://judindex.forum.mn/uploads/courtindex_2021.pdf

⁶³ Нээлттэй нийгэм форум, Оюуны инноваци ТББ, “Монгол улс шүүхийн индекс 2021” судалгааны тайлан, УБ, 2021, 22 дахь тал, http://judindex.forum.mn/uploads/courtindex_2021.pdf



	Шүүх, шүүгчийн аюулгүй байдал
Шүүхийн нээлттэй, ил тод байдал	Шүүгчийн сонгон шалгаруулалт
	Хууль тогтоомж
	Шүүхийн тайлан, статистик
	Шүүх хуралдаан
	Шүүхийн шийдвэр
	Хэргийн материалтай танилцах
	Хэрэг, нэхэмжлэлийн хуваарилалт
	Шүүхийн төсвийн ил тод байдал
	Хэвлэл мэдээллийн сурвалжилга
Шүүхэд итгэх олон нийтийн итгэл	Шүүхийн тогтолцоо
	Шүүгчийн шударга байдал
	Шүүгчийн зан суртахуун
	Шүүгчийн мэдлэг, ур чадвар
	Шүүхийн процессын сэтгэл ханамж
	Шүүхийн шийдвэрийн үндэслэл
Шүүхийн дэд бүтэц, нөөц	Шүүгчийн сонгон шалгаруулалт
	Шүүгчийн мэдлэг, ур чадвар
	Шүүгчийн цалин хөлс
	Шүүхийн захиргааны ажилтан
	Шүүхийн барилга байгууламж
	Шүүхийн мэдээллийн технологи
	Эрсдэлийн удирдлагын тогтолцоо
Шүүгчийн ёс зүй ба хариуцлага	Шүүгчийн ажлын гүйцэтгэл
	Шүүгчийн хариуцлагын тогтолцоо
	Шүүгчийн сахилгын зөрчлийн процесс
	Сахилгын шийтгэл
	Шүүгчийн ёс зүй
	Шүүгчтэй холбоотой гомдлын мэдээлэл
Шүүхийн үр ашигтай үйл ажиллагаа	Шийдвэрлэгдээгүй хэргийн тоо
	Хэрэг шийдвэрлэлтийн хувь
	Шүүгчийн ажлын ачаалал
	Шүүхийн шийдвэрийн тогтвортой байдал
	Шүүхийн үр ашгийн тухай төсөөлөл
	Шүүхийн захиргааны үйлчилгээ
	Шүүхийн шийдвэрийн биелэлт

Давуу тал:

- Монгол Улсын хэмжээнд шүүхийн индексийг тодорхойлсон;
- Шүүхийн индексийн шалгуур үзүүлэлтийг нарийвчлан тодорхойлж, тал бүрээс нь шүүх эрх мэдлийн зохион байгуулалтын ойлголтыг авч үзсэн;
- Судалгааны арга зүйн хувьд тохирсон аргачлалыг бий болгож ашигласан.

Сул тал:

- Зөвхөн шүүх эрх мэдлийн хүрээнд л тухайн индексийг тодорхойлдог;
- Нийслэлийн хүрээнд бус Монгол Улсын хэмжээнд шүүхийн индексийн хэмждэг;
- Анхны удаа хэрэгжиж буй төсөл учраас засаж сайжруулах зүйл байж болзошгүй.

Дээрхээс дүгнэвэл, сул тал багатай, давуу тал ихтэй индекс үзүүлэлтийн тухайд Дэлхийн шударга ёсны төсөл (World Justice Project)-ийн “Rule of Law index” буюу “Хууль

дээдлэх ёсны индекс” байна. Хууль дээдлэх ёсны индекс”-ийн тухайд шалгуур үзүүлэлт нь өргөн хүрээнд нарийвчлагдсанаас гадна судалгааны арга зүй сайтай, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эх сурвалж юм. Иймд нийслэлийн “Шударга байдлын үнэлгээ” индексийг тооцохдоо дээрх индекс шалгуур үзүүлэлтэд үндэслэх нь зүйтэй байна.

4.3. СУДАЛГААНЫ ДАТА ЦУГЛУУЛАХ

“Төрийн эрх мэдлийн хязгаарлалт” шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

- Нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн мэдээлэл⁶⁴

Хүснэгт 45. Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн нийт шийдвэрлэсэн хэргийн тоо

Шүүх	Он		Өсөлт, бууралт	
	2021	2022	Тоо	Хувь
Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүх	984	1065	81	8.2
Улсын нийт	1764	2173	409	23.2

- Нийслэлийн төрийн албан хаагчдын мэдээлэл⁶⁵

Хүснэгт 46. Төрийн албан хаагчийн нийт тоо

Он	Хүн амын тоо	Төрийн албан хаагч	Нийт хүн амд эзлэх хувь
2022	3368632	225205	6.68%

Хүснэгт 47. Нийслэл дэх төрийн байгууллагын тоо, байршлаар

Байршил /Нутаг дэвсгэрээр/	Төрийн байгууллагын тоо
Нийслэл	689

Хүснэгт 48. Төрийн байгууллагын тоо, чиг үүргийн ангилал, байршлаар

Байршил	Төрийн төв, төрийн захиргааны төв, төрийн захиргааны байгууллага	Төрийн тусгай чиг үүргийн байгууллага	Төрийн үйлчилгээний байгууллага	Нийт
Нийслэл	131	14	544	689

Хүснэгт 49. Төрийн албан хаагчийн тоо, байршил, төрийн албаны ангиллаар

Аймаг хотын нэр	Нийт төрийн албан хаагч	Үүнээс			
		Төрийн улс төр	Төрийн захиргаа	Төрийн тусгай	Төрийн үйлчилгээ

⁶⁴ Шүүхийн ерөнхий зөвлөл “Монгол Улсын шүүхийн тайлан 2022 он”, УБ, 2023, 270-271 дэх тал.

⁶⁵ Төрийн албаны зөвлөл, “Монгол Улсын төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны тайлан-2022”, УБ, 2023.

Нийслэл	60686	312	5400	934	54040
---------	-------	-----	------	-----	-------

Хүснэгт 50. Нийслэлийн төрийн байгууллага, түүнд хамаарах төрийн албан хаагчийн тоо, мэдээлэл дүүргээр

№	Дүүргийн нэр	Байгууллагын тоо	Төрийн албан хаагч			Төрийн захиргаа			Төрийн улс төр			Төрийн тусгай			Төрийн үйлчилгээ		
			Нийт	Эмэгтэй	Эрэгтэй	Нийт	Эмэгтэй	Эрэгтэй	Нийт	Эмэгтэй	Эрэгтэй	Нийт	Эмэгтэй	Эрэгтэй	Нийт	Эмэгтэй	Эрэгтэй
1	Нийслэлийн байгууллага	54	4247	2765	1482	2072	1365	707	13	2	11	447	244	203	1715	1154	561
2	Багануур	28	1608	1308	300	142	116	26	10	7	3	21	12	9	1435	1173	262
3	Багахангай	14	329	242	87	60	45	15	9	6	3	7	3	4	253	188	65
4	Баянгол	83	11085	9064	2021	613	482	131	45	22	23	97	52	45	10330	8508	1822
5	Баянзүрх	118	12626	10087	2539	625	498	127	52	20	32	99	54	45	11850	9515	2335
6	Налайх	32	1873	1449	424	145	114	31	14	9	5	15	7	8	1699	1319	380
7	Сонгинохайрхан	114	9115	7421	1694	468	366	102	47	22	25	60	34	26	8540	6999	1541
8	Сүхбаатар	100	9829	7353	2476	480	375	105	66	33	33	93	60	33	9190	6885	2305
9	Хан-Уул	74	5284	4313	971	368	291	77	28	14	14	32	17	15	4856	3991	865
10	Чингэлтэй	72	4690	3812	878	427	326	101	28	11	17	63	33	30	4172	3442	730
	Бүгд	689	60686	47814	12872	5400	3978	1422	312	146	166	934	516	418	54040	43174	10866

- Төрийн бус байгууллагуудын мэдээлэл⁶⁶

Статистик үзүүлэлт	Аймаг сум	2023-1
Төрийн бус байгууллага	Улаанбаатар	4740
	Баянзүрх дүүрэг	1195
	Сүхбаатар дүүрэг	1022
	Чингэлтэй дүүрэг	516
	Баянгол дүүрэг	798
	Хан-Уул дүүрэг	777
	Сонгинохайрхан дүүрэг	345
	Багануур дүүрэг	43
	Налайх дүүрэг	38
	Багахангай дүүрэг	6

“Авлигагүй байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

- Авлигатай тэмцэх газрын мэдээлэл

1. Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааны тайлан

Хүснэгт 51. ХАСХОМ мэдүүлэг гаргагчийн тоо, нийслэлээр

⁶⁶ Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, “ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО, улирал, улс, бүс, аймаг, нийслэл, сум, дүүрэг, хариуцлагын хэлбэрээр”, https://www2.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NS0_2600_011V3&13999001_select_all=0&13999001SingleSelect=T8&Aimags_soums_select_all=0&Aimags_soumsSingleSelect=0501&YearQ_select_all=0&YearQSingleSelect=202301&viewtype=table

ХАСХОМ мэдүүлэг гаргагч	Тоо
Улаанбаатар	23302
Нийт	41686

График 6. Хянан шийдвэрлэсэн гэмт хэргийн талаархи гомдол, мэдээлэл (өмнөх оны мөн үетэй харьцуулбал)




График 7. Гомдол мэдээлэлд холбогдох албан тушаалтны ангилал



График 8. Авлигын хэргийн шийдвэрлэлт (өмнөх оны мөн үетэй харьцуулбал)




График 9. Гэмт хэрэгт холбогдон шалгагдсан албан тушаалтан (өмнөх оны мөн үетэй харьцуулбал)



Хүснэгт 52. Шүүхээр шийдвэрлэсэн авлигын хэрэг, оноор

Он	Шүүхээр шийдвэрлэсэн авлигын хэрэг
2021	160
2022	188

2. “Шударга байдлын үнэлгээ” судалгааны тайлан⁶⁷

Хүснэгт 53. Дүүргүүдийн ЗДТГ-ын шударга байдлын үнэлгээ

№	Дүүргүүдийн ЗДТГ	Шударга байдлын үнэлгээний оноо
1.	Хан-уул дүүргийн ЗДТГ	79.3
2.	Багахангай дүүргийн ЗДТГ	77.5
3.	Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ	74.3
4.	Чингэлтэй дүүргийн ЗДТГ	74.2
5.	Сүхбаатар дүүргийн ЗДТГ	73.7
6.	Баянзүрх дүүргийн ЗДТГ	72.9
7.	Баянгол дүүргийн ЗДТГ	72.9
8.	Багануур дүүргийн ЗДТГ	72.9
9.	Налайх дүүргийн ЗДТГ	70.9
Нийслэлийн дундаж		74.2
Нийт шударга байдлын үнэлгээ		73.9

Хүснэгт 54. Дүүргүүдийн ЗДТГ-ын гадаад шударга байдлын үнэлгээ

№	Дүүргүүдийн ЗДТГ	Гадаад шударга байдлын үнэлгээний оноо
1.	Хан-уул дүүргийн ЗДТГ	75.5
2.	Багахангай дүүргийн ЗДТГ	73.1
3.	Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ	73
4.	Чингэлтэй дүүргийн ЗДТГ	68.8
5.	Сүхбаатар дүүргийн ЗДТГ	66.1
6.	Баянзүрх дүүргийн ЗДТГ	66.0
7.	Баянгол дүүргийн ЗДТГ	59.0
8.	Багануур дүүргийн ЗДТГ	58.7

⁶⁷ Авлигатай тэмцэх газар, “Шударга байдлын үнэлгээ” судалгааны тайлан, УБ, 2022.

9.	Налайх дүүргийн ЗДТГ	55.7
Нийслэлийн дундаж		66.2

Хүснэгт 55. Дүүргүүдийн ЗДТГ-ын дотоод шударга байдлын үнэлгээ

№	Дүүргүүдийн ЗДТГ	Дотоод шударга байдлын үнэлгээний оноо
1.	Хан-уул дүүргийн ЗДТГ	89.1
2.	Багахангай дүүргийн ЗДТГ	89.1
3.	Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ	86.4
4.	Чингэлтэй дүүргийн ЗДТГ	85.6
5.	Сүхбаатар дүүргийн ЗДТГ	85.5
6.	Баянзүрх дүүргийн ЗДТГ	83.6
7.	Баянгол дүүргийн ЗДТГ	83.5
8.	Багануур дүүргийн ЗДТГ	82.8
9.	Налайх дүүргийн ЗДТГ	82.7
Нийслэлийн дундаж		85.4

Хүснэгт 56. Бодлогод оролцогчдын шударга байдлын үнэлгээ

№	Дүүргүүдийн ЗДТГ	Бодлогод оролцогчдын шударга байдлын үнэлгээний оноо
1.	Хан-уул дүүргийн ЗДТГ	80.3
2.	Багахангай дүүргийн ЗДТГ	75.9
3.	Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ	74.2
4.	Чингэлтэй дүүргийн ЗДТГ	74.2
5.	Сүхбаатар дүүргийн ЗДТГ	70.4
6.	Баянзүрх дүүргийн ЗДТГ	69.0
7.	Баянгол дүүргийн ЗДТГ	67.1
8.	Багануур дүүргийн ЗДТГ	66.0
9.	Налайх дүүргийн ЗДТГ	64.2
Нийслэлийн дундаж		71.2

- Шүүхийн мэдээлэл

Хүснэгт 57. Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сангийн шүүхээр шийдвэрлэсэн авлигын гэмт хэргийн мэдээлэл⁶⁸

Дүүргийн шүүхүүд	Шийдвэрлэсэн хэргийн тоо
Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	9
Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	13
Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	14
Баянгол дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	10
Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	9

⁶⁸ Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан, <https://shuukh.mn/>

Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	9
Багануур дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	0
Налайх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	0
Багахангай дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	0

“Нээлттэй засаглал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

- Олон нийтэд түгээсэн хууль, тогтоомжийн мэдээлэл⁶⁹

№	Эрх зүйн актын төрлөөр	Эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд байршуулсан тоо
1.	Монгол Улсын Үндсэн хууль	1
2.	Монгол Улсын хууль	887
3.	Монгол Улсын олон улсын гэрээ	674
4.	Ерөнхийлөгчийн зарлиг	215
5.	Улсын Их Хурлын тогтоол	2262
6.	Засгийн газрын тогтоол	5163
7.	Үндсэн хуулийн цэцийн шийдвэр	307
8.	Улсын дээд шүүхийн тогтоол	257
9.	УИХ-аас томилогддог байгууллагын дарга, түүнтэй адилтгах албан тушаалтны шийдвэр	153
10.	Сайдын тушаал	891
11.	Засгийн газрын агентлагийн даргын тушаал	193
12.	Хууль, хяналтын байгууллага	3
13.	Төрийн зарим чиг үүргийг хууль болон гэрээний үндсэн дээр хэрэгжүүлж буй байгууллага	3
14.	Аймаг, нийслэлийн ИТХ-ын шийдвэр	1060
15.	Аймаг, нийслэлийн Засаг даргын захирамж	60
16.	Зөвлөл, хороо, бусад байгууллага	404
17.	Шүүхийн ерөнхий зөвлөл	9
18.	Албан бус орчуулга	313

- Төрийн байгууллагуудын мэдээллийн хүртээмжтэй байдлын талаар мэдээлэл

Хүснэгт 58. Нийслэлийн харьяа байгууллагуудын мэдээллийн хүртээмжтэй байдал

№	Нийслэлийн байгууллагууд	Мэдээллийн хүртээмжтэй байдал
1.	Нийслэлийн Засаг даргын тамгын газар	Хүртээмжтэй
2.	Улаанбаатар хотын захирагчийн ажлын алба	Хүртээмжтэй
3.	Агаар, орчны бохирдолтой тэмцэх газар;	Хүртээмжтэй
4.	Архивын газар;	Хүртээмжтэй
5.	Аялал жуулчлалын газар;	Хүртээмжтэй
6.	Байгаль орчны газар (Зуслангийн товчоотой);	Хүртээмжтэй

⁶⁹ Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, <https://legalinfo.mn/mn>

7.	Бизнес инновац хөгжлийн газар;	Хүртээмжтэй
8.	Дотоод аудитын алба;	Зарим талаар хүртээмжтэй
9.	Замын хөгжлийн газар;	Хүртээмжтэй
10.	Биеийн тамир, спортын газар;	Хүртээмжтэй
11.	Боловсролын газар;	Хүртээмжтэй
12.	Газар зохион байгуулалтын алба;	Хүртээмжтэй
13.	Хот байгуулалт, хөгжлийн газар;	Хүртээмжтэй
14.	Орон сууцны бодлогын газар;	Хүртээмжтэй
15.	Цахим хөгжил, мэдээллийн технологийн газар;	Хүртээмжтэй
16.	Нийтийн тээврийн газар;	Хүртээмжтэй
17.	Дагуул хот, эдийн засгийн тусгай бүсийн хөгжлийн газар;	Хүртээмжтэй
18.	Өмчийн харилцааны газар;	Хүртээмжтэй
19.	Соёл, урлагийн газар;	Хүртээмжтэй
20.	Худалдан авах ажиллагааны газар;	Хүртээмжтэй
21.	Хүнс, хөдөө аж ахуйн газар;	Хүртээмжтэй
22.	Эрүүл мэндийн газар;	Хүртээмжтэй
23.	Хотын стандарт, хяналтын газар;	Хүртээмжтэй
24.	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар;	Хүртээмжтэй
25.	Мал эмнэлгийн газар;	Хүртээмжтэй
26.	Нийгмийн даатгалын газар;	Хүртээмжтэй
27.	Хөдөлмөр, халамжийн газар;	Хүртээмжтэй
28.	Нийтлэг үйлчилгээний газар;	Хүртээмжтэй
29.	Улсын бүртгэлийн газар;	Хүртээмжтэй
30.	Онцгой байдлын газар (нөөцийн албатай);	Хүртээмжтэй
31.	Статистикийн газар;	Хүртээмжтэй
32.	Татварын газар;	Хүртээмжтэй
33.	Цагдаагийн удирдах газар;	Хүртээмжтэй
34.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар.	Хүртээмжтэй
35.	Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ	Хүртээмжтэй
36.	Нийслэлийн Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих төв ОНӨТҮГ	Хүртээмжтэй
37.	Нийслэлийн Төр захиргааны автобааз ОНӨТҮГ	Хүртээмжтэй
38.	Багануур дүүргийн үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ	Зарим талаар хүртээмжтэй
39.	Багахангай дүүргийн Үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ	Зарим талаар хүртээмжтэй
40.	Эмээлт эко аж үйлдвэрийн парк НӨААТҮГ	Хүртээмжтэй
41.	Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк ОНӨААТҮГ	Хүртээмжтэй
42.	Монгол наадам ОНӨТҮГ	Зарим талаар хүртээмжтэй
43.	Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ	Хүртээмжтэй
44.	Улаанбаатар театр ОНӨТҮГ	Зарим талаар хүртээмжтэй
45.	Хүүхэд залуучуудын сургалт хүмүүжлийн тусгай цогцолбор ОНӨТҮГ	Хүртээмжтэй
46.	Монголын хүүхдийн ордон ОНӨТҮГ	Хүртээмжтэй
47.	Монголын хүүхдийн урлан бүтээх төв ОНӨТҮГ	Хүртээмжтэй



48.	Нийгмийн хамгааллын тусгай төв ОНӨТҮГ	Хүртээмжтэй
49.	Асгат ОНӨААТҮГ	Хүртээмжтэй
50.	Багачууд хүнс ОНӨААТҮГ	Хүртээмжтэй
51.	Хүнс хангамж ОНӨААТҮГ	Хүртээмжтэй
52.	Өсвөр үе хүнс ОНӨААТҮГ	Зарим талаар хүртээмжтэй
53.	Гэрлэх ёслолын ордон ОНӨААТҮГ	Зарим талаар хүртээмжтэй
54.	Замын хөдөлөгөөний удирдлагын төв ОНӨТҮГ	Хүртээмжтэй
55.	Улаанбаатар лифт ОНӨТҮГ	Хүртээмжтэй
56.	Улаанбаатар хотын шуурхай, удирдлага, зохицуулалтын төв	Хүртээмжтэй
57.	Үндэсний цэцэрлэгт хүрээлэн ОНӨТҮГ	Хүртээмжтэй
58.	Үртсэн шахмал түлшний үйлдвэр ОНӨААТҮГ	Зарим талаар хүртээмжтэй
59.	Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ	Зарим талаар хүртээмжтэй
60.	Зорчигч тээврийн гурав ОНӨААТҮГ	Хүртээмжтэй
61.	Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ	Зарим талаар хүртээмжтэй
62.	Геодизи усны барилга, байгууламжийн газар ОНӨААТҮГ	Хүртээмжтэй
63.	Улаанбаатар хотын нийтийн төв номын сан	Хүртээмжтэй
64.	Улаанбаатар хотын музей	Хүртээмжтэй
65.	Соёлын төв өргөө	Хүртээмжтэй
66.	Нийслэлийн Аддиктологийн төв	Хүртээмжтэй
67.	Нийслэлийн Амгалан амаржих газар	Хүртээмжтэй
68.	Нийслэлийн Өргөө амаржих газар	Хүртээмжтэй
69.	Нийслэлийн Хүрээ амаржих газар	Хүртээмжтэй
70.	Нийслэлийн түргэн тусламжийн төв	Хүртээмжтэй
71.	Нийслэлийн шүд, эрүү, нүүрний төв	Хүртээмжтэй
72.	Нийслэлийн хүүхлийн сэргээн засах эрүүл үрс төв	Зарим талаар хүртээмжтэй
73.	Сэргээн засах клиник эмнэлэг	Зарим талаар хүртээмжтэй
74.	Уламжлалт анагаах ухааны элэг судлалын клиник төв	Зарим талаар хүртээмжтэй
75.	Энэрэл эмнэлэг	Хүртээмжтэй
76.	Хүүхдийн сэргээн засах Хан туул төв	Зарим талаар хүртээмжтэй
77.	Ахмадын хороо	Зарим талаар хүртээмжтэй
78.	Орон сууц нийтийн аж ахуйн газар	Зарим талаар хүртээмжтэй
79.	Улаанбаатар зам засвар арчлалтын газар	Хүртээмжтэй
80.	Улаанбаатар хотын Ус сувгийн удирдах газар	Хүртээмжтэй
81.	Хот тохижилтын газар	Хүртээмжтэй
82.	Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдамжийн газар	Хүртээмжтэй
83.	Нийслэлийн орон сууцны корпораци ХК	Хүртээмжтэй
84.	Улаанбаатар шинэ бүтээн байгуулалт ХХК	Зарим талаар хүртээмжтэй
85.	Тавантолгой түлш ХХК	Хүртээмжтэй
86.	Улаанбаатар хотын хийн сүлжээ ХХК	Зарим талаар хүртээмжтэй
87.	Улаанбаатар хотын хөгжлийн корпораци ХК	Зарим талаар хүртээмжтэй
88.	Олон улсын худалдаа логистикийн төв ХК	Зарим талаар хүртээмжтэй



“Хүний үндсэн эрх” шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

- Хүний эрхийн үндэсний комиссын тайлан⁷⁰

Халдашгүй чөлөөтэй байх эрх

1. Сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлгүй баривчлах ажиллагаатай холбоотой эрх зүйн зохицуулалтыг Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцод нийцүүлэн боловсронгуй болгох;

• Сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлгүй баривчилсан үндэслэлийг хянах шүүхийн хэлэлцүүлэг, сэжигтнийг баривчилснаас хойш 24 цагийн дотор шүүхэд мэгдээгүй эсхүл прокурор, баривчлах байрны даргын шийдвэрээр сулласан тохиолдол бүрийн үндэслэл, шалтгаан, уг арга хэмжээг хэрэгжүүлсэн албан тушаалтан, баривчилсан хугацааны талаарх тайлбарыг уг ажиллагааг хийснээс хойш 30 хоногийн дотор шүүхэд мэдэгдэж байх, тухайн хүн өөрийг нь баривчилсантай холбоотой баримт материалыг холбогдох байгууллагаас гаргуулан авах эрх зүйн зохицуулалтыг хуульчлах;

2. Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах нийтлэг журам, цагдан хорих үндсэн болон сунгах хугацаа, өсвөр насны яллагдагчийг цагдан хорих тусгай журам, цагдан хорих үндэслэлд хамаарах хэт ерөнхий болон өргөжүүлсэн зохицуулалт, шүүхийн хэлэлцүүлэг, шүүхийн шатанд таслан сэргийлэх арга хэмжээ хэрэглэх процессын зохицуулалтыг нарийвчлан хуульчлах;

3. Хууль бусаар баривчлагдсан, цагдан хоригдсон хүний сэтгэл санааны буюу сэтгэцэд учирсан хохирлыг нөхөн төлөх эрх зүйн орчин бүрдүүлэх;

4. Бүх насаар хорих ялыг бие даасан ялын төрөл болгон хуульчлах, энэ төрлийн ял эдлүүлэх дэглэм, зохион байгуулалт, сургалт, хөдөлмөрийн стандартыг шинээр тогтоох;

5. Хорих ял эдлүүлэх дэглэмийн зэрэглэл хүндрүүлэн ганцаарчлан хорьж байгаа тохиолдлыг таслан зогсоох;

6. Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх үндэслэл, эрх зүйн зохицуулалтыг хүний эрхийн зарчим, хэм хэмжээнд нийцүүлэн цогц байдлаар шинэчлэх;

7. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад хүнийг эрүүлжүүлэх, саатуулах болон бусад албадлагын арга хэмжээ хэрэглэхтэй холбоотой нарийвчилсан зохицуулалтыг холбогдох хууль тогтоомжид тусгах, шүүх, прокурорын хяналтыг бий болгох;

8. Шүүгч, прокурор, мөрдөгч, өмгөөлөгчдөд хүний халдашгүй чөлөөтэй байх эрх, хууль бус, дур мэдэн баривчлах нь хүний эрхийн зөрчил болох талаарх сургалтыг тогтмол зохион байгуулах.

9. Мөрдөх болон шүүх эрх мэдлийн байгууллагуудын бүртгэл, мэдээллийн сан, ЭХХША-нд холбогдох зарим ажиллагаа болон зөвшөөрлийн тогтолцоог цахимжуулах.

⁷⁰ Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисс, “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл”, УБ, 2023,

Иргэний оролцооны эрх зүйн зохицуулалт

10. Хэвлэл мэдээллийн хараат бус, олон ургалч, ил тод, хариуцлагатай байдлыг хангах эрх зүйн зохицуулалтыг энэхүү илтгэлд тусгасан байдлаар боловсруулж, Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг шинэчлэн найруулах. Ингэхдээ ХЭҮК-оос боловсруулсан хуулийн загвар төслийг харгалзан үзэх;

11. Энэхүү илтгэлд тусгасан долоон үндсэн чиглэлийг тусгаж, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний шаардлагад нийцүүлэн ЖЦХЖТХ-ийг шинэчлэн найруулах;

12. Төрийн бус байгууллагын эрх зүйн зохицуулалтыг эвлэлдэн нэгдэх, олон нийтийн байгууллага байгуулах иргэний үндсэн эрх чөлөөг хангах үзэл баримтлалд тулгуурлан шинэчлэн бүрдүүлэх;

Хөдөлмөрлөх эрхийн зарим асуудал

13. Нийгэм, эдийн засаг, хөгжлийн олон талт хүчин зүйл, чиг хандлага өөрчлөгдөж байгаатай уялдуулан Төрийн алба, төрийн албан хаагчийн эрх зүйн байдал, хүний нөөцийн бодлого, нийгмийн баталгаанд дүн шинжилгээ хийж, Төрийн албаны тухай хуулийн үзэл баримтлалыг шинээр тодорхойлох, холбогдох хууль тогтоомжийг шинэчлэх;

14. Төрийн албан хаагчийн цалин хөлсийг амьдралын чанартай нийцүүлэн нэмэгдүүлэх, гүйцэтгэх ажил үүргийн хувьд адилтгасан цалин хөлсний нэгдсэн бодлогыг Улсын Их Хурал, Засгийн газраас тодорхойлж, хэрэгжүүлэх;

15. Төрийн албаны тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1.2 дахь заалтад заасны дагуу төрийн албан хаагчийн нийгмийн баталгааны хөтөлбөрийн хэрэгжилтийг Төрийн албаны зөвлөлөөс нэгтгэн үнэлж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг нэгдмэл байдлаар тодорхойлох, санхүүжилтийг үе шаттайгаар шийдвэрлэх;

16. Төрийн тусгай албан хаагчдын хувцас, хэрэгсэл, хүнсний нормд шаардагдах тооцооллын дагуу төсвийг бүрэн олгох;

17. Төрийн албан хаагчийн эрх зүйн байдлыг баталгаажуулах, хөдөлмөрлөх эрхийг хангахын тулд илтгэлийн 3.3, 3.4 дэх дэд сэдвийн хүрээнд санал болгосон Төрийн албаны тухай, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай, Монгол Улсын хилийн тухай, Цагдаагийн албаны тухай, Боловсролын тухай, Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хууль тогтоомжид зохих өөрчлөлтийг тусгах, төрийн тусгай албан хаагчийн онцгой нөхцөлийн нэмэгдлийг 30 хувиас багагүй тогтоох Засгийн газрын тогтоол, холбогдох бусад эрх зүйн зохицуулалтыг шинэчлэн батлах;


18. Хоригдлын хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг нэмэгдүүлэх, байнгын ажлын байраар хангахад чиглэсэн салбар дундын нэгдсэн бодлого, хөтөлбөрийг батлан хэрэгжүүлэх;

19. “Хоригдлыг суллахад бэлдэх хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангаж, санхүүжилтийг шийдвэрлэх, хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах;

Хүүхдийн эрхийн зарим асуудал

20. Стандартын шаардлага хангахгүй ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрын жагсаалтын дагуу шинэчлэх төлөвлөгөө гарган санхүүжилтийг шийдвэрлэх;





21. Дотуур байрын гадна болон дотор орчны аюулгүй байдал, хоол хүнс, цэвэр усны хэрэглээнд эцэг, эхийн оролцоотой хөндлөнгийн хяналт тавих тогтолцоог бий болгох;

22. Дотуур байр дахь хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг орон нутгийн төсөвт зайлшгүй тусгах;

23. Дотуур байрын багшийн албан тушаалыг ерөнхий боловсролын сургуулийн багштай дүйцүүлэх, туслах, эмч, сэтгэл зүйч, тогооч, жижүүр, үйлчилгээний ажилтны орон тоог дотуур байрын хүчин чадал, суралцагчдын тоотой уялдуулан баталж, цалин хөлсийг нэмэгдүүлэх, нийгмийн баталгааг сайжруулах;

24. Дотуур байрын багш болон ажилчдыг тусгайлан чадавхжуулах хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх, орон нутгийн холбогдох эрх бүхий байгууллагуудын уялдаа холбоотой ажиллах, хамтын ажиллагааг сайжруулах;

25. Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйл ажиллагаанд шаардлагатай төсвийг орон нутгийн төсөвт нарийвчлан тусгадаг болох;

26. “Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.4.4-4.4.8-д заасан төлөвлөгөөг гаргаж, хэрэгжүүлдэг болох;

27. Хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэхийг хойшлуулсан өсвөр насны этгээдэд хэрхэн хяналт тавих, сургууль, боловсрол эзэмших эрхийг нь хэрхэн хангах, хүүхэд хамгааллын бусад байгууллагатай хамтран ажиллах горимыг тодорхой болгох;

28. Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйл ажиллагааг гэмт хэрэгт холбогдсон, гэрч, хохирогч хүүхдийн ар гэртэй ажиллах хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх.

Ахмад настны эрхийн хэрэгжилт

29. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 30 дугаар зүйл, Ахмад настны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсгийн хэрэгжилтийг хангах, тэтгэврийн зөрүүг арилгах арга хэмжээ авах;


30. Олон давхаргат тэтгэврийн тогтолцоонд шилжих хүрээнд Нийгмийн даатгалын багц хуулийн төслийг нэн даруй батлах;

31. Засгийн газраас урт хугацааны тусламж үйлчилгээний нэгдсэн, цогц тогтолцоог бүрдүүлэх зорилтоо эрчимжүүлж энэ хүрээнд асаргааны даатгалын хууль эрх зүйн орчныг бий болгох, ахмад настны эрүүл мэндтэй холбоотой үндэсний хэмжээний суурь судалгааг хийж, насжилтын үеийн өвчний эрсдэлийг нэмэгдүүлдэг хүчин зүйлүүдийн үр нөлөөг бууруулах;

32. Ахмад настанд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх мэргэшсэн эмч, эмнэлгийн мэргэжилтэн, хүний нөөцийг нэмэгдүүлж, бэлтгэх;

33. Улаанбаатар хотын Хан-Уул дүүрэгт баригдаж байгаа Геронтологийн үндэсний төвийн /Ахмадын эмнэлэг/ 60 ортой цогцолбор шинэ эмнэлгийн барилгын асуудлыг шийдвэрлэх;





34. Ахмад настны онцлогоос хамааран хийх боломжтой ажлын байруудыг тусгайлан тогтоож, тухайн ажлын байрыг санал болгож буй ажил олгогчдод шимтгэл, татварын бодлогоор дэмжлэг үзүүлэх бодлогын шийдвэр гаргах;

35. Эрэгтэйчүүд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй, бэлгийн цөөнх зэрэг нийгмийн бүлгийн хэрэгцээ, хүйсийн ялгаатай байдалд нийцүүлж хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвийг төрөлжүүлэх, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих ажлыг эрчимжүүлэх;

Хүний эрх хамгаалагчийн эрх, хамгаалалт

36. Цагдаагийн байгууллагад хүний эрх хамгаалагчийг хамгаалах чиг үүрэг нэмэгдсэнтэй холбоотойгоор хүний эрх хамгаалагч, түүний хамаарал бүхий гэр бүлийн гишүүдийг хамгаалах арга хэмжээний зардлыг улсын төсөвт тусгаж, ЦЕГ-ын Гэрч, хохирогчийн хамгаалах хэлтсийн орон тоог нэмэгдүүлэх асуудлыг судалж шийдвэрлэх;

37. Хүний эрх хамгаалагчдыг гэмт хэрэгт холбогдуулан шалгаж байгаа асуудалд тавих прокурорын хяналтыг сайжруулах, энэ төрлийн гэмт хэргийг УЕПГ-аас нэгдсэн байдлаар татаж хянан, үр дүнг олон нийтэд мэдээлэх горимыг тогтоох;

Улс төрийн хүрэн дэх жендэрийн эрх тэгш байдал

38. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай, Улс төрийн намын тухай хуульд сонгуульд нэр дэвших хүйсийн төлөөлөл 50:50 харьцаатай байхаар хуульчлах;

39. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль тогтоомж зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг Зөрчлийн тухай хуульд тусгах;

40. Улс төрийн намын тухай хуулийн 19 дүгээр зүйлд эмэгтэй нэр дэвшигчийг сонгуульд нэр дэвшүүлж, сонгогдсон суудлын тоогоор төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

41. Улсын Их Хурал Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хэрэгжилтийг хангах;

42. Сонгогчдын боловсролыг тасралтгүй дээшлүүлэх үйл ажиллагааг зохион байгуулахад шаардагдах төсвийг Сонгуулийн ерөнхий хорооны төсөвт жил бүр тусгаж, зорилтот бүлэгт тохирсон, цаг үетэй нийцсэн, шинэлэг сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулах;

43. Сонгуулийн зардлын эцсийн тайланг бүхэлд нь ил болгохыг холбогдох хууль тогтоомжид тусгаж, хэрэгжилтийг хангах.

- Шүүхээр шийдвэрлэсэн хэргийн мэдээлэл⁷¹

⁷¹ Шүүхийн ерөнхий зөвлөл “Монгол Улсын шүүхийн тайлан 2022 он”, Уб, 2023


Хүснэгт 59. Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрлэсэн хэрэг, төрлөөр

№	Хэргийн төрөл	Хэргийн тоо				Ял шийтгүүлэгчдийн тоо				Хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх
		Өсөлт, бууралт				Өсөлт, бууралт				
		2021 он	2022 он	Тоо	Хувь	2021 он	2022 он	Тоо	Хувь	
1	Хүнийг алах	197	179	-18	-9.1	205	177	-28	-13.7	0
2	Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах	327	399	72	22.0	322	402	80	24.8	1
3	Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах	5006	6097	1091	21.8	4926	6509	1583	32.1	13
4	Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	99	97	-2	-2.0	60	84	24	40.0	10
5	Хүчиндэх	346	363	17	4.9	328	333	5	1.5	50
6	Хүн худалдаалах	6	3	-3	-50.0	10	9	-1	-10.0	
7	Хулгайлах	1253	1598	345	27.5	1129	1529	400	35.4	363
8	Дээрэмдэх	191	197	6	3.1	229	257	28	12.2	35
9	Залилах	736	815	79	10.7	705	851	146	20.7	64
10	Улсын хилээр барааг хууль бусаар хил нэвтрүүлэх	7	14	7	100.0	10	17	7	70.0	0
11	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах	147	177	30	20.4	186	241	55	29.6	28
12	Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	788	1074	286	36.3	419	679	260	62.1	361
13	Бусад	2965	3189	224	7.6	2734	3306	572	20.9	744
	Нийт	12068	14202	2134	17.7	11263	14394	3131	27.8	1669

Хүснэгт 60. Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрлэсэн хэрэг, төрлөөр

№	Хэрэг, маргааны төрөл			Өсөлт, бууралт		Нийт хэрэгт эзлэх хувь		Зөрүү /+/, /-/
		2021 он	2022 он	Тоо	Хувь	2021 он	2022 он	
Жигнэсэн дундаж тарифын талаарх хамгийн дэлгэрэнгүй мэдээллийг Дэлхийн банк тогтмол нийтэлдэг. Жигнэсэн дундаж тарифын хувь хэмжээ байхгүй тохиолдолд *Индекс* тухайн улсын хэрэглэсэн дундаж тарифыг ашигладаг. Харин тухайн улсын хэрэглэж буй дундаж тарифын хувь хэмжээ байхгүй тохиолдолд жигнэсэн дундаж буюу хамгийн боломжтой улсын (*most favored nation*) тарифын энгийн дунджийг ашиглана. Гаалийн татвар, гаалийн орлогын талаарх мэдээлэл байхгүй цөөн тохиолдолд оронд нь олон улсын худалдааны татвар эсвэл үр дүнтэй тарифын хувь хэмжээг ашигладаг. Бүх тохиолдолд худалдааны эрх чөлөөний бүрэлдэхүүн хэсгийн холбогдох бичвэрт ашигласан өгөгдлийн төрлийг тодруулахыг оролддог.

Хөрөнгө оруулалтын эрх чөлөө

Нарийн мэдээллийг “Хөрөнгө оруулалтын эрх чөлөөний индекс” үзүүлэлтээс харна уу.

Санхүүгийн эрх чөлөө

Санхүүгийн эрх чөлөө нь банкны үр ашгийн үзүүлэлт төдийгүй санхүүгийн салбар дахь төрийн хяналт, хөндлөнгийн оролцооноос хараат бус байдлын хэмжүүр юм. Даатгалын байгууллага, Хөрөнгийн бирж зэрэг санхүүгийн байгууллага болон төрийн өмчит банкууд нь өрсөлдөөнийг бууруулж, зээлийн хүртээмжийг ерөнхийд нь багасгадаг.

Банк болон санхүүгийн *хамгийн тохиромжтой орчин* гэдэг нь засгийн газрын хөндлөнгийн оролцоо хамгийн бага, Төв банкны бие даасан хяналт, санхүүгийн байгууллагуудын зохицуулалт нь зөвхөн гэрээний үүргээ биелүүлэх, залилан мэхлэхээс урьдчилан сэргийлэхэд чиглэгддэг. Зээлийг зах зээлийн нөхцлөөр олгодог бөгөөд засгийн газар санхүүгийн байгууллагыг эзэмшдэггүй. Санхүүгийн байгууллагууд нь хувь хүн, компаниудад янз бүрийн төрлийн санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг. Банкууд зээл олгох, хадгаламж хүлээн авах, гадаад валютаар үйл ажиллагаа явуулах эрх чөлөөтэй. Гадаадын санхүүгийн байгууллагууд чөлөөтэй үйл ажиллагаа явуулдаг бөгөөд дотоодын байгууллагуудтай адил үйлчилдэг.

Тус *санхүүгийн эрх чөлөөний индекс* нь дараах таван дэд хүчин зүйлийг хамардаг. Үүнд:

- Санхүүгийн үйлчилгээний төрийн зохицуулалтын цар хүрээ,
- Шууд ба шууд бус өмчлөлийн замаар банк болон бусад санхүүгийн фирмүүд дэхь төрийн оролцооны түвшин,
- Зээл олгох тухай засгийн газрын нөлөөлөл,
- Санхүү, хөрөнгийн зах зээлийн хөгжлийн цар хүрээ,
- Гадаадын хөрөнгө оруулагчдад нээлттэй байдал.


Эдгээр таван дэд хүчин зүйл нь санхүүгийн эрх чөлөөний түвшинг үнэлэхэд чиглэгддэг бөгөөд энэ нь эдийн засаг дахь хүмүүс болон бизнес эрхлэгчдэд санхүүгийн хялбар, үр дүнтэй хүртээмжтэй байх боломжийг олгодог. Дээрх 5 чиглэлийн үндсэн дээр улс, орнуудад 0-ээс 100 хүртэлх онооны ерөнхий үнэлгээг хамгийн тохиромжтойг нь сонгож санхүүгийн эрх чөлөөг тодорхойлдог.

Хүснэгт 73. "Санхүүгийн эрх чөлөөний индекс"-ийн шалгуур үзүүлэлт (Heritage Foundation)
100 оноо Төрийн оролцоо маш бага.

90 оноо

Бага төрийн оролцоо. Санхүүгийн байгууллагуудын зохицуулалт хамгийн бага гэхдээ гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх, луйвраас урьдчилан сэргийлэхээс энэ нь илүү байж болно.





80 оноо	Номинал төрийн оролцоо. Төрийн өмчид санхүүгийн байгууллагууд нийт салбарын хөрөнгийн багахан хувийг эзэлдэг. Иймд санхүүгийн байгууллагууд үйлчилгээгээ үзүүлэхэд бараг ямар ч хязгаарлалт байдаггүй.
70 оноо	Хязгаарлагдмал төрийн оролцоо. Зээлийн хуваарилалтад засгийн газар нөлөөлдөг бөгөөд хувийн зээл олгоход бараг ямар ч хязгаарлалт байдаггүй. Төрийн өмчит санхүүгийн байгууллага асар их. Гадаадын санхүүгийн байгууллагууд цөөн тооны хязгаарлалттай байдаг.
60 оноо	Дунд зэргийн төрийн оролцоо. Банк санхүүгийн зохицуулалт бага зэрэг төвөгтэй байдаг. Засгийн газар нь нийт салбарын хөрөнгийн багагүй хувийг эзэлдэг санхүүгийн байгууллагуудыг эзэмшиж, хяналтандаа байлгадаг. Санхүүгийн байгууллагуудын үйлчилгээ үзүүлэх чадвар нь хязгаарлагдмал байдаг.
50 оноо	Их хэмжээний төрийн оролцоо. Зээлийн хуваарилалтад засгийн газар ихээхэн нөлөөлдөг бөгөөд хувийн зээл олгоход ихээхэн саад бэрхшээл тулгардаг. Санхүүгийн байгууллагуудын үйлчилгээ үзүүлэх чадвар нь ихээхэн хязгаарлалт тавигддаг. Гадаадын санхүүгийн байгууллагууд тодорхой хэмжээний хязгаарлалттай байдаг.
40 оноо	Хүчтэй төрийн оролцоо. Төв банк нь засгийн газрын нөлөөнд автдаг, санхүүгийн байгууллагуудад тавих хяналт нь чанга, гэрээ хэлцлийг хэрэгжүүлэх, луйвраас урьдчилан сэргийлэх чадвар сул байдаг. Засгийн газар нь нийт салбарын хөрөнгийн цөөн хувийг эзэлдэг санхүүгийн байгууллагуудыг идэвхтэй эзэмшиж, хяналтыг хэрэгжүүлдэг.
30 оноо	Өргөн хүрээний төрийн оролцоо. Зээлийн хуваарилалтад засгийн газар ихээхэн нөлөөлдөг. Засгийн газар санхүүгийн байгууллагуудын дийлэнх хувийг эзэмшдэг, хянадаг, эсвэл давамгайлсан байр суурьтай байдаг. Санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаа ихээхэн хязгаарлагдаж, банк байгуулахад ихээхэн саад бэрхшээл тулгардаг. Гадаадын санхүүгийн байгууллагууд ихээхэн хязгаарлалтад өртдөг.
20 оноо	Чанга төрийн оролцоо. Төв банк хараат бөгөөд санхүүгийн байгууллагуудад тавих хяналт нь дарангуйлдаг. Гадаадын санхүүгийн байгууллагуудад сөрөг нөлөөтэй буюу маш их хязгаарлалттай байдаг.
10 оноо	Дарангуйлалд ойрхон. Зээлийн хуваарилалтыг засгийн газар хянадаг. Банк байгуулахыг хязгаарласан. Гадаадын санхүүгийн байгууллагуудыг хориглоно.
0 оноо	Дарангуйлагч. Хяналт, зохицуулалт нь хувийн санхүүгийн байгууллагуудыг үйл ажиллагаа явуулахаас урьдчилан сэргийлэх зорилготой юм. Хувийн санхүүгийн байгууллага байхгүй.

Эх сурвалж 1. <https://www.heritage.org/index/financial-freedom>

2. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО, ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН СУДАЛГААНЫ ТӨВӨӨС ЭРХЛЭН ГАРГАДАГ УЛААНБААТАР ХОТЫН ДҮҮРГҮҮДИЙН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН ТАЙЛАН

Эдийн засгийн бодлого өрсөлдөх чадварын судалгааны төв (ЭЗБӨЧСТ) нь үүсгэн байгуулагдсан цагаасаа эхлэн Швейцарь дахь Дэлхийн өрсөлдөх чадварын төвтэй хамтран Монгол Улсын өрсөлдөх чадварын жил тутмын иж бүрэн судалгааг хийж байна. Энэхүү судалгаанд Монгол Улсын хөгжил дэвшлийн түвшинг Сингапур, Болгар, Катар, Казахстан зэрэг нийт 14 оронтой Дэлхийн өрсөлдөх чадварын тайлангийн аргачлалын дагуу хэмжиж нийт 330 илүү шалгуур үзүүлэлтийн дагуу индекс тооцож, эрэмбэлдэг.

Дүүргүүдийн өрсөлдөх чадварыг үнэлэхдээ энэхүү суурь зарчимд үндэслэн дүүргүүдийн буюу хотын хөгжлийн түвшинг цогц байдлаар хэмжих зорилгыг тавьж шалгуур үзүүлэлтүүдийг сонгосон байна. Тус судалгааны тайланд дүүргүүдийн өрсөлдөх чадварыг хэмжихдээ амьдралын чанар, амьдрах орчин, аюулгүй байдал, засаглал, эдийн засаг гэсэн 5 үндсэн бүлэг, тэдгээрийг нарийвчлан үнэлэх тус бүр гурван дэд бүлэг буюу нийт 15 дэд бүлгийн хүрээнд нарийвчлан тодорхойлсон нийт 150 шалгуур үзүүлэлтээр хэмжсэн байна.

Хүснэгт 74. Дүүргүүдийн өрсөлдөх чадварын үндсэн 5 бүлэг, 15 шалгуур үзүүлэлт

№	БҮЛЭГ	ДЭД БҮЛЭГ
1	АМЬДРАЛЫН ЧАНАР	Амьжиргааны түвшин
2		Эрүүл мэнд
3		Боловсрол
4	АМЬДРАХ ОРЧИН	Хотжилт
5		Үндсэн дэд бүтэц
6		Соёл
7	АЮУЛГҮЙ БАЙДАЛ	Амар тайван байдал
8		Аюулгүй орчин
9		Эрүүл орчин
10	ЗАСАГЛАЛ	Төсөв
11		Институцийн тогтолцоо
12		Нийгмийн тогтолцоо
13	ЭДИЙН ЗАСАГ	Эдийн засгийн чадавхи
14		Хөдөлмөр эрхлэлт
15		Бизнесийн идэвхжил

Эх сурвалж 2. ЭЗБӨЧСТ, Дүүргүүдийн өрсөлдөх чадварын тайлан 2021

Эдийн засаг бүлэгт дүүргийн эдийн засгийн чадавхи, хөдөлмөр эрхлэлт, бизнесийн идэвхжилийг үнэлэх 11 шалгуур үзүүлэлт ашигласан байна.

Хүснэгт 75. Эдийн засгийн өрсөлдөх чадварыг үнэлэх шалгуур үзүүлэлт

№	ДЭД БҮЛЭГ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД
1	Эдийн засгийн чадавхи	Амьжиргааны түвшний өсөлт
2		Амьжиргааны түвшний хүлээлт
3		Үнийн өсөлт
4	Хөдөлмөр эрхлэлт	Хөдөлмөрийн насны хүн ам
5		Ажилгүйдлийн түвшин
6		Ажиллагчид
7		Ажиллах хүчиний оролцооны түвшин
8		Хөдөлмөрийн бирж
9	Бизнес ихэвхжилт	Аж ахуй нэгж, байгууллагын төвлөрөл
10		Бүтээмж
11		Зах зээлийн багтаамж

Эх сурвалж 3. ЭЗБӨЧСТ, Дүүргүүдийн өрсөлдөх чадварын тайлан 2021

Судалгааны түүвэрлэлт

Эдийн засаг бүлэгт дүүргийн эдийн засгийн чадавхи, хөдөлмөр эрхлэлт, бизнесийн идэвхжлийг үнэлэх 11 шалгуур үзүүлэлтийг ашигласан ба шалгуур үзүүлэлтүүдийн мэдээллийг дараах 2 төрлийн эх үүсвэрээс бүрдүүлсэн байна. Үүнд:

- Дүүргүүдийн албан ёсны статистик мэдээлэл
- Өрхийн асуулга

Дүүргүүдийн эдийн засгийн өрсөлдөх чадварыг үнэлэх 11 шалгуур үзүүлэлтийн ойролцоогоор 36.4% нь санал агуулгын мэдээлэл, 63.6% нь статистик мэдээлэл байна. Статистик мэдээлэл нь өрсөлдөх чадварыг тодорхой хугацаанд хэмжиж харуулдаг ба өрсөлдөх чадвар ямар түвшинд байгааг илэрхийлдэг. Харин санал асуулгаар статистик



мэдээллийн олдоц муу, шууд хэмжихэд бэрх тоон бус үзүүлэлтүүдийг тодорхойлж олж авсан онцлогтой. Түүнчлэн санал асуулгын мэдээлэл нь тухайн статистик мэдээллүүдийг батлах, бодит байдлыг тодруулах, иргэд, хувийн хэвшлийнхэн тухайн үзүүлэлтийг хэрхэн үнэлж буйг харуулах ач холбогдолтой. Тиймээс статистик тоон үзүүлэлттэй харьцуулахад санал асуулга нь бодит байдалд илүү дөхөм, цаг хугацааны хувьд шинэлэг байдаг.⁸¹

Судалгааны түүврийн хэмжээ

Өрсөлдөх чадварын судалгааны түүврийг энгийн санамсаргүй түүврийн аргаар сонгоно. Энгийн санамсаргүй түүвэр буюу нийт эх олонлогоос судалгаанд хамруулах өрх бүрийг тэнцүү магадлалтайгаар сонгох тохиолдолд түүврийн хэмжээг дараах томъёогоор тооцно.⁸²

$$n = \frac{z^2 p(1-p)}{e^2} deff$$

- | | |
|-------|---|
| n | • Судалгаанд хамруулах өрхийн тоо буюу түүврийн хэмжээ |
| z | • Хүсэж буй ач холбогдлын түвшинг тодорхойлох статистик утга |
| p | • Судалгаагаар хэмжих түлхүүр үзүүлэлтийн тооцооны утга |
| def | • Дизайны нөлөө, ерөнхий тохиолдолд 2.0 байна гэж таамагладаг |
| e | • 95 хувийн итгэх мужид хүлээн зөвшөөрөгдөх алдааны хязгаар |

Түүврийн хэмжээ, түүний хуваарилалтын тооцооллыг хийхдээ түлхүүр үзүүлэлт нь ядуурлын хамралтын хүрээ байхаар тооцож онолын хувьд ядуу болон ядуу бус иргэд судалгаанд хамрагдах магадлалаар тооцно гэж үзсэн байна. Ингэснээр өрхийн энгийн санамсаргүй аргаар хийхэд амьжиргааны түвшний хувьд бүх давхаргын өрх сонгогдох боломж бүрдсэн гэж үзнэ. Ингээд судалгааны нийт түүврийн хэмжээ 2 400 өрх байхаар тооцож, дүүргүүдийг хооронд нь харьцуулах, эрэмбэлэх тохиолдолд түүврийн тэгш хуваарилалт илүү зохимжтой гэж үзсэн байна. Түүврийн хэмжээг дараах байдлаар хийх нь зохимжтой гэж үзжээ.

Хүснэгт 76. Түүврийн зохимжтой хэмжээ

ДҮҮРЭГ	ТҮҮВРИЙН ХЭМЖЭЭ
Багануур	200
Багахангай	200
Баянгол	300
Баянзүрх	300
Налайх	200
Сонгинохайрхан	300
Сүхбаатар	300
Хан-Уул	300
Чингэлтэй	300
НИЙТ (Улаанбаатар)	2 400

Судалгааны түүврийн нэгжийн сонголт

Түүврийн дизайныг 2 шатат энгийн санамсаргүй түүврийн аргаар хийнэ. Эхний шатанд түүврийн анхан шатны нэгж (ТАШН)-ийг хэмжээнд нь пропорционал магадлал

⁸¹ ЭЗБӨЧСТ, “Дүүргүүдийн өрсөлдөх чадварын тайлан 2021”, Уб, 2021, 19 дэх тал.

⁸² ЭЗБӨЧСТ, “Дүүргүүдийн өрсөлдөх чадварын тайлан 2021”, Уб, 2021, 20-21 дэх тал.

аргаар, дараагийн шатанд өрхийг энгийн санамсаргүй аргаар сонгоно. Хэмжээнд нь пропорционал магадлалт түүврийн аргыг дараах байдлаар томъёолдог.

ТҮҮВРИЙН АНХАН ШАТНЫ НЭГЖИЙН СОНГОГДОХ МАГАДЛАЛ НЬ:

$$P_{2hi} = \frac{n_h M_{hi}}{M_h}$$

ХОЁР ДАХЬ ШАТАНД ТУХАЙН ТҮҮВРИЙН АНХАН ШАТНЫ НЭГЖЭЭС ӨРХИЙН СОНГОГДОХ МАГАДЛАЛ НЬ:

$$P_{1hi} = \frac{M_{hi}}{M'_{hi}}$$

ӨРХИЙН СОНГОГДОХ МАГАДЛАЛ НЬ ДЭЭРХ 2 МАГАДЛАЛЫН ҮРЖВЭР:

$$P_{hi} = \frac{n_h M_{hi}}{M_h} * \frac{m_{hi}}{m'_{hi}}$$

P_{hi}	• h страта дахь i-р ТАШН-ийн өрхийн сонгогдох магадлал
n_h	• h стратагаас сонгогдох ТАШН-ийн тоо
M_{hi}	• h страта дахь i-р ТАШН-ийн түүврийн хүрээний өрхийн тоо
M_h	• h страта дахь түүврийн хүрээний нийт өрхийн тоо
m_{hi}	• h страта дахь i-р ТАШН-д сонгогдох өрхийн тоо
M'_{hi}	• h страта дахь i-р ТАШН-ийн жагсаалтаар ирүүлсэн өрхийн тоо

Түүврийн хэмжээ 2 400 байхаар тооцсоны дагуу нийт 240 ТАШН-ээс тус бүр 10 өрхийг судалгаанд хамруулахаар дизайныг гаргаж болно.

Түүврийн жин

2 ШАТАТ ТҮҮВРИЙН ДИЗАЙНЫ ХУВЬД ТҮҮВРИЙН ЖИНГ ТОМЪЁОЛБОЛ:

$$W_{hi} = \frac{M_h M'_{hi}}{n_h M_{hi} m_{hi}}$$

W_{hi}	• h страта дахь i-р ТАШН-ийн өрхийн суурь жин
n_h	• h стратагаас сонгогдох ТАШН-ийн тоо
M_{hi}	• h страта дахь i-р ТАШН-ийн түүврийн хүрээний өрхийн тоо
M_h	• h страта дахь түүврийн хүрээний нийт өрхийн тоо
m_{hi}	• h страта дахь i-р ТАШН-д сонгогдох өрхийн тоо
M'_{hi}	• h страта дахь i-р ТАШН-ийн жагсаалтаар ирүүлсэн өрхийн тоо

ӨРХ СУДАЛГААНД ХАМРАГДААГҮЙ ТОХИОЛДОЛД ТУХАЙН ӨРХӨД НООГДОХ ЖИНГ БУСАД ХАМРАГДСАН ӨРХӨД ДАРААХ ТОМЪЁОГООР ХУВААРИЛНА.



$$W'_{hi} = W_{hi} \frac{m_{hi}}{m'_{hi}}$$

m_{hi}
 m'_{hi}

- h страта дахь i-р кластерийн түүвэрлэсэн өрхийн тоо
- h страта дахь i-р кластерт судалгаанд хамрагдсан өрхийн тоо

Мэдээлэл боловсруулалт

Мэдээллийг боловсруулахдаа CSPRO программ ашиглан мэдээллийг засварлан оруулж, SPSS программыг ашиглан оруулсан мэдээлэлд статистик шинжилгээ хийн боловсруулж, үр дүнг гаргана.

Санал асуулгын мэдээллээр цуглуулсан шалгуур үзүүлэлтүүд нь 1-10 хооронд оноогоор хэмжигдэх ба тухайн үзүүлэлтийн талаарх иргэдийн үнэлгээ сайн бол 10 рүү дөхөх оноо, сул бол 1 рүү дөхөх оноо байна.⁸³

Эдийн засгийн өрсөлдөх чадварын үнэлэх шалгуур үзүүлэлтүүд

Эдийн засгийн өрсөлдөх чадварын үнэлэх 11 шалгуур үзүүлэлтүүдийг дараах санал асуулга болон статистик мэдээлэлд үндэслэн хийнэ. Санал асуулгын хувьд доод утга 1, дээд утга 10 байна. Харин статистик мэдээллийн хувьд хүчин зүйлээс хамаар доод ба дээд утга өөр өөр байна. Мөн шалгуур үзүүлэлтүүдийг шинж чанараас нь хамааруулан эерэг ба сөрөг гэж ангилна. (Хүснэгт 6)

Хүснэгт 77. Эдийн засгийн өрсөлдөх чадварын 11 шалгуур үзүүлэлт

№	Дэд бүлэг	Санал асуулга болон Статистик мэдээлэл	Нэгж	Эх үүсвэр	Доод утга	Дээд утга	Эерэг Сөрөг
ЭДИЙН ЗАСГИЙН ЧАДАВХИ							
1	Амьжиргааны түвшний өсөлт	Өнгөрсөн нэг жилийн хугацаанд таны амьжиргаанд хэр эерэг өөрчлөлт гарсан бэ?	1-10 оноо	Санал асуулга	1	10	+
2	Амьжилгааны түвшний хүлээлт	Ирэх жилийн хугацаанд таны амьжиргаанд хэр эерэг өөрчлөлт гарах хүлээлт байна вэ?	1-10 оноо	Санал асуулга	1	10	+
3	Үнийн өсөлт	Өргөн хэрэглээний барааны үнийн өсөлт таны амьдралд хэр сөргөөр нөлөөлж байна вэ?	1-10 оноо	Санал асуулга	1	10	+
ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ							
4	Хөдөлмөрийн насны хүн ам	Нийт хүн амд 16-59 насны хүн амын эзлэх хувь	%	Статистик мэдээлэл	30	80	+
5	Ажиллагчид	Нийт хүн амын тоонд эзлэх хувь	%	Статистик мэдээлэл	20	50	+
6	Ажилгүйдлийн түвшин	Хувь	%	Статистик мэдээлэл	0	25	-
7	Ажиллах хүчний	Хувь	%	Статистик мэдээлэл	0	100	+

⁸³ ЭЗБӨЧСТ, “Дүүргүүдийн өрсөлдөх чадварын тайлан 2021”, Уб, 2021, 24 дэх тал.

	оролцооны түвшин						
8	Хөдөлмөрийн бирж	Дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага иргэдийг ажил хайж, олоход нь хэр хангалттай тусалж байна вэ?	1-10 оноо	Санал асуулга	0	10	+
БИЗНЕСИЙН ИДЭВХЖИЛ							+
9	Аж ахуй нэгж, байгууллагын төвлөрөл	Үйл ажиллагаа явуулж буй ААНБ, Нийслэлийн дүнд эзлэх хувь	%	Статистик мэдээлэл	0	30	+
10	Бүтээмж	Татварын орлого, дүүргүүдийн нийт дүнд эзлэх хувь	%	Статистик мэдээлэл	0	35	+
11	Зах зээлийн батгаамж	Нийслэлийн хүн амд эзлэх хувь	%	Статистик мэдээлэл	0	30	+

Индекс тооцох аргачлал

Дүүргүүдийн албан ёсны статистик мэдээлэл болон өрхийн асуулгаар цуглуулсан шалгуур үзүүлэлтүүдийг ашиглан эдийн засгийн өрсөлдөх чадварын индексийг Улаанбаатар хот болон 9 дүүрэг тус бүрийн хувьд тооцно. Мөн шалгуур үзүүлэлтүүдийн шинж чанараас нь хамааруулан эерэг ба сөрөг гэж ангилна.

Эерэг үзүүлэлт гэж тухайн үзүүлэлтийг тоон утгыг өсгөхөд шинж чанар нь сайжирдаг үзүүлэлтийг хэлэх ба, сөрөг үзүүлэлт гэж тухай шалгуур үзүүлэлтийн тоон утгыг бууруулахад шинж чанар нь сайжирдаг үзүүлэлтийг хэлнэ. Эерэг болон сөрөг үзүүлэлтийг индексийг дараах томъёогоор тооцно.⁸⁴

Эерэг үзүүлэлтийн индекс:

$$\text{Индекс} = \frac{\text{Бодит утга} - \text{Хамгийн доод утга}}{\text{Хамгийн дээд утга} - \text{Хамгийн доод утга}}$$

Сөрөг үзүүлэлтийн индекс:

$$\text{Индекс} = 1 - \frac{\text{Бодит утга} - \text{Хамгийн доод утга}}{\text{Хамгийн дээд утга} - \text{Хамгийн доод утга}}$$

Дүүргүүдийн эдийн засгийн өрсөлдөх чадварын шалгуур үзүүлэлтүүд нь 11 дэд бүлэгт ангилагдах ба үзүүлэлт бүрийн хувьд индекс тооцсоны дараа дэд бүлгийн индекс тооцож байж “Эдийн засгийн өрсөлдөх чадвар”-ын индекс гарна. Дэд бүлгийн болон бүлгийн индексийг тооцохдоо геометрийн дунджийг ашиглана.

$$\text{Бүлгийн индекс} = \left(\prod_{i=1}^n \text{Индекс}_i \right)^{\frac{1}{n}}$$

Индекс₁
n

- i дугаар үзүүлэлтийн индекс
- Нийт үзүүлэлтийн тоо

⁸⁴ ЭЗБӨЧСТ, “Дүүргүүдийн өрсөлдөх чадварын тайлан 2021”, Уб, 2021, 25 дахь тал.


5.3. СУДАЛГААНЫ ДАТА БОЛОВСРУУЛАЛТ, ИНДЕКСЖҮҮЛЭХ

Судалгааны энэ хэсэгт дээр дурдсан Heritage Foundation-ийн “Эдийн засгийн эрх чөлөөний индекс” болон ЭЗБӨЧСТ-ийн дүүргүүдийн эдийн засгийн өрсөлдөх чадварын тайлан”-г үнэлэх шалгуур үзүүлэлтүүдийн хүчин зүйлстэй холбогдуулан Монгол улсын одоогийн эдийн засгийн нөхцөл байдлын тоймыг тодорхойлно.

Хүснэгт 78. Монгол улсын 2023 оны 9 дүгээр сарын Макро эдийн засгийн үзүүлэлтүүд⁸⁵

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

График



Нөлөөлөл


Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2023 оны 9 дүгээр сард улсын хэмжээнд өмнөх оны мөн үеэс 10.1 хувь өсөв. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2023 оны 9 дүгээр сард өмнөх сараас 0.2 хувиар буурахад хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 1.4 хувь, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээний бүлгийн үнэ 0.3 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээний бүлгийн үнэ 0.1 хувиар буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Валютын ханш



Америк долларын ханш 2023 оны 9 дугаар сард 3466.008 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 208.98 төгрөгөөр суларч, өмнөх сараас 3.9 төгрөгөөр чангарсан байна. Гадаад валютын нийт албан нөөц өмнөх сараас 5%-иар, өнгөрсөн жилийн мөн үеэс 48%-иар тус тус өсөж, 4.1 тэрбум ам.долларт хүрээд байна.

Улсын төсөв




Татварын нийт орлого 2023 оны 9 дүгээр сард 2.2 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 774.5 (55.9%) тэрбум төгрөгөөр өсөхөд орлогын албан татварын орлого 208.3 (60.2%) тэрбум төгрөг, нийгмийн даатгалын орлого 91.4 (34.9%) тэрбум төгрөгөөр, нэмэгдсэн өртгийн албан татвар 90.5 (24.0%) тэрбум төгрөг, бусад төрлийн татвар хураамжийн орлого 334.2 (2.8 дахин) тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.

⁸⁵ ЭЗБӨЧСТ-өөс гаргасан Макро эдийн засгийн 2023 оны 9 дүгээр сарын тойм, <https://ecrc.mn/%D0%BC%D0%B0%D0%BA%D1%80%D0%BE-%D1%8D%D0%B4%D0%B8%D0%B9%D0%BD-%D0%B7%D0%B0%D1%81%D0%B3%D0%B8%D0%B9%D0%BD-2023-%D0%BE%D0%BD%D1%8B-9-%D1%80-%D1%81%D0%B0%D1%80%D1%8B%D0%BD-%D1%82%D0%BE%D0%B9%D0%BC/>



Гадаад худалдаа



Монгол Улс 2023 оны эхний 9 сард нийт 158 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 18.1 тэрбум америк доллар, үүнээс экспорт 11.3 тэрбум америк доллар, импорт 6.8 тэрбум америк доллар байна. Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 2.8 (18.1%) тэрбум америк доллароор, экспорт 2.4 (26.6%) тэрбум америк доллароор, импорт 399.1 (6.3%) сая америк доллароор тус тус өсжээ. Харин 2023 оны 9 дүгээр сард экспорт өмнөх сараас 14.8 (1.1%) сая америк доллароор, импорт 114.2 (12.4%) сая америк доллароор тус тус буурсан байна.

ЭЗБӨЧСТ-ийн “Дүүргүүдийн эдийн засгийн өрсөлдөх чадвар”-ыг үнэлэх шалгуур үзүүлэлтийн хүрээнд 2022 оны Монгол улсын хөдөлмөр эрхлэлт болон бизнес идэвхжлийн талаар:

ДЭД БҮЛЭГ	УТГА	НЭГЖ	СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ
Хөдөлмөрийн насны хүн ам	Нийт хүн амд 16-59 насны хүн амын эзлэх хувь	%	Ажиллах хүчний судалгааны 2022 оны 3 дугаар улирлын дүнгээр улсын хэмжээнд хөдөлмөрийн насны буюу 15, түүнээс дээш насны 2126.5 ⁸⁶ мянган хүн байгаагийн 999.6 (47.0%) мянга нь эрэгтэй, 1126.9 (53.0%) мянга нь эмэгтэйчүүд байна. ⁸⁷
Ажиллагчид	Нийт хүн амын тоонд эзлэх хувь	%	Ажиллах хүчний 1.2 (94.6%) сая нь ажиллагчид, тэдгээрийн 14.0 (1.2%) мянга нь хөдөлмөрийн дутуу ашиглалтын нэг бүлэг болох цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгчид байна. ⁸⁸
Ажилгүйдлийн түвшин	Хувь	%	2022 оны байдлаар 5.4 хувьтай байна. ⁸⁹
Ажиллах хүчний оролцооны түвшин	Хувь	%	2022 оны байдлаар 59.2 хувьтай байна. ⁹⁰
Аж ахуй нэгж, байгууллагын төвлөрөл	Үйл ажиллагаа явуулж буй ААНБ, Нийслэлийн дүнд эзлэх хувь	%	2021 оны байдлаар тооллогод хамрагдсан 180.0 мянган аж ахуйн нэгж, байгууллагын 130.0 мянга (72.2%) нь Улаанбаатар хотод байгаа нь ААНБ-ын төвлөрөл нийслэлд их байгааг харуулж байна. Үлдсэн ААНБ-ын 32.5 мянга (18.1%) нь Хангайн болон Төвийн бүсийн аймгуудад байршиж байгаа бол 17.5

⁸⁶ Энд өрхөөс гадуур амьдарч байгаа гадаадад суугаа иргэд болон цэрэг, хоригдлын тоог оруулахгүй

⁸⁷ Үндэсний статистик хороо, “Ажиллах хүчний судалгааны 2022 оны III улирлын товч танилцуулга”, УБ, 2022, 5 дахь тал.

⁸⁸ Үндэсний статистик хороо, “Ажиллах хүчний судалгааны 2022 оны III улирлын товч танилцуулга”, УБ, 2022, 10 дахь тал.

⁸⁹ Үндэсний статистик хороо, “Ажиллах хүчний судалгааны 2022 оны III улирлын товч танилцуулга”, УБ, 2022, 6 дахь тал.

⁹⁰ Мөн тэнд

			мянга (9.7%) нь Баруун болон Зүүн бүсийн аймгуудад байршилтай байна. ⁹¹
Бүтээмж	Татварын орлого, дүүргүүдийн нийт дүнд эзлэх хувь	%	2023 оны Монгол Улсын нэгдсэн төсвийн орлогод эзлэх татварын орлого 1.019,770,721 мянган төгрөг байна. Үүнээс дүүргүүдийн гүйцэтгэлийн нийт орлого 448,706,365 мянган төгрөг байна. ⁹²
Зах зээлийн батгаамж	Нийслэлийн хүн амд эзлэх хувь	%	-

Дэлхийн банкнаас гаргасан Монгол улсын эдийн засгийн тйм⁹³

Дэлхийн Банкнаас сүүлд гаргасан Монголын эдийн засгийн тйм тайлангаас харахад хөдөлмөрийн зах зээл сайжрахын хэрээр өрхийн хэрэглээ тогтвортой түвшинд хадгалагдаж, улсын хөрөнгө оруулалт тэлснээр энэ онд эдийн засгийн өсөлтийг дэмжих хүлээлттэй байна. Харин өвөлжилтийн хүндрэлээс шалтгаалан хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл саарах төлөвтэй. Цар тахалтай холбоотой хязгаарлалт суларснаар үйлчилгээний салбар, тэр дундаа аялал жуулчлалын салбарын идэвхжил үргэлжлэн сэргэж, дээрх сөрөг нөлөөг нөхөх боломжтой.

Нөгөөтээгүүр, ажиллах хүчний оролцооны түвшин Ковид-19 цар тахлын өмнөх үеэс доогуур түвшинд хэвээр байна. Үүний зэрэгцээ өндөр инфляц, улсын салбарын өр, төсөвт дарамт учруулж болохуйц эрсдэлүүд, гадаад секторын тэнцвэргүй байдал болон уул уурхайн салбараас хэт хамааралтай байдал зэрэг нь эдийн засагт тулгамдаж буй гол асуудлууд болоод байна.

“Уул уурхайн бус салбарыг бэхжүүлэх нь эдийн засгийн өсөлтийг тогтвортой хадгалах, ажиллах хүчний, ялангуяа эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой” хэмээн Дэлхийн Банкны суурин төлөөлөгчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч Тиласони Бенжамин Мусуку хэлэв. Тэрээр мөн *“Байгалийн баялгийн бус салбарын өрсөлдөх чадварыг сайжруулах нь бүтээмжийг дээшлүүлж, түүхий эдийн үнийн цочролд өртөх эмзэг байдлыг бууруулах боломжтой”* болохыг онцоллоо.

Эдийн засгийн хэтийн төлөвт сөргөөр нөлөөлж болзошгүй хэд хэдэн эрсдэлүүдийг тайланд дурджээ. Тухайлбал хөгжингүй орнууд мөнгөний бодлогын төлөвөө хүлээлтээс илүү хэмжээгээр чангаруулах, геополитикийн хурцадмал байдал даамжрах, Засгийн газрын өр төлбөрүүд их хэмжээгээр хуримтлагдах, нүүрсний экспортын гэрээтэй холбоотой тодорхой бус байдал хэвээр хадгалагдах зэрэг нь эдийн засагт сөрөг нөлөө үзүүлж болзошгүй байна.

Уул уурхайн үйлдвэрлэл эрчимжсэнээр эдийн засгийн өсөлт 2024-2025 онуудад 6 хувиас давж өсөх төлөвтэй байна. Гэвч цаашдаа тогтвортой өсөлтийг хангах, дотоод, гадаад болон цаг уурын цочмог нөлөөлөлд тэсвэртэй байдлыг нэмэгдүүлэхийн тулд эдийн засгийн төрөлжилтийг дэмжсэн бүтцийн өөрчлөлтүүд чухал ач холбогдолтой хэвээр байна. Илүү идэвхтэй, динамик хөдөлмөрийн зах зээлийг бий болгосноор уул уурхайн бус салбарын

⁹¹ Үндэсний статистик хороо, “Аж ахуй нэгжийн 2021 оны тооллого, нэгдсэн үр дүн”, УБ, 2022, 13 дахь тал.

⁹² Монгол Улсын Татварын албаны цахим хуудас, <http://nta.mn/single/15>

⁹³ Дэлхийн банкны цахим хуудас, <https://www.worldbank.org/mn/news/press-release/2023/04/19/mongolia-s-economy-to-accelerate-in-2023-but-reforms-and-diversification-needed-to-sustain-growth>



бүтээмжийг нэмэгдүүлж, улмаар эдийн засгийг солонгоруулах үйл явцад дэмжлэг үзүүлэх боломжтой.

Ажиллах хүчний хөдөлмөр эрхлэх боломжийг өргөжүүлэх, тэдний ур чадварыг сайжруулах, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн цогц системийг бий болгох шинэчлэлийг хийх замаар хөдөлмөрийн зах зээлийг бэхжүүлэх тухай бодлогын хэд хэдэн саналыг тайланд дэвшүүлжээ. Эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоог нэмэгдүүлэн, залууст илүү их боломж бололцоог олгож, хотын оршин суугчдыг хөдөлмөрийн зах зээлд татан оролцуулснаар ажиллах хүчний оролцоо тэлж, улмаар Монгол Улсын хөгжилд томоохон түлхэц болох юм.

Төсвийн тогтвортой байдал, аливаа цочмог нөлөөлөлд тэсвэртэй байдлыг нэмэгдүүлэхэд төсвийн сахилга бат, засаглалын реформууд чухал ач холбогдолтой болохыг тайланд онцолсон байна. Түүнчлэн Монгол Улсын гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх, төлбөрийн тэнцлийн дарамтыг багасгахад валютын ханшийн уян хатан байдлыг хангах, хөрөнгө оруулалтын төслүүдийг үр ашиг, зардал, ач холбогдлоос нь хамааруулан эрэмбэ дараатай хэрэгжүүлэх, экспортын орлого ба санхүүгийн хөрөнгийн орох урсгалыг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээг авах нь зүйтэй зэрэг зөвлөмжүүд багтжээ.


5.4. СУДАЛГААНЫ ДАТА ЦУГЛУУЛАХ

Судалгааны энэ хэсэгт дээр дурдсан Heritage Foundation-ийн “Эдийн засгийн эрх чөлөөний индекс” болон ЭЗБӨЧСТ-ийн “Дүүргүүдийн өрсөлдөх чадварын тайлан”-д үндэслэн Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын Эдийн засгийн чөлөөт байдал болон өрсөлдөх чадварыг үнэлэв.

Heritage Foundation-ийн “Эдийн засгийн эрх чөлөөний индекс”

Heritage Foundation-ийн “Эдийн засгийн эрх чөлөөний индекс”-ээр Монгол улсын 2023 оны ерөнхий *Эдийн засгийн индекс*-ийг үнэлэхэд 61.7 оноо байгаа нь дэлхийн 184 орноос 73 дугаарт эрэмбэлэгдэж байна. Харин Ази-Номхон далайн бүсийн 39 орноос 15-д жагссан бөгөөд нийт оноо нь дэлхийн болон бүс нутгийн дунджаас дээгүүр үзүүлэлт гарсан байна.


Зураг 1. Монгол Улсын Эдийн засгийн эрх чөлөөний индекс үзүүлэлт



Эх сурвалж 4.



https://www.heritage.org/index/pdf/2023/countries/2023_IndexofEconomicFreedom-

Heritage Foundation-ийн Монгол Улсын Эдийн засгийн чөлөөт байдлыг дараах байдлаар тодорхойлжээ: Эдийн засгийн шинэчлэл нь эдийн засгийн тэлэлт, ядуурлыг бууруулахад дэмжлэг үзүүлсэн байна. Бизнесийн салбар нээлттэй худалдааны дэглэмээс ашиг хүртдэг ч авлига, хууль дээдлэх ёсны сул байдал нь эдийн засгийн хөгжлийг сааруулж байна. Шүүхийн шинэтгэл, төрийн удирдлага илүү тогтвортой байх нь эдийн засгийн өсөлтийг тогтвортой байлгах, амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд тустай.⁹⁴



Эх сурвалж 5. Heritage Foundation-ийн цахим хаяг



Монгол улс 1992 онд шинэ Үндсэн хуулиа баталсны дараа хаалттай нэг намын коммунист нийгмээс зах зээлийн эдийн засагт шилжиж ардчилсан орон болсон ба энэхүү шилжилт нь чөлөөт зах зээлийн шинэчлэл, улс төрийн харьцангуй тогтвортой байдлыг аажмаар нэвтрүүлсэн. Зөвлөлт Холбоот Улсын үеийн Монгол Ардын Нам 2016 оноос хойш парламентад олонхи болсон ба 2021 оны зургаадугаар сард болсон сонгуулиар Ардчилсан намаас Ерөнхийлөгчийн дэвшсэн нь тус Эдийн засгийн шалгуур үзүүлэлтийг өндөр дүнтэй гарахад чухал үүрэг гүйцэтгэсэн хэмээн үзжээ.



Монгол Улсын хувьд хууль дээдлэх ерөнхий тогтолцоо сул байна. Тус улсын өмчийн эрхийн оноо дэлхийн дунджаас доогуур байна; түүний шүүхийн үр дүнтэй байдлын оноо дэлхийн дунджаас дээгүүр байна; Засгийн газрын шударга байдлын оноо нь дэлхийн дунджаас доогуур байна.

Хувь хүн болон аж ахуйн нэгжийн татвар 10-аас 25 хувь байна. Татварын ачаалал ДНБ-ий 21.2 хувьтай тэнцэж байна. Гурван жилийн төсвийн зарлага, төсвийн тэнцлийн дундаж нь ДНБ-ий 34.6, -3.8 хувьтай тэнцэж байна. Улсын өр ДНБ-ий 79.8 хувьтай тэнцэж байна.

⁹⁴ Mongolia: index of economic freedom, https://www.heritage.org/index/pdf/2023/countries/2023_IndexofEconomicFreedom-Mongolia.pdf



Зохицуулалтын тогтолцоо нь удаан ч гэсэн хөгжиж байна. Бизнес эхлүүлэхэд шаардагдах хөрөнгийн доод хэмжээг бууруулсан. Хөдөлмөр эрхлэлтийн зохицуулалт нь харьцангуй уян хатан боловч хөдөлмөрийн зах зээлд эрч хүч дутагдаж байна. Инфляци тогтворгүй байсан бөгөөд хамгийн сүүлийн үеийн инфляци 7.1 хувьтай байна.

Худалдааны жигнэсэн дундаж тарифын хувь хэмжээ 5.4 хувь байгаа бөгөөд худалдаанд саад болж буй бусад хүчин зүйлс худалдааны урсгалыг сааруулж байна. Монгол Улс илүү эрчимтэй хөрөнгө оруулалт татахын тулд зах зээлийг либералчлах, өрсөлдөх чадвартай санхүүгийн салбарыг хөгжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн ч ахиц дэвшил жигд бус байна.

ЭЗБӨЧСТ-ийн “Дүүргүүдийн эдийн засгийн өрсөлдөх чадварын индекс”

Анхаарах: Дүүргүүдийн эдийн засгийн өрсөлдөх чадварын судалгааны тайланг одоогийн байдлаар хамгийн сүүлд 2021 онд гарсан учир тус судалгааны үр дүнг танилцуулж байна. Харин 2022 оны өрсөлдөх чадварын судалгааны тайлан 2023 оны 12 дугаар сард батгаж гарах тухай мэдээлэл байна.

2021 оны байдлаар нийслэл Улаанбаатар хотын эдийн засгийн өрсөлдөх чадварын индекс **0.595** оноо авсан байна. Ерөнхий индекс нь 0-1 хооронд утга авна.⁹⁵ Санал асуулгын мэдээллээр цуглуулсан шалгуур үзүүлэлтүүд нь 1-10 хооронд оноогоор хэмжигдэх ба тухайн үзүүлэлтийн талаарх иргэдийн үнэлгээ сайн бол 10 руу дөхөх оноо, сул бол 1 рүү дөхөх оноо байна.⁹⁶

Хүснэгт 79. Нийслэл Улаанбаатар хотын эдийн засгийн өрсөлдөх чадварын үзүүлэлт

№	ДЭД БҮЛЭГ	САНАЛ АСУУЛГА БОЛОН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ	ОНОО БА ХУВЬ
ЭДИЙН ЗАСГИЙН ЧАДАВХИ			0.417
1	Амьжиргааны түвшний өсөлт	Өнгөрсөн нэг жилийн хугацаанд таны амьжиргаанд хэр эерэг өөрчлөлт гарсан бэ?	5.28 оноо
2	Амьжилгааны түвшний хүлээлт	Ирэх жилийн хугацаанд таны амьжиргаанд хэр эерэг өөрчлөлт гарах хүлээлт байна вэ?	6.67 оноо
3	Үнийн өсөлт	Өргөн хэрэглээний барааны үнийн өсөлт таны амьдралд хэр сөргөөр нөлөөлж байна вэ?	3.18 оноо
ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ			0.506

⁹⁵ ЭЗБӨЧСТ, “Дүүргүүдийн өрсөлдөх чадварын тайлан 2021”, Уб, 2021, 26 дахь тал.

⁹⁶ ЭЗБӨЧСТ, “Дүүргүүдийн өрсөлдөх чадварын тайлан 2021”, Уб, 2021, 24 дэх тал.

4	Хөдөлмөрийн насны хүн ам	Нийт хүн амд 16-59 насны хүн амын эзлэх хувь	59.03 хувь
5	Ажиллагчид	Нийт хүн амын тоонд эзлэх хувь	32.36 хувь
6	Ажилгүйдлийн түвшин	Хувь	11.04 хувь
7	Ажиллах хүчний оролцооны түвшин	Хувь	61.18 хувь
8	Хөдөлмөрийн бирж	Дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага иргэдийг ажил хайж, олоход нь хэр хангалттай тусалж байна вэ?	4.65 оноо
БИЗНЕСИЙН ИДЭВХЖИЛ			1
9	Аж ахуй нэгж, байгууллагын төвлөрөл	Үйл ажиллагаа явуулж буй ААНБ, Нийслэлийн дүнд эзлэх хувь	-
10	Бүтээмж	Татварын орлого, дүүргүүдийн нийт дүнд эзлэх хувь	-
11	Зах зээлийн батгаамж	Нийслэлийн хүн амд эзлэх хувь	-

2017 онд нийслэл Улаанбаатар хотын эдийн засгийн өрсөлдөх чадварын индекс 0.585 байсан бол 2019 онд 0.039 оноогоор нэмэгдэж 0.624 гэсэн үзүүлэлттэй болсон байна. Харин 2021 онд цар тахлын улмаас Монгол улсын ажилгүйдлийн түвшин өсч, 0 зогсолтод орж, эдийн засгийн зогсонги байдалд орсны улмаас жижиг аж ахуй эрхлэгчид дампуурсан нь эдийн засгийн өрсөлдөх чадварын үзүүлэлтэд нөлөөлж 0.595-д хүртлээ буурсан байна.

График 22. Улаанбаатар хотын Эдийн засгийн өрсөлдөх чадварын хувьсал



Эх сурвалж 6. ЭЗБӨЧСТ, Дүүргүүдийн өрсөлдөх чадварын тайлан 2021.

5.5. ҮР ДҮНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Судалгааны энэ хэсэгт дээр дурдсан ЭЗБӨЧСТ-ийн “Дүүргүүдийн өрсөлдөх чадварын тайлан”-д үндэслэн Монгол Улсын 9 дүүргийн Эдийн засгийн өрсөлдөх чадварыг үнэлэв.

ЭЗБӨЧСТ-ийн “Дүүргүүдийн өрсөлдөх чадварын тайлан 2021”-д нийт 2 400 өрхөөс авсан санал асуулга болон статистик тайланд үндэслэн 2021 оны дүүргүүдийн эдийн засгийн өрсөлдөх чадварын тайланг гаргасан байна. Судалгааны үр дүнд Монгол улсын нийслэл Улаанбаатар хот болон 9 дүүргийн эдийн засгийн өрсөлдөх байдлын үнэлгээ дараах байдлаар гарсан байна.

Хүснэгт 80. 2021 оны УБ хот болон 9 дүүргийн эдийн засгийн өрсөлдөх байдлын үнэлгээ

	Эдийн засаг		Эдийн засгийн чавахи		Хөдөлмөр эрхлэлт		Бизнесийн идэвхжил	
	Индекс	Эрэмбэ	Индекс	Эрэмбэ	Индекс	Эрэмбэ	Индекс	Эрэмбэ
Багануур	0.198	8	0.442	3	0.582	2	0.030	8
Багахангай	0.103	9	0.464	1	0.590	1	0.004	9
Баянгол	0.452	4	0.397	8	0.485	9	0.481	3
Баянзүрх	0.520	1	0.455	2	0.491	7	0.631	1
Налайх	0.215	7	0.422	6	0.549	3	0.043	7
Сонгинохайрхан	0.405	6	0.360	9	0.489	8	0.377	6
Сүхбаатар	0.510	2	0.429	4	0.540	5	0.574	2
Хан-Уул	0.443	5	0.427	5	0.513	6	0.396	5
Чингэлтэй	0.466	3	0.407	7	0.544	4	0.458	4
Улаанбаатар	0.595		0.417		0.506		1.000	


Эх сурвалж 7. ЭЗБӨЧСТ, Дүүргүүдийн өрсөлдөх чадварын тайлан 2021

Улаанбаатар хотын 9 дүүргийн эдийн засгийн өрсөлдөх чадварыг харьцуулахад Баянзүрх дүүрэг тэргүүлж Сүхбаатар дүүрэг, Чингэлтэй дүүрэг удаалжээ. Харин Багануур дүүрэг хамгийн муу үзүүлэлттэй гарсан байна. 2021 оны дүүргүүдийн эдийн засгийн өрсөлдөх чадварын хүчин зүйл бүрийн санал асуулга, статистик мэдээллийн дэлгэрэнгүйг дараах хүснэгтээс харж болно.




**ЭДИЙН ЗАСГИЙН ЧАДАВХИ
АМЖИРГААНЫ ТҮВШНИЙ ӨСӨЛТ**

Өнгөрсөн жилийн хугацаанд таны амьжиргаанд хэр эерэг өөрчлөлт гарсан бэ?
2020




**ЭДИЙН ЗАСГИЙН ЧАДАВХИ
АМЬЖИРГААНЫ ТҮВШНИЙ ХҮЛЭЭЛТ**

Ирэх нэг жилийн хугацаанд таны амьжиргаанд хэр эерэг өөрчлөлт гарах хүлээлт байна вэ?
2020




**ЭДИЙН ЗАСГИЙН ЧАДАВХИ
ҮНИЙН ӨСӨЛТ**

Өргөн хэрэглээний барааны үнийн өсөлт таны амьдралд хэр сөргөөр нөлөөлж байна вэ?
2020




**ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ
ХӨДӨЛМӨРИЙН НАСНЫ ХҮН АМ**

Нийт хүн амд 16-59 насны хүн амын эзлэх хувь
2019




**ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ
АЖИЛЛАГЧИД**

Нийт хүн амын тоонд эзлэх хувь
2019



**ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ
АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН**

Хувь
2019



**ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ
АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ
ТҮВШИН**

Хувь
2019




**ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ
ХӨДӨЛМӨРИЙН БИРЖ**

Дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн
байгууллага иргэдийг ажил хайж олоход нь
хэр хангалттай тусалж байна вэ?
2020




БИЗНЕСИЙН ИДЭВХЖИЛ
АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН
ТӨВЛӨРӨЛ

Үйл ажиллагаа явуулж буй ААНБ,
 нийслэлийн дүнд эзлэх хувь
 2019



БИЗНЕСИЙН ИДЭВХЖИЛ
БҮТЭЭМЖ

Татварын орлоно, дүүргүүдийн нийт дүнд
 эзлэх хувь
 2019



БИЗНЕСИЙН ИДЭВХЖИЛ
ЗАХ ЗЭЭЛИЙН БАГТААМЖ

Нийслэлийн хүн амд эзлэх хувь
 2019



5.6. БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

Монгол улсын эдийн эрх чөлөөг хэмжихэд **Heritage Foundation-ийн “Эдийн засгийн эрх чөлөөний индекс”**-ийг ашиглаж болохоор байна. Энэ нь 12 хүчин зүйл (өмчийн эрх, засгийн газрын шударга байдал, шүүхийн үр нөлөө, засгийн газрын зардал, татварын ачаалал, төсвийн зохистой байдал, бизнесийн эрх чөлөө, хөдөлмөрийн эрх чөлөө, мөнгөний эрх чөлөө, худалдааны эрх чөлөө, хөрөнгө оруулалтын эрх чөлөө, санхүүгийн эрх чөлөө)-ээс бүрддэг ба дэлхийн 184 орны эдийн засагт дүн шинжилгээ хийх эх сурвалж болдог.

Судалгааны дата нь ихэвчлэн статистикт суурилсан тоон датаг ашиглана. Индикатор бүрийг нийтлэг стандартаар үнэлэхийн тулд цуглуулсан датаны хамгийн их утгыг 100, хамгийн бага утгыг 0 гэсэн индекс болгон хөрвүүлнэ. Тухайн улсын нийт онооны арифметик дунджаар эцсийн үнэлгээний үзүүлэлт гарна. Гэхдээ цөөн хэдэн орны хувьд дэд хүчин зүйл бүрийн хувьд харьцуулах боломжтой мэдээлэл байдаггүйгээр тус индекс нь сул талтай. Энэ тохиолдолд тухайн улсын бусад дэд хүчин зүйлсийн харьцангуй хувийн зэрэглэлд үндэслэн дутуу дэд хүчин зүйлийн оноог тооцож байна.


Heritage Foundation-ийн “Эдийн засгийн эрх чөлөөний индекс” нь улсын хэмжээнд эдийн засгийн эрх чөлөөг үнэлдэг ба тус индексээр Монгол Улсын нийслэл, болон 9 дүүргүүдэд үнэлгээ хийх боломжгүй байна. Учир нь индекс үзүүлэлтэд нөлөөлөх хүчин зүйлс нь улс орны хууль тогтоомж, удирдах байгууллагуудтай нягт холбоотой байдаг байна. Иймд тухайн индекс үзүүлэлтээр Монгол Улсын ерөнхий эдийн засгийн эрх чөлөөг тодорхойлж, үнэлнэ.

Монгол улс 2023 оны байдлаар Heritage Foundation-ийн “Эдийн засгийн эрх чөлөөний индекс”-ээс **61.7** оноо авсан байна. Энэ нь дэлхийн 184 орноос 73 дугаарт, харин Ази-Номхон далайн бүсийн 39 орноос 15-д жагссан үзүүлэлт бөгөөд дэлхийн болон бүс нутгийн дунджаас дээгүүр үзүүлэлт гарсан байна. Heritage Foundation-ээс Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдлыг *“Бизнесийн салбар нээлттэй худалдааны дэглэмээс ашиг хүртдэг ч авлига, хууль дээдлэх ёсны сул байдал нь эдийн засгийн хөгжлийг сааруулж байна. Шүүхийн шинэтгэл, төрийн удирдлага илүү тогтвортой байх нь эдийн засгийн өсөлтийг тогтвортой байлгах, амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд тустай”* гэж тодорхойлсон нь оновчтой байна.

Монгол улсын нийслэл Улаанбаатар хот болон 9 дүүргийн эдийн засгийн чадавхыг үнэлэхэд **ЭЗБӨЧСТ-ийн “Дүүргүүдийн өрсөлдөх чадварын үнэлэх тайлан”**-г ашиглах боломжтой байна. Тус индекс нь статистик мэдээлэл болон өрхийн санал асуулга дээр үндэслэн 11 хүчин зүйл (амьжиргааны түвшний өсөлт, амьжиргааны түвшний хүлээлт, үнийн өсөлт, хөдөлмөрийн насны хүн ам, ажиллагчид, ажилгүйдлийн түвшин, ажиллах хүчний оролцооны түвшин, хөдөлмөрийн бирж, аж ахуй нэгж, байгууллагын төвлөрөл, бүтээмж, зах зээлийн багтаамж)-ийн жигнэсэн дундаж оноогоор үнэлгээ тавьдаг. Индексийн хүрээнд эдийн засгийн өрсөлдөх чадварын индекс нь 0-1 хооронд утга авна. 2021 оны байдлаар нийслэл Улаанбаатар хот болон 9 дүүрэг дараах оноог авсан байна.

- Улаанбаатар хот 0.595 оноо
- Багануур дүүрэг 0.198 оноо
- Багахангай дүүрэг 0.103 оноо
- Баянзүрх дүүрэг 0.520 оноо
- Баянгол дүүрэг 0.452 оноо



- 
- Налайх дүүрэг 0.215 оноо
 - Сонгинохайрхан дүүрэг 0.405 оноо
 - Сүхбаатар дүүрэг 0.510 оноо
 - Хан-Уул дүүрэг 0.443 оноо
 - Чингэлтэй дүүрэг 0.466 оноо

2021 оны ЭЗБӨЧСТ-ийн Дүүргүүдийн эдийн засгийн өрсөлдөх чадварын судалгааны тайлангаас харвал Баянзүрх дүүрэг тэргүүлж, Сүхбаатар дүүрэг, Чингэлтэй дүүрэг удаалж байна. Харин Багануур дүүрэг, Багахангай зэрэг нийслэл хотоос зайтай оршдог дүүргүүд хамгийн муу оноо авсан байгааг анхаарах хэрэгтэй. Тодруулбал, нийслэл хотоос зайтай оршдог дүүргүүдийн эдийн засгийн өрсөлдөх чадвар, нийслэлд оршин буй дүүргүүдтэй харьцуулахад даруй 4-5 дахин муу үзүүлэлт гарсан байна.

Дүүргүүдийн эдийн засгийн өрсөлдөх чадварыг үнэлэх 11 шалгуур үзүүлэлтийн ойролцоогоор 36.4% нь санал агуулгын мэдээлэл, 63.6% нь статистик мэдээлэл байна. Статистик мэдээлэл нь өрсөлдөх чадварыг тодорхой хугацаанд хэмжиж харуулдаг ба өрсөлдөх чадвар ямар түвшинд байгааг илэрхийлдэг. Харин санал асуулгаар статистик мэдээллийн олдоц муу, шууд хэмжихэд бэрх тоон бус үзүүлэлтүүдийг тодорхойлж олж авсан онцлогтой. Түүнчлэн санал асуулгын мэдээлэл нь тухайн статистик мэдээллүүдийг батлах, бодит байдлыг тодруулах, иргэд, хувийн хэвшлийнхэн тухайн үзүүлэлтийг хэрхэн үнэлж буйг харуулах ач холбогдолтой.

ЭЗБӨЧСТ-ийн Дүүргүүдийн өрсөлдөх чадварын судалгааны тайлан нь 2 жил тутам гардаг ба 2023 оны тайлан энэ оны 12 сард багтан гарах төлөвтэй байна. Судалгааны тайланг [энэ холбоосоос](#) худалдан авах боломжтой байна.



ЗУРГАА. “ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЭРХ ЧӨЛӨӨ” ИНДЕКС ҮЗҮҮЛЭЛТ

6.1. ЗОРИЛГО

Судалгааны үндсэн зорилго нь Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот болон 9 дүүргийн өмнө тулгамдаж буй хөрөнгө оруулалтын асуудлыг судлах, хөрөнгө оруулалтын эрх чөлөөний байдлыг судалгааны хүрээнд тодорхойлсон шалгуур үзүүлэлтээр тооцсон индексээр үнэлэх, давуу болон сул талууд, түүнийг сайжруулахад тулгарч буй бэрхшээлүүдийг гаргаж ирэхэд оршино. Тус зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлж байна. Үүнд:

- “Хөрөнгө оруулалтын эрх чөлөө” индекс үзүүлэлтийн талаарх олон улсын жишиг аргачлалыг илрүүлэх.
- Тус индексийг тооцохтой холбоотой мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийж тайлагнах.

6.2. АРГА ЗҮЙ, ТООЦООЛОЛ

“Хөрөнгө оруулалтын эрх чөлөө” гэх дэд индексийг үнэлэхдээ АНУ-ын стратеги судалгааны “Heritage Foundation” хүрээлэнгийн “Эдийн засгийн эрх чөлөөний индекс”^{97,98}-т баримталсан эх сурвалжийг ашигласнаас гадна Монгол Улсын хууль тогтоомж, хөрөнгө оруулалтын эрх орчныг үнэлсэн гадаадын зарим судалгааны тайланд үндэслэв.

Шалгуур үзүүлэлтийг үнэлэхдээ суурь түвшинг 2022 он байхаар тогтоосон бөгөөд жил бүр өмнөх оныг суурь түвшин гэж үзэх нь зүйтэй. Индексийг үнэлэх шалгуур үзүүлэлтүүд нь чанарын үзүүлэлт боловч АНУ-ын стратеги судалгааны “Heritage Foundation” хүрээлэнгийн “Эдийн засгийн эрх чөлөөний индекс”^{99,100}-ийн “Хөрөнгө оруулалтын эрх чөлөөний индекс”-ийг жишиг болгон тоон утгаар илэрхийлэхийг зорьсон болно.

“Хөрөнгө оруулалтын эрх чөлөө”-ний оноог доор шалгуур үзүүлэлтүүдийн дагуу тохирол хязгаарлалтын түвшингээр үнэлж нийт гарсан оноог 100 онооноос хасаж гаргана.

⁹⁷ Heritage Foundation, Index of Economic freedom, 2023.

https://www.heritage.org/index/pdf/2023/book/2023_IndexOfEconomicFreedom_FINAL.pdf

⁹⁸ Sources. The Index relies on the following sources for data on capital flows and foreign investment, in order of priority: official government publications of each country; U.S. Department State, Investment Climate Statements; Economist Intelligence Unit, Country Commerce; Office of the U.S. Trade Representative, National Trade Estimate Report on Foreign Trade Barriers; World Bank, Investing Across Borders; Organisation for Economic Co-operation and Development, Services Trade Restrictiveness Index; and U.S. Department of Commerce, Country Commercial Guide.

⁹⁹ Heritage Foundation, Index of Economic freedom, 2023.

https://www.heritage.org/index/pdf/2023/book/2023_IndexOfEconomicFreedom_FINAL.pdf

¹⁰⁰ Sources. The Index relies on the following sources for data on capital flows and foreign investment, in order of priority: official government publications of each country; U.S. Department State, Investment Climate Statements; Economist Intelligence Unit, Country Commerce; Office of the U.S. Trade Representative, National Trade Estimate Report on Foreign Trade Barriers; World Bank, Investing Across Borders; Organisation for Economic Co-operation and Development, Services Trade Restrictiveness Index; and U.S. Department of Commerce, Country Commercial Guide.



Тодруулбал 8 шалгуур үзүүлэлт тус бүрт тохирох оноог сонгож нийт оноог 100 онооноос хасна.

Хүснэгт 81. “Хөрөнгө оруулалтын эрх чөлөөний индекс”-ийн шалгуур үзүүлэлт

№	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	ХЯЗГААРЛАЛТЫН ТҮВШИН	ХАСАГДАХ ОНОО
1	Үндэсний дэглэм үйлчилдэг эсэх	Үндэсний дэглэм үйлчилдэггүй	25
		Зарим үндэсний дэглэм үйлчилдэг	15
		Зарим үндэсний дэглэм үйлчилдэг эсхүл prescreening	5
2	Хөрөнгө оруулалтын хууль тогтоомжийн ил тод, тогтвортой, урьдчилан таамаглахуйц байдал	Хаалттай бөгөөд хүнд суртал ихтэй	20
		Бодлогын хэрэгжилт үр дүнгүй бөгөөд хүнд суртал бүхий	10
		Зарим хууль тогтоомж нээлттэй биш эсхүл хэрэгжилт үр дүнгүй	5
3	Өмчлөх эрхэд тавигдаж буй хязгаарлалт	Бүх төрлийн үл хөдлөх хөрөнгийг шилжүүлэхийг хязгаарласан	15
		Гагцхүү үл хөдлөх хөрөнгийг гадаадын иргэн, хуулийн этгээдэд шилжүүлэхийг хязгаарласан	10
		Үл хөдлөх хөрөнгийг шилжүүлэхийг зөвшөөрдөг ч зарим хязгаарлалт тавьдаг	5
4	Эдийн засгийн секторт тавигдах хязгаарлалт	Олон секторт хязгаарлалт тавьсан	20
		Цөөн салбарт хязгаарлалт тавьсан	10
		Нэг эсхүл хоёр секторт хязгаарлалт тавьсан	5
5	Шударга нөхөн олговоргүйгээр өмчийг дайчлан авах, хураах	Нөхөн төлбөргүйгээр дайчлах тохиолдол олон	25
		Нөхөн төлбөртэйгээр дайчлан авах тохиолдол олон	15
		Дайчлан авах тохиолдол бий боловч цөөн	5
6	Гадаад валютын урсгалд тавигдах хязгаарлалт	Гадаад валютын хөрвүүлэг хийгдэх боломжгүй	25
		Боломжтой хэдий ч хатуу хязгаарлалттай	15
		Боломжтой бөгөөд цөөн хязгаарлалттай	5
7	Хөрөнгө, орлогыг гадаад улсад саадгүйгээр гаргах	Хөрөнгө орлогыг гадаад улсад гаргах боломжгүй, бүх гүйлгээнд төрөөс зөвшөөрөл олгодог	25
		Хөрөнгө, орлогыг шилжүүлэхэд зөвшөөрөл шаардлагатай бөгөөд зарим хязгаарлалт тавигддаг	15
		Зарим хязгаарлалттай боловч ихэнх гүйлгээ зөвшөөрөгдсөн	5
8	Бусад хязгаарлалт	Хөрөнгө оруулалтад шууд бусаар дарамт учруулдаг, хүнд суртал ихтэй, хөрөнгө оруулалтын эрх чөлөөг хязгаарлаж буй засгийн газрын бусад бодлогын улмаас 20 хүртэлх оноо хасаж нэмэлтээр болно.	20 хүртэлх

6.3. СУДАЛГААНЫ ДАТА ЦУГЛУУЛАХ

Монгол Улсад 2000-2021 онд нийтдээ 69.2 их наяд төгрөгийн гадаадын шууд хөрөнгө оруулалт хийгдсэн бөгөөд хөрөнгө оруулалтын хэмжээ жил жилд тогтворгүй байсан. Гадаадын шууд хөрөнгө оруулалтын 70 орчим хувь нь үйлдвэрлэлийн салбар, үүнээс уул уурхай, олборлолтын салбарт орж байна. Монгол Улсад 2021 онд орсон Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг салбараар авч үзвэл, уул уурхайн салбарт 5916.5 (76.5%) тэрбум төгрөг,



бөөний болон жижиглэн худалдааны салбарт 493.1 (6.4%) тэрбум төгрөг, санхүү, даатгалын салбарт 262.0 (3.4%) тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгджээ¹⁰¹.

Гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох урсгалын 2021 оны гүйцэтгэлийг голлох улсаар авч үзвэл, 4422.1 (57.2%) тэрбум төгрөгийг Канад улс, 762.8 (9.9%) тэрбум төгрөгийг Сингапур улс, 700.4 (9.1%) тэрбум төгрөгийг БНХАУ, 589.7 (7.6%) тэрбум төгрөгийг Их Британи улс, 224.3 (2.9%) тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг Люксембург улсаас тус тус хийжээ¹⁰².

Хүснэгт 82. Гадаадын шууд хөрөнгө оруулалт, орох урсгал, улсаар

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	2021	2022	2023-I	2023-II
Нийт	2713.616877	3417.833388	593.4105447	583.09222
Канад	1552.008848	111.0423439	9.398446863	1.242597489
АНУ	51.75381436	91.87084576	3.255993221	6.109584109
БНХАУ	307.3440468	193.6685841	66.15256832	64.68175091
Сингапур	267.7086871	215.9255645	68.39877634	25.99643626
Япон	74.61908079	75.82919396	16.86864232	24.81289552
Швейцар	3.656218292	0.12824	0.558620586	0.227687261
Их Британи	206.9834853	171.6048791	21.73967725	0.487532665
Герман	11.17966854	2.570429384	1.537812912	1.06715616
Итали	1.130173849	0.769534405	0.034445976	0.123268642
Люксембург	78.71376346	85.20163037	64.51863292	0.084692109
Франц	10.92091208	8.983192361	2.009476524	2.949227388
ОХУ	16.80697281	10.91460758	0.623950518	1.539020418
Шинэ Зеланд	0.7	0	0	0
БНСУ	4.488850092	12.78869461	3.08982937	4.00465909
Австрали	17.17780725	24.03720655	3.294747122	3.530826147
Нидерланд	30.70312474	2263.516409	321.4207751	402.416941
Монако	0	0.01377	0	0
Катар	2.372660288	0	0	0.27382
Турк	0.780568885	0.86499	0.01197	0.11245
Бельги	32.40356364	38.7209299	0.06819351	0.015047181
Филиппин	3.043612838	0.09999	0	0.010505
Чех	0.845664731	5.090446994	0.044619598	1.497107617
Камбож	0	0.44295	0.19977	0.89944
Малайз	2.599439479	0.996440998	0.05509	0
Ирланд	0.202778157	0.00504	0.02345	0
Киргиз	0.22005	0	0	0.019
Армен	0.85194	0	0	0
Узбекистан	0	0	0	0
Финлянд	0.575834933	0.013	0	0.054141364
Украйн	0.19263604	0	0	0
Бусад	33.63267462	102.7344742	10.10505631	40.93643366

Нийт гадаад хөрөнгө оруулалт бүхий ББСБ-ын 38.5 хувь буюу 10 нь Япон улсын, 26.9 хувь буюу 7 нь БНСУ-ын, 7.7 хувь буюу 2 нь АНУ-ын, АНУ, Япон улсын хамтарсан хөрөнгө оруулалттай 1, үлдсэн нь БНХАУ, ОХУ, Их Британи, Малайз, Хонг Конг, Канад зэрэг бусад улсын хөрөнгө оруулалттай байна. Гадаадын хөрөнгө оруулалттай нийт 26 (5 хувь) ББСБ-

¹⁰¹ Үндэсний статистикийн хороо, “Хөрөнгө оруулалт 2021”, Уб, 2022, <https://www2.1212.mn/BookLibraryDownload.ashx?url=Investment%202021%20MN.pdf&In=Mn>

¹⁰² Үндэсний статистикийн хороо, “Хөрөнгө оруулалт 2021”, Уб, 2022, <https://www2.1212.mn/BookLibraryDownload.ashx?url=Investment%202021%20MN.pdf&In=Mn>

ын хувьд салбарын нийт хөрөнгийн 15.2 хувийг эзэмшдэг бөгөөд нийт харилцагчдын 2.8 хувьд үйлчилгээ үзүүлдэг байна¹⁰³.

“Heritage Foundation” хүрээлэнгээс эрхлэн гаргадаг “Эдийн засгийн эрх чөлөөний индекс”-ээр Монгол Улсын нийт төлөв байдлыг үнэлсэн. Иймд дээр дурдсан шалгуур үзүүлэлт, аргачлалын дагуу Улаанбаатар хот дахь хөрөнгө оруулалтын эрх чөлөөг тусгайлан үнэлэх нь зүйтэй гэж үзсэний үндсэн дээр Монгол улсын хөрөнгө оруулалтын эрх чөлөөт байдлыг үнэлэв.

1. Үндэсний дэглэм үйлчилдэг эсэх

Үндэсний дэглэм /англ.national treatment, орос.национальный режим/ гэж улс гадаад улсын иргэн, хуулийн этгээдэд эрх зүйн харилцаанд өөрийн иргэд болон хуулийн этгээдтэй тэгш эрх, бололцоо олгохоор харилцан тохиролцохыг ойлгоно. Товчоор илэрхийлбэл, гадаадын хөрөнгө оруулагчдыг алагчлахгүй байх талаарх ойлголт юм.

Монгол Улсын Засгийн газар, эрх бүхий байгууллагаас Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдад ижил төрлийн татварын **хөнгөлөлт** үзүүлдэг. Монгол Улсын импортын 5 хувийн татвар, 10 хувийн нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ)-д хөнгөлөлт үзүүлж болно. Тухайлбал, зарим тохиолдолд ашигт малтмал боловсруулах, хөдөө аж ахуй, дэд бүтэц зэрэг салбар дахь хөрөнгө оруулалтад татварын хөнгөлөлт олгож болно. Түүнчлэн, Хөрөнгө оруулалтын тухай хуулийн дагуу Монгол Улсад зохих ёсоор бүртгүүлэн, татвараа төлж байгаа гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүд дотоодын компаниудын нэгэн адилаар хөрөнгө оруулалтыг урамшуулах багц хөтөлбөрт хамрагдаж, зарим **хөнгөлөлт**, түүний дотор 27 хүртэлх жилийн хугацаанд татварын тогтворжилтын хөнгөлөлт эдлэх боломжтой.

Нийслэл хотын албан татварын тухай хуулиар татвар төлөгчийн худалдан авсан хуульд тусгайлан заасан¹⁰⁴ бараа, үйлчилгээнд нийслэл хотын албан татвар ногдуулдаг бөгөөд татварын хөнгөлөлт, чөлөөлөлт тэгш хэрэгждэг.

Монгол Улсад хоёр томоохон асуудлыг эс тооцвол гадаадын хөрөнгө оруулагчдыг ялгаварлан гадуурхах явдал байдаггүй гэж гадаадын хөрөнгө оруулагчид үзэж байна.¹⁰⁵ Эдгээр хоёр асуудлын **нэгдүгээрт**, гадаадын хөрөнгө оруулагчид аж ахуйн нэгж

¹⁰³Санхүүгийн зохицуулах хороо, “Санхүүгийн салбарын тойм 2022 оны 3 дугаар улирлын тайлан”, <http://www.frc.mn/resource/frc/Document/2022/11/23/7t7d2eo8jduuww3c/Toim%202022q3%20urult%2022.11.23%20last.pdf>

¹⁰⁴ Нийслэл хотын албан татварын тухай хууль

7.1.1.энэ хуулийн 4.1.3-т заасан бүх төрлийн согтууруулах ундаа;

7.1.2.энэ хуулийн 4.1.3-т заасан бүх төрлийн тамхи.

7.2.Татвар төлөгчийн худалдан авсан дараах үйлчилгээнд нийслэл хотын албан татвар ногдуулна:

7.2.1.энэ хуулийн 4.1.4-т заасан зочид буудлын үйлчилгээ;

7.2.2.энэ хуулийн 4.1.5-д заасан амралтын газрын үйлчилгээ;

7.2.3.энэ хуулийн 4.1.6-д заасан рестораны үйлчилгээ;


7.2.4.энэ хуулийн 4.1.7-д заасан баарны үйлчилгээ.

7.2.5.энэ хуулийн 4.1.8-д заасан үйлчилгээ;

7.2.6.энэ хуулийн 4.1.9-д заасан үйлчилгээ.

¹⁰⁵ Монгол Улс дахь Америкийн Нэгдсэн Улсын Элчин сайдын яам, Монгол Улсын 2022 оны Хөрөнгө оруулалтын орчны мэдэгдэл, <https://mn.usembassy.gov/mn/2022-investment-climate-statement-mongolia-mn/>, <https://www.state.gov/reports/2023-investment-climate-statements/mongolia/>.





байгуулахын тулд хамгийн багадаа 100,000 ам. долларын хөрөнгө оруулалт хийх ёстой.¹⁰⁶ Харин Монголын хөрөнгө оруулагчдаас хөрөнгө оруулалтын хамгийн бага хэмжээг зааж шаарддаггүй.

Хөрөнгө оруулалтын индексийн оноогоор тэргүүлж буй Люксембург, Ирланд, Эстони, Нидерланд, Дани, Сингапур, Швейцар, Швед, Америк, Латви зэрэг орнуудыг авч үзвэл дээрх төрлийн ялгамжтай зохицуулалт байхгүй байна.

Гадаадын хөрөнгө оруулагчдад тавих босго хөрөнгө оруулалтын хэмжээг БНСУ тогтоосон. 1981 онд гадаадын хөрөнгө оруулалтын босго хэмжээг 500 сая воноос 100 сая вон болгож бууруулсан. Хуульд “Хөрөнгө оруулалтын хэмжээ гэдэг нь хувьцааг худалдаж авсан үнийн дүн бөгөөд хоёр болоод түүнээс дээш гадаадын иргэд хамтарсан хөрөнгө оруулалт хийвэл тус тусдаа төлөх хэмжээг (100 сая вон) хэлнэ.” гэж заажээ. Хөрөнгө оруулалтын босго нь үндэсний үйлдвэрлэлийг түлхүү дэмжих, гадаадын хөрөнгө оруулалтыг аль болох дотоодын хөрөнгө оруулагчтай хамтрах нөхцөлийг бүрдүүлэх чиглэлтэй, босго дүнгээс хамаарч урамшууллыг нэмэгдүүлдэг нөхцөлтэй байна.¹⁰⁷

Хоёрдугаарт, Гадаадын хөрөнгө оруулагч (иргэн) газар ашиглаж болох боловч энэ эрх нь таван жилийн хугацаатай бөгөөд зөвхөн нэг удаа л дахин таван жилээр сунгагдана.¹⁰⁸ Гадаад хөрөнгө оруулагчийн гэр бүлийн хэрэгцээний дагуу ашиглаж буй газар ашиглах эрхийн гэрчилгээний хугацаа дууссан бол уг этгээдийн газар дээрх барилга байгууламж, бусад эд хөрөнгө өмчлөгч этгээдийн тэрхүү эд хөрөнгөө тухайн газар дээр ашиглах эрх дуусгавар болно.

Энэ нь Монгол Улсын иргэн, хуулийн этгээдэд тавигдах хязгаарлалтаас өөр байх бөгөөд Газрын тухай хуулийн дагуу газрыг Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад 15-60 жил хүртэл хугацаатайгаар эзэмшүүлж болно. Газар эзэмших эрхийн гэрчилгээг нэг удаад сунгах хугацаа 40 жилээс илүүгүй байна. Гэвч бизнесийн үйл ажиллагаа эрхлэхээр байгуулагдсан гадаадын хөрөнгө оруулалтын аж ахуй нэгж нь газрыг 60 хүртэлх хугацаагаар ашиглаж болох бөгөөд нэг удаа 40 жилээс илүүгүй хугацаагаар сунгаж болно. Одоогийн

¹⁰⁶ Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 3.1.5 дахь хэсэг "Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж" гэж Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан, хуулийн этгээдийн нийт гаргасан хувьцааны 25 буюу түүнээс дээш хувийг гадаадын хөрөнгө оруулагч эзэмшиж байгаа бөгөөд гадаадын хөрөнгө оруулагч тус бүрийн оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ нь 100 мянган америк доллар буюу түүнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөс дээш байх аж ахуйн нэгжийг" ойлгоно.


¹⁰⁷ Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгааны тайлан, https://cdn.greensoft.mn/uploads/users/3962/files/4_%20%D0%A5%D1%83%D1%83%D0%BB%D0%B8%D0%B9%D0%BD%20%D1%82%D3%A9%D1%81%D0%BB%D0%B8%D0%B9%D0%BD%20%D1%82%D0%B0%D0%BD%D0%B4%D0%B0%D0%BD%20%D1%81%D1%83%D0%B4%D0%B0%D0%BB%D0%B3%D0%B0%D0%B0.pdf

¹⁰⁸ Газрын тухай хуулийн 44.4 дэх хэсэг. Монгол Улсад байнга /183 хоногоос дээш хугацаагаар/ оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүнд газрыг зөвхөн гэр бүлийн хамтын хэрэгцээний нь зориулалтаар ашиглуулах асуудлыг дуудлага худалдааны зарчмаар тухайн шатны Засаг дарга шийдвэрлэнэ.

44.5. Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид энэ хуулийн дагуу газрыг тусгай зориулалт, хугацаа, болзолтойгоор ашиглуулах бөгөөд уг хугацааг Засгийн газар тогтооно.

44.6. Энэ хуулийн 44.4-т заасан иргэнд хувийн гэр, орон сууцны хашааны зориулалтаар ашиглуулах газрын хэмжээ 0,05 га-аас, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ тарих зориулалтаар олгох газрын хэмжээ 0,1 га-аас тус тус илүүгүй байна. Газрыг 5 жил хүртэл хугацаагаар гэрээгээр ашиглуулах бөгөөд гэрээг нэг удаад сунгах хугацаа 5 жилээс илүүгүй байна.





хууль тогтоомжийн дагуу гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуй нэгж газрыг хуульд заасан хугацаагаар ашиглах эрхтэй. Эзэмших эрхтэй харьцуулан авч үзвэл, ашиглах эрхийг барьцаалах, бусдад шилжүүлэх боломжгүй¹⁰⁹. Гадаадын иргэн, хуулийн этгээдэд газрыг гагцхүү ашиглуулах боломжтойгоор зохицуулсан нь Монгол иргэний нэр дээрх эзэмших эрхийн гэрчилгээтэй газар эсхүл түүний өмчлөлийн газрыг далд байдлаар ашиглах, барилга байгууламж барих, цаашлаад барилга байгууламжийн өмчлөгч, газрын өмчлөгч эсхүл эзэмшигч нарын хооронд маргаан үүсэх тохиолдлууд гарсаар байна.

Түүнчлэн гадаадын хөрөнгө оруулалттай компанийг үүсгэн байгуулах хүсэлтийг гаргахад улсын тэмдэгтийн хураамжийн үнэ 750,000 төгрөг байдаг бол, Монгол Улсын хуулийн этгээдийг бүртгүүлэхэд улсын тэмдэгтийн хураамжийн үнэ 44,000 төгрөг байдаг. Харин хүсэлт шийдвэрлэх хугацааны хувьд адил журам үйлчилж байна. Гадаадын хөрөнгө оруулалттай ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ нь 1 эсхүл 2 жилийн хугацаатай байна. Улсын бүртгэлийн гэрчилгээний хугацаа дуусахаас өмнө гадаадын хөрөнгө оруулалттай ХХК-ийн төлөөлөгч зохих сунгалтыг хийлгэнэ.

Дүгнэвэл, гадаадын хөрөнгө оруулагч нарт тавигдаж буй дээрх хязгаарлалтыг өөрчилж, тэдгээрт үндэсний нөхцөл буюу дотоодын хөрөнгө оруулагч нартай ижил нөхцөлийг олгох шаардлагатай.

Нийслэлийн Засаг дарга, түүний эрхлэх асуудлын хүрээнд ажиллах агентлагийн үйл ажиллагааны хүрээнд дээр зааснаас бусад гадаадын хөрөнгө оруулагчид ялгамжтай хандаж буй байдал илрээгүй.

Иймд Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулагчдад ялгамжтай хандах зохицуулалт бий боловч харьцангуй цөөхөн байгаа тул энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд **15 оноо** хасагдахаар байна.

2. Хөрөнгө оруулалтын бодлого, хууль тогтоомжийн ил тод, тогтвортой, таамаглахуйц байдал

Хөрөнгө оруулалтын бодлого, хууль тогтоомжийн ил тод байдлыг хангах гэдэгт нэгдүгээрт, холбогдох хууль, бусад хэм хэмжээний актыг нийтэд ил тод, хүртээмжтэй байршуулах, хоёрдугаарт хууль тогтоомжийг өөрчлөх тохиолдолд эрх ашиг нь зөрчигдөж буй этгээдүүдэд урьдчилан мэдэгдэх, гуравдугаарт хууль тогтоомжийг нэгдмэл байдлаар ойлгож хэрэглэх, дөрөвдүгээрт хуулийн төслийн үзэл баримтлалыг тайлбарлах, санал, хүсэлт өгөх боломжоор хангах, тохирсон хугацаа тогтоох асуудал, тавдугаарт хөрөнгө оруулалтын саналд зөвшөөрөл олгох процессын ил тод байдлыг хамруулан ойлгодог¹¹⁰.

Холбогдох хууль, бусад хэм хэмжээний актыг нийтэд ил тод, хүртээмжтэй байршуулах хүрээнд мэдээллийн сувгийн хүртээмжтэй байдал, мэдээлэл хүлээн авах

¹⁰⁹ А.Түвшинтөгс, “Гадаадын хөрөнгө оруулалттай компани газар эзэмших эсхүл ашиглах эрхийг эдлэхэд тулгамдаж буй хууль зүйн асуудал” (2020). Legaldata-аас унших боломжтой: <https://legaldata.mn/b/1366>.

¹¹⁰ Transparency and predictability for investment policies addressing national security concerns: a survey of practices, May 2008, <https://www.oecd.org/daf/inv/investment-policy/40700254.pdf>.



хялбар, шуурхай байдал, кодификацлагдсан байдал, эх хэлнээс орчуулагдсан эсэх асуудал хөндөгдөг¹¹¹. Хөндөгдөх асуудлыг үнэлгээний хүснэгт байдлаар илэрхийлбэл:

I. Ил тод байршуулдаг эсэх		II. Мэдээллийн суваг хүртээмжтэй эсэх			III. Эх хэлээс өөр хэлээр орчуулагддаг эсэх
Хуулийг ил тод байршуулдаг эсэх	Захиргааны акт, шийдвэрийг нийтэлдэг эсэх	Интернет, цахим сүлжээ ашигладаг эсэх	Төрийн сэтгүүлд нийтэлдэг эсэх	Чиг үүрэг бүхий байгууллагаар дамжуулан нэг цэгээр мэдээлэл өгдөг эсэх	

Харин хууль тогтоомжийг өөрчлөх тохиолдолд эрх ашиг нь зөрчигдөж буй этгээдэд урьдчилан мэдэгдэх хүрээнд улс бүр харилцан адилгүй практик тогтоосон байх бөгөөд зарим улсад хуульд орох өөрчлөлтийг мэдэгддэг бол, зарим улсад сонирхогч этгээд, хөрөнгө оруулагчдыг оролцуулж хэлэлцээр хийх, эсхүл зөвлөл /advisory board/ байгуулах өндөр шаардлага тавигддаг.

I. Хууль тогтоомжийн хүрээнд			II. Хөрөнгө оруулалтын бодлогын зөвлөгөө байгуулдаг хуулиар зохицуулагүй	III. Хөрөнгө оруулагчдыг оролцуулан тусгай зөвлөгөөн явуулдаг
Урьдчилан шаардлага эсэх	мэдэгдэх тавигддаг	Зөвлөгөөн /consultation/ шаардлага эсэх	хүрээнд зохион боловч	тусгай зөвлөгөөн явуулдаг


Хөрөнгө оруулалтын санал хянах, зөвшөөрөл олгох процессын ил тод, үр дүнтэй байдлын хувьд зарим улс зөвшөөрөл олгох хөрөнгө оруулалтыг салбар салбараар нь жагсаадаг бол зарим улсад хөрөнгө оруулалтын хэмжээ, хяналтын түвшин зэргээс хамруулан зөвшөөрөл өгөх салбарыг тогтоох нь бий. Ийнхүү хөрөнгө оруулалтын саналыг шийдвэрлэх ажиллагааны хугацаа, үнэлэх шалгуур зэргийг ил тод мэдээлэх нь зүйтэй.

Монгол Улсын Хөрөнгө оруулалтын тухай хуульд хөрөнгө оруулалтын хууль тогтоомжийн хууль тогтоомжийг ил тод байлгах талаар аливаа зохицуулалт тусгагдаагүй.

Монгол Улсад 2021 оноос Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль үйлчилж эхэлсэн бөгөөд хаалттай, хязгаарлагдмал, нээлттэй мэдээллийг ангилж тодорхой тусгасан. Тус хуульд заасан олон нийтэд ил тод, нээлттэй байх мэдээлэлтэй иргэн, аж ахуй нэгж ямар ч тохиолдолд танилцах боломжтой. Тухайлбал, төрийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох зорилгоор мэдээлэл хариуцагчийн чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт, хүний нөөц, төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа, үзүүлж байгаа үйлчилгээ болон хуулиар хаалттай, хязгаарлалттай гэж тогтоосноос бусад мэдээллийг ил тод, нээлттэй байлгана. Гэвч тус хуульд заасны дагуу нээлттэй байх ёстой мэдээллийг төрийн байгууллагын албаны нууцад хамааруулах болон хувь хүний нууц, хувийн мэдээллийг албаны нууц гэх ойлголтод хамааруулах асуудал цөөнгүй байгааг үгүйсгэх боломжгүй.¹¹² Хөрөнгө оруулагчид Монгол

¹¹¹ Transparency and predictability for investment policies addressing national security concerns: a survey of practices, May 2008, <https://www.oecd.org/daf/inv/investment-policy/40700254.pdf>.

¹¹² Хууль зүйн үндэсний хүрээлэн, Төрийн болон албаны нууцын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх, 2023.



Улс хууль тогтоомжийг ил тод боловсруулж, урьдчилан таамаглахуйцаар хэрэгжүүлдэг тогтвортой орчныг бий болгох ёстой гэж үзсээр байна.

Хууль тогтоомжийн тухай хуульд зааснаар “хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр”-ийг санаачлан боловсруулах, хууль тогтоомжийн төсөлд тавигдах шаардлагыг тодорхойлох, олон нийтийн оролцоог хангах, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, батлагдсан хууль тогтоомжийг нийтлэх, сурталчлах, түүний хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэхтэй холбогдсон харилцааг зохицуулдаг. Хууль санаачлагчид нь хууль тогтоомжийн төслийг олон нийтээр хэлэлцүүлж, саналыг авах зорилгоор, мөн үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцооны талаарх тайланг УИХ-ын албан ёсны цахим хуудас (Монгол Улсын Их Хурал/Төслүүд)-нд хууль тогтоомжийн төслийг УИХ-д өргөн барихаас 30-аас доошгүй хоногийн өмнө нийтлэх ёстой. Ийнхүү нийтлэхдээ олон нийтээр хэлэлцүүлж, санал авах цаг хугацааг тодорхой зааж өгөх ёстой. Хууль санаачлагчид нь саналыг бичгээр авах, олон нийтийн хурал уулзалтууд зохион байгуулах, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан санал авах, олон нийтийн дунд санал асуулга явуулах шаардлагатай. Олон нийтээр хэлэлцүүлж, санал авах хугацаа дууссанаас хойш 30 хоногийн дотор хууль санаачлагчид бүх санал дүгнэлтийг тусгасан хүснэгтийг бэлтгэж, түүндээ хуулийн төслийг боловсруулахад ашигласан болон ашиглаагүй саналуудыг ч багтаан УИХ-ын албан ёсны цахим хуудсанд байршуулах ёстой. Хууль тогтоомж батлагдсаны дараа УИХ хууль тогтоомжийн хэрэгжилт, үр нөлөөг хянах, үнэлэх ёстой ч хөрөнгө оруулагчдын мэдээлж буйгаар хууль тогтоогчид эдгээр шаардлагыг нэг бүрчлэн хэрэгжүүлдэггүй боловч ихэнх хууль тогтоомжийг батлахаас өмнө УИХ-ын цахим хуудсанд нийтэлсэн байдаг.¹¹³

Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу хууль тогтоомжийн төслүүдийг үндэсний хэмжээнд гардаг сэтгүүлд буюу LegallInfo.mn (LegallInfo)-д байршуулж, олон нийтийн саналыг авах ёстой. Хуулийн төсөл санаачлагчид нь олон нийтээс өгсөн чухал санал зөвлөмжүүдийг тэмдэглэн авч, тайлагнаж, тэдгээрт хариу өгөх ёстой. Хууль зүй, дотоод хэргийн яам нь хууль тогтоомжийн төсөл боловсруулах үйл явц бүр Захиргааны ерөнхий хуультай нийцэж байгаа эсэхийг тухайн хууль тогтоомж хүчин төгөлдөр болохоос өмнө хянан баталгаажуулах ёстой.

Хуульд заасан эдгээр шаардлагыг яам, агентлагууд биелүүлээгүй гэдгийг бизнесийнхэн хэлж байна. Энэ нь хуулиар тогтоосон шаардлагатай холбоотой. Хууль тогтоомжийн хуулиар гагцхүү хууль, Улсын их хурлын бусад шийдвэр, тэдгээрийн төсөл, орчуулгыг цахим хуудсанд байршуулж, санал авахаар тусгасан. Өөрөөр хэлбэл, Засгийн газар, яам, агентлаг, эрх бүхий байгууллагаас баталсан эрх зүйн хэм хэмжээний актын төслийг нийтлэх, сонирхогч этгээдийн саналыг авснаар баталж, ХЗДХЯ-нд бүртгүүлснээр хүчин төгөлдөр болохоор тусгасан ч орчуулгыг тавьдаггүй тул хөрөнгө оруулагчдад төдийлөн хүрдэггүй гэж хэлж болно. Харин дээрх байгууллага, албан тушаалтнаас гарсан захиргааны акт буюу шийдвэрийг гаргах аас өмнө сонирхогч этгээдэд урьдчилан мэдэгдэх, сонсох ажиллагаа явуулахаар Захиргааны ерөнхий хуульд тусгасан ч хэрэгжилт нь төдийлөн жигдрээгүй байгааг дурдах нь зүйтэй.

Бизнес эрхлэгчид орон нутгийн буюу аймаг, сум, дүүргийн түвшинд эрх зүйн зохицуулалттай холбоотой дарамт хүндрэл их байдаг талаар тэмдэглэсэн байна. Тэд нийслэл, аймаг, сум дүүргийн түвшинд хууль тогтоомжийг тогтвортой, уялдаа холбоотой

¹¹³ Монгол Улс дахь Америкийн Нэгдсэн Улсын Элчин сайдын яам, Монгол Улсын 2022 оны Хөрөнгө оруулалтын орчны мэдэгдэл, <https://mn.usembassy.gov/mn/2022-investment-climate-statement-mongolia-mn/>, <https://www.state.gov/reports/2023-investment-climate-statements/mongolia/>.



хэрэглэдэггүй, орон нутгийн байцаагчдын хууль тогтоомжийн талаарх мэдлэг дутмаг байгааг тэмдэглэжээ.¹¹⁴

Нийслэл Улаанбаатар хотын хувьд авч үзвэл, Нийслэлийн Засаг дарга, Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэрийн төсөл ихэвчлэн нийтэд ил тод байдаггүй бөгөөд төсөлд санал авах тохиолдолд гагцхүү Монгол хэлээр нийтлэгддэг. Өөрөөр хэлбэл, Нийслэлийн Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэр нь хөрөнгө оруулагчдын эрхийг зөрчих, эсхүл тэдгээрийн үйл ажиллагаанд гэнэтийн үр дагавар үүсгэхийг үгүйсгэхгүй.

Эдийн засаг, хөгжлийн яамнаас гүйцэтгэсэн Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тандан судалгаагаар Монгол Улсад “хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалтаа хэвийн явуулахад зөвлөмж, чиглэл өгөх талаар зохицуулалт дутмаг, хөрөнгө оруулалтын харилцаанд оролцож буй төрийн байгууллагуудын чиг үүрэг тодорхойгүй, хуульд бүрэн тусгагдаагүй” гэж үнэлсэн байна.¹¹⁵ Монгол Улс хөрөнгө оруулагчдад виз, татвар, нотариат, бизнесийн бүртгэлийн чиглэлээр үйлчилгээ үзүүлдэг “Хөрөнгө оруулагчдад зориулсан нэг цонхны үйлчилгээ”-г санал болгодог хэдий ч хөрөнгө оруулагчдад зөвлөмж чиглэл өгөх асуудлыг үр дүнтэй шийдвэрлэж чадахгүй байгаа юм.¹¹⁶ Одоогийн хууль тогтоомжийн дагуу Эдийн засаг, хөгжлийн яамны бүтцийн нэгж болох Хөрөнгө оруулалтын бодлогын газар нь хөрөнгө оруулалтын цогц бодлогыг тодорхойлох, гадаадын хөрөнгө оруулалтын холбогдох бодлого, зохицуулалтыг тодорхойлон уялдааг хангах, концесс болон төр, хувийн хэвшлийн түншлэлтэй холбоотой бодлогыг боловсруулах чиг үүргийг улсын хэмжээнд хэрэгжүүлж байгаа бөгөөд ийнхүү тус чиг үүргийг дагнан хэрэгжүүлэх болсноор хөрөнгө оруулалтын хууль тогтоомж, бодлогын ил тод, нээлттэй, урьдчилан таамаглахуйц байдал ихсэж байна. Тухайлбал, Эдийн засаг, хөгжлийн яамнаас Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн ээлжит хэлэлцүүлгийг удаа дараа амжилттай зохион байгуулсны үр дүнд хуулийн төсөлд олон улсын байгууллага, хөгжлийн түнш, Монгол Улсад суугаа Элчин сайдын яамд, мэргэжлийн холбоод, бизнесийн зөвлөл, танхимууд, төрийн байгууллага, гадаад, дотоодын аж ахуйн нэгж, иргэдээс нийт 695 саналыг ирүүлсэн байгаагаас хөрөнгө оруулалтын хууль тогтоомж, бодлого, шийдвэр гаргалт харьцангуй нээлттэй болж байгааг харуулж байна.

Төрийн институцийн өөрчлөлтийн үр дагаврын нөлөөгөөр Монгол Улсын хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага сүүлийн хорин жилийн турш байнга өөрчлөгдөж, институцийн хувьд тогтворгүй байдалтай ажилласаар ирсэн.¹¹⁷

Хүснэгт 83. Хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан байгууллага

№	Байгууллага	Хугацаа	Чиг үүрэг
---	-------------	---------	-----------

¹¹⁴ Монгол Улс дахь Америкийн Нэгдсэн Улсын Элчин сайдын яам, Монгол Улсын 2022 оны Хөрөнгө оруулалтын орчны мэдэгдэл, <https://mn.usembassy.gov/mn/2022-investment-climate-statement-mongolia-mn/>, <https://www.state.gov/reports/2023-investment-climate-statements/mongolia/>.

¹¹⁵ Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгааны тайлан, https://cdn.greensoft.mn/uploads/users/3962/files/4_%20%D0%A5%D1%83%D1%83%D0%BB%D0%B8%D0%B9%D0%BD%20%D1%82%D3%A9%D1%81%D0%BB%D0%B8%D0%B9%D0%BD%20%D1%82%D0%B0%D0%BD%D0%B4%D0%B0%D0%BD%20%D1%81%D1%83%D0%B4%D0%B0%D0%BB%D0%B3%D0%B0%D0%B0.pdf

¹¹⁶ Мөн тэнд,

¹¹⁷ Мөн тэнд,

1	Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлаг	1996-2012	- гадаад худалдаа болон ГШХО-тай холбоотой асуудлыг бүхэлд нь хариуцах
2	Гадаадын хөрөнгө оруулалтын зохицуулалт, бүртгэлийн газар	2012-2013	- гадаад худалдаа болон гадаадын шууд хөрөнгө оруулалтай холбоотой асуудлыг цогцоор нь хариуцах, гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлагийн чиг үүргээс экспорт болон жижиг, дунд үйлдвэрийг дэмжих үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтыг дэмжих чиг үүрэг нь Эдийн засгийн хөгжлийн яаманд шилжсэн.
3	Инвест Монголиа агентлаг (Хөрөнгө оруулалтын газар)	2013-2016	- хөрөнгө оруулалтыг дэмжих, зохицуулахын зэрэгцээ татварын тогтворжуулах гэрчилгээ олгох, гэрчилгээ эзэмшигч нарын үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлсэн.
4	Үндэсний хөгжлийн газар (Хөрөнгө оруулалтын бодлого, төлөвлөлтийн газар)	2016-2021	- хөрөнгө оруулалтын цогц бодлогыг тодорхойлох, гадаадын хөрөнгө оруулалтын холбогдох бодлого, зохицуулалтыг тодорхойлон уялдааг хангах, концесс болон төр, хувийн хэвшлийн түншлэлтэй холбоотой бодлого боловсруулах
5	Эдийн засаг, хөгжлийн яам (Хөрөнгө оруулалтын бодлогын газар)	2022 оноос	- хөрөнгө оруулалтын цогц бодлогыг тодорхойлох, гадаадын хөрөнгө оруулалтын холбогдох бодлого, зохицуулалтыг тодорхойлон уялдааг хангах, концесс болон төр, хувийн хэвшлийн түншлэлтэй холбоотой бодлогыг боловсруулах
6	Эдийн засаг, хөгжлийн яамны харъяа Хөрөнгө оруулалт, худалдааны газар		- хөрөнгө оруулалтын орчныг сурталчлах, зорилтот улс, бүс нутаг, эдийн засгийн салбар, тэргүүлэх чиглэлээр хөрөнгө оруулалт татах, хөрөнгө оруулагчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, дэмжлэг үзүүлэх, худалдааны эргэлтийг сайжруулах, импортыг орлох салбарыг хамгаалах, экспортыг дэмжих, эдийн засгийн төрөлжилтийг гүнзгийрүүлэх, худалдааг хөнгөвчлөх, цахим нэг цонхны үйлчилгээ үзүүлэх, нэгдсэн мэдээллийн сан үүсгэх, дүн шинжилгээ хийх

Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Вьетнам Улс, Бүгд Найрамдах Чех Улс, Бүгд Найрамдах Казахстан Улс, Бүгд Найрамдах Чили Улсын хөрөнгө оруулалтын бодлого, хууль тогтоомжийг судалсан судалгааны тайланд дурдсанаар дээрх бүх улсад хөрөнгө оруулагчид дэмжлэг үзүүлэх, бизнесийг хөхиүлэн дэмжих бие даасан агентлаг байгуулагдаж, бүтцийн хувьд өөрчлөлтгүй, тогтвортой үйл ажиллагаа явуулах нь хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлэх оновчтой хэлбэрт тооцогдож байна. Агентлагууд нь шаардлагатай нөхцөлд өөрийн хэрэгжилт, практик туршлага, төр болон хөрөнгө оруулагчдад тулгамдаж байгаа хүндрэл бэрхшээлд үндэслэн хууль тогтоомжийн болон холбогдох дүрэм, журам зэрэг зохицуулалтад өөрчлөлт оруулах санал зөвлөмжийг боловсруулах нийтлэг эрх ба үүрэгтэй. Хөрөнгө оруулагчдыг дэмжих чиг үүрэгтэй агентлагаас гадна Чили улсад тус улсын Ерөнхийлөгчид стратегийн бодлогын зөвлөгөө өгөх сайд нарын зөвлөл хөрөнгө оруулалтын асуудлын давхар хариуцан ажилладаг. Мөн БНСУ-ын Худалдаа, хөрөнгө оруулалт хариуцсан дэд сайд, газрын дарга нар хөрөнгө оруулагч гадаадын компаниудын удирдлагууд, Худалдаа, аж үйлдвэрийн танхимын гишүүд, худалдаа, эдийн засгийн асуудал эрхэлсэн ажилтнуудтай тогтмол уулзаж, санал солилцдог байна.



Монгол Улсын хувьд 2023 оны 2 дугаар сард Хөрөнгө оруулалт, худалдааны газрыг байгуулсан бөгөөд цаашид төрийн бодлого, үйлчилгээг чанар стандартад нийцүүлэн оновчтой, хүртээмжтэй, богино хугацаанд хүргэх, хөрөнгө оруулагч, хэрэглэгчийн сэтгэл ханамжийн түвшинг нэмэгдүүлэх хөрөнгө оруулалт, худалдааны үйл ажиллагаа нэгдсэн зохион байгуулалтаар хангагдана гэж үзэж байна.

Нийслэлийн түвшинд авч үзвэл, Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар нь гадаад, дотоодын болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг нийслэлд татан оролцуулах замаар хөрөнгө оруулалтын зах зээлийг өргөжүүлэх, захиалагчийн хяналтын чанар, үр ашгийг дээшлүүлэх зорилготой¹¹⁸ ажилладаг. Ингэхдээ улс, Нийслэл, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, гадаадын зээл, тусламж болон бусад хөрөнгийн эх үүсвэрээр Нийслэл хотод хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээ, барилга байгууламжийн бүтээн байгуулалтын ажилд мэргэжлийн багтайгаар захиалагчийн хяналтыг хэрэгжүүлдэг. Ингэхдээ хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын нийслэлд татах ажлыг зохион байгуулах үндсэн чиглэлтэй ажиллах боловч хөрөнгө оруулагчийн эрхийг хамгаалах талаарх чиг үүрэг хэрэгжүүлдэггүй.

Монгол Улсад хууль тогтоомжоос бусад эрх бүхий байгууллагын (Төрийн захиргааны төв байгууллага, Нийслэлийн Засаг дарга, НИТХ зэрэг) зарим шийдвэр, тэдгээрийн төсөл англи хэл дээр орчуулагддаггүй бөгөөд хөрөнгө оруулагчдыг оролцуулсан нэгдсэн байдлаар санал, хүсэлтийг авч зөвлөгөөн зохион байгуулдаггүй гэж үзэн **5 оноо** хасах боломжтой байна.. Түүнчлэн Нийслэлийн хүрээнд хөрөнгө оруулагчдыг дэмжих, нэгдсэн мэдээллээр хангах чиг үүрэг бүхий агентлаг одоогоор байхгүй байгааг анхаарах нь зүйтэй.

3. Өмчлөх эрхэд тавигдаж буй хязгаарлалт


Монгол Улсын Үндсэн хууль болон Газрын тухай хуульд заасны дагуу гадаадын иргэн, хуулийн этгээдийн газар өмчлөх, эзэмших эрх хязгаарлагддаг талаар өмнө хэсэгт өгүүлсэн. Газрыг эс тооцвол, үл хөдлөх бусад эд хөрөнгийг гадаадын иргэн, хуулийн этгээд, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуй нэгж өмчлөх боломжтой. Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид нь барилга байгууламж, хувьцаа, газар эзэмших эрх, аж ахуйн нэгж, хөдлөх хөрөнгө зэргийг байгуулах, худалдах, шилжүүлэх, үнэт цаас болгох зэрэг эрхийг адил тэгш эдэлдэг. Монгол Улс нь гадаадын төрийн өмчит аж ахуйн нэгжээс бусад хөрөнгө оруулалтыг гадаадын иргэд эзэмших, хянахад хууль тогтоомж, зохицуулалтын хязгаарлалт тавьдаггүй.

Уул уурхайн тухай хуулиар төрөөс “стратегийн” ач холбогдолтой гэж УИХ-аас тогтоосон ашигт малтмалын ордын 50 хүртэлх хувийг эзэмших боломжийг Засгийн газарт олгодог.

Хөрөнгө оруулагчдын ажигласнаар зохицуулалтын хэт их эрх мэдэл нь хууль ёсны дагуу олгогдсон эрх, компанийн засаглалын шийдвэр, хувьцаа эзэмших зэрэг асуудлууд дээр de facto хуулийн хяналт тавих боломжийг албан тушаалтнуудад олгодог бөгөөд зарим тохиолдолд тэд хуулиар олгогдсон эрх хэмжээнээсээ гадуур дүрэм журам зохиодог гэж тэмдэглэжээ. Үүнээс гадна Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс гадаадын зарим төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн хөрөнгө оруулалтыг хориглосон ч Монгол Улсад хөрөнгө оруулалтыг шигшиж сонгох албан болон албан бус механизм байдаггүй.

¹¹⁸ Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар:Танилцуулга, <http://invest.ub.gov.mn/page/single/1>





Зээлдүүлэгчид барьцаанд тавьсан үл хөдлөх хөрөнгийг хураан авч, захиран зарцуулж болно, гэхдээ энэ үйл явц нь хуулиар шийдэгдэхдээ удаан хугацаагаар саатдаг. Үл хөдлөх хөрөнгө, барилга байгууламж, бусад үл хөдлөх барьцаагаар баталгаажсан өрийн хэрэгслийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын Үл хөдлөх хөрөнгийн газарт бүртгүүлж болно (www.burtgel.gov.mn). Хөдлөх эд хөрөнгө (автомашин, тоног төхөөрөмж, мал, авлага, бусад үнэ бүхий зүйлс)-ийг мөн Улсын бүртгэлийн ерөнхий газарт барьцаагаар бүртгүүлж болно. Хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн систем нь ерөнхийдөө найдвартай хэдий ч техникийн чадавхтай холбоотой асуудал үе үе гардаг гэж хөрөнгө оруулагчид мэдээлж байна.


2021 оны байдлаар Монгол Улсад газар эзэмшигч **486,099**, бусдын эзэмшил газрыг ашиглагч Монгол улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага **821**, газар ашиглагч **1,411** гадаадын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага байгаа бөгөөд 2020 оны үзүүлэлттэй харьцуулахад газар эзэмшигчийн тоо 25,751-аар, газар ашиглагч Монгол улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага 51-ээр, газар ашиглагч гадаадын иргэн, аж ахуйн нэгжийн тоо 147-оор тус тус өсжээ.¹¹⁹ Газар эзэмшигч, ашиглагчдыг газрын нэгдмэл сангийн ангиллаар харвал, 2021 оны жилийн эцсийн байдлаар Хөдөө аж ахуйн газарт, газар эзэмшигч 181,219, газар ашиглагч МУ-ын иргэн, ААН 187, гадаадын иргэн, ААН 17 байна. Хот тосгон бусад суурин газарт, газар эзэмшигч 296,099, газар ашиглагч МУ-ын иргэн ААН 216, гадаадын иргэн ААН 1,000 байна. Зам, шугам сүлжээний газарт, газар эзэмшигч 2896, газар ашиглагч МУ-ын иргэн ААН 30, гадаадын иргэн ААН 334 байна. Ойн сан бүхий газарт, газар эзэмшигч 4,645, газар ашиглагч МУ-ын иргэн ААН 0, гадаадын иргэн ААН 9 байна. Усны сан бүхий газарт, газар эзэмшигч 70, ашиглагч 0 байна. Улсын тусгай хэрэгцээний газарт газар эзэмшигч 1,170, газар ашиглагч МУ-ын иргэн ААН 388, гадаадын иргэн ААН 21 байна. Үүнээс дүгнэвэл, Хот суурин бусад суурины газарт, газарт эзэмшигч, ашиглагч хамгийн өндөр дүнтэй буюу нийт 270,315 байна.¹²⁰ Хэдийгээр Монгол Улс үл хөдлөх эд хөрөнгө, барилга байгууламж, үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийг сайн хийдэг боловч **ашиглах эрхийн нээлттэй бүртгэл байдаггүй учраас** хөрөнгө оруулагч нар, ялангуяа Монголын хөдөө нутагт хөрөнгө оруулалт хийх хүмүүс эрхийн зөрчил байгаа эсэхийг тодруулах боломжгүй байдаг гэж хөрөнгө оруулагчид үзэж байна.¹²¹ Гэвч Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтыг цахим хэлбэрээр түргэн, шуурхай, ил тодоор зохион байгуулах, газрын барьцаа, түрээсийн бүртгэл хийх, газрын зах зээлийн үнийн мэдээ цуглуулж нэгдсэн мэдээллийн сан бий болгох, бүтээгдэхүүн, үйлчилгээ, статистик мэдээллээр иргэд, олон нийтэд үйлчлэх, зорилгоор Газрын биржийн цахим систем [/www.mle.mn/](http://www.mle.mn/)-ийг хэрэглээнд нэвтрүүлсэн бөгөөд 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, нийслэл, дүүргийн Газрын алба, 330 сумын Газрын даамлууд үйл ажиллагаандаа ашиглаж үйлчилгээ үзүүлж байна. Мөн иргэн, хуулийн этгээд Кадастрын мэдээллийн санд баталгаажсан мэдээллээс өөрийн өмчилж, эзэмшиж буй газраа худалдах, түрээслэх зар мэдээллээ тус системд байршуулж бусдад арилжаалах, түрээслэх боломжийг бүрдүүлсэн бөгөөд эрхийн зөрчилгүй газарт хөрөнгө оруулалт хийх боломжтой болсон.¹²² Дээрх системийг хөрөнгө оруулагчдад таниулах, хөрөнгө

¹¹⁹ Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар, “Газрын эрхийн бүртгэлийн тайлан”, УБ, 2022.

¹²⁰ Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар, “Газрын эрхийн бүртгэлийн тайлан”, УБ, 2022.

¹²¹ Монгол Улс дахь Америкийн Нэгдсэн Улсын Элчин сайдын яам, Монгол Улсын 2022 оны Хөрөнгө оруулалтын орчны мэдэгдэл, <https://mn.usembassy.gov/mn/2022-investment-climate-statement-mongolia-mn/>, <https://www.state.gov/reports/2023-investment-climate-statements/mongolia/>.

¹²² Газрын биржийн гарын авлага, <http://land.ub.gov.mn/blog/PublicService/ImprovePublicService/LandExchange/1/1>



оруулагчдын хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн зарим хөгжүүлэлтийг хийх нь үр дүнтэй байж болох юм.

Өмнөх хэсэгт дурдсанаар гадаадын иргэн, хуулийн этгээдэд газрыг гагцхүү ашиглуулах боломжтойгоор зохицуулсан нь Монгол Улсын иргэний нэр дээрх эзэмших эрхийн гэрчилгээтэй газар эсхүл түүний өмчлөлийн газрыг далд байдлаар ашиглах, барилга байгууламж барих, цаашлаад барилга байгууламжийн өмчлөгч, газрын өмчлөгч эсхүл эзэмшигч нарын хооронд маргаан үүсэх тохиолдлууд гарсаар байна. Газрын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6-д газар эзэмшигч нь газар эзэмшүүлэх тухай шийдвэр гаргасан этгээдийн зөвшөөрөлтэйгөөр тухайн газраа бүгдийг нь буюу зарим хэсгийг бусдад ашиглуулж болно гэж зааснаас үүдэн гадаад иргэн, хуулийн этгээдэд газар ашиглуулахаар харилцан тохиролцож хийсэн гэрээг хүчин төгөлдөр бус буюу эрх бүхий этгээдийн зөвшөөрөлгүй хийсэн хэлцэл гэж үзсэн нь тохиолдол бий.¹²³

Монгол Улсын иргэн барилга байгууламжийн өмчлөгч болон газрын эзэмших гэрчилгээтэй этгээдийн хооронд үүссэн маргааныг шүүхээс шийдвэрлэхдээ төрийн болон иргэний хувийн өмчийн газрын харилцаанд өмчийн эрх зүйн суурь ойлголтууд нэгдмэл байх учиртай бөгөөд энэ үүднээс эзэмшил хууль ёсоор үүсэхээс гадна шударгаар үүсэх иргэний эрх зүйн зохицуулалтыг төрийн өмчийн газрын харилцаанд ч баримтлах нь зүйтэй гэж үзэн, газар эзэмших эрхийг бүртгүүлээгүй боловч шударгаар эзэмших эрхийг олж авсан этгээдийн эрх ашгийг хамгаалж байна. Гэвч Монгол Улсын Үндсэн хууль болон Газрын тухай хуульд гадаадын иргэн, хуулийн этгээдийн газар эзэмших эрхийн хязгаарлалтыг тусгайлан заасан тул энэ төрлийн гадаад элемент бүхий харилцаанд гадаадын хөрөнгө оруулагчийн эрхийг хэрхэн хамгаалах талаарх ойлголт тодорхой болоогүй байна.

Түүнчлэн аймгийн Засаг даргаас “эрхийн гэрчилгээг шилжүүлэн авч байгаа этгээд нь уг эрхийн гэрчилгээг эзэмших эрхтэй эсэх”-ийг тодруулаагүйгээс гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж болох компанид газрыг эзэмшүүлэхээр шийдвэрлэсэн нь хууль зөрчсөн гэж шүүх үзэж, тус шийдвэрийг хүчингүй болгосон зэрэг маргаанаас үзэхэд дээрх төрлийн шийдвэрийг анхнаасаа гаргаж хөрөнгө оруулагчид хууль ёсны итгэл төрүүлсэн боловч эсрэгээр шийдвэрлэсэн нь хэдийгээр Монгол Улсын хууль тогтоомжид нийцэх боловч гадаадын иргэн, хуулийн этгээдийн ашиг сонирхолд сөргөөр нөлөөлж, улмаар тухайн аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд гэнэтийн цохилт үзүүлж болохоор байгаа Засаг дарга нар анхаарч газар ашиглах эрхийн гэрчилгээг олгохдоо хариуцлагатай хандах нь зүйтэй.Түүнчлэн энэ төрлийн маргаан, зөрчлийг арилгахад Нийслэлийн Засаг дарга, Нийслэлийн газар зохион байгуулалтын алба чухал үүрэг гүйцэтгэхээр байна.

Төрийн өмчийн газрын хувьд газрын маргааныг шүүхээр шийдвэрлүүлэхээс өмнө аймаг, нийслэлийн Засаг даргад урьдчилан байдлаар маргаанаа шийдвэрлүүлэх тогтолцоог Газрын тухай хуульд тусгасан Нийслэлийн. Өөрөөр хэлбэл, газар ашиглах эрхийн гэрчилгээг олгохтой зэрэгцэн газрын эрхийн маргаанд Засаг дарга чухал үүрэг гүйцэтгэдэг. Газрын тухай хуульд зааснаар Нийслэлийн Засаг дарга нь газартай холбоотой дараах маргааныг хянан шийдвэрлэх бүрэн эрхтэй. Үүнд:

¹²³ Шүүхийн шийдвэрийн цахим сан, https://shuukh.mn/single_case/7697?start_date=&end_date=&id=1&court_cat=3&bb=1

60.1.Газартай холбогдон үүссэн дараах маргааныг дор дурдсан байгууллага, албан тушаалтан шийдвэрлэнэ:

60.1.1.газар эзэмших, ашиглах талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллага болон Засаг даргын хооронд үүссэн маргааныг тухайн Засаг даргын дээд шатны Засаг дарга;

60.1.2.газар эзэмших, ашиглах талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүссэн маргаан, газар ашиглах гэрээний нөхцөл, болзлын талаар газар эзэмшигч ба ашиглагчийн хооронд үүссэн маргааныг зохих шатны Засаг дарга;

Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага газар ашиглаж байгаа гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, олон улсын байгууллагын төлөөлөгчийн газар, гадаад улсын хуулийн этгээд, гадаадын иргэн харьяалалгүй хүн нь газар эзэмшүүлэх, ашиглуулах гэрээний дагуу газрын нэгдмэл сангийн ангилалд хамаарах болон тусгай хэрэгцээний газарт төлөх төлбөр нь газрын төлбөрт хамаарна. Газрын төлбөр нь аймаг, нийслэлийн татварын төсвийн орлогод ордог бөгөөд газрын төлбөртэй холбоотой маргааныг мөн Засаг даргад хандан урьдчилан шийдвэрлүүлж болохоор хуульд заасан. Иймд Нийслэл хотын түвшинд гадаадын хөрөнгө оруулагчдын өмчлөх эрхийг хангахын тулд газар эзэмших гэрчилгээг шилжүүлэх, газар ашиглах гэрчилгээг олгоходоо хуульд заасан үндэслэл журмыг баримтлах, хуульд заасан хугацаанд шийдвэрлэх, гадаадын хөрөнгө оруулагчаас гаргасан үндэслэлгүй хүсэлт, гомдлын талаарх урьдчилсан дүгнэлтийг шуурхай өгч байх, газрын төлбөртэй холбогдон үүссэн маргааныг эвийн журмаар шийдвэрлэх зэргээр хамтарч ажиллах нь зүйтэй байна.

Гадаад хөрөнгө оруулагч газрыг гагцхүү ашиглуулах боломжтойгоор зохицуулсан нь Монгол Улсын иргэний нэр дээрх эзэмших эрхийн гэрчилгээтэй газар эсхүл түүний өмчлөлийн газрыг далд байдлаар ашиглах, барилга байгууламж барих, цаашлаад барилга байгууламжийн өмчлөгч, газрын өмчлөгч эсхүл эзэмшигч нарын хооронд маргаан үүсэх шалтгаан нөхцөл болдог тул Газрын тухай хуулийн зохицуулалтыг сайжруулах шаардлага байгаа нь уг үзүүлэлтийн хүрээнд **10 оноо хасах** үндэслэл болно гэж үзлээ.


4. Эдийн засгийн секторт тавигдах хязгаарлалт

Өмнө дурдсанаар хөрөнгө оруулагч хамгийн өндөр өгөөжтэй гэж үзсэн салбар, үйл ажиллагаанд аливаа хязгаарлалтгүйгээр хөрөнгө оруулж өндөр өгөөжтэй ажиллах боломжтой байх, хууль ёсны үйл ажиллагааны үр дүнд олсон үр өгөөжийг шуурхай бөгөөд аливаа саадгүйгээр татан авч чаддаг байх чадамжаар хөрөнгө оруулалтын эрх чөлөөг хэмжих чиг хандлага зонхилдог. Эндээс үзвэл хөрөнгө оруулалтын эрх чөлөөг үнэлэхэд баримтлах дараагийн нэгэн чухал үзүүлэлт нь эдийн засгийн секторын хувьд тавигдах хязгаарлалт юм. Идеал улсад хөрөнгө оруулагч нь эдийн засгийн хамгийн үр өгөөжтэй секторыг сонгон үйл ажиллагаагаа явуулах эрх чөлөөтэй байна гэсэн үг юм.

Монгол Улсын Хөрөнгө оруулалтын тухай хуульд эдийн засгийн секторын хүрээнд хязгаарлалт тавигдсан ч гагцхүү гадаадын төрийн өмчит компанид үйлчлэхээр тусгасан байдаг .. Тодруулбал, тус хуулийн 21.1-д дараах салбарт үйл ажиллагаа эрхлэх Монгол Улсын хуулийн этгээдийн нийт гаргасан хувьцааны 33 буюу түүнээс дээш хувийг гадаадын төрийн өмчит хуулийн этгээд эзэмших тохиолдолд зөвшөөрөл авахаар тусгасан. Үүнд:

1. уул уурхай;
2. банк, санхүү;
3. хэвлэл, мэдээлэл, харилцаа холбоо.





Гадаадын хөрөнгө оруулагч дээрхээс бусад бүх салбарт хөрөнгө оруулж, үйл ажиллагаа эрхлэхдээ чөлөөтэй сонголт хийж болох бөгөөд Зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу холбогдох эрх бүхий этгээдээс зөвшөөрөл авна. Тухайлбал, даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Санхүүгийн зохицуулах хорооноос гэх мэт.

Засгийн газар ил тод байдалд түлхэц болох, эсвэл хөрөнгө оруулагчид болон хэрэглэгчдэд чанартай ба чанар муутай хөрөнгө оруулалтыг ялгахад нь туслахын тулд компаниудын байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-ын мэдээллийг ил тод байлгахыг дэмжиж, шаарддаггүй. Гэсэн хэдий ч 2022 онд хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн Компанийн засаглалын кодексын дагуу хувьцаат компаниудаас гадна даатгал, хөрөнгө оруулалтын сан, итгэмжлэлийн үйлчилгээ үзүүлдэг хаалттай компаниуд байгаль орчин, нийгэм, засаглалын мэдээллийг нийтэд ил тод мэдээлж эхэлж байгаа. Хөрөнгө оруулагчдын хамгаалах үүднээс Засгийн газар дижитал жетон, криптовалюта зэрэг өндөр эрсдэлтэй үнэт цаасанд хөрөнгө оруулах эрхийг мэргэжлийн хөрөнгө оруулагчид болон бусад өндөр орлоготой хувь хүмүүст хязгаарладаг бөгөөд виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэх харилцааг хуулиар зохицуулан, шаардлага хангасан этгээдэд тусгай зөвшөөрөл олгох тогтолцоог бүрдүүлээд байна.

Нийслэлийн түвшинд авч үзвэл, Зөвшөөрлийн тухай хуульд зааснаар аймаг, нийслэлийн Засаг дарга дараах үйл ажиллагаанд зөвшөөрөл өгөх бүрэн эрхтэй. Үүнд:

1. энгийн хог хаягдлын төвлөрсөн цэгийн болон хог хаягдлыг сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхлэх
2. тусгай зориулалтаар агнуурын амьтныг агнах, барих
3. цэцэрлэгийн үйл ажиллагаа эрхлэх
4. ерөнхий боловсролын сургууль байгуулах
5. ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газрын хэвлийг ашиглуулах
6. түгээмэл тархацтай ашигт малтмал хайх
7. түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах
8. согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх
9. уламжлалт технологиор согтууруулах ундаа үйлдвэрлэх
10. барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх
11. барилга байгууламж барих, өргөтгөх, шугам сүлжээнд холболт хийх зэрэг зайлшгүй шаардлагаар төрийн өмчийн авто замыг сэтлэх, орц, гарц гаргах

Түүнчлэн Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 8.1 дэх хэсэгт зааснаар Нийслэл нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хувьд Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24.1-д зааснаас гадна нийслэл хот болохын хувьд энэ хуульд заасан дараах тусгай болон бусад чиг үүргийг хэрэгжүүлнэ.

1. Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Улсын дээд шүүх, Үндсэн хуулийн цэц, төрийн захиргааны болон төрийн бусад байгууллага, гадаад улсын Дипломат төлөөлөгчийн газар, олон улсын байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад дэмжлэг үзүүлэх;
2. хуульд өөрөөр заагаагүй бол үндэсний болон олон улсын хэмжээний баяр наадам, хурал, урлаг, спортын болон бусад арга хэмжээг зохион байгуулах;
3. олон улсын зорчигч болон ачаа тээвэр, логистикийн үйл ажиллагааны удирдлага, зохицуулалт;
4. нийслэл дэх үндэсний хэмжээний түүх, соёлын дурсгалт газрын хадгалалт, хамгаалалт;




5. нийслэлийн нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх олон улсын чанартай авто зам барих, түүний арчлалт, засвар, холбогдох үйл ажиллагаа;
6. нийслэл хотын хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт;
7. энэ хуульд заасан нийслэл хотын тусгай чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай барилга байгууламж, авто зам, нийтийн эзэмшлийн зам талбай, ногоон байгууламж, гэрэлтүүлэг болон бусад дэд бүтцийн засвар, арчлалт, цэвэрлэгээ, үйлчилгээ, хамгаалалт.
8. нийслэлийг хөгжүүлэх сангийн менежмент;
9. нийслэлийн хүний нөөцийн бодлого, төлөвлөлт, түүний хэрэгжилт;
10. орчны аюулгүй байдал;
11. хүнсний хангамж, хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн хөтөлбөр, нийтлэг зохицуулалт;
12. хот, суурин газрын дахин төлөвлөлт;
13. нийслэлийн авто замын арчлалт, засвар, төлөвлөлт, хяналт;
14. хүн амын ундны болон ахуйн хэрэглээний төвлөрсөн усан хангамж;
15. нийслэлийн ус, дулааны төвлөрсөн бус инженерийн хангамж;
16. сууц өмчлөгчдийн холбооны үйл ажиллагааны зохицуулалт, хяналт;
17. гадна болон явуулын зар сурталчилгааны зохицуулалт, хяналт;
18. авто замын түгжрэлийг бууруулах, нийтийн тээврийн үйлчилгээний төрөл, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, нийслэл хотод тулгамдсан бусад асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн төсөл, арга хэмжээ;
19. гадаадын зээл, тусламжаар нийслэлд хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний нийслэлийн хариуцах хөрөнгө, зээлийн хүүгийн төлбөр;
20. нийслэлийн нутаг дэвсгэр дэх голын хамгаалалт, тохижилт;
21. нийслэлийн нутаг дэвсгэр дэх дархан цаазат болон байгалийн цогцолбор, нөөц, дурсгалт газрыг иргэдийн аялах, амрах орчныг бүрдүүлэх зорилгоор тохижуулах, хамгаалах төсөл, арга хэмжээ;
22. хотын өөрийн мэдлийн орон сууцны ашиглалт, хуваарилалт.

Дээр заасанчлан аймаг, нийслэлийн Засаг дарга нь хот суурин газрын дахин төлөвлөлтөд чухал үүрэг гүйцэтгэдэг. Үүнд:

1. Хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, газар зохион байгуулалтын төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг үндэслэн төсөл санаачлах, боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах
2. Улс, орон нутгийн төсвөөр хэрэгжих төсөл, хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэх
3. Төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах
4. Төсөл хэрэгжүүлэх гурван талт гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтийг хангуулах
5. Төсөл, хөтөлбөр, төлөвлөгөөг нийтэд сурталчлах, мэдээлэх, санал, гомдол хүлээн авах замаар олон нийтийн оролцоог хангах ажлыг зохион байгуулах
6. Сэргээн босголтын үйл ажиллагааг Засгийн газрын шийдвэрээр хэрэгжүүлэх
7. Газар, үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгч иргэн, хуулийн этгээдтэй аймаг, нийслэлийн Засаг дарга гурван талт гэрээ байгуулах.

Засаг даргаас дээр заасан чиг үүргийг хангалттай биелүүлээгүйгээс хот суурин газрыг дахин төлөвлөх харилцаанд төсөл хэрэгжүүлэгч аж ахуй нэгжүүд хохирсон тохиолдлууд олон байгааг анхаарах нь зүйтэй.¹²⁴ Тухайлбал, төрөөс инженер шугам сүлжээн асуудлыг шийдэж өгөөгүйгээс төсөл удаашрах тохиолдол олон гардаг байна.

¹²⁴ Бизнес ба хүний эрх, “Хууль зүйн үндэсний хүрээлэн”, Уб, 2023.



Иймд Нийслэлийн Засаг дарга, түүний харъяа агентлагууд дээрх төрлийн үйл ажиллагаанд зөвшөөрөл олгох, хяналт шалгалт хэрэгжүүлэхдээ гадаадын хөрөнгө оруулагчдыг аливаа байдлаар ялгаварлах, илүү хязгаарлалт, шаардлага тавихаас сэргийлж, дээрх төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуй нэгжүүдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг аль болох багаар хөндөх үүднээс эрх, ашиг нь хөндөгдөж буй этгээдүүдэд хандан уулзалт, зөвлөгөөн хийх, тэдгээрийн саналыг авах зэргээр үйл ажиллагаагаа нийтэд чиглүүлэх бодлого баримтлах нь зүйтэй.

Гадаад хөрөнгө оруулагчтай холбоотойгоор тавигдах эдийн засгийн секторын хязгаарлалт байдаг хэдий ч харьцангуй бага тул **5 оноо** хасах нь зүйтэй гэж үзлээ..

5. Шударга, бүрэн нөхөн төлбөргүйгээр дайчлан авдаг эсэх

Үндсэн хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална.” Уг заалтын 3 дахь хэсэгт “Өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно.” гэж зааснаар Монгол Улсын иргэн өмч өмчлөх, эзэмших, захиран зарцуулах эрхтэй болсон бөгөөд энэхүү эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно. Үүнээс гадна Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Төр газрын эзэнд газартай нь холбогдсон үүрэг хүлээлгэх, улсын тусгай хэрэгцээг үндэслэн нөхөх олговортойгоор газрыг солих буюу эргүүлэн авах, уг газрыг хүн амын эрүүл мэнд, байгаль хамгаалал, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд харшаар ашиглавал хураан авч болно.” гэж заан хувийн өмчийн хөдлөх, үл хөдлөх хөрөнгийг “Улсын тусгай хэрэгцээ”-нд үндэслэн “нөхөх олговор”-ыг олгох үндсэн дээр газрыг эргүүлэн авах боломжтой.¹²⁵

“Улсын тусгай хэрэгцээ” гэдэгт улсын тусгай хамгаалалтын газар, улсын хилийн зурвас, улсын батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах зориулалтаар олгосон газар, гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, олон улсын байгууллагын төлөөлөгчийн газарт олгосон газар, шинжлэх ухаан, технологийн сорилт, туршилт болон байгаль орчин, цаг агаарын төлөв байдлын байнгын ажиглалтын талбай, аймаг дундын отрын бэлчээр, улсын тэжээлийн сангийн хадлангийн талбай, бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу хайгуулын зориулалтаар ашиглах газрын тосны гэрээт талбай, чөлөөт бүсийн газар, цөмийн төхөөрөмж барих, ашиглах зориулалтаар олгосон газар, бичил уурхайн зориулалтаар олгосон газар, хилийн боомтын бүс, үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалт, дэд бүтцийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх газар, аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламж барих газар, хамгаалалтын бүс тогтоосон түүх, соёлын дурсгалт газар, үйлдвэрлэл, технологийн паркийн газрыг ойлгоно (Газрын тухай хуулийн 16 дугаар зүйл).

Мөн Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.13 дахь хэсэгт “хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно.” хэмээж өмчийн олон хэлбэрийг хүлээн зөвшөөрч иргэний өмч өмчлөх эрхийг баталгаажуулсан байна. Ийнхүү өмчийн хамгаалалтыг Үндсэн хуульд оруулсан нь төрийн дур зоргын шинжтэй албадлагаас иргэний эрхийг хамгаалж, эрх чөлөөгөө бүрэн эдлэх эдийн засгийн үндсийг бүрдүүлэхтэй холбоотой.¹²⁶

¹²⁵ Д.Гангабаатар, “Хот суурин газрын дахин төлөвлөлт ба шударга нөхөх олговор”, Эмнести интернэшнл, УБ, 2017, 84 дэх тал.

¹²⁶ Д.Гангабаатар, “Хувийн өмчийн газрыг шууд бусаар дайчлан авахаас хамгаалах Үндсэн хуулийн зохицуулалт”, МУИС-ийн Эрх зүйн сэтгүүл 2015 № 1, 65 дахь тал.



Нөхөн олговрын талаар эрдэмтэн, судлаачдын тайлбарт “Хувийн өмчийн газрыг солих буюу эргүүлэн авах тохиолдолд нөхөх олговрыг улсаас төлөх ёстой бөгөөд түүнийг уг газрыг авахаас өмнө бүрэн хэмжээнд олгосон байх ёстой. Зайлшгүй шаардлагаар газрыг улс эргүүлэн авч байгаа бол газраа өгсөнтэй холбогдох зардлыг газрын үнэлгээний хамт бүрэн хэмжээгээр төлөх учиртай¹²⁷” гэжээ. Уг тайлбараас харахад нөхөн олговор нь **урьдчилан олгосон байх**, тухайн газрыг эргүүлэн өгснөөс үүдэн гарах **зардал, газрын үнэ** гэсэн гурван төрлийн зүйлээс бүрдэж байна. Дэлхий нийтэд нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийг дайчлан авахад нөхөн олговор нь шударга байх ёстой гэсэн үзэл санаа төлөвшжээ¹²⁸. Нөхөх олговор шударга байх ойлголт нь өмчлөгч нь тухайн газрыг дайчлан авсны дараа ямар нэгэн **гомдол, хохиролгүй** тухайн эд хөрөнгийг **зах зээлийн шударга үнэлгээгээр** тооцож нөхөх олговрыг **урьдчилан авсан байх** явдал гэж үзсэн байна¹²⁹.

Монгол Улсын Үндсэн хуулиар хувь хүний өмчлөх ба бусад үүсмэл эрхийг баталгаажуулж өгсөн бөгөөд Монгол Улсын хууль тогтоомжоор төр, засгаас аливаа өмч хөрөнгийг зохих ёсны, зах зээлд суурилсан нөхөн төлбөр төлөхгүйгээр хурааж авахыг хориглодог. Хөрөнгө оруулагчид зарчмын хувьд ийнхүү хурааж авах тал дээр бага зэрэг санал зөрж буйгаа илэрхийлдэг бөгөөд улс, аймаг, орон нутгийн засаг захиргааны байгууллагуудын эрх мэдлийг тодорхой зааж, ялгаж өгөөгүйгээс өмч хөрөнгө, ашиглалтын эрхээ алдахад хүрсэн бодит тохиолдол гарсныг хэлж байна. Жишээ нь, Ашигт малтмалын тухай хуульд газар ашиглах зөвшөөрөл, тусгай зориулалтын эрх олгох чиглэлээр сум, аймаг орон нутаг, улсын эрх мэдлийн зааг ялгааг тодорхой заагаагүй. Төрийн байгууллагуудын янз бүрийн түвшин дэх эрх мэдлийн тодорхой бус байдал, дүрэм журмыг хэрэглэх, тайлбарлах практик харилцан адилгүй байгаа зэрэгтэй тулгарсан хөрөнгө оруулагчид хуулиар олгогдсон эрхээ бүрэн хэрэгжүүлэх боломжгүй болж магадгүй юм.

Орон нутгийн хувьд Газрын тухай хуулийн 16.2 дахь хэсэгт зааснаар Аймаг, сум, нийслэл, дүүрэг дараах зориулалтаар өөрийн эрх хэмжээнд нийцүүлэн газрыг орон нутгийн тусгай хэрэгцээнд авч болдог. Үүнд:

1. улсын тусгай хамгаалалттай газар;
2. аймаг дундын отрын бэлчээр;
3. улсын тэжээлийн сангийн хадлангийн талбай;
4. бичил уурхайн зориулалтаар олгосон газар;
5. үйлдвэрлэл, технологийн паркийн газар.


Хуульд заасан үндэслэлээр орон нутгийн хэрэгцээнд газрыг дайчлах, чөлөөлөх тохиолдол олон. Тухайлбал, Нийслэлд 2019 онд 1060, 2020 онд 360, 2021 онд 135, 2022 онд 828 нэгж талбарыг нөхөн олговортойгоор чөлөөлсөн байна¹³⁰.

¹²⁷ “Хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авах төрийн салшгүй бүрэн эрх”, Black’s law dictionary, deluxe ninth edition, Bryan A.Garner (ed), 2009 Thomas Reuters, 601 дэх тал.

¹²⁸ “Нийтийн болон хувийн өмчийн эрх зүйн тулгамдсан асуудал”, УБ, 2012, Соёмбо принтинг, 41 дэх тал.

¹²⁹ “Хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авах төрийн салшгүй бүрэн эрх”, Black’s law dictionary, deluxe ninth edition, Bryan A.Garner (ed), 2009 Thomas Reuters, 322 дахь тал.

¹³⁰ Нийслэлийн газар зохион байгуулалтын албаны мэдээлэл, <http://land.ub.gov.mn/blog/Transparency/TransparencyOfActivities/ActivityReport/1/1>



Өмч хөрөнгийг хураан авах зарим тохиолдол нь гуравдагч этгээдэд хамаарах эрүүгийн хэргийн шүүх хуралдааны дараах шүүхийн албадан хураах ажиллагаа байдаг бөгөөд хөрөнгө оруулагчдыг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд бүрэн оролцохыг хориглох боловч зөвхөн “иргэний хариуцагч”-аар ирэхийг шаарддаг. Эдгээр тохиолдолд төрийн албан тушаалтнууд авлигын хэрэгт буруутгагдан, өмч хөрөнгө, тусгай зөвшөөрлийг хууль бусаар олж авсан эсэхийг нь шүүхээр тогтоолгүйгээр эрүүгийн хэрэгт буруутгагдаж буй этгээдээс давуу эрх авсан тул иргэний хариуцагчийн эзэмшиж буй тусгай зөвшөөрөл, өмч хөрөнгийг хураах, эсвэл татварын торгууль, шийтгэл төлөх үүргийг түүнд оногдуулдаг.

Татварын маргааныг шийдвэрлэх үйл явц нь өмчийг шууд бусаар хураан авах арга хэлбэр болсон гэж бизнес эрхлэгчид үзэж байна. 2020 онд Татварын тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр татварын асуудлаар маргаан үүсгэхийн тулд маргалдагч тал урьдчилсан болзолт нөхцөлийн дагуу маргаантай татварын тооцоог бүхэлд нь эскроу буюу дундын дансанд байршуулах шаардлагыг татварын байцаагч тавих эрхтэй болсон. Энэ нь хэрэв маргаан шийдвэрлэх ажиллагааг ашиглавал хэт өндөр өртөгтэй, хураалгахад хүргэдэг шийтгэл маягийн татварын хяналт шалгалтыг явуулахад түлхэц болж байна.

Хуульд шударга нөхөн олговортойгоор өмчийг дайчлан авах талаар тусгасан ч Нийслэлийн газар зохион байгуулалтын албатай гэрээ байгуулсан мэргэжлийн үнэлгээчнээр үнэлүүлэхээс¹³¹ шударга нөхөн олговрыг тооцох аргачлал, журам тодорхой байдаггүйгээс дээрх зохицуулалтын хэрэгжилт нэг мөр болоогүй байдлаас шалтгаалж, уг үзүүлэлтийн хүрээнд 15 оноо хасах нь зүйтэй гэж үзлээ.

6. Гадаад валютын урсгалд тавигдах хязгаарлалт

Төвбанк /Монголбанк/-ны тухай хуулийн 22.2 дугаар зүйлд “Монголбанк гадаад валюттай харьцах төгрөгийн ханшийн бодлогыг тодорхойлж, хэрэгжүүлэхдээ ханш нь чөлөөтэй бөгөөд бодитой байх, төгрөгийн тогтвортой байдал болон үндэсний эдийн засгийн тэнцвэртэй хөгжлийг хангах зарчмыг баримтална.” гэжээ.

Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт-төгрөг (MNT) нь гадаад орны олон валют руу хөрвөх бүрэн чадвартай байдаг. Зах зээлээс үүдэлтэй гадаад валютын нөөцийн хомсдолд зарим тохиолдолд орж буйгаас бусдаар мөнгөн хөрөнгө хөрвүүлэх, шилжүүлэхэд асуудал тулгардаггүй .

Монгол Улсын Валютын зохицуулалтын тухай хуульд Монгол Банкнаас өөрөөр тогтоогүй бол дотоодын гүйлгээнд төгрөгийг ашиглахыг шаарддаг. Уг зохицуулалтаар бөөний болон жижиглэнгийн үнийг ямар нэгэн байдлаар, нягтлан бодох бүртгэлийн дотоод практик байсан ч гадаад валютаар илэрхийлэх, төгрөгөөс бусад валютаар үнийг илэрхийлэх буюу индексжүүлэхийг хориглодог. Валютын эрсдэлийг бууруулахын тулд үнийн тааламжгүй өөрчлөлтийн эрсдэлээс хамгаалах механизмууд нь жижиг зах зээлд ерөнхийдөө боломжгүй байдаг. Худалдааг хөнгөвчлөх зорилгоор олон төрлийн валютаар хийсэн аккредитив авах боломжтой. Засгийн газар заримдаа бусад валютаар шууд сольж болохгүй бараа, үйлчилгээний төлбөрийг векселээр төлдөг.

¹³¹ Нийслэлийн газар зохион байгуулалтын албаны мэдээлэл, <http://land.ub.gov.mn/blog/PublicService/OrganizationService/AboutLandAcquisition/1/1>



Бизнес эрхлэгчид хөрөнгө оруулалтын өгөөжийг гуйвуулах, гадаадаас орж ирэх хөрөнгийг хүлээн авахад төрийн зүгээс үүдэлтэй саатал гардаггүй гэж мэдээлдэг боловч корреспондент банкны харилцаанд тулгардаг бэрхшээлүүд нь мөнгөн гуйвуулгыг заримдаа удаашруулдаг¹³². Ихэнх шилжүүлэг нь цөөн хэдэн хоногоос нэг долоо хоног дотор хийгддэг. Гэсэн хэдий ч валютын, голдуу АНУ-ын долларын, хомсдол хааяа үүсдэг ба үүнээс үүдэн арилжааны банкууд болон Төв банк шилжүүлгийг түр хугацаагаар хязгаарлахад хүрдэг¹³³. Хэдийгээр дээр дурдсан хүндрэл, бэрхшээлүүд гардаг ч Засгийн газраас валют чөлөөтэй хөрвөх бодлогыг баримталдаг бөгөөд валютын урсгалд тавигдах хязгаарлалт байдаггүй тул энэ үзүүлэлтийн хүрээнд **оноог хасахгүй** гэж дүгнэлээ.

7. Хөрөнгө, орлогыг гадаад улсад саадгүй гаргах

Тус хүчин зүйлийн хүрээнд Хөрөнгө орлогыг гадаад улсад гаргах боломжгүй, бүх гүйлгээнд төрөөс зөвшөөрөл олгодог бол 25 оноо, Хөрөнгө, орлогыг шилжүүлэхэд зөвшөөрөл шаардлагатай бөгөөд зарим хязгаарлалт тавигддаг бол 15 оноо, харин зарим тохиолдолд хязгаарлалт тавигддаг боловч ихэнх гүйлгээ зөвшөөрөгдсөн бол 5 оноо хасагдана.

Монгол Улсын Хөрөнгө оруулалтын тухай хуулийн дагуу хөрөнгө оруулагч нь Монгол Улсын нутаг дэвсгэрт татвар төлөх үүргээ бүрэн биелүүлсний үндсэн дээр доор дурдсан өөрт ногдох хөрөнгө, орлогыг гадаад улсад саадгүй гаргах эрхтэй байдаг. Үүнд:

1. Үйл ажиллагаанаас олсон ашиг, ногдол ашиг;
2. Оюуны өмчийг бусдад ашиглуулсан эрхийн шимтгэл, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсний төлбөр;
3. Гадаад улсаас олгосон зээлийн үндсэн төлбөр болон хүү;
4. Аж ахуйн нэгжийг татан буулгасны дараа өөрт ногдох хөрөнгө;
5. Хуулийн хүрээнд олсон буюу өмчилж байгаа бусад хөрөнгө.

Мөн гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд хувьцаагаа Монголын зах зээлд зарж борлуулах үүрэг хүлээдэггүй. Монгол Улс ОУВС-гийн дүрмийн VIII заалтыг даган мөрдөж олон улсын төлбөр, гуйвуулгад хязгаарлалт тавьдаггүй ч хөрөнгийн урсгалд цөөн тооны хязгаарлалт тавьдаг. Гэхдээ Монгол улсад хөрөнгийн зах зээл төдийнлөн сайн хөгжөөгүй хэвээр байгаа тул уламжлалт зах зээл дээр фьючерс арилжаа, дериватив арилжаа хийх чадвар хомс байна. Монголын хөрөнгийн бирж (http://www.mse.mn/en/aboutus_en) нь дотоодын хөрөнгө оруулалт, багцын хөрөнгө оруулалт явагддаг үндсэн газар боловч санхүүгийн технологийн компаниуд виртуал хөрөнгийг ашиглан хөрөнгө оруулалтыг дэмжиж эхэлсэн байна. Гадаадын хөрөнгө оруулагчдад дотоодын зах зээлийн нөхцөлөөр зээлийг янз бүрийн хэлбэрээр олгох боломжтой байдаг байна.

Гэвч бизнесийг шинээр бүртгүүлэх хялбар дөхөм байдал нь бизнесийг татан буулгахтай харьцуулахад харилцан адилгүй байна. Гадаадын хөрөнгө оруулагчид болон хуульчдийн мэдээлж буйгаар хүнд суртал, шүүхийн үйл явц доод тал нь 18-24 сар үргэлжилдэг гэжээ. Өөрөөр хэлбэл, компани татан буугдах тохиолдолд хөрөнгө оруулагчид ногдох хөрөнгө, орлогоо авах хугацаа нь харьцангуй урт байдаг байна. Хэдийгээр хууль

¹³² Монгол Улс дахь Америкийн Нэгдсэн Улсын Элчин сайдын яам, Монгол Улсын 2022 оны Хөрөнгө оруулалтын орчны мэдэгдэл, <https://mn.usembassy.gov/mn/2022-investment-climate-statement-mongolia-mn/>, <https://www.state.gov/reports/2023-investment-climate-statements/mongolia/>.

¹³³ Мөн тэнд.



тогтоомжийн хүрээнд тавигдах хязгаарлалтгүй боловч компанийг татан буулгах журмыг сайжруулах шаардлага байна гэж үзэж, уг шалгуур үзүүлэлтийн хувьд **5 оноо** хасах нь зүйтэй гэж үзлээ.

6.4. СУДАЛГААНЫ ДАТА БОЛОВСРУУЛАЛТ, ИНДЕКСЖҮҮЛЭХ

Хөрөнгө оруулалтын орчин тогтвортой, чөлөөтэй байх нь улс орны бизнесийн үйл ажиллагаа, зах зээлийг төрөлжүүлэн өргөжүүлж, улмаар ажлын байрыг нэмэгдүүлэх, үндэсний дотоод нийт бүтээгдэхүүнийг өсгөх зэрэг эерэг үр дүнд хүргэдэг.

Хөрөнгө оруулагчдад ялгавартай хандах, гадаадын хөрөнгө оруулалтад үндэслэлгүйгээр аливаа хязгаарлалт тогтоох, хөрөнгө оруулах боломжийг сектороор хязгаарлах, хөрөнгийн болон валютын урсгалд аливаа хязгаарлалт тавих, төрөөс хууль бусаар эсхүл шударга нөхөн олговоргүйгээр хөрөнгийг дайчлах, хураан авах боломж их байх, хууль, эрх зүйн орчин тогтворгүй буюу улс төрийн шийдвэр гаргалтаас хамааралтай байх нь хөрөнгө оруулагчдын шийдвэр гаргалт, хөрөнгө оруулалтын үр өгөөжид шууд нөлөөлж, зах зээл хумигдахад хүргэдэг. Өөрөөр хэлбэл, хөрөнгө оруулагч хамгийн өндөр өгөөжтэй гэж үзсэн салбар, үйл ажиллагаанд аливаа хязгаарлалтгүйгээр хөрөнгө оруулж өндөр өгөөжтэй ажиллах боломжтой байх, хууль ёсны үйл ажиллагааны үр дүнд олсон үр өгөөжийг шуурхай бөгөөд аливаа саадгүйгээр татан авч чаддаг байх чадамжаар хөрөнгө оруулалтын эрх чөлөөг хэмжих чиг хандлага зонхилж байна.

АНУ-ын стратеги судалгааны “Heritage Foundation” хүрээлэнгээс жил бүр “Эдийн засгийн эрх чөлөөний индекс¹³⁴”-ийг эрхлэн гаргадаг бөгөөд “Хөрөнгө оруулалтын эрх чөлөө” гэх дэд индексийг багтаан хэмждэг. Тус хүрээлэнгээс дэлхийн 180 гаруй орны эдийн засгийн чөлөөт байдлыг 1995 оноос хойш уг индексээр хэмждэг. Монгол Улс 2023 онд 61.7 оноогоор 73-р байранд жагссан нь өмнөх оныхоос буурсан үзүүлэлттэй байна.¹³⁵ 2023 оны үнэлгээнд хамрагдсан 180 гаруй дундаж оноо 59.3 байсан нь сүүлийн 20 жилийн хамгийн бага үзүүлэлт байсан байна.

Нийт шалгуур үзүүлэлт тус бүрд харгалзах онооны дунджаар нийт оноог тогтоодог бөгөөд 100-80.0 бол “Чөлөөт”, 79.9-70 бол “Чөлөөт байдал давамгай”, 69.9-60 “Харьцангуй чөлөөт”, 59.9-50 бол “Чөлөөт бус байдал давамгай”, 50-аас бага бол “Чөлөөт бус” гэж ангилан авч үздэг байна. Тус онд хамгийн өндөр үзүүлэлттэй орноор Сингапур (83.9), Швейцар (83.8), Ирланд (82.0), Тайван (80.7), Шинэ Зеланд (78.9), Эстони (78.6), Люксембург (78.4), Нидерланд (78.0), Дани (77.6), Швед (77.5) улсууд тодорсон байна.¹³⁶

Хөрөнгө оруулалтын индексийн оноогоор Люксембург, Ирланд, Эстони, Нидерланд, Дани, Сингапур, Швейцар, Швед, Америк, Латви зэрэг орнууд тэргүүлж байгаа бол,


¹³⁴ Heritage foundation, Index of Economic freedom, 2023.

https://www.heritage.org/index/pdf/2023/book/2023_IndexOfEconomicFreedom_FINAL.pdf.

¹³⁵ https://www.heritage.org/index/pdf/2023/book/2023_IndexOfEconomicFreedom_FINAL.pdf

¹³⁶ Heritage foundation хүрээлэнгээс дараах тайлан, мэдээлэлд тулгуурлаж индексийг үнэлдэг байна. Үүнд: U.S. Department of State, Investment Climate Statements; Economist Intelligence Unit, Country Commerce; Office of the U.S. Trade Representative, National Trade Estimate Report on Foreign Trade Barriers; World Bank, Investing Across Borders; Organisation for Economic Co-operation and Development, Services Trade Restrictiveness Index; болон U.S. Department of Commerce, Country Commercial Guide.





Венесуэл, Туркменистан, Боливи, Хойд Солонгос, Иран, Судан зэрэг улсууд хамгийн бага оноогоор үнэлэгджээ. Монгол Улсын хувьд Хөрөнгө оруулалтын эрх чөлөө индексийн хүрээнд 2023 онд 50 оноо авсан.

Индексийг үнэлэх аргачлал, шалгуур үзүүлэлт

Өмнө дурдсан үзэл баримтлалын дагуу хөрөнгө оруулалтын эрх чөлөөний индексийг “Heritage Foundation”-ийн “Хөрөнгө оруулалтын эрх чөлөөний индекс”-ийн аргачлал, шалгуур үзүүлэлтээр хэмжиж байна. Тухайлбал, төрөөс тогтоосон ямар ч хязгаарлалтгүйгээр хөрөнгө оруулагч аливаа бизнес, төсөл хөтөлбөрт хөрөнгө оруулах, тодорхой хугацааны дараа үр өгөөжөө аливаа хязгаарлалтгүйгээр шууд татан авах боломжтой байх шинжийг бүрэн хангасан “идеал” улсыг 100 оноо авна гэж үзэх бөгөөд дор заасан хязгаарлалт бий эсэхээс хамаарч харгалзах оноог хасах замаар аливаа улсын хөрөнгө оруулалтын эрх чөлөөг үнэлж байна. Тухайн нэг шалгуур үзүүлэлтийн хүрээнд төрөөс тогтоосон хязгаарлалтгүй бол оноо хасахгүй ба нийтдээ 100 оноос их оноо хасагдсан тохиолдолд 0 гэж үзнэ.

Монгол Улсын хувьд, Хөрөнгө оруулалтын тухай (2013) хуулийн 7 дугаар зүйлд хөрөнгө оруулагч дараах эрхийг баталгаатай эдлэхээр тусгаж, хөрөнгө оруулалтын эрх чөлөөт байдлыг хуулиар баталгаажуулсан. Үүнд:

1. Хөрөнгө оруулалт хийх, хөрөнгө оруулалт хийх хэлбэр, хэмжээ, хөрөнгө оруулалт хийх газар, бүс нутаг зэргийг хараат бусаар сонгох, холбогдох шийдвэрийг бие даан дангаар гаргах;
2. Нэг болон түүнээс дээш салбар, төсөл, үйлдвэрлэл, үйл ажиллагаанд хөрөнгө оруулалт хийх;
3. Хөрөнгө оруулах төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд гадаад улсаас бараа, ажил, үйлчилгээ импортлох, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээг экспортлох;
4. Монгол Улсад бүртгэлтэй банк, банк бус санхүүгийн байгууллагаар дамжуулан гадаадын мөнгөн тэмдэгт худалдан авах, худалдах зэргээр өөрийн гадаад валютын хэрэгцээг хангах;
5. Хөрөнгөө захиран зарцуулах, хууль ёсны орлого, ашгийг гадаадад шилжүүлэх, гадаадаас шилжүүлж авах;
6. Хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийг удирдах буюу удирдахад оролцох, бусад этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу эрх, үүргээ шилжүүлэх;
7. Санхүүжилт, зээл, тусламж, газар, байгалийн баялгийг ашиглах хүсэлт гаргах, хүсэлтээ шийдвэрлүүлэх;
8. Төрийн үйлчилгээг эрх тэгш хүлээн авах;
9. хууль тогтоомжид заасан бусад эрх.

Дээрх байдлаар хөрөнгө оруулагчийн эрхийг хуулиар баталгаажуулах байдлаар хөрөнгө оруулалтын чөлөөт байдлын агуулгыг тогтоосон нь “Heritage Foundation” хүрээлэнгээс эрхлэн гаргадаг “Эдийн засгийн эрх чөлөөний индекс”-ийн “Хөрөнгө оруулалтын эрх чөлөө” гэх дэд индексийг үнэлэх аргачлал, шалгуур үзүүлэлттэй ижил байна.

Иймд “Улаанбаатар хотын хөгжлийн индекс”-ийн нэг индекс болох “Хөрөнгө оруулалтын эрх чөлөө” гэх индексийг АНУ-ын стратеги судалгааны “Heritage Foundation”



хүрээлэнгээс эрхлэн гаргадаг “Эдийн засгийн эрх чөлөөний индекс¹³⁷”-ийн “Хөрөнгө оруулалтын эрх чөлөө” гэх дэд индексийг үнэлэх аргачлал, шалгуур үзүүлэлтийг баримтлах нь оновчтой байна. Тус аргачлалаар Монгол улсын хөрөнгө оруулалтын эрх чөлөөг дараах байдлаар үнэлэв.

Хүснэгт 84. Монгол Улсын “Хөрөнгө оруулалтын эрх чөлөөний индекс”-ийн оноо

№	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	ТОДОРХОЙЛОЛТ	ХАСАГДАХ ОНОО
1	Үндэсний дэглэм үйлчилдэг эсэх	<p>Үндэсний дэглэм үйлчилдэггүй</p> <p><u>Зарим үндэсний дэглэм үйлчилдэг</u></p> <p>Зарим үндэсний дэглэм үйлчилдэг эсхүл prescreening</p>	Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулагчдад ялгамжтай хандах зохицуулалт бий боловч харьцангуй цөөхөн байгаа тул энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд 15 оноо хасагдахаар байна.
2	Хөрөнгө оруулалтын хууль тогтоомжийн ил тод, тогтвортой, урьдчилан таамаглахуйц байдал	<p>Хаалттай бөгөөд хүнд суртал ихтэй</p> <p>Бодлогын хэрэгжилт үр дүнгүй бөгөөд хүнд суртал бүхий</p> <p><u>Зарим хууль тогтоомж нээлттэй биш эсхүл хэрэгжилт үр дүнгүй</u></p>	Монгол Улсад хууль тогтоомжоос бусад эрх бүхий байгууллагын (Төрийн захиргааны төв байгууллага, Нийслэлийн Засаг дарга, НИТХ зэрэг) зарим шийдвэр, тэдгээрийн төсөл англи хэл дээр орчуулагддаггүй бөгөөд хөрөнгө оруулагчдыг оролцуулсан нэгдсэн байдлаар санал, хүсэлтийг авч зөвлөгөөн зохион байгуулдаггүй гэж үзэж 5 оноо хасах нь үндэслэлтэй.
3	Өмчлөх эрхэд тавигдаж буй хязгаарлалт	<p>Бүх төрлийн үл хөдлөх хөрөнгийг шилжүүлэхийг хязгаарласан</p> <p><u>Гагцхүү үл хөдлөх хөрөнгийг гадаадын иргэн, хуулийн этгээдэд шилжүүлэхийг хязгаарласан</u></p> <p>Үл хөдлөх хөрөнгийг шилжүүлэхийг зөвшөөрдөг ч зарим хязгаарлалт тавьдаг</p>	Гадаад хөрөнгө оруулагч газрыг гагцхүү ашиглуулах боломжтойгоор зохицуулсан нь Монгол Улсын иргэний нэр дээрх эзэмших эрхийн гэрчилгээтэй газар эсхүл түүний өмчлөлийн газрыг далд байдлаар ашиглах, барилга байгууламж барих, цаашлаад барилга байгууламжийн өмчлөгч, газрын өмчлөгч эсхүл эзэмшигч нарын хооронд маргаан үүсэх шалтгаан нөхцөл болдог тул Газрын тухай хуулийн зохицуулалтыг сайжруулах шаардлага байгаа нь уг үзүүлэлтийн хүрээнд 10 оноо хасах үндэслэл болно гэж үзлээ.
4	Эдийн засгийн секторт тавигдах хязгаарлалт	<p>Олон секторт хязгаарлалт тавьсан</p> <p>Цөөн салбарт хязгаарлалт тавьсан</p> <p><u>Нэг эсхүл хоёр секторт хязгаарлалт тавьсан</u></p>	Гадаад хөрөнгө оруулагчтай холбоотойгоор тавигдах эдийн засгийн секторын хязгаарлалт байдаг хэдий ч харьцангуй бага тул 5 оноо хасна.
5	Шударга нөхөн олговоргүйгээр өмчийг дайчлан авах, хураах	<p>Нөхөн төлбөргүйгээр дайчлах тохиолдол олон</p> <p><u>Нөхөн төлбөртэйгээр дайчлан авах тохиолдол олон</u></p>	Хуульд шударга нөхөн олговортойгоор өмчийг дайчлан авах талаар тусгасан ч Нийслэлийн газар зохион байгуулалтын албатай гэрээ

¹³⁷ Heritage Foundation, Index of Economic freedom, 2023.

https://www.heritage.org/index/pdf/2023/book/2023_IndexOfEconomicFreedom_FINAL.pdf

		Дайчлан авах тохиолдол бий боловч цөөн	байгуулсан мэргэжлийн үнэлгээчнээр үнэлүүлэхээс ¹³⁸ шударга нөхөн олговрыг тооцох аргачлал, журам тодорхой байдаггүйгээс дээрх зохицуулалтын хэрэгжилт нэг мөр болоогүй байдлаас шалтгаалж, уг үзүүлэлтийн хүрээнд 15 оноо хасав.
6	Гадаад валютын урсгалд тавигдах хязгаарлалт	Гадаад валютын хөрвүүлэг хийгдэх боломжгүй	Засгийн газраас валют чөлөөтэй хөрвөх бодлогыг баримталдаг бөгөөд валютын урсгалд тавигдах хязгаарлалт байдаггүй тул энэ үзүүлэлтийн хүрээнд оноог хасахгүй гэж дүгнэлээ.
		Боломжтой хэдий ч хатуу хязгаарлалттай	
		Боломжтой бөгөөд цөөн хязгаарлалттай	
7	Хөрөнгө, орлогыг гадаад улсад саадгүйгээр гаргах	Хөрөнгө орлогыг гадаад улсад гаргах боломжгүй, бүх гүйлгээнд төрөөс зөвшөөрөл олгодог	Хууль тогтоомжийн хүрээнд тавигдах хязгаарлалтгүй боловч компанийг татан буулгах журмыг сайжруулах шаардлага байна гэж үзэж, уг шалгуур үзүүлэлтийн хувьд 5 оноо хасах нь зүйтэй гэж үзэв.
		Хөрөнгө, орлогыг шилжүүлэхэд зөвшөөрөл шаардлагатай бөгөөд зарим хязгаарлалт тавигддаг	
		<u>Зарим хязгаарлалттай боловч ихэнх гүйлгээ зөвшөөрөгдсөн</u>	
8	Бусад хязгаарлалт	Хөрөнгө оруулалтад шууд бусаар дарамт учруулдаг, хүнд суртал ихтэй, хөрөнгө оруулалтын эрх чөлөөг хязгаарлаж буй засгийн газрын бусад бодлогын улмаас 20 хүртэлх оноог нэмэлтээр хасаж болно. Монгол улсад ийм төрлийн засгийн газрын бодлого байхгүй учир оноо хасахгүй .	
МУ-ийн оноо		45 ОНОО (100 онооноос дээрх шалгуур үзүүлэлтийн хүрээнд 55 оноо хассан үзүүлэлт)	

6.5. ҮР ДҮНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Нийслэлийн хэмжээнд хэмжих боломжтой үзүүлэлт: Дурдсан шалгуур үзүүлэлтүүдээс Хөрөнгө оруулалтын хууль тогтоомжийн ил тод, тогтвортой, урьдчилан таамаглахуйц байдал, Шударга нөхөн олговортойгоор өмчийг дайчлах давтамж, бусад хязгаарлалт /хүнд суртал/ зэргийг хэмжих боломжтой.

Дүүрэгт хэмжих боломжтой үзүүлэлт: Дурдсан шалгуур үзүүлэлтүүдээс Шударга нөхөн олговортойгоор өмчийг дайчлан авах давтамж зэргийг Дүүргийн түвшинд хэмжих боломжтой байна.

6.6. БҮЛГИЙН ДҮГНЭЛТ


“Улаанбаатар хотын хөгжлийн индекс”-ийн нэг индекс болох “Хөрөнгө оруулалтын эрх чөлөө” гэх индексийг АНУ-ын стратеги судалгааны “Heritage Foundation” хүрээлэнгээс эрхлэн гаргадаг “Эдийн засгийн эрх чөлөөний индекс”¹³⁹-ийн “Хөрөнгө оруулалтын эрх

¹³⁸ <http://land.ub.gov.mn/blog/PublicService/OrganizationService/AboutLandAcquisition/1/1>

¹³⁹ Heritage Foundation, Index of Economic freedom, 2023.

https://www.heritage.org/index/pdf/2023/book/2023_IndexOfEconomicFreedom_FINAL.pdf





чөлөө” гэх дэд индексийг үнэлэх аргачлал, шалгуур үзүүлэлтийг баримтлах нь оновчтой гэж үзэж, дээрх индекс, түүний шалгуур үзүүлэлт, аргачлалыг баримтлав. “Эдийн засгийн эрх чөлөөний индекс¹⁴⁰”-ийн “Хөрөнгө оруулалтын эрх чөлөө” гэх дэд индексийн хүрээнд Монгол Улс 100 онооноос 50 оноо авсан байна.

Харин Улаанбаатар хотын хувьд дээрх оноо хамгийн ихдээ 45 байхаар байгаа бөгөөд үүнд Улаанбаатар хотын Засаг дарга, түүний эрхлэх асуудлын хүрээний харъяа агентлагын шийдвэр, дүрэм, журмыг батлахдаа сонсгох ажиллагаа төдийлөн хийдэггүй, цаашлаад нээлттэй бөгөөд хөрөнгө оруулагчид хүртээмжтэй биш байгаа зэрэг нь нөлөөлсөн. Цаашлаад Нийслэлийн харъяа агентлаг дээрх хүнд суртал, хууль тогтоомжийг өөр өөрөөр тайлбарлан хэрэглэх байдал зэрэг нь дээрх оноонд нөлөөлөх боломжтой.

Нийслэлийн Засаг дарга, түүний харъяа агентлагууд хуульд заасан бизнесийн үйл ажиллагаанд зөвшөөрөл олгох, хяналт шалгалт хэрэгжүүлэхдээ гадаадын хөрөнгө оруулагчдыг аливаа байдлаар ялгаварлах, илүү хязгаарлалт, шаардлага тавихаас сэргийлж, дээрх төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуй нэгжүүдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг аль болох багаар хөндөх үүднээс эрх, ашиг нь хөндөгдөж буй этгээдүүдэд хандан уулзалт, зөвлөгөөн хийх, тэдгээрийн саналыг авах зэргээр үйл ажиллагаагаа нийтэд чиглүүлэх бодлого баримталж, хөрөнгө оруулагчдад чухал ач холбогдолтой мэдээллийг хүртээмжтэй байршуулах, түүнчлэн Нийслэл хотын хөгжлийн бодлогод хамаарах төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж буй хөрөнгө оруулагчдыг мэдээллээр хангаж ажиллах шаардлагатай.

¹⁴⁰ Heritage Foundation, Index of Economic freedom, 2023.
https://www.heritage.org/index/pdf/2023/book/2023_IndexOfEconomicFreedom_FINAL.pdf



ДОЛОО. ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Энэхүү судалгаагаар хотын хөгжлийн 86 индексийн 5 индекс үзүүлэлт болох “Нийслэлийн бодлого боловсруулах эрх зүйн орчин”, “Нийслэлийн бодлого, боловсруулалт, төлөвлөлт, хэрэгжилт” /оновчтой, үр дүн, нөлөөтэй, ил тод/, “Шударга байдлын үнэлгээ”, “Хөрөнгө оруулалтын эрх чөлөө”, “Эдийн засгийн эрх зүйн орчин” гэх индекс үзүүлэлтүүдийг нарийвчлан судалж, тухайн индекс үзүүлэлтийн шалгуур үзүүлэлт, арга зүйг тодорхойлсон буюу үндсэн аргачлалыг өргөтгөх бодит суурь мэдээлэлд үндэслэн тооцоог гаргасан. Мөн түүнчлэн тус 5 индексийг тооцохтой холбоотой мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийн нийслэл болон дүүргийн хэмжээнд тус тусын үнэлгээг өгсөн юм.

Дээрх судалгаанд үндэслэн дараах дүгнэлт, зөвлөмжийг боловсрууллаа.

“НИЙСЛЭЛИЙН БОДЛОГО БОЛОВСРУУЛАХ ЭРХ ЗҮЙН ОРЧИН” ИНДЕКС ҮЗҮҮЛЭЛТИЙН ХҮРЭЭНД:

“Нийслэлийн бодлого боловсруулах эрх зүйн орчин” индекс үзүүлэлтийг гаргахдаа SGI буюу (Sustainable governance indicators) “Тогтвортой засаглалын үзүүлэлт”-ийн бүрэлдэхүүн хэсэг болох “Good governance”, “сайн засаглал”-ын 26 шалгуур үзүүлэлтийг жишиг болгон хэрэглэсэн. Энэхүү 26 шалгуур үзүүлэлтээс 14 шалгуур үзүүлэлт нь “Нийслэлийн бодлого боловсруулах эрх зүйн орчин” индекс үзүүлэлтэд хамаарч байна.

Түүнчлэн, тооцооллын хувьд SGI шалгуур нь судлаачийг сонгох боломжийг олгосон байдаг. Тодруулбал, тухайн үзүүлэлтийн үнэлгээг хүснэгтэд заасан 4 шалгуурын дагуу боловсруулж холбогдох оноог өгдөг. Иймд нийслэлийн бодлого боловсруулах эрх зүйн орчин шалгуур үзүүлэлтийн оноог өгөхдөө онооны нээлттэй байдлаас шалтгаалан авч болох дээд, доод, дундаж оноог гаргалаа.

“Нийслэлийн бодлого боловсруулах эрх зүйн орчин” индекс үзүүлэлтийн дээд оноо нь 4.35, доод оноо нь 2.64, дундаж оноо нь **3.5** оноотой байна. Өөрөөр хэлбэл “Нийслэлийн бодлого боловсруулах эрх зүйн орчин” индекс үзүүлэлт 2.64-4.35 онооны хооронд хэлбэлзэхээр байна. “Нийслэлийн бодлого боловсруулах эрх зүйн орчин” индекс үзүүлэлтийг сайжруулах зөвлөмжийг тухайн дэд бүлгийн дүгнэлт хэсэгт боловсруулсан болно.

“НИЙСЛЭЛИЙН БОДЛОГО, БОЛОВСРУУЛАЛТ, ТӨЛӨВЛӨЛТ, ХЭРЭГЖИЛТ” /ОНОВЧТОЙ, ҮР ДҮН, НӨЛӨӨТЭЙ, ИЛ ТОД/ ИНДЕКС ҮЗҮҮЛЭЛТИЙН ХҮРЭЭНД:

Нийслэлийн бодлого боловсруулалт, төлөвлөлт, хэрэгжилт хэсгийн хүрээнд, SGI-ийн Тогтвортой засаглалын индексийн “Гүйцэтгэх чадвар” болон “Гүйцэтгэх хариуцлага” гэсэн 2 үндсэн бүлгийн шалгуур үзүүлэлтийг, нийслэл тулгамдсан асуудлаа тодорхойлж, стратегийн шийдэл боловсруулж чадаж байгаа эсэхийг үнэлэх зорилгоор ашигласан. Тус индексийн “Гүйцэтгэх чадвар-ын шалгуур үзүүлэлтээр, нийслэл бодлого боловсруулж, стратегийн төлөвлөлт хийхдээ талуудын оролцоог хангаж буй байдал болон бодлого хэрэгжүүлэх, суралцах чадавхийг, “Гүйцэтгэх хариуцлага”-ын шалгуур үзүүлэлтээр, иргэд, сонирхлын бүлгүүд, хэвлэл мэдээллийн хэрэгслүүд нийслэлийн бодлого, шийдвэрт хяналт



тавих, санал, хүсэлтээ илэрхийлэх, хариуцлага тооцох чадавхийг үнэлэхэд тус тус ашигласан болно. Тус индексийн шалгуур үзүүлэлтийн дагуу нийслэл **55.9** хувийн үнэлгээ авсан байна.

“ШУДАРГА БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ” ИНДЕКС ҮЗҮҮЛЭЛТИЙН ХҮРЭЭНД:

Хотын хөгжлийн индексийн “Шударга байдлын үнэлгээ” индекс үзүүлэлтийг дэлхий дахинд болон дотоодын эрх зүйн тогтолцоонд олон янзаар тооцож судалгааг хийдэг ба тус судалгааны хүрээнд “Олон улсын “Rule of Law index” буюу “Хууль дээдлэх ёсны индекс””, “Америкийн Нэгдсэн Улсын “Шударга ёс”-ны индекс”, “Хүрээлэн буй орчны “Шударга ёс”-ны индекс”, “Олон улсын “Шударга ёс”-ны индекс”, “Нийгмийн “Шударга ёс”-ны индекс”, “Дэлхийн хотуудын чансааны индекс”, “Монгол Улсын шүүхийн индекс” үзүүлэлтийг судлаж үзлээ. Үүнээс сул тал багатай, давуу тал ихтэй индекс үзүүлэлтийн тухайд Дэлхийн шударга ёсны төсөл (World Justice Project)-ийн “Rule of Law index” буюу “Хууль дээдлэх ёсны индекс” байна. “Хууль дээдлэх ёсны индекс”-ийн тухайд шалгуур үзүүлэлт нь өргөн хүрээнд нарийвчлагдсанаас гадна судалгааны арга зүй сайтай, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эх сурвалж юм. Иймд нийслэлийн “Шударга байдлын үнэлгээ” индексийг тооцохдоо дээрх индекс шалгуур үзүүлэлтэд үндэслэх нь зүйтэй байна.

Нийслэл буюу Улаанбаатар хот, дүүргүүдийн “Шударга байдлын үнэлгээ” индекс үзүүлэлтийг тооцохдоо “Rule of Law index” буюу “Хууль дээдлэх ёсны индекс” шалгуур үзүүлэлт болгонд холбогдох өгөгдлүүдийг харгалзан үнэлгээг гаргахад Монгол Улс **0.54**, Нийслэл **0.55**, Баянзүрх дүүрэг **0.55**, Сүхбаатар дүүрэг **0.56**, Баянгол дүүрэг **0.53**, Чингэлтэй дүүрэг **0.53**, Хан-Уул дүүрэг **0.55**, Сонгинохайрхан дүүрэг **0.55**, Багануур дүүрэг **0.52**, Налайх дүүрэг **0.52**, Багахангай дүүрэг **0.44** оноог тус тус авч байна.

“ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЗҮЙН ОРЧИН” ИНДЕКС ҮЗҮҮЛЭЛТИЙН ХҮРЭЭНД:

Монгол улсын эдийн эрх чөлөөг хэмжихэд Heritage Foundation-ийн “Эдийн засгийн эрх чөлөөний индекс”-ийг ашиглаж болохоор байна. Энэ нь 12 хүчин зүйл (өмчийн эрх, засгийн газрын шударга байдал, шүүхийн үр нөлөө, засгийн газрын зардал, татварын ачаалал, төсвийн зохистой байдал, бизнесийн эрх чөлөө, хөдөлмөрийн эрх чөлөө, мөнгөний эрх чөлөө, худалдааны эрх чөлөө, хөрөнгө оруулалтын эрх чөлөө, санхүүгийн эрх чөлөө)-ээс бүрддэг ба дэлхийн 184 орны эдийн засагт дүн шинжилгээ хийх эх сурвалж болдог.

Монгол улс 2023 оны байдлаар Heritage Foundation-ийн “Эдийн засгийн эрх чөлөөний индекс”-ээс **61.7** оноо авсан байна. Энэ нь дэлхийн 184 орноос 73 дугаарт, харин Ази-Номхон далайн бүсийн 39 орноос 15-д жагссан үзүүлэлт бөгөөд дэлхийн болон бүс нутгийн дунджаас дээгүүр үзүүлэлт гарсан байна.

Монгол улсын нийслэл Улаанбаатар хот болон 9 дүүргийн эдийн засгийн чадавхыг үнэлэхэд ЭЗБӨЧСТ-ийн “Дүүргүүдийн өрсөлдөх чадварын үнэлэх тайлан”-г ашиглах боломжтой байна. 2021 оны байдлаар нийслэл Улаанбаатар хот болон 9 дүүргийн үзүүлэлтийг тодорхойлбол Улаанбаатар хот **0.595**, Багануур дүүрэг **0.198**, Багахангай дүүрэг



0.103, Баянзүрх дүүрэг **0.520**, Баянгол дүүрэг **0.452**, Налайх дүүрэг **0.215**, Сонгинохайрхан дүүрэг **0.405**, Сүхбаатар дүүрэг **0.510**, Хан-Уул дүүрэг **0.443**, Чингэлтэй дүүрэг **0.466** оноог тус тус авсан байна.

“ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЭРХ ЧӨЛӨӨ” ИНДЕКС ҮЗҮҮЛЭЛТИЙН ХҮРЭЭНД:

“Хотын хөгжлийн индекс”-ийн “Хөрөнгө оруулалтын эрх чөлөө” гэх индексийг АНУ-ын стратеги судалгааны “Heritage Foundation” хүрээлэнгээс эрхлэн гаргадаг “Эдийн засгийн эрх чөлөөний индекс”-ийн “Хөрөнгө оруулалтын эрх чөлөө” гэх дэд индексийг үнэлэх аргачлал, шалгуур үзүүлэлтийг баримтлах нь оновчтой гэж үзэж, дээрх индекс, түүний шалгуур үзүүлэлт, аргачлалыг баримтлалаа. “Эдийн засгийн эрх чөлөөний индекс”-ийн “Хөрөнгө оруулалтын эрх чөлөө” гэх дэд индексийн хүрээнд Монгол Улс 100 онооноос 50 оноо авсан байна.


Харин Улаанбаатар хотын хувьд дээрх оноо хамгийн ихдээ **45** байхаар байгаа бөгөөд үүнд Улаанбаатар хотын Засаг дарга, түүний эрхлэх асуудлын хүрээний харъяа агентлагын шийдвэр, дүрэм, журмыг батлахдаа сонсгох ажиллагаа төдийлөн хийдэггүй, цаашлаад нээлттэй бөгөөд хөрөнгө оруулагчид хүртээмжтэй биш байгаа зэрэг нь нөлөөлсөн. Цаашлаад Нийслэлийн харъяа агентлаг дээрх хүнд суртал, хууль тогтоомжийг өөр өөрөөр тайлбарлан хэрэглэх байдал зэрэг нь дээрх оноонд нөлөөлөх боломжтой.

Нийслэлийн Засаг дарга, түүний харъяа агентлагууд хуульд заасан бизнесийн үйл ажиллагаанд зөвшөөрөл олгох, хяналт шалгалтын ажлыг хэрэгжүүлэхдээ гадаадын хөрөнгө оруулагчдыг аливаа байдлаар ялгаварлах, илүү хязгаарлалт, шаардлага тавихаас сэргийлж, дээрх төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуй нэгжүүдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг аль болох багаар хөндөх үүднээс эрх, ашиг нь хөндөгдөж буй этгээдүүдэд хандан уулзалт, зөвлөгөөн хийх, тэдгээрийн саналыг авах зэргээр үйл ажиллагаагаа нийтэд чиглүүлэх бодлого баримталж, хөрөнгө оруулагчдад чухал ач холбогдолтой мэдээллийг хүртээмжтэй байршуулах, түүнчлэн Нийслэл хотын хөгжлийн бодлогод хамаарах төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж буй хөрөнгө оруулагчдыг мэдээллээр хангаж ажиллах шаардлагатай.

Эцэст нь дүгнэвэл, Хотын хөгжлийн 86 индексийн 5 индекс үзүүлэлт болох “Нийслэлийн бодлого боловсруулах эрх зүйн орчин”, “Нийслэлийн бодлого, боловсруулалт, төлөвлөлт, хэрэгжилт” /оновчтой, үр дүн, нөлөөтэй, ил тод/, “Шударга байдлын үнэлгээ”, “Хөрөнгө оруулалтын эрх чөлөө”, “Эдийн засгийн эрх зүйн орчин” гэх индекс үзүүлэлтүүдээр нийслэлийн үнэлгээг гаргахад дараах байдлаар тодорхойлогдож байна.

№	Индекс үзүүлэлтүүд	Нийслэлийг дүгнэсэн оноо	“1-100” хүртэлх оноогоор
1.	Нийслэлийн бодлого боловсруулах эрх зүйн орчин	3.5	35/100
2.	Нийслэлийн бодлого, боловсруулалт, төлөвлөлт,	55.9	56/100

	хэрэгжилт” /оновчтой, үр дүн, нөлөөтэй, ил тод/		
3.	Шударга байдлын үнэлгээ	0.55	55/100
4.	Хөрөнгө оруулалтын эрх чөлөө	45	45/100
5.	Эдийн засгийн эрх зүйн орчин	0.595	59/100



ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Хууль тогтоомж, эрх зүйн акт

Монгол хэлээр:

1. Монгол Улсын Үндсэн хууль, (1992)
2. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, (2020)
3. Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, (1993)
4. Монгол Улсын Нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль, (2021)
5. Төрийн албаны тухай хууль, (2017)
6. Төсвийн тухай хууль, (2011)
7. Хууль тогтоомжийн тухай хууль, (2017)
8. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, (2020)
9. Нийслэл хотын албан татварын тухай хууль, (2015)
10. Эрүүгийн хууль, (2015)
11. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэсэн тухай хууль, (2017)
12. Иргэний хууль, (2002)
13. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, (2002)
14. Захиргаа ерөнхий хууль, (2015)
15. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, (2016)
16. Зөрчлийн тухай хууль, (2017)
17. Зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, (2017)
18. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, (2021)
19. Газрын тухай хууль, (2002)
20. Хөрөнгө оруулалтын тухай хууль, (2013)
21. Татварын ерөнхий хууль, (2019)
22. Төв банк /Монголбанк/-ны тухай хууль, (1996)
23. Валютын зохицуулалтын тухай хууль, (1994)
24. Төрийн захиргааны албан тушаалын тэргүүн түшмэл, түүнтэй адилтгах удирдах албан тушаалд тавигдах тусгай шаардлага, Төрийн албаны зөвлөлтийн 2019 оны 02 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт
25. Төрийн захиргааны албан тушаалын тэргүүн түшмэл, түүнтэй адилтгах удирдах албан тушаалд тавигдах тусгай шаардлага, Төрийн албаны зөвлөлтийн 2019 оны 02 дугаар тогтоолын дөрөвдүгээр хавсралт

Ном, сурах бичиг, судалгааны тайлан, эмхэтгэл

Монгол хэлээр:

1. Нээлттэй нийгэм форум, Оюуны инноваци ТББ, “Монгол улс шүүхийн индекс 2021” судалгааны тайлан, УБ, 2021
2. Шүүхийн ерөнхий зөвлөл “Монгол Улсын шүүхийн тайлан 2022 он”, УБ, 2023
3. Төрийн албаны зөвлөл, “Монгол Улсын төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны тайлан-2022”, УБ, 2023
4. Авлигатай тэмцэх газар, “Шударга байдлын үнэлгээ” судалгааны тайлан, УБ, 2022
5. Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисс, “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл”, УБ, 2023
6. Үндэсний статистикийн хороо, “Хөрөнгө оруулалт 2021”, УБ, 2022



7. Санхүүгийн зохицуулах хороо, “Санхүүгийн салбарын тойм 2022 оны 3 дугаар улирлын тайлан”
8. Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгааны тайлан
9. А.Түвшинтөгс, “Гадаадын хөрөнгө оруулалттай компани газар эзэмших эсхүл ашиглах эрхийг эдлэхэд тулгамдаж буй хууль зүйн асуудал”
10. Хууль зүйн үндэсний хүрээлэн, Төрийн болон албаны нууцын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх, 2023
11. Газар зохион байгуулалт, геодизи, зураг зүйн газар, “Газрын эрхийн бүртгэлийн тайлан”, Уб, 2022
12. Газрын биржийн гарын авлага, <http://land.ub.gov.mn/blog/PublicService/ImprovePublicService/LandExchange/1/1>
13. Бизнес ба хүний эрх, “Хууль зүйн үндэсний хүрээлэн”, Уб, 2023
14. Д.Гангабаатар, “Хот суурин газрын дахин төлөвлөлт ба шударга нөхөх олговор”, Эмнести интернэшнл, Уб, 2017
15. “Нийтийн болон хувийн өмчийн эрх зүйн тулгамдсан асуудал”, Уб, 2012
16. ЭЗБӨЧСТ, “Дүүргүүдийн өрсөлдөх чадварын тайлан 2021”, Уб, 2021
17. Үндэсний статистик хороо, “Ажиллах хүчний судалгааны 2022 оны III улирлын товч танилцуулга”, Уб, 2022
18. Үндэсний статистик хороо, “Аж ахуй нэгжийн 2021 оны тооллого, нэгдсэн үр дүн”, Уб, 2022

Гадаад хэлээр:

1. Sustainable Governance Indicators 2022, Codebook, pp.13, https://www.sgi-network.org/docs/2022/basics/SGI2022_Codebook.pdf
2. An Introduction to the Policy Process: Theories, Concepts, and Model of Public Policy Making/ Third Edition, Thomas A. Birkland.
3. Fudan Institute for Advanced Study in Social Sciences, Global Justice Index Report 2022, https://globaljustice.fudan.edu.cn/attached/UploadFile/202307/02143316_1839.pdf
4. The World Justice, Project Rule of Law Index® 2022, <https://worldjusticeproject.org/rule-of-law-index/downloads/WJPIIndex2022.pdf>
5. Institute for Urban Strategies, The Mori Memorial Foundation, Global Power City Index 2022, https://mori-m-foundation.or.jp/pdf/GPCI2022_summary.pdf
6. Global Justice Index Report 2022, https://globaljustice.fudan.edu.cn/attached/UploadFile/202307/02_143316_1839.pdf
7. Mori Memorial foundation, The Global Power City Index YEARBOOK 2022, <https://mori-m-foundation.or.jp/english/ius2/gpci2/index.shtml>
8. Transparency and predictability for investment policies addressing national security concerns: a survey of practices, May 2008
9. Black’s law dictionary, deluxe ninth edition, Bryan A. Garner (ed), 2009 Thomas Reuters
10. Heritage Foundation, Index of Economic freedom, 2023.

Цахим эх сурвалж

Монгол хэлээр:



1. <https://ubservice.ub.gov.mn/wp-content/uploads/2023/09/%D0%91%D2%AF%D1%82%D1%8D%D1%86-%D0%9016-2023-1-2.pdf>
2. Улаанбаатар хотын захирагчийн ажлын алба, <http://ubservice.mn/>
3. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан, <https://legalinfo.mn/>
4. Иргэд амьдарч буй орчноо камержуулах санал гаргажээ, 2019, <https://itoim.mn/article/HohlR/16822>
5. Нийслэлийн Засаг дарга иргэдийн санал, гомдлыг сонсож, шийдвэрлэж байна, https://m.facebook.com/niisleliinmedeee/posts/2853281171615510/?locale2=en_GB
6. НЗДТГ-ын Хэвлэл мэдээлэлтэй харилцах хэлтэс, Хотын дүрэм боловсруулахад иргэдээс санал авна, <https://ikon.mn/n/2axj>
7. <https://vote.ulaanbaatar.mn/home>
8. Нийслэлийн 2024 оны төсвийн төслийн санал асуулга <https://docs.google.com/forms/d/e/1faipqlsf0totwyyarhv0bfojnmh0e1vpvjylixbysidq37iexhikyua/viewform>
9. Нийслэлийн санхүү, төсвийн өнөөгийн байдал, 2024 оны төсвийн төсөлд санал өгөх, <https://ulaanbaatar.mn/home>
10. <https://docs.google.com/forms/d/e/1FAIpQLSf0TOtwYyaRHV0BfoJNMh0E1VPVJyIJXbySidQ37iexHlKYUA/viewform>
11. <https://ulaanbaatar.mn/home>
12. Нийслэл засаг дарга, Улаанбаатар хотын захирагчийн дугаар А/1321 захирамж, <https://ulaanbaatar.mn/rule/655eeca8eaca082574cb5322>
13. Нийтийн өргөдөл, гомдлын систем, <https://petition.parliament.mn/>
14. <https://niislel.burtgel.gov.mn/post/62236>
15. Нийслэлийн худалдан авах ажиллагааны газар, хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын 2022 оны төлөвлөгөөний тайлан, <https://ub-procurement.mn/uploads/media/default/0001/01/5f51124acf6b2e895dcda48ed8be78bf86662a08.pdf>
16. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, “ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО, улирал, улс, бүс, аймаг, нийслэл, сум, дүүрэг, хариуцлагын хэлбэрээр”, https://www2.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_2600_011V3&13999001_select_all=0&13999001SingleSelect=T8&Aimags_soums_select_all=0&Aimags_soumsSingleSelect=0501&YearQ_select_all=0&YearQSingleSelect=202301&viewtype=table
17. Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан, <https://shuukh.mn/>
18. Цагдаагийн байгууллагын хэмжээнд 2022 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээ, <https://information.police.gov.mn/a/5357>
19. МОНГОЛ УЛСАД ОРШИН СУУГАА ХҮН АМЫН ТОО, баг/хороо, хот/хөдөөгөөр, https://www2.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_0300_004V5&BAG_select_all=0&BAGSingleSelect=0511511015110451107511105111351116511195112251125&RESIDENT_select_all=0&RESIDENTSingleSelect=1&YearY_select_all=0&YearYSingleSelect=2022&viewtype=table
20. Монгол Улс дахь Америкийн Нэгдсэн Улсын Элчин сайдын яам, Монгол Улсын 2022 оны Хөрөнгө оруулалтын орчны мэдэгдэл, <https://mn.usembassy.gov/mn/2022-investment-climate-statement-mongolia-mn/>, <https://www.state.gov/reports/2023-investment-climate-statements/mongolia/>
21. Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар:Танилцуулга, <http://invest.ub.gov.mn/page/single/1>
22. Нийслэлийн газар зохион байгуулалтын албаны мэдээлэл, <http://land.ub.gov.mn/blog/Transparenc y/TransparencyOfActivities/ActivityReport/1/1>



23. ЭЗБӨЧСТ-өөс гаргасан Макро эдийн засгийн 2023 оны 9 дүгээр сарын тойм, <https://ecrc.mn/%D0%BC%D0%B0%D0%BA%D1%80%D0%BE-%D1%8D%D0%B4%D0%B8%D0%B9%D0%BD-%D0%B7%D0%B0%D1%81%D0%B3%D0%B8%D0%B9%D0%BD-2023-%D0%BE%D0%BD%D1%8B-9-%D1%80-%D1%81%D0%B0%D1%80%D1%8B%D0%BD-%D1%82%D0%BE%D0%B9%D0%BC/>
24. Монгол Улсын Татварын албаны цахим хуудас, <http://nta.mn/single/15>

Гадаад хэлээр:

1. Regulatory Impact Analysis: A Tool for Policy Coherence, <https://www.oecd.org/gov/regulatory-policy/ria-tool-for-policy-coherence.htm>
2. GOVERNANCE MANUAL FOR REGULATORY IMPACT ANALYSIS MINISTRY OF INFRASTRUCTURE Regulatory impact assessments, <https://www.gov.br/transportes/pt-br/aceso-a-informacao/air/AIRModelodegovernana20210921-English.pdf>
3. What is strategic planning?, <https://www.techtarget.com/searchcio/definition/strategic-planning>
4. National center for justice, Justice index, <https://ncaj.org/state-rankings/justice-index>
5. Agency for toxic substance and disease registry, Environmental Justice Index, <https://www.atsdr.cdc.gov/placeandhealth/eji/indicators.html>
6. EQM Indexes LLC, Adasina social justice index, <https://eqmindexes.com/social-justice-index-summary/>
7. World justice project: Our Approach, <https://worldjusticeproject.org/about-us/overview/our-approach>
8. Behind the numbers, <https://worldjusticeproject.org/rule-of-law-index/downloads/Index-Methodology-2023.pdf>
9. NCAJ: Justice Index, <https://ncaj.org/state-rankings/justice-index>
10. About the Justice Index, <https://ncaj.org/state-rankings/justice-index>
11. Environmental Justice Index, <https://www.atsdr.cdc.gov/placeandhealth/eji/index.html>
12. Environmental Justice Index Indicators, <https://www.atsdr.cdc.gov/placeandhealth/eji/indicators.html>
13. ADASINA SOCIAL JUSTICE INDEX, <https://eqmindexes.com/social-justice-index-summary/>
14. ADASINA SOCIAL JUSTICE INDEX Methodology Guide, <https://eqmindexes.com/wp-content/uploads/2023/08/Guideline-Adasina-Social-Justice-Index-v2.03.pdf>
15. ADASINA SOCIAL JUSTICE INDEX CRITERIA, <https://eqmindexes.com/social-justice-index-criteria/>
16. Heritage Foundation, Index of Economic freedom, 2023. <https://www.heritage.org/index/pdf/2023/book/2023-IndexOfEconomicFreedom-FINAL.pdf>
17. Дэлхийн банкны цахим хуудас, <https://www.worldbank.org/mn/news/press-release/2023/04/19/mongolia-s-economy-to-accelerate-in-2023-but-reforms-and-diversification-needed-to-sustain-growth>

